

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

(ХУУЛЬ, ТОГТООЛ ,ЗАРЛИГ, ШИЙДВЭР, НИЙТЛЭЛ–ХУУЛИЙН ТАЙЛБАР)

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар

1993 оны 9—11 сар № 6—7 (17—18)

ГАРЧИГ

Хуудасны дугаар

1. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Монгол Улсын Аж ахуйн нэгжийн хууль 715
Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хууль 744
Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хууль 758
Монгол Улсын Их Хурлын тухай хууль 760
Монгол Улсын Хөдөлмөрийн хамтын маргаан зохицуулуулах тухай хууль 801
Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай Монгол Улсын хууль 806
Гэрээ сооёрхон батлах тухай Монгол Улсын хууль 808
Монгол Улс, Бүгд Найрамдах Киргиз Улсын найрсаг харилцааа, хамтын ажиллагааны тухай Гэрээ 808
Гэрээ сооёрхон батлах тухай Монгол Улсын хууль 812
Хөөр тээлийн эдийн засгийн гадаад харилцааны тухай Монгол Улс, Америк Улс хоорондын Хэлэлцээр 813
Монгол Улсын Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль 820
Хууль зүйчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын хууль 826

2. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

«5 төгрөг», «1000 төгрөг»ийн дэвсгэртийг хууль ёсны төлбөрийн харилцаанд тооцох, гүйлгээнд гаргахыг зөвшөөрөх тухай № 69 827
Н. Жанцанноовыг Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх тухай № 70 828

13. Монгол Улсын Их Хурлын 1993 оны намрын чуулганаар хэлэлцэх асуудлын тухай № 71 829
14. Монгол Улсын Батлан хамгаалах тухай хууль, Хилийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай № 72 830
15. Дүрэм батлах тухай № 73 831
16. Санал хураах комисс байгуулах тухай № 74 840
17. Улсын Их Хурлын зарим байнгын хорооны даргыг сонгох тухай № 75 841
18. Монгол Улсын Ерөнхийлөгчид эрх олгох тухай Монгол Улсын хуулийн теслийн тухай № 76 842
19. Зарим албан тушаалтны орлого, эд хөрөнгө бүртгэх журам тогтоох тухай тогтоолын теслийн тухай № 77 843
20. Хөдөлмөрийн хамтын маргаан зохицуулах тухай, хууль, Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай № 78 844
21. Улсын Их Хурлын зарим Байнгын хорооны даргыг сонгох тухай № 79 845
22. Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны бүрэлдэхүүнийг тогтоох тухай № 80 846
23. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийн явцын тухай № 81 849
24. Дэд хорооны бүрэлдэхүүнийг тогтоох тухай № 82 853
25. Зарим газрыг улсыч тусгай хамгаалалтад авахыг зөвшөөрөх тухай № 83 854
26. Улсын Их Хурлын гишүүн Т. Эрдэнэбилэгийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай № 84 855
27. Т. Эрдэнэбилэгийг Байнгын хорооны гишүүнээр батлах тухай № 85 856
28. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн томилох, цэцийн дээд тооны гишүүнээр ажиллуулах тухай № 86 857
29. Монгол Улсын төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай № 87 858

3. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

30. Зарим хүнийг одон медалиар шагнах тухай № 90 859
31. Аваргын Басхүү, Балжинням Мишигдорж нарт Монгол Улсын спортын гавьяат дасгалжуулагч цол олгох тухай № 93 860
32. Агвааны Ганбаатарт Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол олгох тухай № 94 861
33. Зарим тамирчин, дасгалжуулагчийг одонгоор шагнах тухай № 95 862
34. ОХУ-ын зарим хүнийг одон, медалиар шагнах тухай № 96 863
35. Ж. Чойжанцанг Улсын Ерөнхий прокурорын орлогчоор томилох тухай № 97 864
36. Гомбын Ванданмагсар, Дамдинжавын Даваадагва нарыг «Шударга журам» медалиар шагнах тухай № 98 864
37. Шүүхийн бэлгэ тэмдгийн хэв маяг, зураглал, дүрмийг батлах тухай № 101 865
38. Б. Баяртүмэн, С. Халтар нарыг «Алтан гадас» одонгоор шагнах тухай № 102 871
39. Д. Отрядыг «Алтан гадас» одонгоор шагнах тухай № 103 871

40. Х. Мөнхтогоог «Алтан гадас» одонгоор шагнах тухай № 104 872
41. Г. Оргойг «Алтан гадас» одонгоор шагнах тухай № 105 873
42. Б. Загдаар Хөдөлмөрийн хүндэт медалиар шагнах тухай № 106 873
43. Г. Энхжаргалыг Хөдөлмөрийн хүндэт медалиар шагнах тухай № 107 874
44. Л. Цогбадрахыг «Шударга журам» медалиар шагнах тухай № 108 874
45. Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай № 109 875
46. Р. Махумыг «Алтан гадас» одонгоор шагнах тухай № 110 876
47. Прокурорын зэрэг дэв олгох тухай № 111 877
48. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар авсан арга хэмжээ, дүгнэлт, зориатын тухай Монгол Улсын Их Хурлын 1993 оны намрын чуулганы хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд П. Жасрайн тавьсан илтгэл 878

4. НИЙТЛЭЛ, ТАЙЛБАР—ЗӨВЛӨМЖ

49. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай 902
50. Хөдөлмөрийн хамтын маргааныг зохицуулах тухай 906
51. Хилийн тухай хуулийн тухай 910
52. Батлан хамгаалах хуулийн тухай 914
53. Монгол Улсын Их Хурлын хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн талаарх товч тайлбар 919

МОНГОЛ УЛСЫН АЖ АХУЙН НЭГЖИЙН ТУХАЙ ХУУЛЬ

(Аж ахуйн нэгжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын 1993 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуульд заасан нэмэлт, өөрчлөлтийг тусгасан найруулга)

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэхүү хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт аж ахуйн нэгжийг үүсгэн байгуулах, бүртгэх, үйл ажиллагааг нь зогсоох, татан буулгах, тухайн нэгжийн удирдлагын зохион байгуулалт, гишүүний эрх, үүрэг, хариуцлагатай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Аж ахуйн нэгж

1. Өөрийн нэрийн өмнөөс үйлдвэрлэл, үйлчилгээ тогтвортой эрхэлж, үйл ажиллагаатайгаа холбогдон үүсэх үүргийг эд хөрөнгөөрөө хариуцаж байгаа этгээдийг аж ахуйн нэгж гэнэ.

Аж ахуйн нэгжийг төрийн эрх бүхий байгууллага, иргэн, аж ахуйн нэгж үүсгэн байгуулж болно.

2. Аж ахуйн нэгжийн дор дурдсан хэлбэрүүд байж болно:

1) хувираа эрхлэх аж ахуй;

2) хоршоо;

3) компани.

Аж ахуйн нэгж өмчийн төрлөөр төрийн, хувийн болон холимог хэлбэртэй байна.

3. Улсын үйлдвэрийн газрын эрх зүйн онцлогийг энэ хуулийн 5 дугаар бүлгийн заалтаар тодорхойлно.

(Энэ хэсэгт Аж ахуйн нэгжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан)

4. Монгол Улсын хууль тогтоомж болон Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гадаадын иргэн, байгууллага, харьяалалгүй хүмүүс дангаараа эсхүл Монгол Улсын аж ахуйн нэгж, иргэдтэй хамтран энэ хуулийн дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрт аж ахуйн нэгж байгуулж болно.

(Энэ хэсэгт Аж ахуйн нэгжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт оруулсан)

2[1] дүгээр зүйл. Аж ахуйн нэгжүүд нэгдэх

Салбарын, нутаг дэвсгэрийн буюу бусад зарчмыг үндэс болгож, үйл ажиллагаагаа зохицуулах, ашиг сонирхлоо төрийн болон бусад байгууллага, түүнчлэн олон улсын байгууллагад төлөөлөх зорилгоор аж ахуйн нэгжүүд хуульд заасан үндэслэл, журмын дагуу аливаа хэлбэрээр нэгдэж болно.

(Энэ зүйлийг Аж ахуйн нэгжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар нэмсэн)

3 дугаар зүйл. Аж ахуйн нэгжийг байгуулах, бүртгэх

1. Аж ахуйн нэгжийг үүсгэн байгуулагчийн санаачилгаар байгуулна.

2. Хувираа эрхлэх аж ахуйг иргэний гаргасан өргөдөл, бусад аж ахуйн нэгжийг үүсгэн байгуулагчийн бичгээр үйлдсэн гэрээ, дүрмийг үндэслэн Улсын татварын ерөнхий газар, аймаг, нийслэлийн татварын алба, сум, дүүргийн татварын алба (цаашид «бүртгэх байгууллага» гэх) харьяаллын дагуу бүртгэнэ.

Хууль тогтоомжид заасны дагуу тодорхой мэргэжил, тусгай зөвшөөрөл шаардах үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах тохиолдолд эрх бүхий байгууллагын зөвшөөрөл, гэрчилгээг авсан байна.

(Энэ хэсгийг Аж ахуйн нэгжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан)

3. Гэрээнд дор дурдсан зүйлийг заавал тусгана:

1) аж ахуйн нэгжийн оноосон нэр, харьяалал, хаяг, орших газар;

2) гишүүний нэр, мэргэжил, хаяг;

3) эрхлэх ажил, үйлдвэрлэл, үйлчилгээний төрөл, үйл ажиллагааны эрх зүйн үндэс, хугацаа;

4) эд хөрөнгийн хэмжээ, түүнийг бүрдүүлэх хугацаа, хэлбэр.

(Энэ хэсгийн 3 дахь заалтад Аж ахуйн нэгжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан)

4. Хоршоо, компани нь дүрэмтэй байна. Дүрэмд дор дурдсан зүйлийг заавал тусгана:

1) аж ахуйн нэгжийн оноосон нэр, хаяг, орших газар;

2) эрхлэх ажил, үйлдвэрлэл, үйлчилгээний төрөл;

3) дүрмийн сангийн хэмжээ;

4) үйлдвэрлэл, удирдлагын зохион байгуулалтын бүтэц;

5) татаг буулгах, эцсийн тооцоо хийх;

6) ашиг, алдагдлыг хуваарилах;

7) гишүүний эрх, үүрэг;

8) энэ хуулийн дагуу тусгавал зохих бусад зүйл.

(Энэ хэсгийн 2 дахь заалтад Аж ахуйн нэгжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан)

5. Гэрээ, дүрмийн заалтаар маргаан гарсан тохиолдолд гэрээг баримтална.

6. Гэрээ, дүрэмд нэмэлт, өөрчлөлт орвол энэ тухай 14 хоногийн дотор бүртгэх байгууллагад мэдэгдэнэ.

7. Үүсгэн байгуулагч нь гэрээ үйлдэж, нотариатаар гэрчлүүлэн дүрмээ баталснаас хойш 30 хоногийн дотор бүртгэх байгууллагад өргөдлөө гаргана. Аж ахуйн нэгжийн оноосон нэр нь урьд улсын бүртгэлд бүртгэгдсэн аж ахуйн нэгжийн оноосон нэртэй давхардсан байж болохгүй. Гэрээ, дүрмийн үндэслэлийг бүртгэх байгууллага шалгах эрхтэй. Бүртгэх байгууллага энэ хуулийн дагуу аж ахуйн нэгжийг бүртгэж, улсын бүртгэлийн гэрчилгээ олгоно. Гэрчилгээнд аж ахуйн нэгжийн эрх зүйн үндсийг заана. Бүртгэх байгууллага аж ахуйн нэгжийг бүртгэсэн тухай нийтэд мэдээлнэ.

(Энэ хэсэгт Аж ахуйн нэгжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан)

8. Аж ахуйн нэгж нь улсын бүртгэлийн гэрчилгээ авсан өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа явуулах эрхтэй.

9. Бүртгэх байгууллага нь аж ахуйн нэгжийн гэрээ, дүрмийг Монгол Улсын хууль тогтоомжид нийцээгүй гэж үзвэл зохих үндэслэлийг тодорхойлж аж ахуйн нэгжийг бүртгэхээс татгалзана. Аж ахуйн нэгж бүртгэхээс татгалзсан тухай шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргаж болно.

10. Бүртгэх байгууллага нь аж ахуйн нэгж, түүний гэрээ, дүрэмд орсон нэмэлт, өөрчлөлтийг бүртгэсэн тухай 7 хоногийн дотор зохих шатны статистикийн байгууллагад мэдэглэж нийтэд мэдээлнэ.

4 дүгээр зүйл. Санхүүгийн хяналт шалгалт

1. Аж ахуйн нэгжийн санхүүгийн үйл ажиллагааг Монгол улсын хууль тогтоомжийн дагуу улсын санхүүгийн байгууллагаас хянан шалгана.

2. Аж ахуйн нэгж санхүү, аж ахуйн үйл ажиллагаандаа мэргэжлийн дүн шинжилгээ, хяналт шалгалт хийлгэх зорилгоор хөндлөнгийн байцаагчийг гэрээгээр ажиллуулж болно.

3. Хөндлөнгийн байцаагчаар улсын санхүүгийн байгууллагад бүртгэгдсэн мэргэжлийн хүн ажиллана. Аж ахуйн нэгжийн гишүүн, ажилтны шууд удирдлагын дор ажилладаг иргэн тухайн аж ахуйн нэгжид хөндлөнгийн байцаагчаар ажиллахыг хориглоно.

Аж ахуйн нэгжээс гарсан этгээдийг гарснаас нь хойш 2 жилийн дотор тухайн аж ахуйн нэгжид хөндлөнгийн байцаагчаар ажиллуулахыг хориглоно.

4. Хөндлөнгийн байцаагч нь аж ахуйн нэгжийн санхүүгийн баримт бичигтэй танилцах, өөрийн зорилго, үүргийг биелүүлэхтэй холбогдох тайлбар, тодорхойлолтыг аж ахуйн нэгжийн удирдлага, ажилтнаас шаардан гаргуулах эрхтэй.

5. Хөндлөнгийн байцаагч нь бүх гишүүний хуралд оролцож санал, дүгнэлтээ сонгох эрхтэй.

(Энэ хэсэгт Аж ахуйн нэгжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан)

5 дугаар зүйл. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсоох

Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дор дурдсан үндэслэлээр зогсоож болно:

1) гэрээ, дүрэмд заасан хугацаа дууссан;

2) өөр этгээдэд эрхээ шилжүүлэхгүйгээр тухайн аж ахуйн нэгж үйл ажиллагаагаа зогсоохоор шийдвэрлэсэн;

3) шүүхийн шийдвэрээр;

4) хуульд заасан бусад үндэслэлээр.

6 дугаар зүйл. Эцсийн тооцоо хийх, аж ахуйн нэгжийг татан буулгах

1. Үйл ажиллагаа нь зогссон аж ахуйн нэгж нь эцсийн тооцоо хийнэ. Гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 5 дугаар зүйлийн 3-т зааснаас бусад тохиолдолд түүнийг тухайн аж ахуйн нэгжийн удирдлага гүйцэтгэнэ.

2. Эцсийн тооцоо хийж байгаа этгээд нь:

1) энэ тухай банк болон сонирхогч этгээдэд мэдэгдэнэ;

2) дуусгалтын тайлан тэнцлийг гаргаж, бүх гишүүний хурлаар хэлэлцүүлж батлуулна;

3) эцсийн тооцоо хийж дууссаныг бүртгэх байгууллагад мэдэгдэж, тухайн аж ахуйн нэгжийг улсын бүртгэлээс хасуулах тухай хүсэлт гаргана.

3. Эцсийн тооцоо хийж байгаад этгээд, тухайн аж ахуйн нэгжийн гишүүний хооронд үүссэн маргааныг шүүх шийдвэрлэнэ.

4. Аж ахуйн нэгжийн эцсийн тооцоог хийхдээ түүний өр төлбөрийг бүрэн төлсний дараа юуны өмнө гишүүний хувь хөрөнгийг бие т байдлаар эгүүлэн өгөх буюу үнийг төлж, үлдсэн эд хөрөнгийг гишүүдээс оруулсан хувь хөрөнгөтэй хувь тэнцүү хэмжээгээр хуваана. Хэрэв гишүүний хувь хөрөнгийг бүрэн хэмжээгээр олгох боломжгүй байвал үлдсэн эд хөрөнгийг гишүүдийн хувь хөрөнгөтэй хувь тэнцүү хэмжээгээр хуваана.

Гишүүн нас барсан, сураггүй алга болсонд тооцогдсон тохиолдолд эцсийн тооцоог түүний өв залгамжлагчтай хийнэ.

5. Аж ахуйн нэгж бүртгэгдсэн өдрөөсөө хойш 1 жил 6 сарын дотор гэрээ, дүрэмд заасан эрхлэх ажлаа эхлээгүй бол түүнийг улсын бүртгэлээс хасна.

6. Үйл ажиллагаа нь зогссон аж ахуйн нэгжийг улсын бүртгэлээс хассанаар тухайн аж ахуйн нэгжийг татан буугдсанд тооцож, энэ тухай бүртгэх байгууллага нийтэд мэдээлнэ.

7 дугаар зүйл. Бусад заалт

1. Аж ахуйн нэгж гадаад худалдааны үйл ажиллагаа бие даан явуулах эрхтэй.

2. Аж ахуйн нэгж нь банк, санхүү, статистикийн байгууллагад тэдгээрээс тогтоосон журмын дагуу мэдээ, тайлангаа үнэн зөв, тогтмол мэдээлж байх үүрэгтэй.

3. Хувьцаат компани үйл ажиллагааныхаа үр дүнг Монгол Улсын хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол жилд 1 удаа хэвлэн нийтлүүлж байх үүрэгтэй.

7[1] дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

1. Аж ахуйн нэгжийг улсын бүртгэлд бүртгүүлэлгүй ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулсан бол бүртгэх байгууллага олсон орлогыг хураж 500—10000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

2. Дүрэмд орсон өөрчлөлтийг бүртгэх байгууллагад хуульд заасан хугацаанд мэдэгдээгүй буюу гэрээ, дүрэмд зохих нэ-

мэлт, өөрчлөлт хийж улсын бүртгэлд бүртгүүлэлгүйгээр тэдгээрт зааснаас өөр төрлийн ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулсан бол аж ахуйн нэгжийн гэм буруутай албан тушаалтанд бүртгэх байгууллага 500—10000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

3. Энэ хуулийн 18 дугаар зүйлийн 3, 28 дугаар зүйлийн 1, 3, 36 дугаар зүйлийн 1, 4 дэх хэсгүүдэд заасан журмыг зөрчсөн бол бүртгэх байгууллага 1000—25000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

(Энэ зүйлийг Аж ахуйн нэгжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар нэмсэн)

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Хувираа эрхлэх аж ахуй

8 дугаар зүйл. Хувираа эрхлэх аж ахуйн тухай ойлголт

1. Иргэн хувийн өмчдөө тулгуурлан мөнгөн орлогын байнгын эх үүсвэртэй байхын тулд үйлдвэрлэл, үйлчилгээг хоршоо, компанийн хэлбэрээр бус дангаараа тогтвортой эрхэлж үйл ажиллагаатайгаа холбогдон үүсэх үүргийг эд хөрөнгөөрөө хариуцах аж ахуйн нэгжийг хувираа эрхлэх аж ахуй гэнэ.

2. Энэхүү аж ахуй эрхэлж байгаа иргэн хувьцаат компаниас бусад аж ахуйн нэгжийн гишүүн болон хувьцаат компанийн үүсгэн байгуулагч байхыг хориглоно.

9 дүгээр зүйл. Хувираа эрхлэх аж ахуйг бүртгэх

1. Иргэн хувираа эрхлэх аж ахуйг бүртгүүлэх тухай өргөдлөө бүртгэх байгууллагад гаргаж бүртгүүлэх үүрэгтэй. (Энэ заалтад Аж ахуйн нэгжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан)

Өргөдөлд дор дурдсан зүйлийг заавал тусгана:

1) нэр, хаяг, регистрийн дугаар;

2) аж ахуйн нэгжийнх нь хувьд онцгой нэр, хаяг, орших газар;

3) эрхлэх ажил, үйлдвэрлэл, үйлчилгээний төрөл.

(Энэ хэсгийн 3 дахь заалтад Аж ахуйн нэгжийн тухай

хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан)

2. Өргөдөл хүлээн авсан өдрөөс хойш 7 хоногийн дотор хувилараа эрхлэх аж ахуйг улсын бүртгэлд авна.

3. Өргөдөлд дурдсан зүйлд өөрчлөлт орох тохиолдолд энэ тухай 7 хоногийн дотор бүртгэх байгууллагад мэдэгдэнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Хоршоо

10 дугаар зүйл. Хоршооны тухай ойлголт

1. Хоршоог бүрэн болон бүрэн бус хариуцлагатай гэж ангилна.

2. Иргэд эд хөрөнгөө нэгтгэж, хөдөлмөрөө хорших замаар аж ахуй эрхэлж, түүнтэй холбогдон үүсэх үүргийг гишүүн нь хоршооны эд хөрөнгө болон өөрийн эд хөрөнгөөр хамтран хариуцах аж ахуйн нэгжийг бүрэн хариуцлагатай хоршоо гэнэ.

Бүрэн хариуцлагатай хоршооны оноосон нэрийн ард «БХХ» гэсэн ялгах тэмдэг хэрэглэнэ.

3. Иргэд эд хөрөнгөө нэгтгэн аж ахуй эрхэлж, түүнтэй холбогдон үүсэх үүргийг наад зах нь нэг гишүүн өөрийн бүх эд хөрөнгөөр (бүрэн), бусад гишүүн нь зөвхөн оруулсан хувь хөрөнгийнхөө хэмжээгээр (бүрэн бус) хариуцлага хүлээх аж ахуйн нэгжийг бүрэн бус хариуцлагатай хоршоо гэнэ.

Бүрэн бус хариуцлагатай хоршооны оноосон нэрийн ард «ББХХ» гэсэн ялгах тэмдэг хэрэглэнэ.

11 дүгээр зүйл. Бүрэн хариуцлагатай хоршоо байгуулах, бүртгэх

1. Иргэд хоршоог энэ хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу боловсруулсан гэрээ, дүрмийн үндсэн дээр байгуулна.

2. Хоршооны гишүүн нь хувьцаат компаниас бусад аж ахуйн нэгжийн гишүүн болон хувьцаат компанийн үүсгэн байгуулагч байхыг хориглоно.

3. Гишүүд хоршоог бүртгүүлэх тухай өргөдлөө татварын улсын албанд хамтран гаргаж бүртгүүлэх үүрэгтэй. Өргөдөл хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор хоршоог улсын бүртгэлд авна.

4. Гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орох нь хоршоог татан буулгах үндэслэл болно.

12 дугаар зүйл. Бүрэн хариуцлагатай хоршооны эд хөрөнгө

1. Хоршоонд гишүүдээс оруулсан хувь хөрөнгө, үйл ажиллагааных нь явцад шинээр бий болсон хөрөнгө тухайн хоршооны эд хөрөнгө байна. Түүнчлэн гишүүнээс тодорхой хугацаагаар хоршоонд ашиглуулахаар гэрээ байгуулан шилжүүлсэн биет зүйлс нь хоршооны эд хөрөнгөд хамаарна.

2. Хоршооны эд хөрөнгийг гишүүд дундаа хамтран өмчилнө.

13 дугаар зүйл. Бүрэн хариуцлагатай хоршооны гишүүний эрх, үүрэг

1. Гишүүн нь хоршоог төлөөлж, хоршооны үйл ажиллагаанд биечлэн оролцож, оруулсан хувь хөрөнгөтэйгээ хувь тэнцүү хэмжээгээр ашиг хуваарж, алдагдлыг хариуцна.

2. Гишүүн нь хоршооны үйл ажиллагаатай холбогдсон гэрээ, хэлцэл хийхдээ бусад бүх гишүүний зөвшөөрлийг авна.

3. Оруулсан эд хөрөнгийн хэмжээнээс үл хамаарч гишүүн бүр саналын адил эрхтэй байна.

4. Хоршооны үйл ажиллагаа зогссон тохиолдолд тухайн гишүүн хоршоонд оруулсан эд хөрөнгөө биет байдлаар эгүүлэн авах эрхтэй. Хэрэв тухайн эд хөрөнгийг биет байдлаар эгүүлэн өгөх боломжгүй бол түүний үнийг мөнгөөр төлж болно.

14 дүгээр зүйл. Бүрэн хариуцлагатай хоршооны удирдлага

1. Хоршоог аль ч гишүүн удирдах эрхтэй. Хоршооны удирдах эрхийг нэг буюу хэд хэдэн гишүүнд эдлүүлэхээр гэрээнд зааж болно. Энэ тохиолдолд бусад гишүүн хоршоог удирдах эрх эдлэхгүй.

2. Удирдах эрх эдэлж байгаа гишүүн итгэмжлэлгүйгээр, бусад гишүүн итгэмжлэлтэйгээр хоршоог төлөөлнө.

3. Удирдах эрх эдэлж байгаа гишүүнийг үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй гэж үзвэл гишүүд түүнийг уул үүргээс чөлөөлж болно.

4. Хоршооны удирдлага гишүүдэд үйл ажиллагааныхаа талаар тогтмол мэдээлж байх үүрэгтэй.

15 дугаар зүйл. Бүрэн хариуцлагатай хоршооны хариуцлага

1. Хоршоо үйл ажиллагаатайгаа холбогдон үүсэх үүргийг

өөрийн эд хөрөнгөөр бүрэн хариуцна. Хэрэв хоршооны эд хөрөнгө нь тухайн үүрэгтэй холбоотой өр төлбөрийг төлөхөд хүрэлцэхгүй байвал гишүүд өөрсдийн эд хөрөнгөөр хамтран төлнө. Энэ талаар гэрээ, дүрэмд ямар нэг хөнгөлөлт, хязгаарлалт заахыг хориглоно.

2. Шүүх хоршооноос өр төлбөр гаргуулах тухай маргааныг хянаж шийдвэрлэхдээ түүний бүх гишүүнийг заавал байлцуулахыг шаардахгүй. Харин гишүүний эд хөрөнгөөс өр төлбөр гаргуулах тухай хянан шийдвэрлэхдээ тухайн гишүүнийг заавал байлцуулна.

16 дугаар зүйл. Бүрэн бус хариуцлагатай хоршоо байгуулах, бүртгэх

1. Хоршоог иргэд энэ хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу боловсруулсан гэрээ, дүрмийн үндсэн дээр байгуулна. Гэрээ, дүрэмд энэ хуулийн 3 дугаар зүйлд зааснаас гадна гишүүнийг бүрэн буюу бүрэн бус хариуцлага хүлээх байдлаар нь ялгаж заана.

2. Хоршоог бүртгүүлэх тухай өргөдлөө бүрэн хариуцлагатай бүх гишүүн тавварын улсын албанд хамтран гаргана. Өргөдөл хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор хоршоог улсын бүртгэлд авч энэ тухай нийтэд мэдээлэхдээ бүрэн бус хариуцлагатай гишүүний тоо, түүний оруулсан хувь хөрөнгийн хэмжээг заана.

17 дугаар зүйл. Бүрэн бус хариуцлагатай хоршооны эд хөрөнгө

Хоршоонд гишүүдээс оруулсан хувь хөрөнгө, үйл ажиллагааных нь явцад шинээр бий болсон эд хөрөнгө тухайн хоршооны эд хөрөнгө байна.

(Энэ зүйлд Аж ахуйн нэгжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан)

18 дугаар зүйл. Бүрэн бус хариуцлагатай хоршооны гишүүний эрх, үүрэг

1. Хоршооны үйл ажиллагаанд бүрэн хариуцлагатай гишүүн заавал биечлэн оролцоно. Бүрэн бус хариуцлагатай гишүүн хоршооны үйл ажиллагаанд оролцож болно.

2. Бүрэн бус хариуцлагатай гишүүн нь хоршоог удирдах, төлөөлөх эрхгүй. Энэ тухай гэрээ, дүрэмд өөрөөр заасан байвал уул гэрээ, дүрмийг хүчин төгөлдөр бус гэж үзнэ.

3. Хэрэв бүрэн бус хариуцлагатай гишүүн нь хоршооны бусад гишүүнтэй тохиролцсоны үндсэн дээр оруулсан эд хөрөнгийнхөө хэмжээг багасгасан бол энэ тухай улсын бүртгэлд бүртгэх хүртэлх хугацаанд үүссэн үүргийг анх оруулсан эд хөрөнгийнхөө хэмжээгээр хүлээнэ.

4. Бүрэн бус хариуцлагатай гишүүн хоршооны үйл ажиллагааны талаар мэдээлэл авах, бичиг баримттай бичлэн танилцах эрхтэй.

5. Гэрээ, дүрэмд өөрөөр заагаагүй бол оруулсан хувь хөрөнгийн хэмжээнээс үл хамаарч гишүүн бүр санал өгөх адил эрхтэй байна.

6. Гишүүн хоршоонд оруулсан хувь хөрөнгөтэйгээ хувь тэнцүүлсэн хэмжээгээр ашиг хуваарж, алдагдлыг хариуцна.

7. Бүрэн бус хариуцлагатай гишүүн хувь хөрөнгө эзэмших эрхээ бусдад шилжүүлэх эрхтэй.

8. Хоршооноос гарсан гишүүн өөрт ногдох хувь хөрөнгө, гэрээгээр ашиглуулахаар шилжүүлсэн биет зүйлсээ эсхүл түүний үнийг эгүүлэн авах эрхтэй.

9. Хоршооны гишүүн нь бусад гишүүний зөвшөөрсний дагуу хариуцлагын хэлбэрээ өөрчилж болох бөгөөд энэ тухай бүртгэх байгууллагад заавал мэдэгдэнэ.

19 дүгээр зүйл. Бүрэн бус хариуцлагатай хоршооны удирдлага

1. Хоршооны удирдлагыг бүрэн хариуцлагатай гишүүнээс сонгоно. Хоршооны удирдлагад нэг буюу хэд хэдэн гишүүн байж болно.

2. Удирдах эрх эдэлж байгаа гишүүдийн хооронд саналын зөрүү гарвал уул асуудлыг бүх гишүүн хэлэлцэж шийдвэрлэнэ.

3. Дор дурдсан асуудлыг гишүүд санал нэгтэй шийдвэрлэнэ:

1) гэрээ, дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах;

2) хоршооны эрхлэх ажилд үл хамаарах асуудал.

4. Гэрээ, дүрэмд өөрөөр заагаагүй бол дор дурдсан асуудлыг хуралд оролцож байгаа гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ:

1) хоршооны удирдлагыг сонгох, чөлөөлөх;

2) хоршооны гишүүнээр элсүүлэх, гишүүнийг хасах;

3) гэрээнд заасан бусад асуудал.

5. Хоршооны удирдлага үйл ажиллагааныхаа талаар гишүүдэд тогтмол мэдээлж байх үүрэгтэй.

20 дугаар зүйл. Бүрэн бус хариуцлагатай хоршооны хариуцлага

1. Хоршоо үйл ажиллагаатайгаа холбогдон үүсэх үүргийг өөрийн эд хөрөнгөөр бүрэн хариуцна. Хэрэв хоршооны эд хөрөнгө нь тухайн үүрэгтэй холбоотой өр төлбөрийг төлөхөд хүрэлцэхгүй бол бүрэн хариуцлагатай гишүүн өөрийн эд хөрөнгөөр төлнө. Энэ талаар гэрээ, дүрэмд ямар нэг хөнгөлөлт, хязгаарлалт заахыг хориглоно.

2. Шүүх хоршооноос өр төлбөр гаргуулах тухай маргааныг хянаж шийдвэрлэхдээ түүний бүх гишүүнийг заавал байлцуулахыг шаардахгүй. Харин бүрэн хариуцлагатай гишүүний эд хөрөнгөөс өр төлбөр гаргуулах тухай хянан шийдвэрлэхдээ тухайн гишүүнийг заавал байлцуулна.

21 дүгээр зүйл. Бүрэн бус хариуцлагатай хоршооноос гарах, гишүүнийг хасах

Хоршооны гишүүн өөрийн хүсэлтээр хоршооноос гарч болох бөгөөд дор дурдсан үндэслэлээр гишүүнийг хасч болно:

1) гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлээгүй;

2) бүрэн хариуцлагатай гишүүн хоршооны үйл ажиллагаанд биечлэн оролцох боломжгүй болсон;

3) нас барсан буюу сураггүй алга болсонд тооцогдсон.

Нас барсан буюу сураггүй алга болсон гишүүний өв залгамжлагч нь хоршооны гишүүдтэй тохиролцсоны үндсэн дээр хоршооны гишүүнээр элсэж болно. Гишүүнээр элсээгүй тохиолдолд энэ хуулийн 6 дугаар зүйлд зааснаар тооцоо хийнэ.

22 дугаар зүйл. Бүрэн бус хариуцлагатай хоршооны үйл ажиллагааг зогсоох

1. Энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан үндэслэлээр хоршооны үйл ажиллагааг зогсооно.

2. Бүрэн бус хариуцлагатай гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орох нь хоршооны үйл ажиллагааг зогсоох үндэслэл болохгүй.

Харин бүрэн бус хариуцлагатай бүх гишүүн хоршооноос гарсан тохиолдолд үлдсэн гишүүдийн шийдвэрээр хоршоо нь бүрэн хариуцлагатай хоршооны хэлбэрээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлж болох бөгөөд энэ тухайгаа 14 хоногийн дотор бүртгэх байгууллагад мэдэгдэж шинэчлэн бүртгүүлнэ.

3. Бүрэн хариуцлагатай бүх гишүүн хоршооноос гарвал түүний үйл ажиллагааг зогсоож татан буулгана.

4. Хоршоог татан буулгахад бүрэн бус хариуцлагатай гишүүн нь оруулсан хувь хөрөнгөө бүрэн хариуцлагатай гишүүнээс тэргүүн ээлжинд эгүүлэн авах давуу эрхтэй.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Компани

23 дугаар зүйл. Компанийн тухай ойлголт

1. Гишүүдийн хувь хөрөнгөөс бүрдэх дүрмийн сантай, өөртөө гишүүдээс тусгайлан өмчилсөн эд хөрөнгөтэй, хүлээсэн үүргээ эд хөрөнгөөрөө хариуцдаг, гишүүн нь компанийн хүлээсэн үүргийн талаар хариуцлага хүлээдэггүй аж ахуйн нэгжийг компани гэнэ.

Компанийг бүрэн бус хариуцлагатай болон хувьцаат гэж ангилна.

2. Тодорхой тоо хэмжээ, нэг бүрийн тэнцүү үнэлгээ бүхий ногдох хувьд хуваагдах дүрмийн сантай, гишүүн нь зөвхөн оруулсан хувь хөрөнгөөрөө хариуцлага хүлээхээр гэрээнд заасан компанийг бүрэн бус хариуцлагатай компани гэнэ. Түүний оноосон нэрийн ард «ББХК» гэсэн ялгах тэмдэг хэрэглэнэ.

Компани нь ганц гишүүнтэй байж болно.

3. Нэг бүрийн нэрлэсэн үнэ бүхий, тодорхой тоо хэмжээний хувьцаанаас бүрдсэн дүрмийн сантай, хувьцаа эзэмшигч нь захиалсан хувьцааныхаа нийт үнийн хэмжээгээр хариуцлага хүлээдэг компанийг хувьцаат компани гэнэ. Түүний оноосон нэрийн ард «ХК» гэсэн ялгах тэмдэг хэрэглэнэ.

24 дүгээр зүйл. Бүрэн бус хариуцлагатай компани байгуулах, бүртгэх

1. Компанийг энэ хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу гэрээ, дүрмийн үндсэн дээр байгуулна.

2. Компани байгуулах тухай гэрээнд энэ хуулийн 3 дугаар зүйлд зааснаас гадна дор дурдсан зүйлийг заавал тусгана:

1) дүрмийн сангийн хэмжээ, түүнд гишүүнээс оруулсан хувь хөрөнгийн хэмжээ;

2) гишүүнээс дүрмийн санд мөнгөн хэлбэрээр оруулах хувь хөрөнгөө гүйцэд оруулаагүй бол түүнийг гүйцээн оруулах хугацаа, хүлээлгэх хариуцлага;

3) санал хураах болон санал тэнцсэн үед шийдвэр гаргах журам;

4) компанийн удирдлага, компанийг төлөөлөх журам;

5) хяналтын зөвлөл байгуулах шаардлагатай гэж үзвэл уул зөвлөл, түүний гишүүний эрх, үүрэг, бүрэн эрхийн хугацаа, гишүүнийг сонгох журам.

3. Ганц гишүүнтэй компани байгуулахад нийм компани байгуулах тухай баримт үйлдэнэ. Уул баримтыг үйлдэхэд энэ хуулийн 3 дугаар зүйлийн заалтыг үндэс болгоно.

4. Бүрэн бус хариуцлагатай компанийн дүрмийн сан нь гишүүдийн оруулсан хувь хөрөнгөөс бүрдэнэ. Дүрмийн сангийн хэмжээ 500 мянган төгрөгөөс доош байхыг хориглоно.

5. Дүрмийн санг бүрдүүлэхэд гишүүдээс мөнгөн хэлбэрээр оруулсан хувь хөрөнгийн хэмжээ нь дүрмийн сангийн 30 хувиас багагүй байна. Гэхдээ түүний хэмжээ 200 мянган төгрөгөөс доошгүй байна.

6. Компанийн үүсгэн байгуулагч компанийг бүртгүүлэх тухай өргөдлөө татварын улсын албанд гаргана. Өргөдөл хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор компанийг улсын бүртгэлд авна.

7. Дүрмийн санд гишүүдээс мөнгөн хэлбэрээр оруулах хувь хөрөнгийн тал хувь, биет зүйлсээр оруулах хувь хөрөнгө компанийн мэдэлд бүрэн шилжсэн, ганц гишүүнтэй компанийн гишүүн дүрмийн сангаа бүрдүүлсэн нөхцөлд компанийг бүртгэнэ.

25 дугаар зүйл. Бүрэн бус хариуцлагатай компанийн гишүүний эрх, үүрэг

1. Дүрмийн санд оруулах хувь хөрөнгөө гишүүн нь компанийн мэдэлд бүрэн шилжүүлэх үүрэгтэй.

2. Гишүүнийг хувь хөрөнгөө нийлүүлэхээс чөлөөлөх, түүнчлэн хувь хөрөнгөө нийлүүлээгүй байхад нь нийлүүлсэнд тооцохыг хориглоно. Энэ талаар гэрээнд өөрөөр зааж болохгүй.

3. Дүрмийн санд мөнгөн болон биет зүйлсээр оруулах хувь хөрөнгөө гишүүн гэрээнд заасан хугацаанд оруулаагүй нөхцөлд хүлээлгэх хариуцлагыг гэрээнд тусгана.

4. Гишүүн дүрмийн санд хувь хөрөнгө оруулахаас гадна нэмэлт ажил гүйцэтгэх, үйлчилгээ хийх үүрэг хүлээж болно.

5. Гишүүн дүрмийн санд оруулсан хувь хөрөнгийнхөө хэмжээгээр ногдол хувь эзэмших эрхтэй. Ногдол хувь нь ги-

шүүний санал, ногдол ашиг авах эрхийг тодорхойлох бөгөөд гишүүнд ногдол хувь эзэмших эрхийн гэрчилгээ олгоно.

6. Ногдол хувь эзэмших эрхийг тухайн компанийн гишүүд өөр хоорондоо шилжүүлж болно. Ногдол хувь эзэмших эрхээ компанийн гишүүн бус этгээдэд зөвхөн бусад гишүүнтэй зөвшөөрөлцсөнний үндсэн дээр шилжүүлж болно.

7. Ногдол хувь эзэмших эрхийг тухайн компанийн гишүүн тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрхтэй.

8. Санал хураалтад нэг ногдол хувь тутамд нэг саналын эрх ногдоно.

9. Ногдол хувь эзэмших эрх авсан этгээд түүний эзэмшигч болсон тухайгаа болон тухайн компанийн гэрээ, дүрмийг хүлээн зөвшөөрч байгаагаа компанид бичгээр мэдэгдэнэ.

10. Компаниас гарсан гишүүн оруулсан хувь хөрөнгийн үнийг эгүүлэн авах эрхтэй.

11. Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгахаас бусад тохиолдолд гишүүн нь дүрмийн санд оруулсан биет зүйлсийг эгүүлэн олгохыг шаардах эрхгүй. Энэ тухай гэрээнд өөрөөр заахыг хориглоно.

26 дугаар зүйл. Бүрэн бус хариуцлагатай компанийн удирдлага, бүх гишүүний хурал

1. Компанийн эрх барих байгууллага нь бүх гишүүний хурал бөгөөд чөлөө цагт нь түүний бүрэн эрхийг төлөөлөн удирдах зөвлөл хэрэгжүүлнэ.

Компанийн үйл ажиллагааны цар хүрээ, онцлогоос шалтгаалж төлөөлөн удирдах зөвлөлийг байгуулахгүйгээр түүний бүрэн эрхийг Ерөнхий захирал хэрэгжүүлж болно.

(Энэ хэсгийг Аж ахуйн нэгжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан)

2. Бүх гишүүний хурлыг жилд нэгээс доошгүй удаа хийнэ. Дор дурдсан асуудлыг заавал бүх гишүүний хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ:

1) тайлан тэнцэл, ашиг хуваарилах;

2) гишүүнээс нэмэлт хөрөнгө гаргуулах, эгүүлэн олгох;

3) гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орох;

4) төлөөлөн удирдах болон хяналтын зөвлөлийн гишүүн, Ерөнхий захирлыг сонгох, чөлөөлөх, тэдгээрт олгох цалин хөлс, урамшууллыг тогтоох;

5) (хасагдсан)

6) компанийг өөрчлөн байгуулах (нийлүүлэх, нэгтгэх, салгах, тусгаарлах), үйл ажиллагааг нь зогсоох;

7) гэрээ, дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах;

8) гэрээнд заасан бусад зүйл.

(Энэ хэсгийн 4 дэх заалтыг Аж ахуйн нэгжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан. Энэ хэсгийн 5 дахь заалтыг мөн хуулиар хассан)

3. Нэг гишүүнтэй компанийг үүсгэн байгуулагч нь бүх гишүүний хурлын эрхийг эдэлнэ.

4. Компанийн аль нэг гишүүн нь өөрийн төлөөлөх этгээдийг бичгээр олгосон итгэмжлэлийн үндсэн дээр бүх гишүүний хуралд оролцуулж болно. Төлөөлөх тухай итгэмжлэх нь зөвхөн тухайн хуралд хүчинтэй. Төлөөлөх тухай итгэмжлэлийг төлөөлөн удирдах зөвлөлд ирүүлнэ. Бүх гишүүний хурал хойшлосон тохиолдолд тухайн итгэмжлэл хүчинтэй хэвээр байна.

Ерөнхий захирал, төлөөлөн удирдах болон хяналтын зөвлөлийн гишүүн компанийн гишүүнийг төлөөлөх эрхгүй.

(Энэ хэсэгт Аж ахуйн нэгжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан)

5. Бүх гишүүний хурлыг төлөөлөн удирдах зөвлөл зарлан хуралдуулах бөгөөд хурлаар хэлэлцэх асуудлыг холбогдох танилцуулгын хамт хурал эхлэх өдрөөс 21-ээс доошгүй хоногийн өмнө гишүүн бүрт хүргэнэ.

Хууль тогтоомж болон гэрээнд өөрөөр заагаагүй бол бүх гишүүний хурлаар хэлэлцсэн асуудлыг саналын олонхиор шийдвэрлэнэ.

(Энэ хэсгийг Аж ахуйн нэгжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан)

6. Бүх гишүүний хуралд компанийн дүрмийн сангийн 50-иас дээш хувийг эзэмшигчид оролцож байвал хурлыг хүчин төгөлдөр гэж тооцох боловч хэлэлцэх асуудлын төрөл, компанийн гишүүдийн тоо зэргийг харгалзан компанийн дүрэмд өөрөөр тогтоож болно. Ингэхдээ тайлан тэнцэл батлах, ашиг хуваарилах, компанийн удирдлагыг сонгох, компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг хэлэлцэх хурлыг компанийн дүрмийн сангийн 50-иас доошгүй хувийг эзэмшигчдийн ирцтэй хийхээр дүрэмд зааж болохгүй.

Бүх гишүүний хурлыг төлөөлөн удирдах зөвлөлийн дарга удирдах бөгөөд түүний эзгүйд хурлыг удирдах хүнийг дүрэмд заана.

(Энэ хэсгийг Аж ахуйн нэгжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан)

7. Бүх гишүүний хуралд асуудал хэлэлцүүлэхээр компанийн гишүүн бүр санал оруулах эрхтэй.

8. Хэлэлцэхээр товлоогүй асуудлыг зөвхөн хуралд оролцож байгаа гишүүдийн зөвшөөрснөөр хэлэлцэж болно.

(Энэ хэсэгт Аж ахуйн нэгжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан)

9. Дүрмийн сангийн аравны нэгээс доошгүй хэсгийг оруулсан гишүүн зорилго, шалтгаанаа зааж бүх гишүүний хурал хуралдуулах тухай хүсэлтээ (бичгээр) төлөөлөн удирдах зөвлөлд хэдийд ч гаргах эрхтэй. Төлөөлөн удирдах зөвлөл 7 хоногийн дотор хариу өгөөгүй буюу шийдвэр гаргах эрх бүхий этгээд эзгүй байвал хүсэлт гаргасан гишүүн бүх гишүүний хурлыг зарлан хуралдуулж болно.

(Энэ хэсэгт Аж ахуйн нэгжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан)

10. Гишүүд нь хуралдахгүйгээр шийдвэр гаргаж болно. Ийм шийдвэрийн төслийг гишүүдэд бичгээр мэдэгдэх бөгөөд гишүүд төсөлд мөн бичгээр санал өгнө. Гишүүдээс ирүүлсэн саналын дүн, гаргасан шийдвэр болон түүний хугацаат төлөөлөн удирдах зөвлөл хамгийн сүүлийн санал хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор гишүүдэд бичгээр мэдэгдэнэ. Хэрэв аль нэг гишүүн уг асуудлыг хурлаар хэлэлцэхийг шаардвал бүх гишүүний хурлыг хуралдуулна.

(Энэ хэсэгт Аж ахуйн нэгжийн тухай хуульд, нэмэлт өөрчлөлт оруулах тухай 1993 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан)

11. Бүх гишүүний хурлаас гаргасан шийдвэрийн бүртгэлийг компанийн төлөөлөн удирдах зөвлөл хөтөлнө. Ганц гишүүнтэй компанийн шийдвэрийн бүртгэлийг үүсгэн байгуулагч нь компаниг удирддаггүй тохиолдолд хөтөлнө.

(Энэ хэсэгт Аж ахуйн нэгжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан)

12. Бүх гишүүний хурал нь Ерөнхий захирал, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, чөлөөлөх тухай асуудлыг саналын дийлэнх олонхиор шийдвэрлэнэ.

Ерөнхий захирал, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр тухайн компанийн гишүүн биш хүнийг сонгож болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь бүх гишүүний хурлын зөвшөөрөлгүйгээр өөр аж ахуйн нэгжийн удирдлагад байхыг хориглоно.

Төлөөлөн удирдах зөвлөлийг түүний гишүүдийн дотроос сонгосон дарга толгойлно. Ерөнхий захирал, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, даргыг сонгох хугацаа, журам, зөвлөлийн гишүүний тоог дүрэмд заана.

(Энэ хэсгийг Аж ахуйн нэгжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан)

13. Ерөнхий захирал дор дурдсан эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

1) компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж, төлөөлөн удирдах зөвлөлд ажлаа тогтмол мэдээлнэ;

2) бүх гишүүний хуралд ажлаа хариуцан тайлагнана;

3) компанийг төлөөлж харилцана. Гэхдээ тодорхой асуудлаар Ерөнхий захирлын төлөөлөх эрхийг хязгаарлах тухай гэрээнд тусгаж болно;

4) тухайн компанид хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчидтай компанийг төлөөлөн гэрээ байгуулна;

5) бүрэн эрхийнхээ асуудлаар тушаал гаргана. Ерөнхий захирал төлөөлөн удирдах зөвлөлтэй зөвшилцөн шийдвэрлэх асуудлыг хуульд өөрөөр заагаагүй бол бүх гишүүний хурлаас тогтооно;

6) тайлан тэнцэл болон компанийн эд хөрөнгийн талаарх мэдээ, тайланг хариуцаж, бүх гишүүний хурлаар хэлэлцүүлэхийн хамт компанийн үйл ажиллагааны талаар гишүүдэд мэдээлэх, санхүүгийн болон бусад бичиг баримттай танилцах боломж тэдэнд олгоно;

7) компаннас гарсан мэдээ, мэдээллийн үнэн зөвийг хариуцна;

8) шаардлагатай бол бүх гишүүний хурлыг зарлан хуралдуулна.

(Энэ хэсгийн 1, 5 дахь заалтыг Аж ахуйн нэгжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан. Энэ хэсгийн 8 дахь заалтыг мөн хуулиар нэмсэн.)

14. Ерөнхий захирал хувийн эрх ашгийн үүднээс компанийн нэрийг ашиглан гэрээ, хэлцэл хийхийг хориглоно. Түүнчлэн бүх гишүүний хурлын зөвшөөрөлгүйгээр өөр аж ахуйн нэгжийн удирдлагад байхыг хориглоно.

(Энэ хэсэгт Аж ахуйн нэгжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан)

15. Ерөнхий захирлыг чөлөөлсөн, мөн компанийг төлөөлөх эрх бүхий этгээд өөрчлөгдсөн тохиолдолд компанийн шинээр сонгогдсон удирдлага энэ тухай бүртгэх байгууллагад мэдэгдэж бүртгүүлэх бөгөөд бүртгэх байгууллага нь нийтэд мэдээлнэ.

16. Ерөнхий захирал, төлөөлөн удирдах зөвлөлийн хооронд санал зөрвөл Ерөнхий захирал нь төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй.

(Энэ хэсгийг Аж ахуйн нэгжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар нэмсэн)

26[1] дүгээр зүйл. Төлөөлөн удирдах зөвлөл

1. Төлөөлөн удирдах зөвлөл дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) компанийн эдийн засаг, технологийн бодлого, хэтийн төлөв, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлох;

2) компанийн аппаратын зохион байгуулалтын бүтэц, цалингийн сан, урамшууллын журмыг тогтоох;

3) компанийн өмч хөрөнгийг захиран зарцуулах талаарх Ерөнхий захирлын эрх хэмжээг тогтоох;

4) компанийн гишүүдийн бүртгэлийг хөтлөх (бүртгэлд гишүүний тоо, нэр, хаяг, дүрмийн санд оруулсан хувь хөрөнгө, нэмэлт ажил гүйцэтгэх, үйлчилгээ хийх тухай гишүүний хүлээсэн үүрэг зэргийг бичнэ), бүртгэлд орсон өөрчлөлтийн талаар бүртгэх байгууллагад мэдээлэх;

5) бүх гишүүний хурлыг зарлан хуралдуулах;

6) компанийн тайлан тэнцэл, ашиг хуваарилалт, дүрмийн сангийн өөрчлөлтийн талаар хэлэлцэх, эдгээр асуудлаар бүх гишүүний хуралд дүгнэлт гаргах;

7) дүрэмд заасан бусад бүрэн эрх.

2. Төлөөлөн удирдах зөвлөл эрх хэмжээнийхээ асуудлыг хурлаараа хэлэлцэж олонхийн саналаар шийдвэрлэнэ. Хурлаас тогтоол гаргах бөгөөд түүнд зөвлөлийн дарга гарын үсэг зурж, компанийн тэмдэг дарна.

3. Төлөөлөн удирдах зөвлөл ажлаа бүх гишүүний хуралд харицуцан тайлагнана.

4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн орон гарсан бол түүний бүрэн эрхийн төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр бүх гишүүний дараагийн хурал хүртэлх хугацаанд өөр этгээдэд шилжүүлж болно.

5. Ганц гишүүнтэй компанийн үүсгэн байгуулагч нь төлөөлөн удирдах зөвлөлийн холбогдох бүрэн эрхийг хэрэгжүүлж болно.

(Энэ зүйлийг Аж ахуйн нэгжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар нэмсэн)

27 дугаар зүйл. Бүрэн бус харицуцлагатай компанийн хяналтын зөвлөл

1. Компани нь гишүүний тоо, эрхлэх ажлын шинж чанараас хамаарч 3-аас доошгүй гишүүнтэй хяналтын зөвлөлийг компанийн удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор сонгон ажиллуулж болно. Харин дүрмийн сангийн хэмжээ 10 сая төгрөгөөс дээш буюу гишүүний тоо 50-иас дээш байвал хяналтын зөвлөлийг заавал сонгон ажиллуулна.

2. Бүх гишүүний хурлаас хяналтын зөвлөлийг сонгоно. Тухайн компанид хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдыг хяналтын зөвлөлийн гишүүнээр сонгохыг хориглоно.

3. Хяналтын зөвлөлийн гишүүнийг сонгох, чөлөөлөх тухай асуудлыг бүх гишүүний дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.

4. Шаардлагатай гэж үзвэл бүх гишүүний хурлыг хяналтын зөвлөл зарлан хуралдуулах эрхтэй.

5. Ерөнхий захирлын болон төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан шийдвэртэй холбогдон үүссэн маргааныг шүүх хянан шийдвэрлэхэд хяналтын зөвлөлөөс томилсон хяналтын зөвлөлийн гишүүн нь компанийг төлөөлөн оролцож болно.

(Энэ хэсгийг Аж ахуйн нэгжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан)

6. Хяналтын зөвлөлийн гишүүнд энэ хуулийн 26 дугаар зүйлийн 14-т заасан заалт нэг адил хамаарна.

28 дугаар зүйл. Бүрэн бус харицуцлагатай компанийн дүрмийн сангийн хэмжээг өөрчлөх

1. Бүх гишүүний хурлын шийдвэрийн дагуу дүрмийн сангийн хэмжээг өөрчилж болно. Гэхдээ гишүүд гэрээнд заасан

хувь хөрөнгөө дүрмийн санд бүрэн гүйцэд оруулсан нөхцөлд дүрмийн санг нэмэгдүүлнэ. Дүрмийн санг өөрчлөх тухай шийдвэр гарснаас хойш 14 хоногийн дотор бүртгэх байгууллагад мэдэгдэх бөгөөд энэ тухай бүртгэх байгууллага нийтэд мэдээлнэ.

2. Дүрмийн санг нэмэгдүүлэх тухай шийдвэрийг дор дурдсан тохиолдолд улсын бүртгэлд бүртгэнэ:

1) дүрмийн санд мөнгөн хэлбэрээр нэмж оруулах хувь хөрөнгийн 50-иас доошгүй хувийг оруулсан;

2) бичиг зүйлсээр нэмж оруулах хувь хөрөнгийг компанийн мэдэлд бүрэн шилжүүлсэн.

3. Дүрмийн санг хорогдуулах тухай шийдвэр гарч энэ тухай бүртгүүлэхээр мэдэгдэж нийтэд мэдээлснээс хойш 90 хоногийн дотор харилцагч талын гомдлын шаардлагыг барагдуулсан, тэдгээрийн өр төлбөрийг төлөх талаар баталгаа гаргасан нөхцөлд улсын бүртгэлд бүртгэнэ.

4. Дүрмийн санг өөрчилсөн тухай шийдвэрийг улсын бүртгэлд авсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр гэж үзнэ.

29 дүгээр зүйл. Бүрэн бус хариуцлагатай компаниас гишүүнийг хасах

1. Гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлээгүй гишүүнийг компаниас хасч болно.

2. Гишүүнээс хасах шалтгааныг тухайн гишүүнд мэдэгдэх ёстой. Гишүүнээс хасах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэхэд тухайн гишүүн санал өгөх эрхтэй.

3. Хасагдсан гишүүн хасах тухай шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл тухайн шийдвэр авснаас хойш 30 хоногийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй.

30 дугаар зүйл. Бүрэн бус хариуцлагатай компаниас гишүүн гарах

1. Компаниас гишүүнийг хассан буюу гишүүнээс өөрөө татгалзсан нь компаниас гишүүн гарах үндэслэл болно.

2. Гишүүн нас барсан, сураггүй алга болсонд тооцогдсон тохиолдолд өв залгамжлагч, гишүүн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа зогссон тохиолдолд эрх залгамжлагч нөгдөх хувь эзэмших эрхийг нь тус тус эзэмшиж болно.

31 дүгээр зүйл. Хувьцаат компанийг байгуулах, бүртгэх

1. Хувьцаат компанийг үүсгэн байгуулагчийн төслийн үндсэн дээр байгуулна.

Компани нь ганц үүсгэн байгуулагчтай байж болно.

2. Хувьцаат компанийг байгуулахад захиалагчдаас мөнгөн хэлбэрээр оруулах хувь хөрөнгийн хэмжээ дүрмийн сангийн 30 хувиас багагүй байна. Гэхдээ түүний хэмжээ 2 сая төгрөгөөс доошгүй байна. Хувьцааны захиалга авах замаар компанийн дүрмийн санг бүрдүүлнэ.

3. Хувьцаа захиалах эрх зүйн үндэслэл нь төсөл байна. Төсөлд дор дурдсан зүйлийг заавал тусгана:

1) компанийн оноосон нэр, хаяг, орших газар, харьяалал, эрхлэх ажил, ажиллах хугацаа;

2) дүрмийн сангийн төлөвлөсөн хэмжээ (5 сая төгрөгөөс доошгүй);

3) хувьцааны тоо хэмжээ, нэрлэсэн үнэ;

4) захиалга эхлэх, дуусах хугацаа;

5) үүсгэн байгуулагчийн эдлэх давуу эрх;

6) дүрмийн санд биет зүйлсээр оруулах хувь хөрөнгө, түүний үнэ;

7) төлөвлөсөн хувьцааны хэмжээнээс хэтэрсэн захиалгыг хэрхэн шийдвэрлэх;

8) зохион байгуулах хурал хуралдуулах журам.

4. Захиалгын хуудсанд захиалагч этгээд өөрөө буюу түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурсан байвал хувьцааны захиалга хийгдсэнд тооцно.

Хувьцаа захиалагч этгээд захиалсан хувьцааны нийт үнийн 30-аас доошгүй хувийг үүсгэн байгуулагчийн дансанд шилжүүлнэ.

Захиалга хүлээн авах хугацаа дуусах өдөр хүртэл хүлээн авсан захиалга (хувьцаа) нь компанийн төлөвлөсөн дүрмийн санг бүрдүүлэхэд хүрэхгүй бол үүл компанийг байгуулагдаагүйд тооцно. Ийм тохиолдолд захиалагчдаас урьдчилгаа болгон оруулсан хувь хөрөнгийг 15 хоногийн дотор тэдэнд буцаан олгоно. Энэ үүргийг үүсгэн байгуулагчид хамтран хариуцна.

5. Хувьцааны захиалгыг хүлээн авах хугацаа дууссанаас хойш 30 хоногийн дотор зохион байгуулах хурлыг үүсгэн байгуулагч зарлан хуралдуулна.

Үүсгэн байгуулагч заасан хугацаанд зохион байгуулах хурлыг зарлан хуралдуулаагүй бол захиалагч хүлээсэн үүргээсээ татгалзаж, урьдчилгаа болгон оруулсан хувь хөрөнгөө бүрэн хэмжээгээр эгүүлэн авах эрхтэй.

6. Зохион байгуулах хурал дор дурдсан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ:

1) хувьцаа захиалгын үр дүнг гаргаж дүрмийн сангийн 30-аас доошгүй хувь бүрдсэн эсэхийг тогтоох;

2) компани байгуулсан тухай шийдвэр гаргах;

3) компанийн дүрэм батлах;

4) бист зүйлсээр оруулах хувь хөрөнгийг үнэлсэн тухай шийдвэр гаргах, түүнийг компанийн мэдэлд шилжүүлэх хугацаа тогтоох;

5) компанийн удирдлагыг сонгох.

Компанийн дүрмийн сангийн 50-иас доошгүй хувийг захиалагчид хуралд биечлэн оролцсон, эсвэл өөрийн төлөөлөх этгээдийг бичгээр олгосон итгэмжлэлийн үндсэн дээр оролцуулсан тохиолдолд зохион байгуулах хурал шийдвэр гаргах эрхтэй.

7. Дор дурдсан шаардлага хангагдсан нөхцөлд компанийг бүртгүүлэх тухай өргөдлийг уул компанийн удирдлага татварын улсын албанд гаргана:

1) зохион байгуулах хурлыг зохих журмын дагуу хуралдуулсан;

2) хувьцааг дүрмийн сангийн хэмжээгээр захиалагчид нь бүрэн захиалсан;

3) захиалагчид дүрмийн сангийн 30-аас доошгүй хувийг бүрдүүлсэн;

4) бусад.

8. Өргөдөл хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор компанийг улсын бүртгэлд авна.

32 дугаар зүйл. Хувьцаат компанийн дүрэм

1. Компанийн дүрэмд энэ хуулийн 3 дугаар зүйлд заасснаас гадна дор дурдсан зүйлийг заавал тусгана:

1) дүрмийн сангийн хэмжээ, хувьцааны төлбөрийн нөхцөл;

2) хувьцааны тоо хэмжээ, нэрлэсэн үнэ, төрөл;

3) компанийн эрх барих дээд байгууллага, түүнийг хуралдуулах журам, хуралдааны дэг, эрх хэмжээ;

4) компанийн удирдлага, хяналтын зөвлөлийн гишүүний тоо, тэдгээрийг сонгох журам, бүрэн эрхийн хугацаа;

5) гишүүний эрх үүрэг;

6) ашиг хуваарилах журам;

7) хувьцааны үнийг хугацаа хожимдуулж төлснөөс үүсэх хохирлыг төлүүлэх журам.

33 дугаар зүйл. Хувьцаа эзэмшигчийн эрх, үүрэг

1. Хувьцаат компанийн гишүүнийг хувьцаа эзэмшигч гэнэ.

Төрийн өмчийн оролцоотой компанийн төрийн төлөөллийг орон нутгийн төсөвтэй харьцдаг аж ахуйн нэгжийн хувьд тухайн шатны Засаг дарга, улсын төвлөрсөн төсөвтэй харьцдаг аж ахуйн нэгжийн хувьд Засгийн газраас эрх олгосон яам, тусгай газар хэрэгжүүлнэ.

(Энэ заалтыг Аж ахуйн нэгжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар нэмсэн)

Хувьцаа эзэмшигч дор дурдсан эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

1) хувьцааныхаа үнийг компанийг бүртгэснээс хойш нэг жилийн дотор бүрэн төлөх;

2) хувьцааныхаа нэрлэсэн үнийн нийт хэмжээтэй хувь тэнцүүлсэн хэмжээгээр ногдол ашиг кампаниас авах;

3) компанийн үйл ажиллагаа зогссон тохиолдолд түүний өр төлбөрийг бүрэн төлсний дараа үлдсэн хөрөнгөөс хувьцааныхаа нэрлэсэн үнийн нийт хэмжээтэй хувь тэнцүүлсэн хэмжээгээр өөрт ногдох хэсгийг авах. Харин дүрмийн санд биет зүйлсээр оруулсан хувь хөрөнгөө биет зүйлсээр нь эгүүлэн олгохыг шаардах эрхгүй;

4) хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, тайлбар өгөх, санал гаргах;

5) хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдолтой мэдээллийг бичгээр авах. Энэ талаарх хүсэлтэд төлөөлөн удирдах зөвлөл хурал эхлэхээс 7 хоногийн өмнө хариу өгөх үүрэгтэй;

6) хувьцаа эзэмшигчдийн хуралд өөрийн төлөөлөх этгээдээр дамжуулан оролцох. Төлөөлөх этгээдийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцуулахад энэ хуулийн 26 дугаар зүйлийн 4-т заасан заалтыг баримтална.

7) хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчдийн буюу төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын протокол, Ерөнхий захирлын тушаал, компанийн санхүүгийн тайлантай танилцах эрхтэй.

(Энэ хэсгийн 5 дахь заалтад Аж ахуйн нэгжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан. Энэ хэсгийн 7 дахь заалтыг мөн хуулиар нэмсэн)

2. Монгол Улсын хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол нэг хувьцаанд нэг саналын эрх ногдоно.

34 дүгээр зүйл. Хувьцаат компанийн удирдлага, хувьцаа эзэмшигчдийн хурал

1. Компанийн эрх барих байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд чөлөө цагт нь түүний бүрэн эрхийг төлөөлөн удирдах зөвлөл хэрэгжүүлнэ.

(Энэ хэсгийг Аж ахуйн нэгжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан)

2. Дор дурдсан асуудлыг заавал хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ:

1) компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах;

2) дүрмийн сангийн хэмжээг өөрчлөх;

3) компанийг өөрчлөн байгуулах, үйл ажиллагааг нь зогсоох;

4) төлөөлөн удирдах болон хяналтын зөвлөлийн гишүүнийг сонгох, чөлөөлөх, тэдгээрт олгох цалин хөлс, урамшууллыг тогтоох;

5) тайлан тэнцэл хэлэлцэх, ашиг хуваарилах.

(Энэ хэсгийн 4 дэх заалтыг Аж ахуйн нэгжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан)

3. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг жилд нэгээс доошгүй удаа хийнэ. Шаардлагатай үед төлөөлөн удирдах зөвлөл хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулна.

(Энэ хэсэгт Аж ахуйн нэгжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан)

4. Хувьцаа эзэмшигчдийн хуралд энэ хуулийн 26 дугаар зүйлийн 6, 7, 9, 10 дахь хэсэг, төлөөлөн удирдах зөвлөлд энэ хуулийн 26 дугаар зүйлийн 12 дахь хэсэг, 26[1] дүгээр зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсэг нэгэн адил хамаарна.

(Энэ хэсгийг Аж ахуйн нэгжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан)

5. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол хувьцаа эзэмшигчид зөвхөн санал нэгтэй зөвшөөрсөн тохиолдолд хурлын хэлэлцэх асуудалд тусгагдаагүй зүйлийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж болно.

6. Төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн хурал хийснээс хойш 14 хоногийн дотор хурлын шийдвэр болон ирцийн бүртгэлийн баталгаат нэг хувийг бүртгэх байгууллагад бүртгүүлнэ.

(Энэ хэсэгт Аж ахуйн нэгжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан)

7. Ерөнхий захирлыг төлөөлөн удирдах зөвлөл сонгоно.

(Энэ хэсгийг Аж ахуйн нэгжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан)

8. Ерөнхий захирал дор дурдсан эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

1) компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж, төлөөлөн удирдах зөвлөлд ажлаа тайлагнана;

2) тухайн компанид хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчидтай компанийг төлөөлөн гэрээ байгуулна;

3) компанийн тайлан тэнцэл, эд хөрөнгө, ашиг хуваарилах журмын талаар санал боловсруулж төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ;

4- (хасагдсан)

5) бүрэн эрхийнхээ асуудлаар тушаал гаргана.

(Энэ хэсгийн 1, 3, 5 дахь заалтыг Аж ахуйн нэгжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан. Энэ хэсгийн 4 дэх заалтыг мөн хуулиар хассан)

9. Ерөнхий захирлын эрхийг тодорхой асуудлаар компанийн дүрэм, хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр хязгаарлаж болно. Тогтоосон хязгаарлалтыг зөрчсөний улмаас тухайн компанид ямар нэгэн хохирол учруулбал уул хохирлыг Ерөнхий захирал хариуцна.

10. Ерөнхий захиралд энэ хуулийн 26 дугаар зүйлийн 13 дахь хэсгийн 3, 7 дахь заалт, мөн зүйлийн 14 дэх хэсэг нэгэн адил хамаарна.

(Энэ хэсгийг Аж ахуйн нэгжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан)

35 дугаар зүйл. Хувьцаат компанийн хяналтын зөвлөл

1. Хувьцаат компани нь дүрмийн сангийн хэмжээ, гишүүний тоог үл харгалзан 3-аас доошгүй гишүүнтэй хяналтын зөвлөлийг заавал ажиллуулна.

2. Хяналтын зөвлөлд энэ хуулийн 27 дугаар зүйлийн заалт нэгэн адил хамаарна.

36 дугаар зүйл. Хувьцаат компанийн дүрмийн сангийн хэмжээг өөрчлөх

1. Дүрмийн сангийн хэмжээг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр өөрчилнө. Өөрчлөх тухай шийдвэр гарснаас хойш 14 хоногийн дотор бүртгэх байгууллагад мэдэгдэнэ.

2. Хувьцаа захиалагч хувьцаа эзэмшигчдийн хурлаар тогтоосон хувьцааны нэрлэсэн үнийг төлөх замаар шинээр гарсан хувьцааг авна. Гэхдээ захиалга хийх үед хувьцааны нэрлэсэн үнийн 30-аас доошгүй хувийг төлнө.

3. Шинээр гарсан хувьцааг эзэмшигч нь компанийн дүрмийн санг нэмэгдүүлсэн тухайн жилийн ашиг хуваарилахад оролцох эрхтэй.

4. Дүрмийн санг хорогдуулах тухай шийдвэр гарч энэ тухай бүртгүүлэхээр мэдэгдэж нийтэд мэдээлснээс хойш 90 хоногийн дотор харилцагч талын гомдлын шаардлагыг барагдуулсан, тэдгээрийн өр төлбөрийг төлөх талаар баталгаа гаргасан нөхцөлд улсын бүртгэлд бүртгэнэ.

5. Дүрмийн санг өөрчилсөн тухай шийдвэрийг улсын бүртгэлд авсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр гэж үзнэ.

37 дугаар зүйл. Компанийн удирдлагын харилцлага

Компанийн удирдлага буруу шийдвэр гаргасны улмаас хохирол учирвал түүнд Монгол улсын хууль тогтоомжид заасны дагуу харилцлага хүлээлгэнэ.

38 дугаар зүйл. Компанийн үйл ажиллагааг зогсоох

1. Энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан үндэслэлээр компанийн үйл ажиллагаа зогсох тохиолдолд эцсийн тооцоо хийнэ.

2. Компанийн эрх барих байгууллага нь дуусгалтын тайлант хэлэлцэж батлахын хамт Ерөнхий захирал, төлөөлөн удирдах болон хяналтын зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх тухай шийдвэр гаргана.

(Энэ хэсэгт Аж ахуйн нэгжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан)

3. Компанийн үйл ажиллагаа зогссон тухай нийтэд мэдээлснээс хойш 6 сарын дотор тухайн компанийн эд хөрөнгийг гишүүдэд хуваахыг хориглоно.

ТАВДУГААР БҮЛЭГ

Улсын үйлдвэрийн газар

39 дүгээр зүйл. Улсын үйлдвэрийн газрын тухай ойлголт

1. Улсын хөрөнгө оруулалтаар байгуулагдсан, өмчлөгч нь төр дангаараа байх аж ахуйн нэгжийг улсын үйлдвэрийн газар (цаашид «үйлдвэрийн газар» гэх) гэнэ. Улсын үйлдвэрийн газрын оноосон нэрийн ард «ҮҮГ» гэсэн ялгах тэмдэг хэрэглэнэ.

(Энэ хэсэгт Аж ахуйн нэгжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан)

2. Улсын төвлөрсөн хөрөнгөөр санхүүжиж байгуулагдсан үйлдвэрийн газар нь Монгол улсын Засгийн газар болон түүнээс эрх олгосон төв байгууллагад, орон нутгийн төсвийн хөрөнгөөс санхүүжиж байгуулагдсан үйлдвэрийн газар нь зохих засаг захиргааны нэгжийн төрийн эрх барих болон түүний гүйцэтгэх байгууллагад ажлаа тус тус хариуцан тайлагнана.

3. Үйлдвэрийн газар нь энэ хууль болон бусад хуульд нийцүүлэн боловсруулсан, Засгийн газар, төрийн эрх бүхий байгууллагаасаа батлуулсан дүрэмтэй байна.

40 дүгээр зүйл. Үйлдвэрийн газрыг байгуулах, бүртгэх

1. Үйлдвэрийн газрыг Монгол Улсын Засгийн газар, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр байгуулна.

2. Үйлдвэрийн газар нь татварын улсын албанд бүртгүүлнэ.

41 дүгээр зүйл. Үйлдвэрийн газрын эд хөрөнгө

1. Үйлдвэрийн газрын эд хөрөнгө нь үндсэн сан, эргэлтийн хөрөнгө, санхүүгийн бусад нөөцөөс бүрдэнэ. Үйлдвэрийн газар нь эд хөрөнгөө Монгол Улсын хууль тогтоомж болон дүрэмдээ нийцүүлэн үйл ажиллагаанаасаа чиглэлийн дагуу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхтэй.

2. Үйлдвэрийн газрын хөрөнгийг бүрдүүлэх эх үүсвэр нь улсын төсвийн хөрөнгө, бүх төрлийн зээл, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний болон бусад үйл ажиллагаанаас олсон орлого, Монгол Улсын хууль тогтоомжид харшлаагүй бусад эх үүсвэр болно.

42 дугаар зүйл. Үйлдвэрийн газрын удирдлага

1. Үйлдвэрийн газрын үйл ажиллагааг түүний дарга удирдаж, томилсон байгууллагадаа ажлаа харнуцан тайлагнана.

2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид харьяалагдах үйлдвэрийн газрын даргыг тухайн нэгжийн Засаг дарга, бусад үйлдвэрийн газрын даргыг Засгийн газрын гишүүн буюу түүний эрх олгосноор уг үйлдвэрийн газрыг харьяалах дээд байгууллагын удирдлага гэрээний үндсэн дээр тус тус томилно.

(Энэ хэсгийг Аж ахуйн нэгжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан)

3. Гэрээнд үйлдвэрийн газрын даргын ажиллах хугацаа, гэрээ байгуулагч талуудын эрх, үүрэг, харнуцлага, түүнд олгох цалин хөлс, нийгэм ахуйн болон бусад нөхцөл, гэрээг цуцлах үндэслэл зэргийг тусгана.

4. Үйлдвэрийн газрын дарга, захиргааны гишүүд аж ахуйн бусад нэгжийн гишүүн, удирдлагын бүрэлдэхүүнд байхыг хориглоно. Харин хувьцаа эзэмшигч байж болно.

5. Дарга нь үйлдвэрийн газрыг төлөөлж дор дурдсан эрх эдэлнэ:

1) тухайн үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс бусад байгууллага, иргэнтэй шууд харилцаж, хөдөлмөр, иргэний болон бусад гэрээ байгуулах, хэлцэл хийх;

2) үйлдвэрийн газрын эд хөрөнгийн Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу захиран зарцуулах;

3) үйлдвэрийн газрын захиргааны бусад албан тушаалтан болон салбар, нэгжийн даргыг томилох, чөлөөлөх;

4) үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, технологийн нууцад хамаарах мэдээллийг тогтоох.

6. Үйлдвэрийн газрын дарга Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн тушаал, заавар гаргана. Тушаал, заавар нь тухайн үйлдвэрийн газрын үйл ажиллагааны хүрээнд мөрдөнө.

43 дугаар зүйл. Үйлдвэрийн газрыг өөрчлөн байгуулах, татан буулгах

Үйлдвэрийн газрыг өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг Монгол Улсын Засгийн газар, төрийн эрх бүхий байгууллага шийдвэрлэнэ.

44 дүгээр зүйл. Бусад заалт

Монгол Улсын Засгийн газар энэ хууль болон бусад хуульд нийцүүлэн үйлдвэрийн газрын эрх, үүрэг, үйл ажиллагааны талаар журам тогтооно.

45 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1991 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөнө.

Улсын Бага Хурлын дарга **Р. ГОНЧИГДОРЖ**

Улсын Бага Хурлын нарийн бичгийн дарга **Б. ЧИМИД**

1991 оны 5 дугаар сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1993 оны 10 дугаар сарын 21-ний өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн дараахь зүйл, хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалт:

«8) Улсын Их Хурлын хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлэх, хуулийн төслийн талаар дүгнэлт гаргахад туслалцаа авах зорилгоор мэргэжлийн олон нийтийн санал авах, шинжээч, мэргэжилтнээс бүрдсэн ажлын хэсэг байгуулж ажиллуулах.»

15 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь өгүүлбэр:

«Хуралдааныг Байнгын хорооны нийт гишүүний дийлэнх олонхи нь хүрэлцэн ирснээр хүчин төгөлдөрт тооцно.»

17 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 3, 4 дэх өгүүлбэр:

«Намын бүлгийн гишүүдийн тоог харгалзан унаа, албан томилолт, бичиг хэргийн зардал, ажилтны цалингийн санг Улсын Их Хурлын төсөвт тусгана. Намын бүлэг батлагдсан төсвөө Улсын Их Хурлаас баталсан журмын дагуу зарцуулна.

Төсвийн зарцуулалтад Дотоод асуудлын байнгын хороо хяналт тавина.

Намын бүлгийг ажиллах нөхцөлөөр хангах асуудлыг Тамгын газар хариуцна.»

21 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг:

«5. Улсын Их Хурлын гишүүн Тамгын газарт харьяалагдах өөрийн орон тооны ажилтантай байж болно. Ажилтны цалингийн сан, бичиг хэргийн зардлыг Улсын Их Хурлын төсөвт тусгана.»

21 дүгээр зүйлийн 10 дахь хэсэг:

«10. Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн хугацаа

дууставар болсон буюу энэ хуулийн 6 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 2-т заасан тохиолдолд түүнийг төрийн сонгуульт ажилд сонгогдохоос өмнөх ажилд нь эгүүлэн ажиллуулна. Хэрэв тийм боломжгүй бол 6 сарын хугацаанд амьдралын түвшинг бууруулахгүй байх арга хэмжээг Улсын Их Хурал авна.»

25 дугаар зүйлийн эхний догол:

«Улсын Их Хурлын дэд дарга дараахь ажлыг биечлэн эрхэлнэ:»

25 дугаар зүйлийн 3 дахь заалт:

«3) аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Улсын Их Хурлын дэргэдэх болон Улсын Их Хурлаас байгуулдаг байгууллагын үйл ажиллагааг зохицуулах;»

28 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

«2. Хэлэлцэх асуудлын шинж байдлыг харгалзан хуралдааныг нээлттэй буюу хаалттай явуулна.

Улсын нууцын жагсаалтад хамаарах асуудлыг хаалттай хуралдаанаар хэлэлцэнэ. Хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар энэ жагсаалтад ороогүй асуудлыг хаалттай хуралдаанаар хэлэлцэж болно.

Хаалттай хуралдаанд Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга (цаашид «Ерөнхий нарийн бичгийн дарга» гэх), түүний орлогч, Тамгын газрын хэвлэл, мэдээллийн албаны итгэмжлэгдсэн төлөөлөгч, тухайн асуудлыг боловсруулахад оролцсон ажлын хэсгийн гишүүдээс бусад хүн байлцах зөвшөөрлийг Ерөнхий нарийн бичгийн дарга олгоно.

Ерөнхийлөгч, Ерөнхий сайдаас бусад Улсын Их Хурлын чуулганд зөвлөх эрхтэй оролцож болох албан тушаалтныг хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар хаалттай хуралдаанд байлцуулна.

Хаалттай хуралдааны талаар зөвхөн нууцын дэвтэрт тэмдэглэл хийнэ.

Хаалттай хуралдааны нууц алдагдахгүй байх нөхцөлийг хангах асуудлыг Улсын Их Хурлын Тамгын газар хариуцна.

Хаалттай хуралдааны талаар энэ хуулийн 53 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу нийтэд мэдээлж болно.»

30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт:

«2) илтгэл сонсох, санал дүгнэлт гаргах, санал хураах цагийг тогтоож зарлах;»

30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

«2. Хуралдаан даргалагч энэ хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар чуулганы хуралдаанд хүрэлцэн ирсэн гишүүдэд танхимаас гарах зөвшөөрөл олгоно.»

31 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь догол:

«Улсын Их Хурлын гишүүнд Байнгын болон бусад хороо, ажлын хэсэгт ажиллах, хэлэлцэх асуудлын төсөл, холбогдох ажил хэргийн материалтай танилцах, сонгогчидтойгоо уулзах боломж олгох зорилгоор долоо хоногийн Лхагва, Бямба гаригт чуулганы хуралдаан хийхгүй.

Улсын Их Хурал дахь аль нэг намын бүлэг, Байнгын хороо тодорхой асуудал хэлэлцэж санал, дүгнэлтээ бэлтгэх зайлшгүй шаардлагатай бол энэ тухай чуулганы хуралдаан дээр урьдчилан мэдэгдэж долоо хоногийн Баасан гаригт хуралдаж болно.»

31 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

«2. Улсын Их Хурал сар бүрийн 2, 4 дэх долоо хоногийн Пүрэв гаригийн 15.00 цагаас 16.00 цаг хүртэл Засгийн газарт асуулт тавьж, хариулт авах буюу өмнө тавьсан асуулгын хариуг сонсоно. Засгийн газарт тавьсан асуулгынхаа талаар Улсын Их Хурлын гишүүн дангаараа болон бусад гишүүнтэй хамтран санал, дүгнэлт гаргаж болно. Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл уг асуудлаар шийдвэр гаргана.»

48 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг:

«1. Төслийг зөвхөн зохих Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх бөгөөд уг хуралдаанд бусад Байнгын хороо, Улсын Их Хурлын гишүүн оролцож санал, дүгнэлт гаргаж болно. Зохих Байнгын хороо хуралдаан болох өдөр, цаг, газрыг хуралдаан болохоос гурваас доошгүй хоногийн өмнө бусад Байнгын хороо, Улсын Их Хурлын гишүүдэд мэдэгдэнэ. Төсөл хэлэлцэхэд бичлэн оролцох боломжгүй Улсын Их Хурлын гишүүн санал, дүгнэлтээ зохих Байнгын хороонд бичгээр урьдчилан гаргаж болох бөгөөд түүнийг Байнгын хорооны хуралдаан дээр заавал танилцуулж хэлэлцүүлнэ.

Байнгын хорооны хуралдаан дээр тухайн төслийн талаар хууль санаачлагчид асуулт тавьж, хариулт авна. Асуулт, хариулт үргэлжлэх хугацааг хуралдаан даргалагч тогтооно.

Хэрэв уг төслийг баталснаар тухайн санхүүгийн жилийн улсын төсвийн зарлагын хэмжээ нэмэгдэхээр байвал энэ тухай Засгийн газрын санал, дүгнэлтийг заавал сонсоно.

2. Байгын хорооны хуралдааныг тухайн Байгын хорооны дарга даргалах бөгөөд уг хуралдаанд зөвхөн тухайн Байгын хорооны гишүүн таслах эрхтэй оролцоно. Төслийн талаар бусад Байгын хороо, Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэйгээ бусад саналыг зохих Байгын хороо өөрийн санал, дүгнэлтдээ бүрэн тусгана.»

49 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь догол:

«Ерөнхийлөгчийн хориг, Ерөнхийлөгчөөс Улсын Их Хуралд хандаж гаргасан илгээлт, Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын ажлын дүн, тайлан сонсох, түүний удирдлагыг томилох, чөлөөлөх, Монгол Улсын олон улсын гэрээг соёрхон батлахаас бусад асуудлаар чуулганы хуралдааны хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд ороогүй төслийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхээр тухайн чуулганы явцад өргөн мэдүүлбэл Дотоод асуудлын байнгын хороо, зохих Байнгын хорооны санал, дүгнэлтийг харгалзан түүнийг тухайн чуулганаар хэлэлцэх эсэхийг чуулганы хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар шийдвэрлэнэ.»

49 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2, 3, 4 дэх заалт:

«2) зохих Байгын хорооны дүгнэлтийг танилцуулах хугацаа 20 минутаас илүүгүй байна. Дүгнэлтэд уг төсөл төрийн бодлогод нийцэж байгаа болон хуулийн зорилт, хууль тогтоомжийн техник, хэл зүйн шаардлагыг хангасан эсэх, тухайн чуулганаар түүнийг хэлэлцэж, батлах боломжтой эсэхийг тодорхойлохоос гадна төслийн үндэслэл, зүйл, заалтын талаар зарчмын өөр саналтай бол бүрэн томъёоллоор илэрхийлсэн үндэслэл, шалтгааныг заана.

Зохих Байгын хороо хуулийн төсөлд оруулах нэмэлт, өөрчлөлтийн тухай зарчмын саналаа томъёолж Улсын Их Хурлын гишүүдэд тараасан байна.

3) төслийн тухай хууль санаачлагчийн илтгэл, зохих Байгын хорооны дүгнэлтийг сонссоны дараа зохих Байнгын хорооны хуралдаан дээр зөвшилцөлд хүрээгүй зарчмын зөрүүтэй асуудлаар бусад Байгын хороо санал, дүгнэлт гаргаж болно.

Хэрэв Улсын Их Хурал дахь намын бүлэг санал, дүгнэлт гаргах шаардлагатай гэж үзвэл түүнийг бүлгийн ахлагч, эсхүл, уг бүлгээс томилогдсон аль нэг гишүүн танилцуулна.

Зохих байнгын хорооны хуралдаанд оролцож зарчмын өөр санал гаргасан боловч санал нь олонхийн дэмжлэг авч чадаагүй Улсын Их Хурлын гишүүн хүсвэл дангаараа буюу бусад гишүүнтэй хамтран санал, дүгнэлт гаргаж болно.

Санал, дүгнэлт гаргахдаа энэ хуулийн 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2-т заасан хугацааг баримтлах бөгөөд санал, дүгнэлтийг урьдчилан тараасан байна;

4) зарчмын зөрүүтэй санал гэдэгт зохих Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж зөвшилцөлд хүрээгүй саналыг ойлгоно;»

49 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 7 дахь заалтын «а» дэд заалт:

«а) төслийг бүхэлд нь эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх;»

49 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 8, 9 дэх заалт:

8) Улсын Их Хурал төслийг бүхэлд нь эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхээр тохирсон нөхцөлд түүнийг зохих саналын дагуу зарчмын хувьд өөрчлөх, найруулан засах үүрэг бүхий Улсын Их Хурлын болон хууль санаачлагчийн хамтарсан ажлын хэсэг байгуулж болно;

9) анхны хэлэлцүүлгийн явцад төслийн талаар зарчмын зөрүүтэй санал гараагүй бол түүний эцсийн хэлэлцүүлгийг шууд явуулж болно;»

49 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг:

«4. Анхны хэлэлцүүлгээр шийдвэрлэсэн асуудлыг төсөлд тусгаж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх ажлыг дараахь үе шаттай хэрэгжүүлнэ:

1) төслийг хууль санаачлагч хариуцаж ажлын хэсэгт эцэслэн боловсруулна;

2) төслийн анхны хэлэлцүүлэгт дүгнэлт гаргасан зохих Байнгын хороо анхны хэлэлцүүлгээр тогтсон зарчмын тохиролцоог үндэслэн Улсын Их Хурлын гишүүний болон хууль санаачлагчийн томьёолж өгсөн саналыг нэгбүрчлэн хянан үзэж төсөлд зохих нэмэлт, өөрчлөлт хийж, хууль тогтоомжийн

техник, хэл зүй, найруулгын талаас нь нягтлан үзэж зохих танилцуулга бэлтгэнэ.

5. Төслийн эцсийн хэлэлцүүлэг явуулахад дараахь журам баримтална:

1) төслийн талаар зохих Байнгын хороо танилцуулга хийх хугацаа 20 минутаас илүүгүй байна;

2) зохих Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт, хариулт явуулж болно;

3) эцсийн хэлэлцүүлэгт төслийг бүлэг, зүйл тус бүрээр буюу хэрэв санал зөрүүгүй бол бүхэлд нь хэлэлцэж батална. Ажлын хэсгийн эцэслэн боловсруулсан төслийн томьёололтой санал нийлээгүй гишүүн өөрийн томьёоллоо хуралдаан даргалагчид бичгээр урьдчилан өгсөн байх бөгөөд уг саналынхаа талаар тайлбар өгч болно. Иймхүү тайлбар өгөхдөө энэ хуулийн 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2-т заасан хугацааг баримтална;

4) шаардлагатай гэж үзвэл эцсийн хэлэлцүүлгээр батлагдсан хуулийг дагаж мөрдөх журмын тухай тогтоолыг хэлэлцэн батална;

5) төсөл батлагдаагүй бол түүнийг хууль санаачлагчид буцаасан тухай Улсын Их Хурлын тогтоол гаргана. Иймхүү тогтоол гаргахын өмнө хууль санаачлагч саналаа Улсын Их Хуралд сонгох эрхтэй бөгөөд түүнийг авч хэлэлцэх эсэхийг хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар шийднэ;

6) эцсийн хэлэлцүүлгээр батлагдсан төслийг эцсийн найруулгад шилжүүлж, эцсийн хэлэлцүүлэг дууссанаас хойш ажлын 6 өдөрт багтаан эцсийн найруулгыг Улсын Их Хуралд танилцуулна. Эцсийн найруулгыг танилцуулах ажлыг Ерөнхий нарийн бичгийн дарга хариуцна;

7) Улсын Их Хурал эцэслэн найруулсан төсөлтэй танилцах явцад аливаа хэлэлцүүлэг явуулахгүй. Харин төслийн аль нэг зүйл, заалт, хүчин төгөлдөр дагаж мөрдөж байгаа хууль болон уг төсөлд тусгагдсан зүйл, заалттай зөрчилдөж байна гэсэн үндэслэлээ тухайн асуудал харьяалсан зохих Байнгын хороо болон Хууль зүйн байнгын хороонд бичгээр урьдчилан мэдэгдсээр байхад уг асуудал эцсийн найруулгад

хэвээр үлдсэн тохиолдолд дээрх Байнгын хороодын дүгнэлтийг сонссоны эцэст тухайн асуудлаар санал хураах шийдвэрлэж болно.»

Есдүгээр бүлгийн нэр:

«Улсын Их Хурал шийдвэр гаргах, түүнийг нийтлэх, хянан шалгах»

50 дугаар зүйл:

«50 дугаар зүйл. Улсын Их Хурлын шийдвэр

Улсын Их Хурал хууль, бусад шийдвэр гаргана. Улсын Их Хурал хууль, бусад шийдвэрийн эцсийн найруулгатай танилцсанаас хойш 72 цагийн дотор Улсын Их Хурлын дарга уг шийдвэрт гарын үсэг зурж ёсчлоно.»

51 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг:

«1. Үндсэн хууль, энэ хууль бусад хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурал тухайн асуудлаар санал хураалт явуулж чуулганы хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар шийдвэрлэнэ.

Энэ хууль болон бусад хуульд нууц санал хураалт явуулж шийдвэрлэхээр зааснаас бусад тохиолдолд санал хураалтыг илээр явуулна. Ил санал хураалтыг гар өргөж, эсхүл цахим төхөөрөмжөөр, нууц санал хураалтыг санал хураах хуудсаар, эсхүл цахим тооцоолуур ашиглан явуулна.

Тухайн хуралдаанд оролцсон 5-аас доошгүй гишүүний шаардсанаар, эсхүл хуралдаан даргалагчийн санаачилгаар ил санал хураалтыг нэрээр хураах болно. Ийнхүү нэрээр санал хураахдаа хуралдаан даргалагч цахим тооцоолуур дээр бичигдсэн, эсхүл гар өргөсөн гишүүн нэг бүрийн нэр, өгсөн санал болон санал хураалтын дүнг танилцуулна.

2. Улсын Их Хурлын гишүүн чуулганы тухайн өдрийн тухайн асуудлаархи хуралдаанд ирцээ бүртгүүлсэн бол хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд уг асуудлаар санал хураахад заавал оролцоно. Санал хураалт явуулах цагийг хуралдаан даргалагч урьдчилан зарлана. Хуульд заасан журмын дагуу санал хурааж нэгэнт баталсан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг санал хураах үед байгаагүй гэсэн шалтгаанаар Улсын Их Хурлын гишүүн дахин хэлэлцүүлэх эрх эдлэхгүй.»

56 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг:

«2. Улсын Их Хурал, түүний дэргэдэх бусад байгууллагын үйл ажиллагаанд шаардагдах зардлын төсвийн төсөл, төс-

вийн гүйцэтгэлийн тайланг Дотоод асуудлын байнгын хорооны хуралдаанаар урьдчилан хэлэлцэнэ. Дотоод асуудлын байнгын хороо уг асуудлаарх санал, дүгнэлтээ чуулганы хуралдаанаар улсын нэгдсэн төсвийн төсөл, түүний гүйцэтгэлийг хэлэлцэх үед оруулна.

3. Улсын Их Хурлын төсвийн зарцуулалтад Дотоод асуудлын байнгын хороо хяналт тавина.»

61 дүгээр зүйл:

«61 дүгээр зүйл. Улсын Их Хурлын дэргэдэх байгууллага Улсын Их Хурал дэргэдээ төрийн тогтолцоо, бодлого, хөгжлийн чиг хандлага, түүхэн уламжлал, Улсын Их Хурлын хууль тогтоох, хянан шалгах чиг үүрэг, улсын төсвийн үйл ажиллагаа, хууль тогтоомжийн үр ашиг, тэдгээрийг боловсронгуй болгох арга зам зэрэг асуудлаар эрдэм шинжилгээ, судалгаатын ажил эрхэлж Улсын Их Хурлыг мэдээллээр хангах үндсэн үүрэг бүхий байгууллагатай байж болно.»

2 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд дараахь зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь догол:

«Энэхүү ирц нь Улсын Их Хурлын ээлжит, ээлжит бус, онцгой чуулганы нээлтийн хуралдаан, чуулганы өдөр бүрийн хуралдааныг эхлүүлэх, тухайн өдрийн хуралдаанаар шинэ асуудал хэлэлцэж эхлэх, аль ч асуудлаар санал хураахад заавал бүрдсэн байна.»

18 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7, 8 дахь заалт:

«7) Байнгын хорооны бүрэлдэхүүний талаар Улсын Их Хурлын даргатай зөвшилцөх;

8) Улсын Их Хурлын зохион байгуулалтын үйл ажиллагаатай холбогдсон саналаа Улсын Их Хурал, Байнгын хороонд оруулах;»

21 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн 2, 3 дахь өгүүлбэр:

«Улсын Их Хурлын гишүүний унаа, албан томилолт, бичиг хэргийн зардлыг Улсын Их Хурлын төсөвт гишүүн нэг бүрээр тооцож тусгах бөгөөд батлагдсан төсвөө Улсын Их Хурлаас баталсан журмын дагуу зөвхөн тухайн гишүүн мэдэж зарцуулна. Улсын Их Хурлын гишүүний төсвийн зарцуулалтад Дотоод асуудлын байнгын хороо хяналт тавина.»

37 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, 3 дахь догол:

«Хэрэв Ерөнхий сайд Ерөнхийлөгчтэй зөвшилцөх явцад

нэгдсэн тохиролцоонд хүрч чадаагүй бол саналаа зохих Байнгын хороо, улмаар Улсын Их Хуралд танилцуулна.

Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах тухай Ерөнхийлөгчтэй зөвшилцөж Улсын Их Хуралд өргөн барьсан Ерөнхий сайдын саналыг хянан хэлэлцэхдээ энэ журмыг мөн баримтална.»

43 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

«4. Ерөнхийлөгчийн санал болгосон нэр дэвшигч Хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн дэмжлэг авч чадаагүй тохиолдолд Ерөнхийлөгч дахин өөр санал оруулж болно.»

45 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

«5. Ерөнхийлөгчийн санал болгосон нэр дэвшигч Хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн дэмжлэг авч чадаагүй тохиолдолд Ерөнхийлөгч дахин өөр санал оруулж болно.»

45[1] дүгээр зүйл:

«45[1] дүгээр зүйл. Ерөнхийлөгчийн хоригийг хянан хэлэлцэх

1. Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасны дагуу Улсын Их Хурлын баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь Ерөнхийлөгчийн тавьсан хоригийн үндэслэлийг Ерөнхийлөгч, эсхүл Ерөнхийлөгчийн итгэмжилснээр түүний төлөөлөгч Улсын Их Хуралд танилцуулна.

2. Хориг үндэслэлтэй эсэх, түүнийг хүлээн авах эсэх талаар тухайн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хариуцаж байсан зохих Байнгын хороо, Хууль зүйн байнгын хорооны дүгнэлтийг тус тус сонссоны дараа санал хураалт явуулна.

Чуулганы хуралдаанд оролцсон нийт гишүүний гуравны хоёр нь уг хоригийг хүлээж аваагүй бол уг хууль, шийдвэр, түүний зүйл, заалт хэвээр үлдэнэ. Улсын Их Хурал Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн аваагүй бол энэ тухай тогтоол гаргана.

3. Хоригийг хүлээж авахаас татгалзсан гишүүдийн саналын тоо чуулганы хуралдаанд оролцсон нийт гишүүний гуравны хоёрт хүрэхгүй байвал уг хоригийг хүлээн авсанд тооцно. Иймхүү хоригийг хүлээн авсанд тооцсон тохиолдолд хоригийн талаар асуулт, хариулт явуулж, гишүүд санал, дүгнэлт гаргаж болно. Байнгын хороод, гишүүдээс тавьсан саналыг үндэслэн санал хураалт явуулж чуулганы хуралдаанд

оролцсон нийт гишүүний олонхийн саналаар асуудлыг эцэслэн шийдвэрлэнэ.

4. Улсын Их Хурал хоригийг үндэслэлтэй гэж үзсэн тохиолдолд тухайн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг бүхэлд нь буюу түүний зарим хэсгийг хүчингүй болгож, эсхүл тэдгээрт зохих нэмэлт,, өөрчлөлт оруулна.

5. Тухайн хууль, бусад шийдвэрийг хүчин төгөлдөр дагаж мөрдөж эхлэх тусгайлан заасан хугацаа Ерөнхийлөгчийн хориг тавьсан хугацаатай давхацвал хоригийг хэрхэх тухай асуудлыг Улсын Их Хурал хянан хэлэлцэж дуусах хүртэл уг хууль, бусад шийдвэр бүхэлдээ буюу түүний зарим хэсгийн үйлчлэл түр зогсоно.

6. Хоригт тусгагдсан асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн тухай хариуг уг шийдвэрийг баталснаас хойш 72 цагийн дотор Ерөнхийлөгчид илгээнэ.»

45[2] дугаар зүйл:

«45[2] дугаар зүйл. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хянан хэлэлцэх

1. Үндсэн хуулийн жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын шийдвэрийн талаар гаргасан Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн дарга, эсхүл түүний итгэмжилснээр Үндсэн хуулийн цэцийн аль нэг гишүүн Улсын Их Хуралд танилцуулна.

2. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг танилцуулсны дараа тухайн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хариуцаж байсан зохих Байнгын хороо, Хууль зүйн байнгын хороо дүгнэлт гаргана. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн талаар Улсын Их Хурлын гишүүд асуулт тавьж, хариулт авч, санал, дүгнэлт гаргаж болно.

3. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөх эсэхийг чуулганы хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар шийдвэрлэнэ. Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хянан хэлэлцээд уг дүгнэлтийг хууль зүйн үндэслэлгүй гэж үзсэн тохиолдолд энэ тухай тогтоол гаргана.

4. Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хянан хэлэлцээд уг дүгнэлт хууль зүйн үндэслэлтэй гэж үзсэн тохиолдолд тухайн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг бүхэлд нь буюу түүний зарим хэсгийг хүчингүй болгож, эсхүл тэдгээрт зохих нэмэлт, өөрчлөлт оруулна.

5. Үндсэн хуулийн жаран зургадугаар зүйлийн 3, 4 дэх хэсэгт заасан тохиолдолд Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн эцсийн шийдвэрийн дагуу авах арга хэмжээний талаарх асуудлыг хэлэлцэнэ.»

45³ дугаар зүйл:

«45³ дугаар зүйл. Ерөнхийлөгч, Засгийн газар, Монгол Улсын олон улсын гэрээний төслийг Улсын Их Хуралтай зөвшилцөх

1. Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-т заасны дагуу Ерөнхийлөгч Монгол Улсын нэрийн өмнөөс байгуулах олон улсын гэрээний, мөн хуулийн гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 9-д заасны дагуу Засгийн газар дараа соёрхон батлуулах Монгол Улсын олон улсын гэрээний төслийг Улсын Их Хуралтай зөвшилцөнө.

2. Монгол Улсын олон улсын гэрээний төслийг нөгөө талтай зарчмын хувьд тохиролцсоны дараа, түүнд гарын үсэг зурахаас өмнө Улсын Их Хурлын Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хороо урьдчилан хэлэлцэнэ. Гэрээний төсөл, эсхүл түүний дэлгэрэнгүй танилцуулга, холбогдох бусад баримт бичгийг Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хороо урьдчилан хэлэлцэхээс гурваас доошгүй хоногийн өмнө Улсын Их Хурлын гишүүдэд тараасан байна.

3. Бусад Байнгын хороо, Улсын Их Хурлын гишүүн төслийн талаарх санал, дүгнэлтээ Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хороонд бичгээр ирүүлэх бөгөөд уг саналыг тус Байнгын хорооны хуралдаанд заавал танилцуулна. Байнгын хорооны хуралдаанаас төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар санал, дүгнэлт гарвал Засгийн газар гэрээний төслийг нөгөө талтай эцэслэн тохиролцохдоо тэдгээрийг тусгах чиглэлээр ажиллаж, дүнг Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хороонд танилцуулна.

4. Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хороо Монгол Улсын олон улсын гэрээний төслийг урьдчилан хэлэлцэж дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

1) гэрээний төслийг бүхэлд нь зөвшөөрөх;

2) гэрээг байгуулах шаардлагагүй гэж үзэж татгалзах.

5. Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хороо гэрээний төслийг бүхэлд нь зөвшөөрсөн, эсхүл уг гэрээг байгуулахаас татгалзсан тухай шийдвэр, түүнд холбогдох санал, дүгнэлтээ шаардлагатай гэж үзвэл чуулганы хуралдаанд танилцуулна.

6. Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хороо гэрээг байгуулах шаардлагагүй гэж үзсэн тухай шийдвэр гаргасан тохиолдолд Ерөнхийлөгч, Засгийн газар уг асуудлыг чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж болно.

7. Хүчин төгөлдөр болоогүй байгаа олон улсын олон талт гэрээнд Ерөнхийлөгч Монгол Улсын нэрийн өмнөөс гарын үсэг зурахын өмнө уг асуудлыг Улсын Их Хуралтай зөвшилцөхөд энэ зүйлийг баримтална.»

45⁴ дүгээр зүйл:

«45⁴ дүгээр зүйл. Гадаад улсыг хүлээн зөвшөөрөх, түүнтэй дипломат харилцаа тогтоох, цуцлах тухай асуудлыг хянан хэлэлцэх

1. Гадаад улсыг хүлээн зөвшөөрөх тухай Засгийн газраас өргөн мэдүүлсэн асуудлыг Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хороо урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлтээ чуулганы хуралдаанаар хэлэлцүүлнэ.

2. Гадаад улстай дипломат харилцаа шинээр буюу сэргээн тогтоох тухай Засгийн газраас өргөн мэдүүлсэн асуудлыг Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хороо урьдчилан хэлэлцэнэ. Байнгын хороо уг асуудлыг сайшаан зөвшөөрч тухайн улстай тодорхой тохиролцохыг Засгийн газарт үүрэг болгоно. Засгийн газар тухайн улстай тодорхой тохиролцсоны дараа уг асуудлыг Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хороо дахин хэлэлцэж, санал дүгнэлтээ чуулганы хуралдаанаар хэлэлцүүлнэ.

3. Гадаад улстай дипломат харилцаагаа цуцлах тухай Засгийн газраас өргөн мэдүүлсэн асуудлыг зохих Байнгын хороо урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлтээ чуулганы хуралдаанаар хэлэлцүүлнэ.»

48 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

«5. Хууль санаачлагч, зохих Байнгын хороо болон бусад Байнгын хороо зарчмын зөрүүтэй саналаар зөвшилцөлд хүрэхийн тулд шинжээч томилон дүгнэлт гаргуулах, Засгийн газрын холбогдох гишүүний болон бусад албан тушаалтны санал сонсох зэргээр ажиллаж болно.»

51 дүгээр зүйлийн 4, 5 дахь хэсэг:

«4. Тухайн асуудлаар санал хураалт явуулсны дараа санал хураалтад цөөнх болсон, эсхүл цөөнхийг төлөөлсөн 3 хүртэл гишүүн тайлбар хэлж болно. Хэрэв цөөнх дахин санал

хураалгахыг хүсвэл эхний санал хураалтад олонхийн дэмжлэг авсан томьёоллоор дахин санал хураалт явуулна.

Эхний 2 санал хураалтад нэг томьёолол 2 удаа олонхийн дэмжлэг авсан бол уг томьёоллыг батлагдсанд тооцох бөгөөд энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан тохиолдолд уг томьёоллоор зөвхөн нэг удаа дахин санал хурааж шийдвэрлэнэ.

Хэрэв эхний санал хураалтад олонхийн дэмжлэг авсан томьёолол 2 дахь санал хураалтад олонхийн дэмжлэг авч чадаагүй бол 2 дахь санал хураалтад цөөнх болсон, эсхүл цөөнхийг төлөөлсөн 3 хүртэл гишүүн тайлбар хэлж болно. Хэрэв цөөнх дахин санал хураалгахыг хүсвэл 2 дахь санал хураалтад олонхийн дэмжлэг авсан томьёоллоор дахин нэг удаа санал хураалт явуулж олонхийн санал авсан томьёоллыг батлагдсанд тооцох бөгөөд зөвхөн энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан тохиолдолд уг томьёоллоор эцсийн удаа санал хурааж шийдвэрлэнэ.

5. Хуралдаанд оролцсон нийг гишүүний гуравны нэгээс доошгүй нь тухайн асуудал батлагдсаны эцэст уг томьёололтой зарчмын хувьд санал нийлэхгүй байгаа гэсэн шалтгаанаар зөвхөн нэг удаа санал хураалгаж болно. Энэ санал хураалтын дүн эцсийн шийдвэр байна.»

53[1] дүгээр зүйл:

«53[1] дүгээр зүйл. «Төрийн мэдээлэл» эмхтгэл

1. «Төрийн мэдээлэл» эмхтгэл нь Улсын Их Хурлаас батлагдсан хууль, бусад шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, хуулийн талаарх Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбарыг бүрэн эхээр нь эмхтгэн нийтлэх төрийн албан ёсны хэвлэл мөн. Энэхүү эмхтгэлийг Улсын Их Хурлын Тамгын газраас эрхлэн сар тутам гаргана.

2. «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн эрхлэгч нь Ерөнхий нарийн бичгийн дарга байна.

3. «Төрийн мэдээлэл» эмхтгэлийг Засгийн газрын хэвлэх үйлдвэрт тогтмол хэвлэн гаргана.»

55[1] дүгээр зүйл:

«55[1] дүгээр зүйл. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах

1. Улсын Их Хурал чуулганы хуралдааны болон түүний чөлөө цагт хянан шалгах бүрэн эрхээ Улсын Их Хурлын ги-

шүүн, Байнгын хороо, мөн Улсын Их Хурал буюу Байнгын хорооноос байгуулсан ажлын хэсгээр дамжуулан хэрэгжүүлнэ.

2. Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ дараахь хэлбэрээр хэрэгжүүлнэ:

1) Улсын Их Хурлын гишүүн асуулт, асуулга тавьж, хариулт авах;

2) холбогдох албан тушаалтны мэдээлэл сонсох, түүний илтгэл, сонсголыг хэлэлцэх;

3) хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг хэрхэн биелүүлж байгаа байдлыг шалгах;

4) хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийн талаар иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн санал, хүсэлт, мэдээллийг сонсох, хүлээн авах.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хэлбэрээр хэрэгжүүлсэн хяналт шалгалтын дүнг Улсын Их Хурлын чуулганы болон Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж шаардлагатай гэж үзвэл зохих шийдвэр гаргана.

4. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах явцад уг шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл түүнийг хүчингүй болгохоор байвал Улсын Их Хурал уг асуудлыг даруй хэлэлцэж шийдвэрлэнэ.»

57 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

«3. Улсын төсвийн төсөл боловсруулах, батлах, түүний гүйцэтгэлд хяналт тавих, Улсын Их Хурлын хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлэхэд мэргэжлийн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг Тамгын газарт байна.»

3 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 57 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн дугаарыг «4» гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалтын 2 дахь доголыг хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл. Энэ хуулийг 1993 оны 10 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Монгол Улсын Их Хурлын дарга **Н. БАГАБАНДИ**

Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн дарга **Н. РИНЧИНДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ

1993 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс тавьсан хоригийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн дараахь зүйл, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

31 дүгээр зүйлийн 10 дахь хэсэг:

«10. Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн хугацаа дууссавар болсон, энэ хуулийн 6 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 2-т заасан тохиолдолд түүнийг төрийн сонгуульт ажилд сонгогдохоос өмнөх ажилд нь эгүүлэн ажиллуулах буюу тухайн ажил байхгүй бол ажил эрхлэх хүртэл 6 сарын хугацаанд Улсын Их Хурлын гишүүн байсан үеийн авч байсан цалингийн хэмжээнээс буурахаргүй тэтгэмж, хэрэв бага цалинтай ажил эрхэлж байгаа бол цалингийн зөрүүтэй тэнцэх хэмжээний тэтгэмж мөн хугацаанд олгоно. Хэрэв Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдохоос өмнө оршин сууж байсан газраа шилжвэл өөрийнх нь болон гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүний замын зардал, ачаа тээшийн хөлсийг авто хөсгийн тарифаар тооцож олгоно.»

45[1] дүгээр зүйлийн 2, 3, 4 дэх хэсэг:

«2. Ерөнхийлөгчийн хоригийн талаар тухайн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хариуцаж байсан зохих Байнгын хороо, Хууль зүйн байнгын хорооны дүгнэлтийг сонсоно. Хэрэв эдгээр Байнгын хороо хоригийг хүлээн зөвшөөрсөн санал, дүгнэлт гаргасан бол тухайн хууль, Улсын Их Хурлын шийдвэрийг бүхэлд нь буюу түүний зарим хэсгийг хүчингүй болгох, эсхүл тэдгээрт зохих нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн

төслийг Улсын Их Хурлын гишүүдэд урьдчилан тараасан байна.

Байнгын хороодын санал, дүгнэлтийг сонссоны дараа асуулт, хариулт явуулж, гишүүд санал гаргаж болно. Иймхүү санал, дүгнэлт гаргаж дууссаны дараа Ерөнхийлөгч тухайн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавьсаныг үндэслэн уг хоригийг хүлээн зөвшөөрөх эсэх асуудлаар санал хураалт явуулна. Хэрэв Ерөнхийлөгч хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн зарим хэсэгт хориг тавьсан бол тухайн зүйл, заалт нэг бүрээр санал хураалт явуулна.

3. Улсын Их Хурал Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн зөвшөөрөөгүй бол энэ тухай тогтоол гаргана.

4. Улсын Их Хурал хоригийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд тухайн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг бүхэлд нь буюу түүний зарим хэсгийг хүчингүй болгож, эсхүл тэдгээрт зохих нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэж батална.»

2 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 3 дахь заалтын «аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Улсын Их Хурлын дэргэдэх болон Улсын Их Хурлаас байгууллагын үйл ажиллагааг зохицуулах;», 37 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн «Хэрэв Ерөнхий сайд Ерөнхийлөгчтэй зөвшилцөх явцад нэгдсэн тохиролцоонд хүрч чадаагүй бол саналаа зохих Байнгын хороо, улмаар Улсын Их Хуралд танилцуулна. Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах тухай Ерөнхийлөгчтэй зөвшилцөж Улсын Их Хуралд өргөн барьсан Ерөнхий сайдын саналыг хянан хэлэлцэхдээ энэ журмыг мөн баримтална.» гэснийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 4 дэх заалтын дугаарыг «3)» гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн хууль болон энэ хуулийг 1993 оны 11 дүгээр сарын 8-ны өдрөөс эхлэн тус тус дагаж мөрдсүгэй.

Монгол Улсын Их Хурлын дарга **Н. БАГАБАНДИ**

Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга **Н. РИНЧИНДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурал

1. Монгол Улсын Их Хурал (цаашид «Улсын Их Хурал» гэх) төрийн эрх барих дээд байгууллага мөн.

2. Монгол улсад хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.

2 дугаар зүйл. Улсын Их Хурлын тухай хууль тогтоомж

Улсын Их Хурлын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль (цаашид «Үндсэн хууль» гэх) энэ хууль Улсын Их Хурлын бусад шийдвэрээс бүрдэнэ.

3 дугаар зүйл. Улсын Их Хурлын үйл ажиллагааны үндсэн зарчим

Улсын Их Хурлын үйл ажиллагаа нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, ард түмнийхээ нийтлэг эрх ашгийг эрхэмлэх, ардчилсан ёс, шударга ёс, хүний эрх, эрх чөлөө, үндэснийхээ эв нэгдлийг хангах, хууль дээдлэх зарчимд үндэслэнэ.

4 дүгээр зүйл. Улсын Их Хурлын бүрэлдэхүүн

Улсын Их Хурал нь Үндсэн хуулийн хорин нэгдүгээр зүйлийн 1, 2, 3, дахь хэсэгт зааснаар нэг танхимтай, Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд, нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж сонгосон далан зургаан гишүүнээс бүрдэнэ.

5 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

1. Улсын Их Хурал нь Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлд заасан онцгой бүрэн эрх, хуулиар тогтоосон бусад бүрэн эрх эдэлнэ.

2. Энэ хуульд заасан «Улсын Их Хурлын нийт гишүүн» гэдгийг Үндсэн хуульд заасан ёсоор 76 гэж ойлгох бөгөөд тэдний дөрөвний гурав буюу 57-гоос доошгүйн бүрэн эрх хууль ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн нөхцөлд Улсын Их Ху-

рал бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах бүрэлдэхүүнтэйд тооцно.

3. Улсын Их Хурлын нийт гишүүний ердийн олонхи буюу 39-өөс доошгүйн бүрэн эрх хууль ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн нам, эсхүл эвслийг Улсын Их Хурал дахь олонхийн суудал авсан нам буюу эвсэлд тооцно.

4. Улсын Их Хурал нь Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 16-д заасан ёсоор ард нийтийн санал асуулга явуулах тухай асуудлыг гагцхүү хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтны саналаар үүсгэн хэлэлцэж шийдвэрлэнэ.

6 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаа

1. Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаа 4 жил байна.

2. Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаа нь Үндсэн хуулийн хорин гуравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар гишүүд Төрийн сүлдэнд тангараг өргөснөөр эхэлж, Улсын Их Хурлын дараагийн сонгуулиар шинэ сонгогдсон гишүүд тангараг өргөснөөр дуусгавар болно.

3. Улсын Их Хурлын гишүүн Төрийн сүлдэндээ «Монгол Улсын Их Хурлын гишүүн би ард түмнийхээ элчийн хувьд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн хамгаалж, төрийн хуулийг дээдлэн сахиж, гишүүний үүргээ чин шударгаар биелүүлэхээ тангаргалъя» гэж тангараг өргөнө.

4. Үндсэн хуулийн хорин хоёрдугаар зүйлд заасан онцгой нөхцөлийн улмаас ээлжит сонгууль явуулах боломжгүй бол мөнхүү нөхцөл арилж, шинэ сонгогдсон гишүүдээ тангараг өргөтөл Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлнэ.

5. Улсын Их Хурал Үндсэн хуулийн хорин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь үзсэнээр буюу эсхүл мөнхүү шалтгаанаар Ерөнхийлөгч Улсын Их Хурлын даргатай зөвшилцөн санал болгосноор хэлэлцэж Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн саналаар өөрөө тарах шийдвэр гаргаж болно. Улсын Их Хурал ийнхүү тарах шийдвэр гаргасан бол шинэ сонгогдсон гишүүдээ тангараг өргөтөл бүрэн эрхээ хэвээр эдэлнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Улсын Их Хурлын чуулган

7 дугаар зүйл. Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх хэлбэр

1. Улсын Их Хурал бүрэн эрхээ чуулган, байнгын болон түр, дэд хороо, намын бүлэг, зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ.

2. Чуулган бол Улсын Их Хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр мөн.

3. Чуулганы хуралдаан, байнгын хороодын дагнасан буюу хамтарсан хуралдааныг чуулганы ажиллагаанд тооцно.

4. Улсын Их Хурал, бусад шийдвэрийг гагцхүү чуулганы хуралдаанаар батлан гаргана.

8 дугаар зүйл. Улсын Их Хурлын анхдугаар чуулган

1. Улсын Их Хурлын анхдугаар чуулганыг Улсын Их Хурлын сонгууль явуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Ерөнхийлөгч товлон зарлаж, энэ тухай зарлиг гаргана.

2. Улсын Их Хурлын анхдугаар чуулган дээр Улсын Их Хурлын шинэ сонгогдсон гишүүд тангараг өргөсний дараа Улсын Их Хурлын дарга, дэд даргыг сонгох, Байнгын хороодыг байгуулах, тэдгээрийн гишүүд, дарга нарыг сонгох, Ерөнхий сайд, Засгийн газрын бусад гишүүдийг томилох асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.

3. Улсын Их Хурлын даргыг сонгох хүртэл анхдугаар чуулганы хуралдааныг Улсын Их Хурлын насаар хамгийн ахмад гишүүн даргална.

9 дүгээр зүйл. Ээлжит чуулган

1. Үндсэн хуулийн хорин долдугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар Улсын Их Хурлын ээлжит чуулган хагас жил тутам нэг удаа дараалан таваас доошгүй ажлын өдөр чуулна. Ээлжит чуулганыг жил бүрийн билгийн тооллын хаврын дунд сарын шинийн 3, намрын дунд сарын 17-ы өдөр тус тус нээнэ. Улсын Их Хурлын ээлжит чуулган нээх өдөр нь амралт, баяр ёслолын өдөртэй давхцвал дараагийн өдөр шилжүүлнэ.

2. Улсын Их Хурлын ээлжит чуулганыг Улсын Их Хурлын дарга товлон зарлаж, энэ тухай захирамж гаргана.

10 дугаар зүйл. Ээлжит бус чуулган

1. Ээлжит чуулганы чөлөө цагт зайлшгүй шаалтгаанаар ээлжит бус чуулган чуулж болно.

2. Ээлжит бус чуулганыг Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны нэгээс дээшхийн шаардсанаар, эсхүл Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, түүний эзгүйд дэд даргын санаачилгаар хийнэ.

3. Улсын Их Хурлын дарга, түүний эзгүйд дэд дарга нь ээлжит бус чуулган чуулах тухай захирамж гаргана.

4. Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан нөхцөл байдал бий болсон үед Улсын Их Хурлын дарга, дэд дарга ээлжит бус чуулган чуулах тухай захирамж гаргах боломжгүй байвал Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны нэгээс доошгүй нь санал нэгдэж ээлжит бус чуулганы хуралдааныг зохион байгуулж болно.

11 дүгээр зүйл. Онцгой чуулган

1. Ерөнхийлөгч онц болон дайны байдал зарлавал түүнээс хойш далан хоёр цагийн дотор Улсын Их Хурал онцгой чуулганаа товлохгүйгээр, тухайлбал Улсын Их Хурлын гишүүд зар мэдээ хүлээлгүйгээр өөрсдөө ирж чуулна.

2. Улсын Их Хурлын онцгой чуулганаар онц болон дайны байдал зарласан тухай Ерөнхийлөгчийн зарлигийг уул зарлиг гарснаас хойш долоо хоногийн дотор батлах эсхүл хүчингүй болгох, түүнчлэн тухайн нөхцөл байдлаас үүссэн хойшлуулшгүй бусад асуудлыг шийдвэрлэнэ.

3. Улсын Их Хурлын ээлжит болон ээлжит бус чуулган чуулж байх үед онц болон дайны байдал зарлах онцгой нөхцөл бий болвол тухайн чуулганаар хэлэлцэх аливаа асуудлыг хойшлуулж онц болон дайны байдал зарлах тухай асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.

12 дугаар зүйл. Улсын Их Хурлын чуулганы хуралдаан

1. Улсын Их Хурлын чуулганы хуралдааныг Үндсэн хуулийн хорин долдугаар зүйлийн 8 дахь хэсэгт зааснаар нийт гишүүний дийлэнх олонхи буюу гуравны хоёр нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд тооцно.

Энэхүү ирц нь Улсын Их Хурлын ээлжит, ээлжит бус, онцгой чуулганы нээлтийн хуралдаан, чуулганы өдөр бүрийн хуралдааныг эхлүүлэх, тухайн өдрийн хуралдаанаар шинэ асуудал хэлэлцэж эхлэх, аль ч асуудлаар санал хураахад заавал бүрдсэн байна.

2. Улсын Их Хурлын чуулганы хуралдааныг бэлтгэн явуулахдаа энэ хуулийн зургадугаар бүлэгт заасан журмыг баримтална.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Улсын Их Хурлын зохион байгуулалтын бүтэц

13 дугаар зүйл. Улсын Их Хурлын Байнгын хороо, түүний бүтэц, бүрэлдэхүүн

1. Улсын Их Хурлын Байнгын хороо (цаашид «Байнгын хороо» гэх) нь чуулганаар хэлэлцэх асуудал боловсруулах, урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гаргах, түүнчлэн эрхлэх асуудлынхаа хүрээнд Улсын Их Хурлын хянан шалгах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

2. Улсын Их Хурал Байнгын хороог үйл ажиллагааныхаа салбар; чиглэлээр байгуулах бөгөөд дараахь Байнгын хороотой байна:

1) Байгаль орчныг хамгаалах;
2) Боловсрол, шинжлэх ухаан, соёлын;
3) Гадаад бодлого, аюулгүй байдлын;
4) Дотоод асуудлын;
5) Төсөв, санхүү, мөнгө, зээлийн бодлогын;
6) Хурал, захиргааны;
7) Хууль зүйн;
8) Хүн ам зүй, эрүүл мэнд, хөдөлмөр, нийгэм хангамжийн;
9) Хүнс, хөдөө аж ахуйн;
10) Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн бодлогын.

3. Байнгын хороо нь 12-оос доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Улсын Их Хурлын нэг гишүүн нэгэн зэрэг 3 хүртэл Байнгын хорооны гишүүнээр сонгогдон ажиллаж болно.

4. Байнгын хороог Улсын Их Хурлаас 1 жилийн хугацаатай сонгогдсон дарга толгойлно. Байнгын хорооны даргыг улируулан сонгож болно.

5. Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл Байнгын хорооны дотор дэд хороо байгуулж болно. Дэд хороо нь харьяалах Байнгын хорооныхоо үйл ажиллагааны тодорхой чиглэлийг эрхлэн хариуцаж, туслах үүрэгтэй.

Дэд хороо нь эрх хэмжээнийхээ хүрээнд хамаарах асуудлыг зөвхөн Байнгын хороондоо хэлэлцүүлэхээр оруулах эрхтэй бөгөөд Улсын Их Хуралд тухайн асуудлыг уул Байнгын хорооогоор уламжлан оруулна.

14 дүгээр зүйл. Байнгын хорооны үндсэн бүрэн эрх

1. Байнгын хороо тус тусын эрхлэх асуудлаар дараахь үндсэн бүрэн эрхтэй:

1) Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн болон бусад шийдвэрийн төсөл, эрх бүхий байгууллагаас чуулганд хэлэлцүүлэхээр оруулж буй аливаа асуудлаар санал, дүгнэлт гаргах;

2) Улсын Их Хуралд санал дүгнэлт оруулах, илтгэл, хавсралт илтгэл тавих;

3) хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг шаардлага хангаагүй гэж үзвэл чуулганы хуралдаанд оруулахгүйгээр зохих үндэслэлээ зааж, гүйцээн боловсруулахаар буцаах;

4) Улсын Их Хурлын даалгаснаар, эсхүл өөрийн санаачилгаар Засгийн газарт санал оруулах, хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр биелүүлэх талаар шаардлага тавих;

5) Улсын Их Хуралд ажлаа шууд харицуцан тайлагнадаг байгууллагын үйл ажиллагааг хянан шалгах;

6) Засгийн газар, түүний гишүүн, Улсын Их Хурлаас байгууллага бусад байгууллагын эрх баригчдын мэдээлэл сонсож хэлэлцэх, тэдэнд асуулт, асуулга тавьж, харицулт авах;

7) Улсын Их Хурлаар хэлэлцэх асуудлаар болон хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийн талаар судалгаа, тайлан мэдээ, дүгнэлт зэрэг баримт сэлтийг холбогдох байгууллага, албан тушаалтнаас гаргуулан авах, тэдний мэдээллийг сонсох;

8) Улсын Их Хурлын хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлэх, хуулийн төслийн талаар дүгнэлт гаргахад туслалцаа авах зорилгоор мэргэжлийн олон нийтийн санал авах, шинжээч, мэргэжилтнээс бүрдсэн ажлын хэсэг байгуулж ажиллуулах.

2. Байнгын хорооны чиг үүрэг, тодорхой бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг Улсын Их Хурал тогтооно.

15 дугаар зүйл. Байнгын хорооны ажлын зохион байгуулалт

1. Байнгын хорооны ажлын зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хуралдаан мөн.

2. Байнгын хороо эрх хэмжээнийхээ асуудлыг хуралдаанаар хэлэлцэж оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Хуралдааныг Байнгын хорооны нийт гишүүний дийлэнх олонхи нь хүрэлцэн ирснээр хүчин төгөлдөрт тооцно.

3. Байнгын хорооны дарга хорооныхоо өдөр тутмын ажлыг удирдаж, хуралдаан даргална. Түүний эзгүйд Байнгын хорооны даргын саналыг харгалзан Улсын Их Хурлын даргын захирамжаар томилсон нэг гишүүн үүргийг нь орлон гүйцэтгэнэ.

4. Байнгын хороо шийдвэрлэсэн асуудлаараа дүгнэлт, тогтоол гаргана. Хуралдааныхаа явцыг протоколд нэг бүрчлэн тэмдэглэнэ.

16 дугаар зүйл. Улсын Их Хурлын бусад хороо, ажлын хэсэг

1. Улсын Их Хурал хууль тогтоох, хянан шалгах чиг үүргээ хэрэгжүүлэхдээ шаардлагатай асуудлаар түр хороо байгуулан ажиллуулж болно. Түр хороо зөвхөн Улсын Их Хурлын гишүүнээс бүрэлдэх бөгөөд түүний тоог тухайн үед тогтоож, түр хороо нь эрхлэх асуудлаараа Байнгын хороотой адил бүрэн эрх эдэлнэ.

Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл холимог болон дагнасан бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно.

2. Түр хороо, ажлын хэсгийн үйл ажиллагааны журмыг Улсын Их Хурал тогтооно.

17 дугаар зүйл. Улсын Их Хурал дахь нам (эвсэл)-ын бүлэг

1. Улсын Их Хуралд 8-аас доошгүй суудал бүхий нам бүлэг (цаашид «намын бүлэг» гэх) байгуулж болно. Улсын Их Хурлын гишүүн зөвхөн өөрийнх нь нэр дэвшүүлсэн намын бүлэгт харьяалагдана.

Улсын Их Хурлын сонгуульд эвсэл байгуулан оролцсон намууд Улсын Их Хуралд 8-аас доошгүй суудал эзэлсэн нөхцөлд Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн хуулийн 19 дүгээр зүйлийн 2-т зааснаар Улсын Их Хуралд нам (эвсэл)-ын нэг бүлэгтэй байна.

Бие даан ᵻэр дэвшүүлж сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд аль нэг намын бүлэгт нэгдэн ажиллаж болох боловч дангаараа бүлэг байгуулж болохгүй. Улсын Их Хуралд 8 хүрэхгүй суудал бүхий хэд хэдэн намын гишүүд нийлж намын нэг бүлэг байгуулахыг хориглоно. Харин тэдгээр нь аль нэг намын бүлэгт эвсэн нэгдэж болно.

2. Намын бүлгийн ахлагч Улсын Их Хурлын анхдугаар чуулган дээр Улсын Их Хурлын даргыг сонгосноос хойш 24 цагийн дотор намын бүлэг байгуулсан тухай шийдвэр, гишүүдийн нэрсийн жагсаалтыг Улсын Их Хурлын даргад өргөн барина.

Улсын Их Хурлын дарга намын бүлгээс өргөн барьсан баримт бичгийг үндэслэн намын бүлгийг бүртгэж энэ тухай Улсын Их Хурлын чуулганы хуралдаан дээр албан ёсоор зарлана.

3. Аль нэг нам тарах буюу намууд эвслээ цуцалбал Улсын Их Хурал дахь тухайн намын бүлгийн үйл ажиллагаа дуусгавар болсонд тооцно.

4. Улсын Их Хурал дахь намын бүлэг орон тооны ажилтантай байж болно. Намын бүлэг тухайн бүлгийн 2 гишүүнд нэг ажилтан байхаар тооцсон орон тооны ажилтантай байж болно. Намын бүлгийн гишүүдийн тоог харгалзан унаа, албан томилолт, бичиг хэргийн зардал, ажилтны цалингийн санг Улсын Их Хурлын төсөвт тусгана. Намын бүлэг батлагдсан төсвөө Улсын Их Хурлаас баталсан журмын дагуу зарцуулна.

Төсвийн зарцуулалтад Дотоод асуудлын байнгын хороо хяналт тавина.

Намын бүлгийг ажиллах нөхцөлөөр хангах асуудлыг Тамгын газар хариуцна.

Аль ч намын бүлэгт харьяалагдаагүй Улсын Их Хурлын гишүүнд Тамгын газрын холбогдох ажилтан туслалцаа үзүүлнэ.

5. Намын бүлэг Улсын Их Хурлын бүтцийн хэсгийн хувьд эрхлэх ажлаа намынхаа төв байгууллагын удирдлагад шууд хариуцахгүй.

18 дугаар зүйл. Намын бүлгийн эрх, үүрэг

1. Улсын Их Хурал дахь намын бүлэг дараахь эрх, үүрэгтэй:

1) Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцэж байгаа хуулийн болон Улсын Их Хурлын бусад шийдвэрийн

төслийн үндэслэл, бодлогын талаар тус тусын санал, дүгнэлт гаргах;

2) чуулганы хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах санал гаргах;

3) Улсын Их хурлын чуулганы хуралдааны үед завсарлага авах;

4) Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг чанд сахих;

5) чуулган, Байнгын хорооны үйл ажиллагаанд өөрийн бүлгийн гишүүдийг татан оролцуулах;

6) бүлгийн төсвийн гүйцэтгэлийг үнэн зөв мэдээлэх;

7) Байнгын хорооны бүрэлдэхүүний талаар Улсын Их Хурлын даргатай зөвшилцөх;

8) Улсын Их Хурлын зохион байгуулалтын үйл ажиллагаатай холбогдсон саналаа Улсын Их Хурал, Байнгын хороонд оруулах.

2. Улсын Их Хурал дахь намын бүлгийн бусад эрх, үүргийг Улсын Их Хурал тогтоож болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Улсын Их Хурлын гишүүн, түүний бүрэн эрх

19 дүгээр зүйл. Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн хугацаа

1. Үндсэн хуулийн хорин гуравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх, Төрийн сүлдэндээ тангараг өргөснөөр эхэлж Улсын Их Хурлын дараагийн сонгуулиар шинэ сонгогдсон гишүүн тангараг өргөснөөр дуусгавар болно.

2. Улсын Их Хурлын гишүүнийг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч, Улсын ерөнхий прокурор, түүний орлогч Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилохыг хориглоно.

3. Үндсэн хуулийн хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлж болно.

4. Дараахь тохиолдолд Улсын Их Хурлын гишүүнийг чөлөөлөх буюу эгүүлэн татна:

1) Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон;

2) биеийн эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсноос чөлөөлж өгөхийг хүсэж өргөдөл гаргасан.

5. Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон тохиолдолд Улсын Их Хурал түүнийг гишүүнээс эгүүлэн татах шийдвэр гаргана.

20 дугаар зүйл. Улсын Их Хурлын гишүүний үндсэн эрх, үүрэг

1. Улсын Их Хурлын гишүүн үйл ажиллагаагаа Улсын Их Хурлын өмнө хариуцна.

2. Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ дараахь үндсэн эрх, үүрэгтэй:

1) хууль санаачлах, тодорхой асуудал хэлэлцүүлэхээр санал оруулах;

2) асуудал хэлэлцэн шийдвэрлэхэд таслах эрхтэй оролцох;

3) Байнгын хороо болон бусад хороо, Улсын Их Хурлын бусад байгууллагыг сонгох, тэдгээрт сонгогдох;

4) чуулганы хэлэлцэж байгаа асуудлын талаар илтгэгчээс асуух, хариулт авах, санал, шүүмжлэл гаргах, дүгнэлт хийх;

5) Улсын Их Хурлаас байгуулсан байгууллагын бүтэц, бүрэлдэхүүн, мөн сонгох, томилох албан тушаалтны талаар санал гаргах, дүгнэлт хийх;

6) Улсын Их Хурлаас сонгосон, томилсон албан тушаалтны илтгэл, сонсгол хэлэлцэх тухай болон тэдэнд үл итгэхээ илэрхийлж эгүүлэн татах, огцруулах тухай санал оруулах;

7) Байнгын хороонд заавал харьяалагдах;

8) Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан, харьяалагдах байнгын болон бусад хороодын дагнасан, хамтарсан хуралдаанд тогтмол оролцож, олонхнор шийдвэрлэсэн асуудлыг хүндэтгэн сахих;

9) сонгогчидтойгоо тогтмол холбоотой ажиллаж, тэдний санаа бодлыг үйл ажиллагаандаа тусгах;

10) төрийн зүтгэлтний ёс зүйн хэм хэмжээг чанд сахих, төрийн нууц хадгалах, нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтлах.

3. Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ асуудлаар аль ч байгууллагад чөлөөтэй нэвтэрч, хэнтэй ч хүлээгдэлгүй уулзах, тухайн албан тушаалтанд асуулт, асуулга тавих, хариуг нь 30 хоногийн дотор амаар буюу бичгээр авах эрхтэй. Шаардлагатай гэж үзвэл өөрийн тавьсан асуудлын хариуг

Улсын Их Хурлын чуулганы хуралдаан, Байнгын хорооны дагнасан болон хамтарсан хуралдаанд сонордуулж болно. Улсын Их Хурлын гишүүний тавьсан асуулт, асуулгын талаар гарсан маргааныг Улсын Их Хурал эцэслэн шийдвэрлэнэ.

4. Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд Үндсэн хууль, энэ хууль, бусад хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах цалинтай ажил, албан тушаал хавсарч болохгүй.

5. Улсын Их Хурлын гишүүн хуулийн этгээдийн эрх бүхий аж ахуйн нэгж, тэдгээрийн нэгтгэлийн үйл ажиллагаа эрхэлдэг бол уг ажлаа өөрийнхөө итгэмжлэгдсэн хүнээр хөтлүүлэх бөгөөд эрхэлдэг аж ахуй болон өмч эзэмшилтэй нь холбоотойгоор орж ирсэн орлогыг жил бүр, дотоод, гадаадын хөндлөнгийн этгээдээс албан үйл ажиллагаатай нь холбогдуулан өөрт нь өгсөн 5000 төгрөгөөс дээш үнэтэй бэлгийн талаар тухай бүр Дотоод асуудлын байнгын хороонд тус тус мэдэгдэх үүрэгтэй.

21 дүгээр зүйл. Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн баталгаа

1. Улсын Их Хурлын гишүүнийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь төрийн байгууллага, тэдгээрийн албан тушаалтан бүх талын туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

2. Улсын Их Хурлын гишүүнийг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилсан бол энэ тухай Улсын Их Хурлын даргад 24 цагийн дотор мэдэгдэнэ. Үүнээс бусад тохиолдолд Улсын Их хурлын зөвшөөрөлгүйгээр Улсын Их Хурлын гишүүнийг цагдан хорих, түүнд шүүхийн журмаар захиргааны шийтгэл оногдуулах, гэр, албан тасалгаа, биед нь нэгжлэг хийхийг хориглоно.

3. Бусдыг доромжилсон, гүтгэснээс бусад тохиолдолд Улсын Их Хурлын гишүүн чуулган дээр хэлсэн үг, дэвшүүлсэн саналынхаа төлөө бүрэн эрхийнхээ хугацаанд болон түүний дараа хуулийн хариуцлага хүлээхгүй.

4. Улсын Их Хурлын гишүүн гадаадад зорчих, байх хугацаандаа дипломат эрх ямба, дархан эрх эдэлнэ.

5. Улсын Их Хурлын гишүүн Тамгын газарт харьяалагдах өөрийн орон тооны ажилтантай байж болно. Ажилтны цалингийн сан, бичиг хэргийн зардлыг Улсын Их Хурлын төсөвт тусгана.

6. Улсын Их Хурлын гишүүн төрийн өндөр албан тушаалтны зэрэг дэвд тохирсон цалин авна. Улсын Их Хурлын гишүүний унаа, албан томилолт, бичиг хэргийн зардлыг Улсын Их Хурлын төсөвт гишүүн нэг бүрээр тооцож тусгах бөгөөд батлагдсан төсвөө Улсын Их Хурлаас баталсан журмын дагуу зөвхөн тухайн гишүүн мэдэж зарцуулна. Улсын Их Хурлын гишүүний төсвийн зарцуулалтад дотоод асуудлын байнгын хороо хяналт тавина. Улсын Их Хурлын гишүүний цалин, бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай бусад хангамжийг Улсын Их хурал тогтооно.

7. Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд үнэмлэх, энгэрийн тэмдэг, албаны хэвлэмэл хуудас, нэрийн хуудас хэрэглэнэ. Тэдгээрийн загвар, хэрэглэх журмыг Улсын Их Хурлын дарга захирамжаараа батална.

8. Улсын Их Хурлын гишүүний харилцуур утас болон бусад холбооны хэрэгсэл улсын хамгаалалтад байх бөгөөд бүрэн эрхээ хэрэгжүүлэх, үйл ажиллагаагаа явуулахтай холбогдсон захидал харилцааны нууцыг задруулахыг хориглоно.

9. Улсын Их Хурлын гишүүний албан тушаалд ажилласан хугацааг мэргэжлээрээ ажилласан хугацаанд оруулан тооцно.

10. Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон, энэ хуулийн 6 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 2-т заасан тохиолдолд түүнийг төрийн сонгуульт ажилд сонгогдохоос өмнөх ажилд нь эгүүлэн ажиллуулах буюу тухайн ажил байхгүй бол ажил эрхлэх хүртэлх 6 сарын хугацаанд Улсын Их Хурлын гишүүн байсан үеийн авч байсан цалингийн хэмжээнээс буурахаргүй тэтгэмж, хэрэв бага цалинтай ажил эрхэлж байгаа бол цалингийн зөрүүтэй тэнцэх хэмжээний тэтгэмж мөн хугацаанд олгоно. Хэрэв Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдохоос өмнө оршин сууж байсан газраа шилжвэл өөрийнх нь болон гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүний замын зардал, ачаа тээшийн хөлсийг авто хөсгийн тарифаар тооцож олгоно.

22 дугаар зүйл. Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүнээр томилогдох

1. Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүнээр томилогдвол гишүүнийхээ бүрэн эрхийг хэвээр хадгална. Засгийн газрын бүрэлдэхүүнд байх Улсын Их Хурлын гишүүдийн тоо Засгийн газрын нийт гишүүний гуравны нэгээс хэтэрч болохгүй.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурлын Байнгын болон бусад хорооны даргаар сонгогдож болохгүй бөгөөд Засгийн газарт итгэл хүлээлгэх, түүнийг огцруулах, өөрийг нь Засгийн газрын гишүүнээр томилох зэрэг өөртэй нь шууд холбогдсон асуудлаар санал хураахад таслах эрх эдлэхгүй.

3. Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын бүрэлдэхүүнд орвол энэ хоёр албан тушаалын цалин, хангамжийн аль нэгийг нь сонгох эрхтэй. Түүний ажлын цагийг зохицуулах журмыг Улсын Их Хурлын дарга Ерөнхий сайдтай зөвшилцөн захирамжаараа тогтооно.

ТАВДУГААР БҮЛЭГ

Улсын Их Хурлын дарга, дэд дарга тэдний чиг үүрэг

23 дугаар зүйл. Улсын Их Хурлын дарга, дэд даргыг сонгох

1. Улсын Их Хурлын дарга, дэд даргын сонгуулийг тус тусад нь тэгэхдээ даргын сонгуулийг эхэлж явуулна.

2. Улсын Их Хуралд хамгийн олон суудал авсан нам буюу эвсэл Улсын Их Хурлын даргын сонгуульд эхэлж нэр дэвшүүлэх эрхтэй.

3. Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурлын дарга, дэд даргад өөрийн болон бусад гишүүний нэрийг дэвшүүлж болно.

4. Улсын Их Хурлын даргын сонгуульд зөвхөн нэг хүний нэр дэвшсэн бол нууц санал хураалт явуулж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар түүнийг Улсын Их Хурлын даргаар сонгогдсонд тооцно. Улсын Их Хурлын даргад хоёр түүнээс дээш хүний нэр дэвшсэн бол нууц санал хураалт явуулж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн санал авсан хүнийг Улсын Их Хурлын даргаар сонгогдсонд тооцно. Хоёр нэр дэвшигчийн талаар санал тэнцсэн буюу тэдгээрийн хэн нь ч олонхийн санал аваагүй бол санал тэнцсэн хоёр гишүүний буюу хамгийн олон санал авсан 2 гишүүний талаар дахин нууц санал хураалт явуулна. Гурав дахь удаа санал хураахад хүрвэл энэ зүйлд заасан журмаар дахин нэр дэвшүүлнэ. Улсын Их Хурлын гишүүн санал хураалтад оролцохдоо зөвхөн нэг хүний төлөө санал өгнө. Улсын Их

Хурлын даргад нэр дэвшсэн Улсын Их Хурлын гишүүн санал хураалтад оролцохгүй.

5. Улсын Их Хурлын дэд даргын сонгуулийг явуулахад энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан журмыг баримтална.

24 дүгээр зүйл. Улсын Их Хурлын даргын чиг үүрэг

1. Улсын Их Хурлын дарга нь Улсын Их Хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэх ажлыг бүхэлд нь уялдуулан зохицуулж, дараахь ажлыг биечлэн эрхэлнэ:

1) Улсын Их Хурлын ээлжит болон ээлжит бус чуулган зарлаж, бэлтгэлийг хангах;

2) чуулганаар хэлэлцэх асуудлын дараалал тогтоох;

3) чуулганы хуралдаан даргалж хуулийн төсөл, бусад асуудал хэлэлцүүлэх;

4) Бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь Улсын Их Хурлын гишүүдэд туслах;

5) Улсын Их Хурлаас Засгийн газрын үйл ажиллагааг хянан шалгах ажлыг зохион байгуулах;

6) Улсын Их Хурлын үйл ажиллагаанд Үндсэн хууль, бусад хуулийг сахин биелүүлэх ажлыг зохион байгуулах;

7) Улсын Их Хурлын гадаад харилцаа.

2. Улсын Их Хурлын дарга дотоод, гадаад харилцаанд Улсын Их хурлыг бүрэн эрхтэйгээр төлөөлнө.

3. Улсын Их Хурлын дарга улсын хамгаалалтад байна. Улсын Их Хурлын даргын орон сууц, унааны зардлыг улс харнуцах бөгөөд түүний бие, өргөө, унаа халдашгүй дархан байна.

4. Улсын Их Хурлын дарга хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэгтэй.

25 дугаар зүйл. Улсын Их Хурлын дэд даргын чиг үүрэг

Улсын Их Хурлын дэд дарга дараахь ажлыг биечлэн эрхэлнэ:

1) Улсын Их Хурлын даргын эзгүйд түүний үүргийг гүйцэтгэх;

2) Улсын Их Хурлын хороод, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

3 Улсын Их Хурал, түүний даргаас даалгасан бусад ажил эрхлэх.

26 дугаар зүйл. Улсын Их Хурлын даргын шийдвэр

Улсын Их Хурлын дарга эрх хэмжээнийхээ асуудлаар хууль тогтоомжид нийцүүлэн захирамж гаргана.

27 дугаар зүйл. Улсын Их Хурлын дарга, дэд даргыг үүрэгт ажлаас чөлөөлөх, огцруулах

1. Улсын Их Хурлын дарга, дэд дарга биеийн эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсноос үүрэгт ажлаас чөлөөлж өгөхийг хүсэж Улсын Их Хуралд өргөдөл гаргавал Улсын Их Хурал чуулганы хуралдаанаар уг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

2. Улсын Их Хурлын дарга, дэд дарга гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай болохыг шүүх тогтоосон, түүнчлэн үүрэгт ажилдаа харшлах ноцтой бусад зөрчил гаргасан тохиолдолд бүрэн эрхийнх нь хугацаа дуусахаас өмнө тухайн албан тушаалаас огцруулах тухай Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Улсын Их Хурлын чуулганы хуралдаан

28 дугаар зүйл. Чуулганы хуралдааны нийтлэг журам

1. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны (цаашид «хуралдаан» гэх) ажиллагаа хууль дээдлэх, дэгээ чанд сахих, асуудлыг чөлөөтэй хэлэлцэж, цөөнхийн санаа бодлыг хүндэтгэн олонхийн саналаар шийдвэрлэх зарчимд үндэслэнэ.

2. Хэлэлцэх асуудлын шинж байдлыг харгалзан хуралдааныг нээлттэй буюу хаалттай явуулна.

Улсын нууцын жагсаалтад хамаарах асуудлыг хаалттай хуралдаанаар хэлэлцэнэ. Хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар энэ жагсаалтад ороогүй асуудлыг хаалттай хуралдаанаар хэлэлцэж болно.

Хаалттай хуралдаанд Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга (цаашид «Ерөнхий нарийн бичгийн дарга» гэх), түүний орлогч, Тамгын газрын хэвлэл, мэдээллийн албаны итгэмжлэгдсэн төлөөлөгч, тухайн асуудлыг боловсруулахад оролцсон ажлын хэсгийн гишүүдээс бусад хүн байлцах зөвшөөрлийг Ерөнхий нарийн бичгийн дарга олгоно.

Ерөнхийлөгч, Ерөнхий сайдаас бусад Улсын Их Хурлын чуулганд зөвлөх эрхтэй оролцож болох албан тушаалтныг

хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар хаалттай хуралдаанд байлцуулна.

Хаалттай хуралдааны талаар зөвхөн нууцын дэвтэрт тэмдэглэл хийнэ.

Хаалттай хуралдааны нууц алдагдахгүй байх нөхцөлийг хангах асуудлыг Улсын Их Хурлын Тамгын газар хариуцна.

Хаалттай хуралдааны талаар энэ хуулийн 53 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу нийтэд мэдээлж болно.

3. Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Ерөнхий прокурор, Үндсэн хуулийн Цэцийн дарга чуулганд зөвлөх эрхтэй оролцож болно.

4. Улсын Их Хурлаас байгууллаг бусад байгууллагын эрх баригчид, хэлэлцэж байгаа асуудал эрхэлсэн ажлын хэсгийн гишүүд, Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтан нээлттэй хуралдаанд байлцах эрхтэй.

5. Улсын Их Хурлын даргын урилгаар хуралдаанд бусад хүмүүсийг байлцуулж болно.

6. Энэ зүйлийн 4, 5 дахь хэсэгт дурдсан хүмүүс зөвхөн чуулганы хуралдаан даргалагчийн зөвшөөрснөөр үг хэлж болно.

7. Улсын Их Хурлын нээлттэй хуралдаанд иргэд, дотоод, гадаадын хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан зохих журмын дагуу байлцаж болно. Энэ журмыг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга тогтооно.

8. Улсын Их Хурлын хуралдааны явц, шийдвэрийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.

29 дүгээр зүйл. Хуралдаанаар хэлэлцэх асуудал

1. Улсын Их Хурлын хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Байнгын хороо урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.

Зохих Байнгын хороо урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гаргаагүй асуудлыг Улсын Их Хурлын хуралдаанд оруулж болохгүй.

2. Байнгын хороо, намын бүлэг, Улсын Их Хурлын гишүүн хуралдаанд шинээр асуудал хэлэлцүүлэх тухай саналаа Улсын Их Хурлын даргад бичгээр буюу амаар гаргаж болно.

30 дугаар зүйл. Хуралдаан даргалагчийн эрх, үүрэг

1. Хуралдаан даргалагч дараахь эрх, үүрэгтэй:

1) энэ хууль болон хуралдааны дэгийн биелэлтэд хяналт тавьж, гишүүдээс түүнийг биелүүлэхийг шаардах;

2) илтгэл сонсох, санал дүгнэлт гаргах, санал хураах цагийг тогтоож зарлах;

3) саналаа ирүүлсэн дарааллыг баримтлан гишүүдэд үг хэлэх зөвшөөрөл олгох;

4) хэлэлцсэн асуудлаар санал хураалт явуулж, дүнг мэдээлж, эцсийн шийдвэрийг сонсгон батлуулах;

5) чуулганы баримт бичгийг цаг тухайд нь гаргах ажлыг зохион байгуулах;

6) хуралдааны дэг, дотоод журам зөрчигчдөд энэ хуулийн 32 дугаар зүйлд заасан арга хэмжээ авах.

2. Хуралдаан даргалагч энэ хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар чуулганы хуралдаанд хүрэлцэн ирсэн гишүүдэд танхимаас гарах зөвшөөрөл олгоно.

3. Улсын Их Хурал хуралдаан даргалагчид нэмэлт эрх олгож болно.

31 дүгээр зүйл. Улсын Их Хурлын хуралдааны дэг

1. Улсын Их Хурлын өглөөний хуралдааныг 9.00 цагаас 13.00 цаг хүртэл, оройн хуралдааныг 15.00 цагаас 17.00 цаг хүртэл 2 цаг тутам 20 минутын завсарлагатай явуулна. Улсын Их Хурлын гишүүд хуралдаан даргалагч танхимд орж ирэхээс өмнө суудлаа эзэлсэн байна.

Тодорхой асуудал хэлэлцэх явцад шаардлагатай бол гишүүдийн олонхийн саналаар хуралдааныг түр завсарлах буюу хугацааг нь сунгаж болно.

Улсын Их Хурлын гишүүн Байнгын болон бусад хороо, ажлын хэсэг, намын бүлэгт ажиллах, хэлэлцэх асуудлын төсөл, холбогдох ажил хэргийн материалтай танилцах, сонгогчидтойгоо уулзах боломж олгох зорилгоор долоо хоногийн Лхагва, Бямба гаригт чуулганы хуралдаан хийхгүй.

Улсын Их Хурал дахь аль нэг намын бүлэг, Байнгын хороо тодорхой асуудал хэлэлцэж санал, дүгнэлтээ бэлтгэх зайлшгүй шаардлагатай бол энэ тухай чуулганы хуралдаан дээр урьдчилан мэдэгдэж долоо хоногийн Баасан гаригт хуралдаж болно.

2. Улсын Их Хурал сар бүрийн 2, 4 дэх долоо хоногийн Пүрэв гаригийн 15.00 цагаас 16.00 цаг хүртэл Засгийн газарт асуулт тавьж, хариулт авах буюу өмнө тавьсан асуулгын харуг сонсоно. Засгийн газарт тавьсан асуулгынхаа талаар Улсын Их Хурлын гишүүн дангаараа болон бусад гишүүнтэй хамтран санал, дүгнэлт гаргаж болно. Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл уг асуудлаар шийдвэр гаргана.

3. Улсын Их Хурлын гишүүн чуулганы хуралдаанд оролцохдоо энэ хууль, хуралдааны дэгийг чанд сахих үүрэгтэй бөгөөд үг хэлэхдээ дараахь журам баримтална:

1) хуралдаан даргалагчаас зөвшөөрөл авна;

2) санал, дүгнэлт гаргах хугацаа 10 минутаас илүүгүй байх бөгөөд зарчмын өөр саналтай гишүүн эхний удаа 7, дахин нэг удаа 3 минутаас илүүгүй хугацаагаар үг хэлж болно;

3) үг хэлэх хугацааг бусдад шилжүүлэхгүй.

4. Улсын Их Хурлын аль нэг гишүүнээр үг хэлүүлэхийг гурав, түүнээс дээш гишүүн хүсвэл хуралдаан даргалагч тухайн гишүүнд үг хэлэх зөвшөөрөл олгоно. Энэ тохиолдолд гишүүн уг асуудлаар санал хураалгах эрхтэй.

5. Чуулганы хуралдаанаар хэлэлцэх тодорхой асуудлыг эрс эсэргүүцсэн шалтгаанаар Улсын Их Хурлын гишүүн, намын бүлэг тухайн асуудлыг хэлэлцэхэд оролцохгүй гэдгээ уг асуудлыг хэлэлцэж эхлэхээс өмнө хуралдаан даргалагчид албан ёсоор мэдэгдэж болно. Иймхүү чуулганы хуралдаанд оролцоогүй нь хуралдааны хүчин төгөлдөр байхад нөлөөлөхөөр байвал хэрхэхийг Улсын Их Хурлын дарга шийдвэрлэх бөгөөд шаардлагатай гэж үзвэл захирамж гаргаж болно.

32 дугаар зүйл. Чуулганы дэг зөрчигчид хүлээлгэх хариуцлага

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг зөрчсөн, хараалын үг хэлсэн, бусдыг доромжилсон, гүтгэсэн бол хуралдаан даргалагч дараахь хариуцлага хүлээлгэнэ:

1) урьдчилан сануулах;

2) тухайн өдрийн хуралдаан дээр урьдчилан сануулга авсан гишүүн дахин зөрчил гаргавал түүний үг хэлэх эрхийг хасах;

3) урьд үг хэлэх эрхээ хасуулсан гишүүн тухайн өдрийн хуралдаан дээр дахин зөрчил гаргавал урьдчилан сануулахгүйгээр чуулганы хуралдаанаас гаргана.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Тодорхой асуудал хэлэлцэж шийдвэрлэх

33 дугаар зүйл. Улсын Их Хурлын Байнгын хороо, бусад байгууллага байгуулах

1. Улсын Их Хурлын дарга Байнгын хорооны бүрэлдэ-

хүүний талаар намуудын бүлгийн ахлагч нартай зөвшилцсөнөөр Улсын Их Хурал өөрийн гишүүдээс сонгон Байнгын хороог байгуулна.

Тухайн Байнгын хороо гишүүдийнхээ дотроос байнгын хорооны даргад нэр дэвшүүлнэ.

Улсын Их Хурлын гишүүн Байнгын хорооны даргад өөр гишүүний буюу өөрийн нэрийг дэвшүүлэх эрхтэй. Хэрэв нэг албан тушаалд 3 буюу түүнээс дээш тооны хүний нэр дэвшвэл хүн тус бүр дээр саналыг нууцаар хурааж олонхийн санал авсан хүнийг Байнгын хорооны даргаар сонгогдсонд тооцно. Хэрэв нэр дэвшигчдийн хэн нь ч олонхийн санал аваагүй бол хамгийн олон санал авсан хоёр хүнийг үлдээж, дахин санал хураалт явуулна. Санал тэнцсэн тохиолдолд Улсын Их Хурлын даргын саналаар шийдвэрлэнэ. Хэн нь ч олонхийн санал аваагүй бол сонгуулийг эхнээс нь явуулна.

2. Санал нууцаар хураах тохиолдолд уг ажлыг зохион байгуулж, дүнг илтгэх үүрэг бүхий санал хураах комиссыг дарга, нарийн бичгийн даргыг оролцуулан 5 хүртэл гишүүний бүрэлдэхүүнтэйгээр сонгож байгуулна. Улсын Их Хурлаас тухайн санал хураалтаар зохих албан тушаалд сонгогдох буюу томилогдохоор нэр дэвшигчийг санал хураах комиссын бүрэлдэхүүнд оруулахгүй.

3. Улсын Их Хурлын бусад байгууллагыг байгуулахад дээрх журмыг баримтална.

34 дүгээр зүйл. Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх

1. Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн ерөнхий хорооны нэрийн өмнөөс түүний дарга Үндсэн хуулийн гучин нэгдүгээр зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар нийт сонгогчийн олонхийн санал авсан нэр дэвшигчийг Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж санал хураасан өдрөөс хойш 30 хоногийн дотор бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрөх тухай асуудлыг Улсын Их Хуралд тавина.

2. Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн ерөнхий хороо Ерөнхийлөгчийн сонгууль хуулийн дагуу явагдсан эсэхийг дүгнэж, санал хураалтын дүнгийн талаар Улсын Их Хуралд илтгэнэ. Уг илтгэлийг сонссоны дараа Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг сонсоно.

3. Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай хуулийг Улсын Их хурлын гишүүд олонхийн саналаар батална.

35 дугаар зүйл. Ерөнхийлөгчийг чөлөөлөх, огцруулах

1. Ерөнхийлөгч биеийн эрүүл мэнд, бусад хүндэтгэн үзэх шалтгаан нөхцөлийн улмаас Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлж чадахгүйгээ илэрхийлж Улсын Их Хуралд хүсэлт гаргасан бол Улсын Их хурал түүнийг чөлөөлөх эсэхийг хянан хэлэлцэж олонхийн саналаар шийдвэрлэнэ.

Ерөнхийлөгчийн хүсэлтийг хэлэлцэхдээ эхлээд түүний тайлбарыг сонсоно. Хэрэв энэ талаар Байнгын хороо, намын бүлгийн дүгнэлт байгаа бол тэдгээрийг Улсын Их Хуралд уншиж сонсгоно. Дараа нь Улсын Их Хурлын гишүүд асуулт, хариулт явуулж санал, дүгнэлтээ хэлнэ.

2. Ерөнхийлөгчийг огцруулах асуудлыг Үндсэн хуулийн гучин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндэслэл, журмын дагуу хэлэлцэж дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ. Улсын Их Хурал Ерөнхийлөгчийг огцруулах асуудлыг хэлэлцэхдээ дараахь шалтгаан нөхцөлийг заавал тогтоосон байна:

1) Үндсэн хуулийн жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4-т заасан үндэслэлээр Үндсэн хуулийн цэцийн гаргасан дүгнэлт үнэн зөв эсэх;

2) Ерөнхийлөгч тангаргаасаа няцаж, Үндсэн хууль зөрчсөн үндэслэл, шалтгааныг зөв тогтоосон эсэх;

3) Ерөнхийлөгч бүрэн эрхээ зөрчсөн хүрээ, нөхцөл байдлыг зөв тогтоосон эсэх.

36 дугаар зүйл. Ерөнхий сайдыг томилох

1. Ерөнхийлөгч Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасан журмаар нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилуулах тухай саналаа Улсын Их Хурлын даргыг сонгосноос хойш 14 хоногийн дотор Улсын Их Хуралд өргөн барина.

2. Ерөнхий сайдын албан тушаалд нэг хүний нэр дэвшүүлнэ. Нэр дэвшигчийг Ерөнхийлөгч танилцуулна. Улсын Их Хурлын гишүүд Ерөнхий сайдад нэр дэвшигчид асуулт тавьж, хариулт авсны дараа саналыг нууцаар хурааж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар Ерөнхий сайдыг томилсон тухай тогтоол гаргана.

3. Ерөнхий сайдад нэр дэвшигч олонхийн санал авч чадаагүй бол 14 хоногийн дотор дахин өөр хүний нэр дэвшүүлэхийг Ерөнхийлөгчид Улсын Их Хурал зөвлөнө. Дахин нэр дэвшүүлж томилох асуудлыг энэ зүйлд заасан журмаар гүйцэтгэнэ.

4. Ерөнхий сайдыг томилсон тухай Улсын Их хурлын тогтоол хүчин төгөлдөр болсноор Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа эхэлж шинэ Ерөнхий сайдыг томилсноор дуусгавар болно.

37 дугаар зүйл. Засгийн газрын гишүүдийг томилох

1. Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6, гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар Улсын Их Хурал Ерөнхий сайдын санал болгосноор Засгийн газрын гишүүдийг томилж Засгийн газрыг эмхлэн байгуулна. Ерөнхий сайд Ерөнхийлөгчтэй зөвшилцөж Засгийн газрын гишүүнд нэр дэвшүүлсэн хүн бүрийг Улсын Их Хурлын зохих Байнгын хороогоор урьдчилан хэлэлцүүлэх бөгөөд Байнгын хорооны санал дүгнэлт гарсны дараа Улсын Их Хурал чуулганаараа хэлэлцэнэ.

2. Улсын Их Хурал Засгийн газрын гишүүнд Ерөнхий сайдын нэр дэвшүүлсэн хүн бүрийг тусад нь хэлэлцэнэ. Улсын Их Хурлын гишүүд нэр дэвшигчид асуулт тавьж, хариулт авсны дараа санал, дүгнэлтээ гаргана. Нэр дэвшигчийг Засгийн газрын гишүүнээр томилох талаар нууц санал хураалтыг хүн бүрээр явуулна. Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн санал авсан хүнийг Засгийн газрын гишүүнээр томилогдсонд тооцно.

3. Нэр дэвшигч нь чуулганд оролцсон гишүүдийн олонхийн санал авч чадаагүй тохиолдолд Ерөнхий сайд энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан журмын дагуу 14 хоногийн дотор тухайн тушаалд өөр хүний нэр дэвшүүлж Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

38 дугаар зүйл. Засгийн газрыг огцруулах тухай Улсын Их Хурлын санаачилга

1. Үндсэн хуулийн дөчин гуравдугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь Засгийн газрыг огцруулахыг хүсэж гарын үсэг зурсан саналаа Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлснээс хойш хорин дөрвөөс доошгүй цагийн / дараа, гэхдээ 15 хоногийн дотор Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцэнэ. Ийнхүү хэлэлцэхдээ Засгийн газрыг огцруулах болсон үндэслэл бүхий санал, Байнгын хороодын дүгнэлт, намын бүлгийн саналыг сонсоно. Уг асуудлаар Ерөнхийлөгч, Ерөнхий сайдын санал, хэрэв Үндсэн хуулийн жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4-т заасан үндэслэл байна гэж үзвэл Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг заавал

сонсоно. Дараа нь Улсын Их Хурлын гишүүн Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд болон Засгийн газрыг огцруулахыг санаачлагч гишүүдэд асуулт тавьж, харилцаа авна. Улсын Их Хурлын даргын саналаар асуулт хариултыг тасалсны дараа санал, шүүмжлэл явуулна. Санал, шүүмжлэл тасалсны дараа Ерөнхийлөгч, Ерөнхий сайд үг хэлж болно.

2. Засгийн газрыг огцруулах асуудлыг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Улсын Их Хурлын гишүүд саналаа нууцаар гаргана.

3. Улсын Их Хурлаас Засгийн газрыг огцруулах гэж шийдвэрлэсэн бол нийхүү шийдвэрлэснээс хойш 6 сарын дотор энэ асуудлыг Улсын Их Хурал дахин авч хэлэлцэхгүй.

4. Улсын Их Хурал Засгийн газрыг огцруулахаар шийдвэрлэсэн тохиолдолд шийдвэр гаргасан өдрөөс хойш 30 хоногийн дотор шинэ Ерөнхий сайдыг томилох үүрэгтэй.

39 дүгээр зүйл. Засгийн газрыг огцруулах тухай Ерөнхийлөгчийн санал

Засгийн газрыг огцруулах тухай Ерөнхийлөгчийн саналыг энэ хуулийн 38 дугаар зүйлд заасан журмаар Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэнэ.

40 дүгээр зүйл. Засгийн газар огцрох тухайгаа өргөн мэдүүлэх

Үндсэн хуулийн дөчин гуравдугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт зааснаар Ерөнхий сайд, эсхүл Засгийн газрын гишүүдийн тэн хагас нь огцрох тухайгаа Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бол Улсын Их Хурал уг асуудлыг энэ хуулийн 38 дугаар зүйлд заасан журмаар хэлэлцэн шийдвэрлэнэ. Гэхдээ Ерөнхий сайдын санал, дүгнэлтийг эхний ээлжинд сонсоно.

41 дүгээр зүйл. Улсын Их Хурал, Засгийн газарт итгэл хүлээлгэх эсэхээ илэрхийлэх

Үндсэн хуулийн дөчин дөрөвдүгээр зүйлд заасны дагуу өөрт нь итгэл хүлээлгэж байгаа эсэхээ илэрхийлж өгөхийг хүсч Засгийн газар холбогдох тогтоолын төсөл Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бол уг асуудлыг Улсын Их Хурал хэлэлцэж олонхийн саналаар шийдвэрлэнэ. Улсын Их Хурлын гишүүд саналаа илээр гаргана.

2. Улсын Их Хурал Засгийн газарт итгэл хүлээлгэхгүй байгаа тухай шийдвэр гаргавал Засгийн газар огцорно. Гэхдээ Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэс-

гийн 2, дөчдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт, мөн энэ хуулийн 36, 37 дугаар зүйлд заасан үндэслэл, журмаар шинэ Ерөнхий сайдыг томилох хүртэл тухайн Засгийн газар бүрэн эрхээ хэрэгжүүлнэ.

42 дугаар зүйл. Улсын Их Хуралд Улсын дээд шүүхийн шүүгчдийг танилцуулах

1. Үндсэн хуулийн тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар Шүүхийн ерөнхий зөвлөл Улсын дээд шүүхийн шүүгчдийг томилуулахаар Ерөнхийлөгчид санал болгохын өмнө нэр дэвшигч бүрийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд танилцулна.

2. Хууль зүйн байнгын хороо Шүүхийн ерөнхий зөвлөлөөс санал болгосон нэр дэвшигчийн талаар Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд мэдээлнэ. Улсын дээд шүүхийн шүүгчээр томилогдохоор нэр дэвшигчийн талаар Улсын Их Хурал ямар нэг шийдвэр гаргахгүй.

43 дугаар зүйл. Ерөнхий прокурор, түүний орлогчийг Ерөнхийлөгч томилохдоо Улсын Их Хуралтай зөвшилцөх

1. Үндсэн хуулийн тавин зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар Ерөнхий прокурор, түүний орлогчийг Ерөнхийлөгч томилохдоо Улсын Их Хуралтай зөвшилцөнө.

2. Ерөнхий прокурор, түүний орлогчоор томилогдохоор нэр дэвшсэн хүмүүсийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлтээ Улсын Их Хурлын чуулганы хуралдаанад танилцуулна.

3. Улсын Их Хурал Ерөнхийлөгчийн санал, Хууль зүйн байнгын хорооны дүгнэлттэй танилцаад Ерөнхий прокурор, түүний орлогчоор томилогдохоор нэр дэвшигчдийн талаар санал хураалт явуулж дүнг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.

4. Ерөнхийлөгчийн санал болгосон нэр дэвшигч хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн дэмжлэг авч чадаагүй тохиолдолд Ерөнхийлөгч дахин өөр санал оруулж болно.

44 дүгээр зүйл. Үндсэн хуулийн цэцийн гишүүдийг томилох, эгүүлэн татах

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн гуравдугаар зүйлд зааснаар Улсын Их Хурлын дарга Дотоод асуудлын байнгын хорооны санал, дүгнэлтийг үндэслэн Үндсэн хуулийн Цэцийн гишүүнд 3 хүний нэр дэвшүүлнэ.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан нэр дэвшигч болон Үндсэн хуулийн Цэцийн гишүүнд Ерөнхийлөгч, Улсын дээд шүүхээс санал болгосон нэр дэвшигчийг Хууль зүйн байнгын хороо урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлтээ Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд танилцуулна.

3. Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар Хууль зүйн байнгын хорооны дүгнэлт, Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн саналыг сонсож нэр дэвшигч тус бүрээр нууц санал хураалт явуулж, чуулганы хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн санал авсан хүнийг үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилогдсонд тооцно.

4. Үндсэн хуулийн жаран тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар Үндсэн хуулийн Цэцийн гишүүнийг эгүүлэн татах асуудлыг Улсын Их хурал хэлэлцэхдээ энэ талаар гарсан Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, анх нэр дэвшүүлсэн байгууллагын саналыг сонссоны дараа нууц санал хураалт явуулж чуулганы хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

45 дугаар зүйл. Гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг Ерөнхийлөгч томилох, эгүүлэн татахдаа Улсын Их хуралтай зөвшилцөх

1. Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5-д зааснаар Монгол Улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг Ерөнхийлөгч томилох, эгүүлэн татахдаа Улсын Их хуралтай зөвшилцөнө.

2. Гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилох, эгүүлэн татах асуудлыг Улсын Их Хурлын Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хороо урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлтээ Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд танилцуулна.

3. Улсын Их Хурал Ерөнхийлөгчийн санал, Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хорооны санал, дүгнэлттэй танилцаад бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилох, эгүүлэн татах асуудлаар нууц санал хураалт явуулж дүнг Ерөнхийлөгчид өргөн барина.

4. Гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилохтой холбогдож гарсан тухайн төлөөлөгчийн газрын байршилтай холбогдсон асуудлыг энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан журмаар шийдвэрлэнэ.

5. Ерөнхийлөгчийн санал болгосон нэр дэвшигч хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн санал авч чадаагүй тохиолдолд Ерөнхийлөгч дахин өөр санал оруулж болно.

45[1] дүгээр зүйл. Ерөнхийлөгчийн хоригийг хянан хэлэлцэх

1. Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасны дагуу Улсын Их Хурлын баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь Ерөнхийлөгчийн тавьсан хоригийн үндэслэлийг Ерөнхийлөгч, эсхүл Ерөнхийлөгчийн итгэмжилснээр түүний төлөөлөгч Улсын Их Хуралд танилцуулна.

2. Ерөнхийлөгчийн хоригийн талаар тухайн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хариуцаж байсан зохих Байнгын хороо, Хууль зүйн байнгын хорооны дүгнэлтийг сонсоно. Хэрэв эдгээр Байнгын хороо хоригийг хүлээн зөвшөөрсөн санал, дүгнэлт гаргасан бол тухайн хууль, Улсын Их Хурлын шийдвэрийг бүхэлд нь буюу түүний зарим хэсгийг хүчингүй болгох, эсхүл тэдгээрт зохих нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг Улсын Их Хурлын гишүүдэд урьдчилан тараасан байна.

Байнгын хороодын санал, дүгнэлтийг сонссоны дараа асуулт, хариулт явуулж, гишүүд санал гаргаж болно. Ийнхүү санал дүгнэлт гаргаж дууссаны дараа Ерөнхийлөгч тухайн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавьсныг үндэслэн уг хоригийг хүлээн зөвшөөрөх эсэх асуудлаар санал хураалт явуулна. Хэрэв Ерөнхийлөгч хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн зарим хэсэгт хориг тавьсан бол тухайн зүйл, заалт нэг бүрээр санал хураалт явуулна.

3. Улсын Их Хурал Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн зөвшөөрөөгүй бол энэ тухай тогтоол гаргана.

4. Улсын Их Хурал хоригийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд тухайн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг бүхэлд нь буюу түүний зарим хэсгийг хүчингүй болгож, эсхүл тэдгээрт зохих нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэж батална.

5. Тухайн хууль, бусад шийдвэрийг хүчин төгөлдөр дагаж мөрдөж эхлэх тусгайлан заасан хугацаа Ерөнхийлөгчийн хориг тавьсан хугацаатай давхцвал хоригийг хэрхэх тухай асуудлыг Улсын Их Хурал хянан хэлэлцэж дуусах хүртэл уг

хууль, бусад шийдвэр бүхэлдээ буюу түүний зарим хэсгийн үйлчлэл түр зогсоно.

6. Хоригт тусгагдсан асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн тухай хариуг уг шийдвэрийг баталснаас хойш 72 цагийн дотор Ерөнхийлөгчид илгээнэ.

45² дугаар зүйл. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хянан хэлэлцэх

1. Үндсэн хуулийн жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын шийдвэрийн талаар гаргасан Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг Үндсэн хуулийн Цэцийн дарга, эсхүл түүний итгэмжилснээр Үндсэн хуулийн Цэцийн аль нэг гишүүн Улсын Их Хуралд танилцуулна.

2. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг танилцуулсны дараа тухайн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг харьцаж байсан зохих Байнгын хороо, Хууль зүйн байнгын хороо дүгнэлт гаргана. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн талаар Улсын Их Хурлын гишүүд асуулт тавьж, хариулт авч, санал, дүгнэлт гаргаж болно.

3. Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөх эсэхийг чуулганы хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар шийдвэрлэнэ. Улсын Их Хурал Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг хянан хэлэлцээд уг дүгнэлтийг хууль зүйн үндэслэлгүй гэж үзсэн тохиолдолд энэ тухай тогтоол гаргана.

4. Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хянан хэлэлцээд уг дүгнэлт хууль зүйн үндэслэлтэй гэж үзсэн тохиолдолд тухайн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг бүхэлд нь буюу түүний зарим хэсгийг хүчингүй болгож, эсхүл тэдгээрт зохих нэмэлт, өөрчлөлт оруулна.

5. Үндсэн хуулийн жаран зургадугаар зүйлийн 3, 4 дэх хэсэгт заасан тохиолдолд Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн эцсийн шийдвэрийн дагуу авах арга хэмжээний талаарх асуудлыг хэлэлцэнэ.

45³ дугаар зүйл. Ерөнхийлөгч, Засгийн газар Монгол Улсын олон улсын гэрээний төслийг Улсын Их Хуралтай зөвшилцөх

1. Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-т заасны дагуу Ерөнхийлөгч Монгол Улсын нэрийн өмнөөс байгуулах олон улсын гэрээний, мөн хуулийн гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 9-д заасны дагуу Зас-

гийн газар дараа соёрхон батлуулах Монгол Улсын олон улсын гэрээний төслийг Улсын Их Хуралтай зөвшилцөнө.

2. Монгол Улсын олон улсын гэрээний төслийг нөгөө талтай зарчмын хувьд тохиролцсоны дараа, түүнд гарын үсэг зурахаас өмнө Улсын Их Хурлын Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хороо урьдчилан хэлэлцэнэ. Гэрээний төсөл, эсхүл түүний дэлгэрэнгүй танилцуулга, холбогдох бусад баримт бичгийг Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хороо урьдчилан хэлэлцэхээс гурваас доошгүй хоногийн өмнө Улсын Их Хурлын гишүүдэд тараасан байна.

3. Бусад Байнгын хороо, Улсын Их Хурлын гишүүн төслийн талаарх санал, дүгнэлтээ Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хороонд бичгээр ирүүлэх бөгөөд уг саналыг тус Байнгын хорооны хуралдаанд заавал танилцуулна. Байнгын хорооны хуралдаанаас төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар санал, дүгнэлт гарвал Засгийн газар гэрээний төслийг нөгөө талтай эцэслэн тохиролцохдоо тэдгээрийг тусгах чиглэлээр ажиллаж, дүнг Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хороонд танилцуулна.

4. Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хороо Монгол Улсын олон улсын гэрээний төслийг урьдчилан хэлэлцэж дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

1) гэрээний төслийг бүхэлд нь зөвшөөрөх;

2) гэрээг байгуулах шаардлагагүй гэж үзэж татгалзах.

5. Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хороо гэрээний төслийг бүхэлд нь зөвшөөрсөн, эсхүл уг гэрээг байгуулахаас татгалзсан тухай шийдвэр, түүнд холбогдох санал дүгнэлтээ шаардлагатай гэж үзвэл чуулганы хуралдаанд танилцуулна.

6. Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хороо гэрээг байгуулах шаардлагагүй гэж үзсэн тухай шийдвэр гаргасан тохиолдолд Ерөнхийлөгч, Засгийн газар уг асуудлыг чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж болно.

7. Хүчин төгөлдөр болоогүй байгаа олон улсын олон талт гэрээнд Ерөнхийлөгч Монгол Улсын нэрийн өмнөөс гарын үсэг зурахын өмнө уг асуудлыг Улсын Их Хуралтай зөвшилцөхөд энэ зүйлийг баримтална.

45[4] дүгээр зүйл. Гадаад улсыг хүлээн зөвшөөрөх, түүнтэй дипломат харилцаа тогтоох, цуцлах тухай асуудлыг хянан хэлэлцэх.

1. Гадаад улсыг хүлээн зөвшөөрөх тухай Засгийн газраас

өргөн мэдүүлсэн асуудлыг Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хороо урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлтээ чуулганы хуралдаанаар хэлэлцүүлнэ.

2. Гадаад улстай дипломат харилцаа шинээр буюу сэргээн тогтоох тухай Засгийн газраас өргөн мэдүүлсэн асуудлыг Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хороо урьдчилан хэлэлцэнэ. Байнгын хороо уг асуудлыг сайшаан зөвшөөрч тухайн улстай тодорхой тохиролцохыг Засгийн газарт үүрэг болгоно. Засгийн газар тухайн улстай тодорхой тохиролцсоны дараа уг асуудлыг Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хороо дахин хэлэлцэж санал, дүгнэлтээ чуулганы хуралдаанаар хэлэлцүүлнэ.

3. Гадаад улстай дипломат харилцаагаа цуцлах тухай Засгийн газраас өргөн мэдүүлсэн асуудлыг зохих Байнгын хороо урьдчилан хэлэлцэж, санал, дүгнэлтээ чуулганы хуралдаанаар хэлэлцүүлнэ.

НАЙМДУГААР БҮЛЭГ

Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл хянан хэлэлцэх, батлах

46 дугаар зүйл. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл өргөн мэдүүлэх

1. Хууль санаачлагч хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг (цаашид «төсөл» гэх) Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлнэ.

2. Өргөн мэдүүлсэн төслийг Улсын Их Хурлын дарга зохих Байнгын хороонд шилжүүлнэ.

47 дугаар зүйл. Төсөл хянан хэлэлцэх, батлах үе шат

1. Улсын Их Хурал төсөл хянан хэлэлцэх, батлах үйл ажиллагаагаа дараахь үе шаттай хийнэ:

1) Байнгын хорооны дагнасан болон хамтарсан хуралдаанаар төсөл хэлэлцэж санал, дүгнэлт гаргах;

2) Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар төслийн анхны хэлэлцүүлэг явуулах;

3) Анхны хэлэлцүүлгээр шийдвэрлэсэн асуудлыг тусгаж төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх;

4) төслийн эцсийн хэлэлцүүлэг явуулж батлах;

5) эцсийн хэлэлцүүлгээр шийдвэрлэсэн асуудлыг тусгаж төслийн эцсийн найруулгыг хянах;

6) Улсын Их Хурал эцсийн найруулгатай танилцах;

7) шийдвэрийг ёсчлох;

8) Ерөнхийлөгч Улсын Их Хурлын шийдвэрт хориг тавьсан бол тухайн асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх.

2. Төсөл хянан хэлэлцэх явцад Улсын Их Хурал, эсхүл түүний Байнгын хороо ажлын хэсэг байгуулж болно.

48 дугаар зүйл. Байнгын хороогоор төсөл урьдчилан хэлэлцэх

1. Төслийг зөвхөн зохих Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх бөгөөд уг хуралдаанд бусад Байнгын хороо, Улсын Их Хурлын гишүүн оролцож санал, дүгнэлт гаргаж болно. Зохих Байнгын хороо хуралдаан болох өдөр, цаг, газрыг хуралдаан болохоос гурваас доошгүй хоногийн өмнө бусад Байнгын хороо, Улсын Их Хурлын гишүүдэд мэдэгдэнэ. Төсөл хэлэлцэхэд биечлэн оролцох боломжгүй Улсын Их Хурлын гишүүн санал, дүгнэлтээ зохих Байнгын хороонд бичгээр урьдчилан гаргаж болох бөгөөд түүнийг Байнгын хорооны хуралдаан дээр заавал танилцуулж хэлэлцүүлнэ.

Байнгын хорооны хуралдаан дээр тухайн төслийн талаар хууль санаачлагчид асуулт тавьж, хариулт авна. Асуулт, хариулт үргэлжлэх хугацааг хуралдаан даргалагч тогтооно.

Хэрэв уг төслийг баталснаар тухайн санхүүгийн жилийн улсын төслийн зарлагын хэмжээ нэмэгдэхээр байвал энэ тухай Засгийн газрын санал, дүгнэлтийг заавал сонсоно.

2. Байнгын хорооны хуралдааныг тухайн Байнгын хорооны дарга даргалах бөгөөд уг хуралдаанд зөвхөн тухайн Байнгын хорооны гишүүн таслах эрхтэй оролцоно. Төслийн талаар бусад Байнгын хороо, Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэйгээс бусад саналыг зохих Байнгын хороо өөрийн санал, дүгнэлтдээ бүрэн тусгана.

3. Байнгын хорооны хуралдаанаар дараахь асуудлыг санал хураалт явуулж шийдвэрлэнэ:

1) төслийг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд хэлэлцүүлэхээр оруулах эсхүл дахин боловеруулахаар буцаах;

2) төслийн талаархи Байнгын хорооны дүгнэлтийг чуулганы хуралдаанд илтгэх гишүүнийг томилох.

4. Хэрэв нэг асуудлаар хоёр түүнээс дээш тооны төсөл байгаа бол тэдгээрийг нэгтгэн зохицуулж нэг төсөл болгож болно. Ийнхүү хэд хэдэн төслийг нэгтгэхийг хууль санаач-

лагч зөвшөөрөхгүй бол Байнгын хороо тэдгээр төслийн аль нэгийг сонгон авч хэлэлцэх бөгөөд зөвхөн уг төслийг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэхээр дүгнэлт гаргана.

5. Хууль санаачлагч, зохих Байнгын хороо болон бусад Байнгын хороо зарчмын зөрүүтэй саналаар зөвшилцөлд хүрэхийн тулд шинжээч томилон дүгнэлт гаргуулах, Засгийн газрын холбогдох гишүүний болон бусад албан тушаалтны санал сонсох зэргээр ажиллаж болно.

49 дүгээр зүйл. Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар төсөл хэлэлцэх

1. Улсын Их Хурал Үндсэн хуулийн хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хууль санаачлагчаас өргөн мэдүүлж, зохих Байнгын хороо урьдчилан хэлэлцэж дүгнэлт гаргасан, улмаар чуулганы хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулж баталсан төслийг хэлэлцэнэ.

Ерөнхийлөгчийн хориг, Ерөнхийлөгчөөс Улсын Их Хуралд хандаж гаргасан илгээлт, Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, Улсын Их Хуралд ажлаа шууд харицуан тайлагнадаг байгууллагын ажлын дүн, тайлан сонсох, түүний удирдлагыг томилох, чөлөөлөх, Монгол Улсын олон улсын гэрээг соёрхон батлахаас бусад асуудлаар чуулганы хуралдааны хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулгүй төслийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхээр тухайн чуулганы явцад өргөн мэдүүлбэл дотоод асуудлын байнгын хороо, зохих Байнгын хорооны санал, дүгнэлтийг харгалзан түүнийг тухайн чуулганаар хэлэлцэх эсэхийг чуулганы хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар шийдвэрлэнэ.

2. Чуулганаар хэлэлцэхээр тогтсон төслийг илтгэл, дүгнэлт, холбогдох бусад баримт бичгийн хамт Улсын Их Хурлын гишүүдэд уг төсөл хэлэлцэж эхлэхээс долоо хоногийн өмнө зохих Байнгын хороо эрхлэн тараана. Төсөл олшруулах, гараах ажлыг Улсын Их Хурлын Тамгын газар эрхэлнэ.

3. Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулахдаа дараахь журмыг баримтална:

1) төслийн тухай хууль санаачлагчийн илтгэл тавих хугацаа 30 минутаас илүүгүй байна. Илтгэлд тухайн төсөл боловсруулах болсон шалтгаан, үндэслэл, зорилго боловсруулсан нь, тухайн хууль, Улсын Их Хурлын шийдвэр үйлчилж эхэлснээс үүсч гарах нийгэм, эдийн засаг, хууль зүйн ур

дагаварыг хураангуйлан тодорхойлж, санхүү, эдийн засгийн тооцоог хавсаргана;

2) зохих Байнгын хорооны дүгнэлтийг танилцуулах хугацаа 20 минутаас илүүгүй байна. Дүгнэлтэд уг төсөл төрийн бодлогод нийцэж байгаа болон хуулийн зорилт, хууль тогтоомжийн техник, хэл зүйн шаардлагыг хангасан эсэх, тухайн чуулганаар түүнийг хэлэлцэж, батлах боломжтой эсэхийг тодорхойлохоос гадна төслийн үндэслэл, зүйл, заалтын талаар зарчмын өөр саналтай бол бүрэн томьёоллоор илэрхийлсэн үндэслэл, шалтгааныг заана.

Зохих Байнгын хороо хуулийн төсөлд оруулах нэмэлт, өөрчлөлтийн тухай зарчмын саналаа томьёолж Улсын Их Хурлын гишүүдэд тараасан байна;

3) төслийн тухай хууль санаачлагчийн илтгэл, зохих Байнгын хорооны дүгнэлтийг сонссоны дараа зохих Байнгын хорооны хуралдаан дээр зөвшилцөлд хүрээгүй зарчмын зөрүүтэй асуудлаар бусад Байнгын хороо, санал, дүгнэлт гаргаж болно.

Хэрэв Улсын Их Хурал дахь намын бүлэг санал, дүгнэлт гаргах шаардлагатай гэж үзвэл түүнийг бүлгийн ахлагч, эсхүл уг бүлгээс томилогдсон аль нэг гишүүн танилцуулна.

Зохих Байнгын хорооны хуралдаанд оролцож зарчмын өөр санал гаргасан боловч санал нь олонхийн дэмжлэг авч чадаагүй Улсын Их Хурлын гишүүн хүсвэл дангаараа буюу бусад гишүүнтэй хамтран санал, дүгнэлт гаргаж болно.

Санал, дүгнэлт гаргахдаа энэ хуулийн гучин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2-т заасан хугацааг баримтлах бөгөөд санал, дүгнэлтийг урьдчилан тараасан байна;

4) зарчмын зөрүүтэй санал гэдэгт зохих Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж зөвшилцөлд хүрээгүй саналыг ойлгоно;

5) Улсын Их Хурлын гишүүд төслийн талаархи зарчмын зөрүүтэй саналаа бичгээр бүрэн томъёолж хуралдаан даргалагчид өгнө. Харин найруулгын чанартай засварыг ажлын хэсэгт өгнө;

6) гишүүд санал гаргаж дууссаны дараа зарчмын зөрүүтэй асуудал бүрээр санал хураана. Тэгэхдээ зарчмын зөрүүтэй асуудлыг ямар хувилбараар шийдвэрлэх саналтай байгаа, эсхүл уг асуудлаарх төслийн заалтыг дахин гүйцээн боловсруулж саналыг сонсохын аль нэгээр хэлэлцүүлж гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ;

7) зарчмын зөрүүтэй асуудлаар санал хураасны дараа төслийг бүхэлд нь хэрхэх талаар санал хурааж, дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана;

а) төслийг бүхэлд нь эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх;

б) төслийг тухайн чуулганаар цаашид хянан хэлэлцэхээс татгалзаж тухайн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг гаргах шаардлагагүй гэж үзэх;

в) төслийг дахин боловсруулахаар хууль санаачлагчид буцаах;

8) Улсын Их Хурал төслийг бүхэлд нь эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхээр тохирсон нөхцөлд түүнийг зохих саналын дагуу зарчмын хувьд өөрчлөх, найруулан засах үүрэг бүхий Улсын Их Хурлын болон хууль санаачлагчийн хамтарсан ажлын хэсэг байгуулж болно;

9) анхны хэлэлцүүлгийн явцад төслийн талаар зарчмын зөрүүтэй санал гаргаагүй бол түүний эцсийн хэлэлцүүлгийг шууд явуулж болно;

10) төслийг цаашид хэлэлцэхээс татгалзсан, хууль санаачлагчид буцаасан тухай шийдвэрийн талаар хууль санаачлагч саналаа илэрхийлж болох бөгөөд уул саналыг хэлэлцэх эсэхийг гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ;

11) төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэж, хэлэлцүүлэхээр оруулах хугацааг төслийн боловсруулалтын түвшин, ажлын хэмжээ, шаардлагыг харгалзан хуралдаан даргалагч тогтооно.

4. Анхны хэлэлцүүлгээр шийдвэрлэсэн асуудлыг төсөлд тусгаж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх ажлыг дараахь үе шаттай хэрэгжүүлнэ:

1) төслийг хууль санаачлагч хариуцаж ажлын хэсэгт эцэслэн боловсруулна;

2) төслийн анхны хэлэлцүүлэгт дүгнэлт гаргасан зохих Байнгын хороо анхны хэлэлцүүлгээр тогтсон зарчмын тохиролцоог үндэслэн Улсын Их Хурлын гишүүний болон хууль санаачлагчийн томъёолж өгсөн саналыг нэгбүрчлэн хянан үзэж төсөлд зохих нэмэлт, өөрчлөлт хийж, хууль тогтоомжийн техник, хэл зүй, найруулгын талаас нь нягтлан үзэж зохих танилцуулга бэлтгэнэ.

5. Төслийн эцсийн хэлэлцүүлэг явуулахад дараахь журам баримтална:

1) төслийн талаар зохих Байнгын хороо танилцуулга хийх хугацаа 20 минутаас илүүгүй байна;

2) зохих Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт, харилт явуулж болно;

3) эцсийн хэлэлцүүлэгт төслийг бүлэг, зүйл тус бүрээр буюу хэрэв санал зөрүүгүй бол бүхэлд нь хэлэлцэж батална. Ажлын хэсгийн эцэслэн боловсруулсан төслийн томъёололтой санал нийлээгүй гишүүн өөрийн томъёоллоо хуралдаан даргалагчид бичгээр урьдчилан өгсөн байх бөгөөд уг саналынхаа талаар тайлбар өгч болно. Ийнхүү тайлбар өгөхдөө энэ хуулийн 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2-т заасан хугацааг баримтална;

4) шаардлагатай гэж үзвэл эцсийн хэлэлцүүлгээр баталсан хуулийг дагаж мөрдөх журмын тухай тогтоолыг хэлэлцэн батална;

5) төсөл батлагдаагүй бол түүнийг хууль санаачлагчид буцаасан тухай Улсын Их Хурлын тогтоол гаргана. Ийнхүү тогтоол гаргахын өмнө хууль санаачлагч саналаа Улсын Их Хуралд сонгох эрхтэй бөгөөд түүнийг авч хэлэлцэх эсэхийг хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар шийднэ;

6) эцсийн хэлэлцүүлгээр баталсан төслийг эцсийн найруулгад шилжүүлж, эцсийн хэлэлцүүлэг дуусснаас хойш ажлын 6 өдөрт багтаан эцсийн найруулгыг Улсын Их Хуралд танилцуулна. Эцсийн найруулгыг танилцуулах ажлыг Ерөнхий нарийн бичгийн дарга хариуцна;

7) Улсын Их Хурал эцэслэн найруулсан төсөлтэй танилцах явцад аливаа хэлэлцүүлэг явуулахгүй. Харин төслийн аль нэг зүйл, заалт хүчин төгөлдөр дагаж мөрдөж байгаа хууль болон уг төсөлд тусгагдсан зүйл, заалттай зөрчилдөж байна гэсэн үндэслэлээр тухайн асуудал хариуцсан зохих Байнгын хороо болон Хууль зүйн байнгын хороонд бичгээр урьдчилан мэдэгдсээр байхад уг асуудал эцсийн найруулгад хэвээр үлдсэн тохиолдолд дээрх Байнгын хороодын дүгнэлтийг сонссоны эцэст тухайн асуудлаар санал хураж шийдвэрлэж болно.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Улсын Их Хурал шийдвэр гаргах, түүнийг нийтлэх, хянан шалгах

50 дугаар зүйл. Улсын Их Хурлын шийдвэр

Улсын Их Хурал хууль, бусад шийдвэр гаргана. Улсын

Их Хурал, хууль, бусад шийдвэрийн эцсийн найруулгатай танилцсанаас хойш 72 цагийн дотор Улсын Их Хурлын дарга уг шийдвэрт гарын үсэг зурж ёсчлоно.

51 дүгээр зүйл. Санал хураалт, түүнийг явуулах журам

1. Үндсэн хууль, энэ хууль, бусад хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурал тухайн асуудлаар санал хураалт явуулж чуулганы хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар шийдвэрлэнэ.

Энэ хууль болон бусад хуульд нууц санал хураалт явуулж шийдвэрлэхээр зааснаас бусад тохиолдолд санал хураалтыг илээр явуулна. Ил санал хураалтыг гар өргөж, эсхүл цахим тооцоолууураар, нууц санал хураалтыг санал хураах хуудсаар, эсхүл цахим тооцоолуур ашиглан явуулна.

Тухайн хуралдаанд оролцсон 5-аас доошгүй гишүүний шаардсанаар, эсхүл хуралдаан даргалагчийн санаачилгаар ил санал хураалтыг нэрээр хурааж болно. Ийнхүү нэрээр санал хураахдаа хуралдаан даргалагч цахим тооцоолуур дээр бичигдсэн, эсхүл гар өргөсөн гишүүн нэг бүрийн нэр, өгсөн санал болон санал хураалтын дүнг танилцуулна.

2. Улсын Их Хурлын гишүүн чуулганы тухайн өдрийн тухайн асуудлаарх хуралдаанд ирцээ бүртгүүлсэн бол хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд уг асуудлаар санал хураахад заавал оролцоно. Санал хураалт явуулах цагийг хуралдаан даргалагч урьдчилан зарлана. Хуульд заасан журмын дагуу санал хурааж нэгэнт баталсан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг санал хураах үед байгаагүй гэсэн шалтгаанаар Улсын Их Хурлын гишүүн дахин хэлэлцүүлэх эрх эдлэхгүй.

3. Улсын Их Хурлын гишүүн зөвхөн «зөвшөөрсөн», «татгалзсан» гэсэн хоёр саналын аль нэгийг өгнө.

4. Тухайн асуудлаар санал хураалт явуулсны дараа санал хураалтад цөөнх болсон, эсхүл цөөнхийг төлөөлсөн 3 хүртэл гишүүн тайлбар хэлж болно. Хэрэв цөөнх дахин санал хураалгахыг хүсвэл эхний санал хураалтад олонхийн дэмжлэг авсан томьёоллоор дахин санал хураалт явуулна.

Эхний 2 санал хураалтад нэг томьёолол 2 удаа олонхийн дэмжлэг авсан бол уг томьёоллыг батлагдсанд тооцох бөгөөд энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан тохиолдолд уг томьёоллоор зөвхөн нэг удаа дахин санал хурааж шийдвэрлэнэ.

Хэрэв эхний санал хураалтад олонхийн дэмжлэг авсан томьёолол 2 дахь санал хураалтад олонхийн дэмжлэг авч

чадаагүй бол 2 дахь санал хураалтад цөөнх болсон, эсхүл цөөнхийг төлөөлсөн 3 хүртэл гишүүн тайлбар хэлж болно. Хэрэв цөөнх дахин санал хураалгахыг хүсвэл 2 дахь санал хураалтад олонхийн дэмжлэг авсан томьёоллоор дахин нэг удаа санал хураалт явуулж олонхийн санал авсан томьёоллыг батлагдсанд тооцох бөгөөд зөвхөн энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан тохиолдолд уг томьёоллоор эцсийн удаа санал хураажж шийдвэрлэнэ.

5. Хуралдаанд оролцсон нийт гишүүний гуравны нэгээс доошгүй нь тухайн асуудал батлагдсаны эцэст уг томьёололтой зарчмын хувьд санал нийлэхгүй байгаа гэсэн шалтгаанаар зөвхөн нэг удаа санал хураалгаж болно. Энэ санал хураалтын дүн эцсийн шийдвэр байна.

52 дугаар зүйл. Улсын Их Хурлын шийдвэр хүчин төгөлдөр болох

1. Улсын Их Хурлын шийдвэрийг ёсчилсноос хойш 24 цагийн дотор Ерөнхийлөгчид илгээнэ. Хэрэв Улсын Их Хурал өөр хугацаа тогтоогоогүй бол иймхүү илгээснээс хойш Ерөнхийлөгч 72 цагийн дотор тухайн хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавьсан бол уг асуудлыг хэлэлцэх асуудлын дараалал харгалзахгүйгээр тэргүүн ээлжинд хэлэлцэж чуулганы хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёр нь хоригийг хүлээн зөвшөөрөөгүй бол Улсын Их Хурлын тухайн шийдвэр хэвээр үлдэнэ.

2. Улсын Их Хурлын тухайн шийдвэрт өөрөөр заагаагүй бол уг шийдвэр албан ёсоор нийтлэгдсэнээсээ хойш 10 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

53 дугаар зүйл. Хууль, бусад шийдвэр нийтлэх, мэдээлэх

1. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг батлагдсанаас хойш Ерөнхий нарийн бичгийн даргын зөвшөөрснөөр төрийн төв хэвлэлд албан ёсоор нийтлэхээс гадна хэвлэл, мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

2. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг төв, орон нутгийн бусад сонин, хэвлэлд нийтлэх, радио, телевизээр дамжуулахдаа төрийн төв хэвлэлд нийтлэгдсэн албан ёсны эхийг баримтлах бөгөөд иймхүү дамжуулан нийтэлснийг албан ёсны бус гэж үзнэ.

3. Улсын Их Хурлын чуулганы явцын тухай олон нийтэд сонордуулах албан ёсны мэдээллийг зөвхөн Улсын Их Хурлын Тамгын газар харицуан нийтлүүлнэ.

53[1] дүгээр зүйл. «Төрийн мэдээлэл» эмхтгэл

1. «Төрийн мэдээлэл» эмхтгэл нь Улсын Их Хурлаас батлсан хууль, бусад шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, хуулийн талаарх Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбарыг бүрэн эхээр нь эмхтгэн нийтлэх төрийн албан ёсны хэвлэл мөн. Энэхүү эмхтгэлийг Улсын Их Хурлын Тамгын газраас эрхлэн сар тутам гаргана.

2. «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн эрхлэгч нь Ерөнхий нарийн бичгийн дарга байна.

3. «Төрийн мэдээлэл» эмхтгэлийг Засгийн газрын хэвлэх үйлдвэрт тогтмол хэвлэн гаргана.

54 дүгээр зүйл. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны тэмдэглэл хөтлөх, түүнийг ашиглах, хадгалах

1. Улсын Их Хурлын чуулганы хуралдаан, Улсын Их Хурлын гишүүдийн ажлын зөвлөлгөөн, Байнгын хорооны хуралдааны явцыг албан ёсоор дэс дараалан тэмдэглэн авах, уг тэмдэглэлийг ашиглах, хадгалах ажлыг Ерөнхий нарийн бичгийн даргын тогтоосон журмын дагуу Улсын Их Хурлын Тамгын газар эрхлэн гүйцэтгэнэ.

2. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны явцын тэмдэглэлийг гараар болон соронзон хальсанд нэгэн зэрэг бичнэ. Шаардлагатай гэж үзвэл хуралдааны явцын талаар дуутай дүрс бичлэг хийж хадгална.

3. Хуралдааны явцын тэмдэглэлд дараахь баримт бичгийг заавал хавсаргана:

1) тухайн өдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, урилгаар оролцсон болон байлцсан хүмүүсийн нэр, албан тушаал;

2) хуралдаанаар хэлэлцсэн хууль, бусад шийдвэрийн төсөл (хувилбарууд) тэдгээрийн танилцуулга, дүгнэлт, санал;

3) хэлэлцэж байгаа асуудлаар Улсын Их Хурлын гишүүнээс бусад гишүүнд тараасан санал;

4) хуралдааны явцад Улсын Их Хурлын гишүүдэд сонордуулсан өргөх бичиг, мэдэгдэл, цахилгаан утас;

5) хуралдааны явцад хэлэлцсэн, сонордуулсан, тараасан бусад баримт бичиг;

6) гишүүн тусгайлан тэмдэглүүлэхээр өөрөө бичсэн зүйл.

4. Хуралдааны явцын тэмдэглэлийг гараар бичихдээ дараахь зүйлийг заавал тусгана:

1) хуралдаан эхэлсэн, завсарласан, дууссан болон асуудлыг хэлэлцэж эхэлсэн, дууссан он, сар, өдөр, цаг, минут;

2) ямар асуудал, хаанаас, хэн төлөөлж оруулсан тухай товч томьёолол;

3) хэлэлцэж байгаа асуудалтай холбогдсон асуулт, хариулт, гаргасан санал, шүүмжлэл, хэлсэн үг;

4) санал хураалтын дүн (тоо, хувиар), хэрэв нэрээр санал хураавал Улсын Их Хурлын гишүүн нэг бүрийн нэр, өгсөн санал;

5) ирцийн байдал (тоо, хувиар), байхгүй гишүүний нэр, шалтгаан;

6) хуралдаанд хоцорч ирсэн, чөлөө авсан, өвчтэй байсан, тасалсан, хуралдааны даргын зөвшөөрөлгүй гарч явсан гишүүний нэр, цаг минут;

7) гишүүний тусгайлан тэмдэглүүлэхээр хэлсэн үг.

5. Гишүүний хуралдаан дээр хэлсэн үгийг тодорхой бичих бөгөөд тусгайлан тэмдэглүүлсэн зүйлийг тухайн гишүүнд хянуулан гарын үсэг зуруулна.

6. Улсын Их Хурлын гишүүн хүсвэл өөрийн болон бусдын хэлсэн үгийн бичлэгтэй танилцаж болно.

7. Гаргасан шийдвэрийг (төслийн хувилбарын хамт) гар тэмдэглэлд хэлэлцсэн дарааллаар нь дугаарлан заавал хавсаргана.

8. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны явцын тэмдэглэлд Ерөнхий нарийн бичгийн дарга гарын үсэг зурна.

55 дугаар зүйл. Хуралдааны явцын гар тэмдэглэл, соронзон болон дуутай дүрс бичлэг, ашиглах, хадгалах

1. Хуралдааны явцын гар тэмдэглэл, соронзон бичлэгийг Улсын Их Хурлын чуулганы материал бэлтгэж хэвлүүлэх, хэвлэл, мэдээллийн байгууллагад лавлагаа өгөх, маргаантай асуудал шийдвэрлэхэд ашиглуулна.

2. Хуралдааны явцын гар тэмдэглэл, соронзон болон дуутай дүрс бичлэгийг Улсын Их Хурлын гишүүд, Ерөнхий нарийн бичгийн дарга, Тамгын газрын хэлтсийн дарга шууд Улсын Их Хурлын Тамгын газрын бусад ажилтанд эрхэлсэн хэлтсийн даргын, бусад байгууллагын албан тушаалтанд Ерөнхий нарийн бичгийн даргын зөвшөөрснийг үндэслэн дээрх үзүүлж, сонсгоно.

3. Хуралдааны явцын гар тэмдэглэл, соронзон болон дуутай дүрс бичлэгийг зөвхөн уг ажлыг эрхлэх ажилтан эсхүл

архивчийн дэргэд үзэж, сонсох бөгөөд тэдгээрийг олшруулах, хувилахыг хориглоно.

4. Хуралдааны явцын гар тэмдэглэл, соронзон болон дуутай дүрс бичлэгийг Улсын Их Хурлын Тамгын газрын архивт хадгална. Энэ тухай журмыг Ерөнхий нарийн бичгийн дарга тогтооно.

55[1] **дүгээр зүйл.** Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах

1. Улсын Их Хурал чуулганы хуралдааны болон түүний чөлөө цагт хянан шалгах бүрэн эрхээ Улсын Их Хурлын гишүүн, Байнгын хороо, мөн Улсын Их Хурал буюу Байнгын хорооноос байгуулсан ажлын хэсгээр дамжуулан хэрэгжүүлнэ.

2. Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ дараахь хэлбэрээр хэрэгжүүлнэ:

1) Улсын Их Хурлын гишүүн асуулт, асуулга тавьж, хариулт авах;

2) холбогдох албан тушаалтны мэдээлэл сонсох, түүний илтгэл, сонсголыг хэлэлцэх;

3) хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг хэрхэн биелүүлж байгаа байдлыг шалгах;

4) хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийн талаар, иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн санал, хүсэлт, мэдээллийг сонсох, хүлээн авах.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хэлбэрээр хэрэгжүүлсэн хяналт шалгалтын дүнг Улсын Их Хурлын чуулганы болон Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж, шаардлагатай гэж үзвэл зохих шийдвэр гаргана.

4. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах явцад уг шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл түүнийг хүчингүй болгохоор байвал Улсын Их Хурал уг асуудлыг даруй хэлэлцэж шийдвэрлэнэ.

АРАВДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

56 дугаар зүйл. Улсын Их Хурлын төсвийг батлах, тайлагнах

1. Улсын Их Хурал аж ахуй, санхүүгийн хувьд бие даасан байна.

2. Улсын Их Хурал, түүний дэргэдэх бусад байгууллагын үйл ажиллагаанд шаардагдах зардлын төсвийн төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дотоод асуудлын байнгын хорооны хуралдаанаар урьдчилан хэлэлцэнэ. Дотоод асуудлын байнгын хороо уг асуудлаарх санал, дүгнэлтээ чуулганы хуралдаанаар улсын нэгдсэн төсвийн төсөл, түүний гүйцэтгэлийг хэлэлцэх үед оруулна.

3. Улсын Их Хурлын төсвийн зарцуулалтад Дотоод асуудлын байнгын хороо хяналт тавина.

57 дугаар зүйл. Улсын Их Хурлын Тамгын газар

1. Улсын Их Хурал нь өөрийн гишүүд, Байнгын болон бусад хорооны үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх үүрэг бүхий Тамгын газартай байна. Тамгын газрыг Ерөнхий нарийн бичгийн дарга толгойлно.

2. Улсын Их Хурлын даргад үйлчлэн туслах ажлын хэсэг Тамгын газарт багтах бөгөөд Ерөнхий нарийн бичгийн даргын шууд харьяанд байж Улсын Их Хурлын даргад үйлчилнэ.

3. Улсын төсвийн төсөл боловсруулах, батлах, түүний гүйцэтгэлд хяналт тавих, Улсын Их Хурлын хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлэхэд мэргэжлийн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг Тамгын газарт байна.

4. Тамгын газар нь хуулийн этгээд мөн бөгөөд өөрийн тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

58 дугаар зүйл. Ерөнхий нарийн бичгийн дарга

1. Улсын Их Хурлын чуулган бэлтгэн явуулах, түүний өдөр тутмын ажлыг зохицуулахад Улсын Их Хурлын даргад туслах, Улсын Их Хурлын Тамгын газрыг удирдах үндсэн үүрэг бүхий Ерөнхий нарийн бичгийн даргыг Улсын Их Хурлаас томилно.

2. Ерөнхий нарийн бичгийн дарга нам бус байна.

3. Ерөнхий нарийн бичгийн дарга эрхлэх асуудлаараа захирамж гаргана.

59 дүгээр зүйл. Ерөнхий нарийн бичгийн даргын эрхлэх ажил

1. Ерөнхий нарийн бичгийн дарга дараахь ажлыг эрхлэн гүйцэтгэнэ:

1) Улсын Их Хурлын чуулганы хуралдааны бэлтгэл ажлыг зохион байгуулах;

2) Улсын Их Хурлын чуулганы хуралдаан даргалагчид зөвлөх, хэлэлцэж буй асуудлын талаар хууль зүйн туслалцаа үзүүлэх;

3) Улсын Их Хурал, түүний даргын нэр дээр ирсэн иргэдийн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;

4) Улсын Их Хурлын дарга, гишүүд иргэдийг хүлээн авах ажлыг зохион байгуулах;

5) Улсын Их Хурлын Тамгын газрын боловсон хүчний бодлого боловсруулах;

6) Улсын Их Хурлын Тамгын газрыг удирдаж, түүнд ажиллах боловсон хүчнийг томилох, чөлөөлөх.

2. Ерөнхий нарийн бичгийн даргын эрхлэх бусад ажлын чиг үүргийг Улсын Их Хурал тогтооно.

60 дугаар зүйл. Тамгын газрын эрхлэх ажил

1. Тамгын газар нь дараахь ажлыг эрхлэн гүйцэтгэнэ:

1) Улсын Их Хурал, түүний гишүүд, Байнгын болон бусад хорооны үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

2) Улсын Их Хурлын төсөв, санхүүг зохих журмын дагуу зарцуулах;

3) Улсын Их Хурлын чуулганы бэлтгэл, хуралдааны хэвийн ажиллагааг хангах;

4) чуулганы болон хороо, ажлын хэсгийн хуралдааны танхим, шаардлагатай техник, хэрэгслийг бэлэн байлгах, танхимд журам сахиулах;

5) хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр, баримт бичгийг нийтлэх, тараах ажил зохион байгуулах;

6) хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг сурталчлах, биелэлтийг зохион байгуулах;

7) Улсын Их Хуралд иргэд, байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авч шийдвэрлүүлэх арга хэмжээ авах;

8) Улсын Их Хурлын гишүүдийг шаардлагатай мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах;

9) Улсын Их Хурлын бичиг хэргийг хөтлөн явуулах, түүний баримт бичгийг архивлан хадгалах;

10) Улсын Их Хурал, Тамгын газар, түүний харьяа байгууллагын гадаад харилцааны асуудлыг хариуцан шаардлагатай баримт бичиг бэлтгэх, Улсын Их Хурлын шугамаар

гадаад оронд айлчлах болон гадаадаас ирэх төлөөлөгчдийг хүлээн авах, бэлтгэл хангах, гадаадын зочин, төлөөлөгчид үйлчлэх;

11) Улсын Их Хурлын аж ахуй, санхүүг хөтлөн явуулах.

2) Улсын Их Хурлын Тамгын газрын бүтэц, орон тоо, ажилтны цалинг Улсын Их Хурлаас батлсан санд багтаан Ерөнхий нарийн бичгийн дарга Улсын Их Хурлын даргатай зөвшилцөн тогтооно.

3. Улсын Их Хурлын Тамгын газрын эрхлэх бусад ажлын чиг үүргийг Ерөнхий нарийн бичгийн дарга тогтооно.

61 дүгээр зүйл. Улсын Их Хурлын дэргэдэх байгууллага

Улсын Их Хурал дэргэдээ төрийн тогтолцоо, бодлого, хөгжлийн чиг хандлага, түүхэн уламжлал, Улсын Их Хурлын хууль тогтоох, хянан шалгах чиг үүрэг, улсын төсвийн үйл ажиллагаа, хууль тогтоомжийн үр ашиг, тэдгээрийг боловсронгуй болгох арга зам зэрэг асуудлаар эрдэм шинжилгээ, сургалтын ажил эрхэлж, Улсын Их хурлыг мэдээллээр хангах үндсэн үүрэг бүхий байгууллагатай байж болно.

62 дугаар зүйл. Улсын Их Хурлын тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас

Улсын Их Хурал нь тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

63 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хууль 1992 оны 7 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН ХАМТЫН МАРГААН ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь хамтын гэрээ байгуулах буюу түүнийг биелүүлэх явцад гэрээнд оролцогч талуудын хооронд үүссэн хөдөлмөрийн хамтын маргаантай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хөдөлмөрийн хамтын маргааны тухай хууль тогтоомж

Хөдөлмөрийн хамтын маргааны тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Хөдөлмөрийн хамтын маргаан

Хамтын гэрээ байгуулах буюу түүнийг биелүүлэх явцад гэрээнд оролцогч нэг талын тавьсан шаардлагыг нөгөө тал нь хүлээн зөвшөөрөөгүй, эсхүл бүрэн шийдвэрлээгүйгээс үүссэн маргааныг хөдөлмөрийн хамтын маргаан (цаашид «хамтын маргаан» гэх) гэнэ.

4 дүгээр зүйл. Санал зөрүүтэй асуудлаар шаардлага тавих, түүнд хариу өгөх

1. Хамтын гэрээ байгуулах буюу түүнийг биелүүлэх явцад үүссэн санал зөрүүтэй асуудлаар гэрээнд оролцогч нэг тал өөрийн шаардлагыг нөгөө талдаа бичгээр өгнө.

2. Шаардлага хүлээн авсан тал ажлын 3 өдрийн дотор шаардлагын хариуг нөгөө талдаа бичгээр өгнө.

5 дугаар зүйл. Санал зөрүүтэй асуудлыг эвлэрэх хорооогоор зохицуулах

1. Шаардлага тавьсан тал нөгөө талаас өгсөн хариуг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзвэл ажлын 3 өдрийн дотор эвлэрэх хороо байгуулан уг асуудлыг зохицуулах ажлыг санаачлан зохион байгуулна. Нөгөө тал эвлэрэх хороо байгуулах, түүнд төлөөлөгчдөө оруулахаас татгалзахыг хориглоно.

2. Эвлэрэх хороо гэрээнд оролцогч тал тус бүрээс томилогдсон тэнцүү тооны төлөөлөгчдөөс бүрдэнэ.

3. Эвлэрэх хороо ажлын 7 өдрийн дотор хэлэлцээ хийж санал зөрүүтэй асуудлыг зохицуулах арга хэмжээ авна. Хэ-

лэлцээний явц, дүнг тусгасан албан ёсны дэлгэрэнгүй тэмдэглэлийг хөтөлнө.

4. Эвлэрэх хороо хэлэлцээний дүнг тухайн сум, дүүргийн Засаг даргад бичгээр мэдэгдэнэ.

5. Эвлэрэх хороо санал зөрүүтэй асуудлыг зохицуулах талаар тохиролцоонд хүрсэн бол энэ тухай шийдвэрийг гэрээнд оролцогч талууд биелүүлэх үүрэгтэй. Хэрэв уг шийдвэрийг гэрээнд оролцогч аль нэг тал биелүүлэхгүй бол нөгөө тал энэ талаар шүүхэд гомдол гаргах эрхтэй.

6 дугаар зүйл. Хамтын маргаан үүсгэх тухай гомдол гаргах

Санал зөрүүтэй асуудлыг энэ хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу эвлэрэх хороогоор зохицуулж чадаагүй тохиолдолд шаардлага тавьсан тал дараахь журмаар хамтын маргаан үүсгэх тухай гомдол гаргах эрхтэй:

1) хамтын гэрээний заалтыг биелүүлээгүй буюу хамтын гэрээний заалт нь хууль тогтоомж зөрчсөн гэж үзсэн бол шүүхэд;

2) энэ зүйлийн 1 дэх заалтад зааснаас бусад шалтгаанаар хамтын маргаан үүсгэх шаардлагатай гэж үзсэн бол энэ хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу хамтын маргаан зохицуулах гурван талт эвлэрүүлэх хороонд.

7 дугаар зүйл. Хамтын маргааныг гурван талт эвлэрүүлэх хороогоор зохицуулах

1. Шаардлага тавьсан тал хамтын маргаан үүсгэх тухай гомдлыг гурван талт эвлэрүүлэх хороо байгуулах хүсэлтийн хамт тухайн сум, дүүргийн Засаг даргад тавина.

2. Засаг дарга хүсэлт хүлээн авсан өдрөөс хойш ажлын 3 өдрийн дотор хамтын маргаан зохицуулах гурван талт эвлэрүүлэх хороо (цаашид «гурван талт эвлэрүүлэх хороо» гэх) байгуулна.

3. Гурван талт эвлэрүүлэх хороо нь Засаг дарга болон гэрээнд оролцогч тал тус бүрээс томилогдсон тэнцүү тооны төлөөлөгчдөөс бүрдэнэ.

4. Засаг дарга гурван талт эвлэрүүлэх хорооны төлөөлөгчдийн тоог тогтоож, даргыг нь томилно.

5. Гурван талт эвлэрүүлэх хороо ажлын 5 өдрийн дотор хамтын маргааныг хянан хэлэлцэж нийт төлөөлөгчдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Хянан хэлэлцэх хуралдааны явц, дүнг тусгасан албан ёсны дэлгэрэнгүй тэмдэглэлийг хөтөлнө.

6. Гурван талт эвлэрүүлэх хороо гаргасан шийдвэрээ талуудад нэн даруй мэдэгдэж, тайлбарлана. Талууд уг шийдвэрийг хүлээн зөвшөөрсөн эсэхээ Засаг даргад бичгээр мэдэгдэнэ.

7. Гэрээнд оролцогч талууд гурван талт эвлэрүүлэх хорооны шийдвэрийг хүлээн зөвшөөрсөн бол түүнийг биелүүлэх үүрэгтэй.

8. Гэрээнд оролцогч талууд гурван талт эвлэрүүлэх хорооны шийдвэрийг хууль бус гэж үзвэл энэ талаар гомдлоо шүүхэд гаргах эрхтэй.

8 дугаар зүйл. Ажил хаялт зохион байгуулах, ажлын байрыг түр хаах

1. Аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны эрх ашгийг төлөөлөн хамгаалах үйлдвэрчний эвлэлийн байгууллага, хэрэв тийм байгууллага байхгүй бол хамт олны төлөөлөгч (цаашид «үйлдвэрчний эвлэл» гэх) гурван талт эвлэрүүлэх хорооны шийдвэрийг хүлээн зөвшөөрөх боломжгүй бөгөөд хамтын маргааныг цаашид үргэлжлүүлэх шаардлагатай гэж үзвэл тавьсан шаардлагаа шийдвэрлүүлэх эцсийн арга хэмжээ болгон ажил хаялтыг санаачлах эрхтэй.

2. Үйлдвэрчний эвлэл ажил хаялтын тухай асуудлыг нийт ажилтны хурлаар хэлэлцүүлэх бөгөөд ажил хаялтыг нийт ажилтны олонхи дэмжсэн тохиолдолд тухайн аж ахуйн нэгж, байгууллагын ажлыг бүхэлд нь буюу хэсэгчлэн зогсоож ажил хаях тухай шийдвэр гаргана.

3. Ажил хаялтыг санаачилсан үйлдвэрчний эвлэл уг арга хэмжээг зохион байгуулах үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

4. Аж ахуйн нэгж, байгууллагын захиргаа нөгөө талаас тавьсан шаардлагыг хүлээн авах боломжгүй гэж үзвэл ажил хаялтын эсрэг арга хэмжээ болгож ажил хаялтад оролцож байгаа ажилтны ажлын байрыг тэдний хувьд түр хааж (локаут) болно.

5. Үйлдвэрчний эвлэл ажил хаялт эхлэхээс ажлын 3-аас доошгүй өдрийн өмнө ажил хаялтад оролцох ажилтны нэрс, ажил хаялт эхлэх, үргэлжлэх хугацааны тухай мэдээллийг нөгөө талд албан ёсоор бичгээр өгөх үүрэгтэй.

6. Аж ахуйн нэгж, байгууллагын захиргаа ажлын байрыг түр хаахаас ажлын 3-аас доошгүй өдрийн өмнө уг арга хэмжээнд хамрагдах ажлын байрны жагсаалт, ажлын байрыг түр

хаах үйл ажиллагаа эхлэх, үргэлжлэх хугацааны тухай мэдээллийг нөгөө талд албан ёсоор бичгээр өгөх үүрэгтэй.

7. Аж ахуйн нэгж, байгууллагын захиргаа нь ажил хаях, ажлын байрыг түр хаах үйл ажиллагаа явагдах тухай хэрэглэгч, бэлтгэн нийлүүлэгч болон холбогдох бусад этгээдэд урьдчилан мэдэгдэнэ.

8. Ажил хаялтад оролцох, түүнийг үргэлжлүүлэхийг, түүнчлэн хуульд зааснаас бусад тохиолдолд ажил хаялтыг зогсоох, түүнд оролцохоос татгалзахыг тулган шаардаж болохгүй.

Санал зөрүүтэй асуудлаараа талууд санал бодлоо солилцох, чөлөөтэй сонголт хийхэд нь хуульд зааснаас бусад тохиолдолд бусад этгээд хөндлөнгөөс оролцохыг хориглоно.

9. Ажил хаялт зохион байгуулж, ажлын байрыг түр хааж байгаа тал эдгээр арга хэмжээг бэлтгэх болон түүний үргэлжлэх хугацаанд улс орны аюулгүй байдал, хүний амь нас, эрүүл мэнд, хууль ёс, нийгмийн дэг журмын эсрэг аливаа үйлдэл гаргуулахгүй байлгах арга хэмжээг зохих үүрэг бүхий төрийн байгууллагуудын тусламжтайгаар авна.

9 дүгээр зүйл. Ажил хаяхыг хориглох, хойшлуулах

1. Батлан хамгаалах, улсын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журам сахиулах үүрэг бүхий байгууллагад ажил хаяхыг хориглоно.

2. Санал зөрүүтэй асуудлаар хэлэлцээ хийх, хамтын маргааныг гурван талт эвлэрүүлэх хороогоор болон шүүхээр хянан нийдвэрлэх шатанд ажил хаяхыг хориглоно.

3. Цахилгаан, дулааны эрчим хүч, нийтийн усан хангамж, хотын нийтийн хүн тээвэр, улс, хот хоорондын болон цахилгаан холбоо, төмөр замын хөдөлгөөний албаны аж ахуйн нэгж, байгууллагад ажил хаях нь улс орны аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохирохоор байвал Засгийн газар уг арга хэмжээг 1 сар хүртэл хугацаагаар хойшлуулж болно.

10 дугаар зүйл. Ажил хаялт, ажлын байр түр хаасныг хууль бус гэж тооцох

1. Ажил хаялт, ажлын байрыг түр хаасныг хууль бус гэж үзэж байгаа этгээд энэ тухай өргөдлөө шүүхэд гаргана.

2. Шүүх ажил хаялт, ажлын байрыг түр хаасныг хууль бус гэж тооцох эсэх талаар шийдвэр гаргана.

3. Шүүх ажил хаялт, ажлын байрыг түр хаасныг хууль бус гэж тооцсон бол талууд уг үйл ажиллагаагаа нэн даруй зогсооно.

11 дүгээр зүйл. Ажилтны баталгаа

1. Хууль бус гэж тооцогдоогүй ажил хаялтад оролцсон, хууль бус гэж тооцогдсон ажлын байрыг түр хаах арга хэмжээнд хамрагдсан ажилтныг хөдөлмөрийн сахилга зөрчсөн гэж үзэхгүй бөгөөд түүнд хөдөлмөрийн сахилгын болон бусад шийтгэл ногдуулж болохгүй.

2. Хууль бус гэж тооцогдоогүй ажил хаялтад оролцсон ажилтанд ажил хаялт үргэлжилсэн хугацааны дундаж хөлсийг аж ахуйн нэгж, байгууллагын захиргаа олгоно.

3. Ажил хаялтад оролцоогүй боловч түүнээс шалтгаалан ажил үүргээ гүйцэтгэх боломжгүй байсан, хууль бус гэж тооцогдсон ажлын байрыг түр хаах арга хэмжээнд хамаарагдсан ажилтанд аж ахуйн нэгж, байгууллагын захиргаа Хөдөлмөрийн хуулийн 44 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу хөлс олгоно.

12 дугаар зүйл. Хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

1. Хууль бус ажил хаялтыг зохион байгуулсан, хууль бусаар ажлын байрыг түр хаасан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч үйлдвэрчний эвлэл, аж ахуйн нэгж, байгууллагын эрх баригчид 25000 хүртэл төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

2. Энэ хуулийн 8 дугаар зүйлийн 8 дахь хэсгийн заалтыг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч 25000 хүртэл төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

3. Хууль бус ажил хаялт зохион байгуулсан буюу хууль бусаар ажлын байрыг түр хаасны улмаас бусдад учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу гэм буруутай этгээд хариуцна.

Монгол Улсын Их Хурлын дарга **Н. БАГАБАНДИ**

1993 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1993 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр

Улаанбаатар хот

ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛҮҮДИЙН ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуульд дор дурдсан агуулгатай 4^1, 4^2, 4^3, 4^4 дүгээр зүйл нэмсүгэй:

4^1 дүгээр зүйл:

«4^1 дүгээр зүйл. Үйлдвэрчний эвлэлийг бүртгэх

1. Үүсгэн байгуулагч нь үйлдвэрчний эвлэлийг улсын бүртгэлд бүртгүүлэх тухай өргөдлөө хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

2. Өргөдөлд дараахь баримт бичгийг хавсаргана:

1) үйлдвэрчний эвлэлийн нэр, байрлаж байгаа газрын нэр, үйлдвэрчний эвлэлийн бүтэц, зохион байгуулалтын мэдээ;

2) үйлдвэрчний эвлэлийн дүрэм;

3) үүсгэн байгуулсан гишүүний бүртгэл (гишүүдийн овог, нэр, регистрийн дугаар);

4) хөрөнгийн эх үүсвэрийн тухай мэдээ.

3. Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан өргөдөл, баримт бичгийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянан үзээд үйлдвэрчний эвлэлийг 14 хоногийн дотор улсын бүртгэлд бүртгэж, гэрчилгээ олгоно.

4. Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага үйлдвэрчний эвлэлийг бүртгэхээс татгалзвал энэ тухай үндэслэл бүхий шийдвэр гаргана.»

4^2 дугаар зүйл:

«4^2 дугаар зүйл. Үйлдвэрчний эвлэлийг бүртгэхтэй холбогдсон шийдвэрийн талаар гомдол гаргах

1. Үүсгэн байгуулагч нь үйлдвэрчний эвлэлийг бүртгэх талаар гарсан шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргана.

2. Шүүх гомдлыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ. Энэ нь эцсийн шийдвэр болно.»

4³ дугаар зүйл:

«4³ дугаар зүйл. Үйлдвэрчний эвлэл тарах, үйл ажиллагаагаа зогсоох

Үйлдвэрчний эвлэл сайн дурааараа тарах буюу бусад үйлдвэрчний эвлэлд нэгдэж үйл ажиллагаагаа зогсоож болно. Энэ тухай хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад 10 хоногийн дотор мэдэгдэнэ.»

4⁴ дүгээр зүйл:

«4⁴ дүгээр зүйл. Үйлдвэрчний эвлэлийг бүртгэлээс хасах

Үйлдвэрчний эвлэл Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт болон өөрийн дүрмийг зөрчсөн нь шүүхээр тогтоогдож, энэ нь түүний үйл ажиллагааг зогсоох үндэслэл болохоор байвал хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага түүнийг улсын бүртгэлээс хасна.»

Монгол Улсын Их Хурлын дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1993 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 15-т заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1993 оны 7 дугаар сарын 10-ны өдөр Улаанбаатар хотноо байгуулсан «Монгол Улс, Бүгд Найрамдах Киргиз Улсын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай Гэрээ»-г Засгийн газраас өргөн мэдүүлсний дагуу соёрхон баталсугай.

Монгол Улсын Их Хурлын дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛС, БҮГД НАЙРАМДАХ КИРГИЗ УЛСЫН НАЙРСАГ ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ГЭРЭЭ

Монгол Улс, Бүгд Найрамдах Киргиз Улс (цаашид Талууд хэмээх),

Монгол Улс, Бүгд Найрамдах Киргиз Улсын ард түмний найрсаг харилцааны уламжлалаас үүдэн,

Түс хоёр орны хоорондын эрх тэгш, харилцан ашигтай, бүх талын хамтын ажиллагаа монгол, киргизийн ард түмний эрх ашигт нийцнэ гэдэгт итгэн,

НҮБ-ын Дүрмийн зорилго, зарчмуудад үнэнчээ нотлон,

Аз тивд харилцан ойлгох, хамтран ажиллах уур амьсгалыг бэхжүүлэхэд түс дөхөм үзүүлэхийг хүсч,

Монгол Улс, Бүгд Найрамдах Киргиз Улсын харилцааны эрх зүйн үндсийг бэхжүүлэхийн чухлыг харгалзан,

дор дурдсан зүйлийн талаар хэлэлцэн тохиров.

Нэгдүгээр зүйл

Талууд бие биеэ найрсаг улсууд хэмээн үзэх бөгөөд өөр хоорондын харилцаандаа бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолыг хүндэтгэх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хилийн халдашгүй дархан байдал, бүрэн тэгш эрх, дотоод хэрэгт үл оролцох, хүч үл хэрэглэх буюу хүчээр сүрдүүлэхгүй байх, маргааныг эв зүйгээр зохицуулах, хүний эрх болон үндсэн эрх чөлөөг хүндэтгэх, харилцан ашигтай хамтран ажиллах болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмыг удирдлага болгоно.

Хоёрдугаар зүйл

Талууд улс төр, худалдаа-эдийн засаг, соёл, шинжлэх ухаан-техник, эрх зүй, хүмүүнлэг, экологийн болон бусад салбарт харилцан ашигтай хамтын ажиллагаа хөгжүүлнэ.

Гуравдугаар зүйл

Талууд хоёр орны парламент болон төрийн бусад сонгуульт байгууллагуудын хооронд хэлхээ холбоо хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Дөрөвдүгээр зүйл

Талууд бие биеийн эсрэг чиглэсэн цэрэг-улс төрийн аливаа эвсэлд оролцохгүй бөгөөд нөгөө Талын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолын эрх ашигт харшилсан ямар нэг гэрээ, хэлэлцээрийг гуравдагч оронтой байгуулахгүй байх үүрэг хүлээнэ.

Тавдугаар зүйл

Талууд хоёр талын харилцааг гүнзгийрүүлэн хөгжүүлэх, түүнчлэн харилцан сонирхсон олон улсын харилцааны асуудлуудаар тогтмол санал солилцоно.

Зургадугаар зүйл

Талууд Ази тивд тогтвортой байдлыг бэхжүүлэх, итгэлцэх уур амьсгал, харилцан ажиллах үзэл санааг хэвшүүлэ-

хэд дэмжлэг үзүүлж, бүс нутгийн улсуудын хооронд эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн болон бусад хэлхээ холбоог өргөжүүлэхэд тус дөхөм үзүүлнэ.

Долдугаар зүйл

Талууд энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх болон олон улсын тулгамдсан бусад асуудлыг шийдвэрлэх үүднээс НҮБ, олон улсын бусад байгууллагын хүрээнд хамтын ажиллагааг хөгжүүлнэ.

Наймдугаар зүйл

Талууд өөр хоорондоо нээлттэй эдийн засгийн бодлого явуулж, эрх тэгш, харилцан ашигтай хамтын ажиллагаа хөгжүүлнэ. Энэ зорилгоор арилжаа, аж үйлдвэр, санхүүгийн үйл ажиллагаанд оролцогч төрийн болон төрийн бус өмчийн үйлдвэр, хувь хүмүүс, бусад этгээдэд нэн тааламжтай нөхцөл харилцан олгох үүрэг хүлээнэ. Талууд гуравдагч орны түншийг оролцуулан харилцан хөрөнгө оруулах, хамтарсан үйлдвэр хөгжүүлэхийг хөхүүлэн дэмжинэ.

Есдүгээр зүйл

Талууд төрөл бүрийн салбарт мэргэжилтэн бэлтгэхэд хамтын ажиллагаа хөгжүүлэх, оюутан, мэргэжил дээшлүүлэгч, багш, эрдэмтдийг харилцан солилцоход тус дөхөм үзүүлнэ.

Аравдугаар зүйл

Талууд соёлын хамтын ажиллагааны уламжлалд тулгуурлан, хоёр ард түмний харилцан ойлголцоход соёлын солилцоо ач холбогдолтой болохыг харгалзан энэ салбарт өөрсдийн хэлхээ холбоог өргөжүүлнэ.

Арван нэгдүгээр зүйл

Талууд байгаль орчныг хамгаалах, түүний дотор цөлжилттай тэмцэх, байгалийн баялгийг оновчтой ашиглах талаар хамтран ажиллаж, хүний аж ахуйн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд учирч болох хортой нөлөөллийг зогсоох талаар авах арга хэмжээ боловсруулахад хуримтлагдсан мэдээлэл, туршлагаа солилцоно.

Арван хоёрдугаар зүйл

Талууд аймаг, муж, хот, дүүрэг, үйлдвэр, албан газар, байгууллагын түвшинд шууд хэлхээ холбоог хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлнэ.

Арван гуравдугаар зүйл

Талууд зохион байгуулалттай гэмт хэрэг, алан хядлага, иргэний агаарын тээврийн аюулгүй байдлын эсрэг чиглэсэн хууль бус үйлдэл, мансууруулах бодис хууль бусаар зөөвөрлөх, контрбандтай тэмцэхэд хоёр талын хийгээд олон талын үндсэн дээр хамтран ажиллана.

Арван дөрөвдүгээр зүйл

Энэхүү Гэрээний үндсэн дээр түүнийг хэрэгжүүлэх үүднээс Талуудын Засгийн газар, эрх бүхий байгууллагууд тусгай гэрээ, хэлэлцээр, протокол байгуулна.

Арван тавдугаар зүйл

Энэхүү Гэрээ нь Талуудаас бусад улстай байгуулсан хоёр болон олон талын хүчин төгөлдөр гэрээ хэлэлцээрээр хүлээсэн үүргийг үл хөндөнө.

Арван зургадугаар зүйл

Энэхүү Гэрээг арван жилийн хугацаагаар байгуулсан бөгөөд хэрэв аль нэг Тал түүнийг цуцлах тухай хүсэлтээ Гэрээний хүчин төгөлдөр байх хугацаа дуусахаас 6 сарын өмнө бичгээр нөгөө Талдаа мэдэгдээгүй бол тав таван жилээр аяндаа сунгагдана.

Арван долдугаар зүйл

Энэхүү Гэрээг соёрхон батлах ёстой бөгөөд Батламж Жуух бичгүүдийг солилцсон өдрөөс хүчин төгөлдөр болно.

Энэхүү Гэрээг Улаанбаатар хотноо 1993 оны долдугаар сарын 10-ны өдөр монгол, киргиз, орос хэлнээ тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд бүх эх бичвэрүүд ижил бөгөөд адил хүчинтэй байна.

Энэхүү Гэрээг тайлбарлах явцад санал зөрөл орос хэл дээрх эх бичвэрийг баримтална.

МОНГОЛ УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ

ЗҮГД НАЙРАМДАХ КИРГИЗ УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1993 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 15-т заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1992 оны 12 дугаар сарын 15-ны өдөр Вена хотноо байгуулсан «Хоёр талын эдийн засгийн гадаад харилцааны тухай Монгол Улс, Австри Улс хоорондын Хэлэлцээр»-ийг Засгийн газраас өргөн мэдүүлсний дагуу соёрхон баталсугай.

Монгол Улсын Их Хурлын дарга Н. БАГАБАНДИ

ХОЁР ТАЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ГАДААД ХАРИЛЦААНЫ ТУХАЙ МОНГОЛ УЛС, АВСТРИ УЛС ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР

Монгол Улс, Австри Улс нь (цаашид «Хэлэлцэн тохирогч Талууд» гэж нэрлэх),

хоёр талын эдийн засгийн гадаад харилцааг бэхжүүлэх хүслээ илэрхийлэн,

худалдаа-эдийн засаг, үйлдвэр, техник, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааг эрх тэгш, харилцан ашигтай байх, зарчмын үндсэн дээр хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлэхийг эрмэлзэн,

энэхүү Хэлэлцээр нь хоёр талын эдийн засгийн гадаад харилцааг цаашид хөгжүүлэхэд таатай нөхцөл бүрдүүлэх үндэс болно гэдэгт итгэн,

зах зээлийн эдийн засгийн үндсэн зарчимд тулгуурлан,

хоёр улсад хүчин төгөлдөр мөрдөж буй хууль тогтоомжийн хүрээнд,

дараах зүйлийг хэлэлцэн тохиров:

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

Хэлэлцэн тохирогч Талууд өөрсдийн оронд мөрдөж буй хууль тогтоомжийн хүрээнд хоёр орны үйлдвэр, байгууллага, нийгэмлэг компани (цаашид «байгууллага» гэж нэрлэх)-ийн хооронд явуулах хоёр талын эдийн засгийн гадаад харилцааг хөхүүлэн дэмжиж хөгжүүлнэ.

ХОЁРДУГААР ЗҮЙЛ

1. Монгол улс, Австри улс нь бараг хилээр оруулах, гаргахтай холбогдуулан ногдуулдаг гаалийн татвар болон аливаа хураамж, түүнчлэн эдгээр татвар хураамжийг тооцох аргын хувьд бие биедээ нэн таалмжтай нөхцөл олгоно.

2. Хэлэлцэн тохирогч Талууд аль нэг Хэлэлцэн тохирогч Талаас

а) хил худалдааг хөнгөвчлөх зорилгоор хөрш орнуудад,

б) одоо байгаа болон хойшид байгуулагдах гаалийн холбоо, болон худалдааны чөлөөт, хөнгөлөлттэй бүсэд хамт ордог орнуудад,

в) Хэлэлцэн тохирогч нөгөө Тал ордоггүй олон талын гэрээ, Хэлэлцээрийн хүрээнд гуравдах орнуудад олгож буй эсвэл хойшид олгох хөнгөлөлт, давуутай нөхцөлийг нэн тааламжтай нөхцөлд хамааруулахгүй байхаар тохиролцов.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ

1. Хэлэлцэн тохирогч Талууд өөрсдийн боломжийн болон өөрийн оронд хүчин төгөлдөр мөрдөж буй хууль тогтоомжийн хүрээнд эдийн засаг, үйлдвэрлэл, техник, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааг хөхүүлэн дэмжинэ.

2. Хэлэлцэн тохирогч Талууд ялангуяа дараах салбарт хамтран ажиллах боломжтой болохыг тохиролцов. Үүнд:

— эдийн засгийн бүх салбарт шууд хөрөнгө оруулах болон хамтарсан үйлдвэр байгуулах,
— технологи, «ноу-хау» түүний дотор хэрэглээний судалгааг солилцоход тус дөхөм үзүүлэх,
— арьс шир, үслэг эдлэлийг боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх,
— хөдөө аж ахуй, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулах, хадгалах,
— нэхмэл, бөс барааны үйлдвэрлэл,
— хөнгөн үйлдвэрлэл,
— одоо байгаа үйлдвэрүүдийг өөрчлөх, шинэчлэх, өргөтгөх, автоматжуулах,
— орон сууц, эмнэлэг, нийтийн байр барих,
— барилгын материал үйлдвэрлэх,
— эмийн үйлдвэрлэл, эмнэлгийн төхөөрөмж, багаж хэрэгслийн болон химийн, түүний дотор ургамал хамгаалах хэрэгслийн үйлдвэрлэл,
— уул уурхай, эрчим хүчний үйлдвэрлэл, эрэл хайгуул, олборлох, боловсруулах, зах зээлд гаргах тэрчлэн гуравдахь зах зээл дээр хамтран ажиллах,
— эрчим хүч, цахилгаан станц өндөр хүчдэлийн шугамын системийг өргөтгөх, шинэчлэх,
— хүрээлэн буй байгаль орчин, байгалийн унаган төрхийг хамгаалах,
— мэргэжилтэн, удирдах ажилтан менежерийг сургах, бэлтгэх,

— ярмаг, үзэсгэлэн, семинар зохион явуулах, худалдаа-
эдийн засгийн төлөөлөгчид, мэрэгжилтнүүд солилцох,

3. Хамтын ажиллагааны бүх салбарт төслүүдийг экологийн дээд түвшиний хишигт тохирсон тэргүүний технологоор хэрэгжүүлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

Хэлэлцэн тохирогч Талууд эдийн засгийн хувьд ашигтай экологийн хор хохиролгүй дэд бүтцийг байгуулах зайлшгүй шаардлагаас үүдэн дор дурдсан салбарын хамтын ажиллагааг онцгой анхаарч үзэхээр тохиролцов. Үүнд:

— эрчим хүч,
— зам барилга,
— хог хаягдлыг дахин ашиглах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх,
— төмөр замын тээвэр,
— агаарын тээвэр,
— усан тээвэр,
— сансрын холбоо,
— усны аж ахуй.

ТАВДУГААР ЗҮЙЛ

Хэлэлцэн тохирогч Талууд хоёр талын эдийн засгийн гадаад харилцааг гүнзгийрүүлэхэд жуулчлал үлэмж хувь нэмэр оруулах болно гэж үзэв.

1. Хэлэлцэн тохирогч Талууд Нэгдсэн Үндэсний Байгууллагын олон улсын аялал жуулчлалын Бага Хурлын зөвлөмж (1963 он, Рим), түүнчлэн «Жуулчлалын Харти болон жуулчлын кодекс» (Софи, 1985 он)-ийн зөвлөмжийг үндэслэн жуулчлалыг хөгжүүлэхэд өөрийн хууль тогтоомжийн хүрээнд туслалцаа үзүүлнэ.

2. Жуулчлалын салбарт төслүүд хэрэгжүүлэх, түүнчлэн зохих дэд бүтцийг хөгжүүлэх эдийн засаг, үйлдвэрлэл, техник, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагаа нь хүрээлэн буй орчныг хамгаалах, жуулчлалыг чанарын өндөр түвшинд зохион байгуулах зарчмын үндсэн дээр хэрэгжинэ.

ЗУРГАДУГААР ЗҮЙЛ

Монгол улс ба Австри улсын хоорондын төлбөр тооцоо нь улс тус бүрд мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу төлөөтэй хөрвөх валютаар хийгдэнэ.

ДОЛДУГААР ЗҮЙЛ

1. Энэхүү Хэлэлцээрийн хүрээнд явуулах бараа солилцоо, эдийн засаг, үйлдвэрлэл, техник, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагаа нь арилжааны зарчмын үндсэн дээр явагдана.

2. Хоёр улсын байгууллагуудын хоорондын худалдаанд дэлхийн зах зээлийн үнийг баримтална.

3. Хоёр улсад мөрдөж буй хууль тогтоомжийн хүрээнд Хэлэлцэн тохирогч Талуудын үйлдвэрүүд бараа эргэлтийг нэмэгдүүлэх, тэдгээрийн нэр төрлийг олшруулах зорилгоор олон улсын практикт хэрэглэгддэг бүх төрлийн худалдаа, түүний дотор бараа солилцоо болон уғтвар худалдааг эрхлэн явуулж болно.

НАЙМДУГААР ЗҮЙЛ

1. Хэрэв гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны үнэ, хэмжээ, нөхцөл нь дотоодын ижил төрлийн бараа үйлдвэрлэгчид буюу эсвэл өрсөлдөх барааны хувьд хохирол учруулсан буюу хохирол учруулахаар бол Хэлэлцэн тохирогч Талууд хоёр талын зөвлөлдөөн хийнэ.

2. Зөвлөлдөөний явцад Хэлэлцэн тохирогч Талууд дээр (1) дурдсан нөхцөл бүрдсэн гэж үзвэл нийлүүлэлтийг хязгаарлах буюу өөр арга хэмжээ авч хохирлоос урьдчилан сэргийлэх буюу түүнийг арилгана.

3. Хэрэв Хэлэлцэн тохирогч Талууд тохирч чадахгүй бол зөвлөлдөөн хийхийг санаачлагч Хэлэлцэн тохирогч Тал хохирлыг арилгах буюу түүнээс урьдчилан сэргийлэхэд зайлшгүй шаардлагатай хугацаа, хэмжээнд бараа нийлүүлэлтийг хязгаарлах арга хэмжээ авах эрхтэй. Ийм тохиолдолд Хэлэлцэн тохирогч нөгөө тал Хэлэлцэн тохирогч эхний Талын өмнө хүлээсэн үүргээсээ адил хэмжээгээр худалдаанд татгалзах эрхтэй.

4. Хугацаа алдсанаар үлэмж хэмжээний хохирол учирч болзошгүй тохиолдолд урьдчилан зөвлөлдөөн хийлгүйгээр түр арга хэмжээ авч болно. Энэ тохиолдолд уг арга хэмжээг авсан Хэлэлцэн тохирогч Тал энэ тухай Хэлэлцэн тохирогч нөгөө Талд бичгээр нэн даруй мэдэгдэх бөгөөд дараа нь зөвлөлдөөнийг яаралтай эхлүүлнэ.

5. Энэхүү зүйлд тусгагдсан арга хэмжээг сонгохдоо энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд хамгийн бага сөрөг нөлөө үзүүлэх арга хэмжээг Хэлэлцэн тохирогч Талууд чухалчилж үзнэ.

ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ

Хэлэлцэн тохирогч Талууд хоёр талын эдийн засгийн гадаад харилцаанд жижиг, дунд үйлдвэрийг идэвхтэй оролцуулах нь шаардлагатай бөгөөд ашигтай гэж үзнэ.

АРАВДУГААР ЗҮЙЛ

1. Хэлэлцэн тохирогч Талууд маргаантай асуудлыг хоёр талын харилцан ойлголцсоны үндсэн дээр найрсаг замаар шийдвэрлэхийг эрхэмлэнэ.

2. Хоёр улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хүрээнд болон Хэлэлцэн тохирогч Талуудын байгууллагуудын хоорондын гэрээнд заасны дагуу Хэлэлцэн тохирогч Талууд:

а) худалдаа, хамтын ажиллагааны хэлцэл, түүнчлэн хамтарсан үйлдвэр байгуулах болон шууд хөрөнгө оруулах тухай хэлцэлтэй холбогдолтой Хэлэлцэн тохирогч Талуудын байгууллагуудын хоорондын маргааныг арбитражийн газраар шийдвэрлүүлэх,

б) Нэгдсэн Үндэсний Байгууллагын олон улсын худалдааны эрхийн комисс (ЮНСИЕРАЛ)-ийн боловсруулсан арбитражийн журмыг хэрэглэх, түүнчлэн Гадаад улсын арбитражийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай Конвенци (Нью-Йорк, 1958 он)-д оролцогч аль нэг орны арбитражийн газраар шийдвэрлүүлж байна.

АРВАН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

Энэхүү Хэлэлцээр нь хүчингүй болох эсвэл түүнд өөрчлөлт орсны дараа Хэлэлцээрийн заалтууд нь энэхүү Хэлэлцээрийг хүчин төгөлдөр байхад үүссэн бөгөөд түүнийг хүчингүй болох болон түүнд өөрчлөлт ороход хагас нь эсвэл бүхэлдээ биелээгүй хоёр орны байгууллагуудын хоорондын гэрээгээр хүлээсэн үүргийн хувьд хэвээр мөрдөгдөнө.

АРВАН ХОЁРДУГААР ЗҮЙЛ

1. Энэхүү Хэлэлцээрийн дагуу Хамтарсан комиссийг байгуулах бөгөөд Хэлэлцэн тохирогч Талуудын тохиролцсоны

дагуу ажлын уулзалтыг Монгол болон Австри улсад ээлжлэн зохион байгуулж байна.

2. Энэхүү Хамтарсан комиссын зорилгод тухайлбал дараах зүйл орно. Үүнд:

— хоёр талын эдийн засгийн гадаад харилцааны хөгжлийг дүгнэх,
— эдийн засгийн хамтын ажиллагааны хэтийн шинэ төлвийг боловсруулах,
— хоёр улсын байгууллагуудын хоорондын эдийн засаг, үйлдвэрлэл, техник, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааг сайжруулах санал боловсруулах,
— энэхүү Хэлэлцээрийг хэрэглэх талаар зөвлөлгөө бэлтгэх.

АРВАН ГУРАВДУГААР ЗҮЙЛ

1. Хэлэлцэн тохирогч аль нэг Тал, эсвэл Хэлэлцэн тохирогч Талууд Европын Эдийн Засгийн Бүс (ЕЭЗБ), эсвэл Европын Хамтын Нийгэмлэг (ЕХН), эсвэл тэдгээрийн эрхийг залгамжлагч байгууллагуудад гишүүнээр элссэн тохиолдолд Хэлэлцэн тохирогч Талууд энэхүү Хэлэлцээрийн энэ зүйлд дурдсан байгууллагуудын гишүүний эрх зүйн байдалд үл нийцэх заалтуудыг мөрдөхгүй болно.

2. Дээрх тохиолдолд Хэлэлцэн тохирогч Талууд энэхүү Хэлэлцээрийн үлдэх зүйл заалтыг цаашид хэрхэн мөрдөх талаар хамтран тохиролцоно.

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

1. Энэхүү Хэлэлцээрийг хоёр жилийн хугацаатай байгуулсан бөгөөд Хэлэлцэн тохирогч Талуудын аль нэг нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талдаа Хэлэлцээрийн хугацаа дуусахаас 3 сарын өмнө Хэлэлцээрийг цуцлах тухай дипломат шугамаар бичгээр мэдэгдээгүй тохиолдолд тэрээр нэг жилээр аяндаа сунгагдана.

2. Энэхүү Хэлэлцээр нь түүнийг хүчин төгөлдөр болох талаар хоёр орны хууль тогтоомжид заасан дотоодын журмын дагуу шийдвэрлэсэн тухай ноот бичиг солилцон бие биедээ мэдэгдсэнээс хойш гуравдах сарын эхний өдөр хүчин төгөлдөр болно.

3. Энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Австрийн

Холбооны Улсын Засгийн газрын хооронд 1963 оны 7 дугаар сарын 15-нд байгуулсан Худалдаа ба Төлбөрийн Хэлэлцээр хүчингүй болно.

Хэлэлцээрийг 1992 оны 12 дугаар сарын «15»-ны өдөр Вена хотноо монгол, герман хэл дээр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх хувнуд нь адил хүчинтэй байна.

МОНГОЛ УЛСЫГ ТӨЛӨӨЛӨН

АВСТРИ УЛСЫГ ТӨЛӨӨЛӨН

МОНГОЛ УЛСЫН ТӨР, СҮМ ХИЙДИЙН ХАРИЛЦААНЫ ТУХАЙ ХУУЛЬ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуулиар зарлан тунхагласан иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хангах баталгааг тогтоож, төр, сүм хийдийн хоорондын харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Төр, сүм хийдийн харилцааг зохицуулах хууль тогтоомж

Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө

1. Аливаа шашныг шүтэх буюу эс шүтэх нь тухайн хүний итгэл үнэмшлийн хэрэг байна.

2. Иргэнийг шашин шүтэх, эс шүтэхэд албадах, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно.

3. Иргэдийг шашин шүтлэгийн ялгаа болон шашин шүтэх, эс шүтэх байдлаар нь ялгаварлан гадуурхах, доромжлох, хагалан бутаргах үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

4. Иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг гагцхүү бусад иргэний мөнхүү эрх чөлөө, эрүүл мэнд, ёс суртахуун болон үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг тогтоон зохицуулж байгаа Монгол Улсын хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ зохицуулан хэрэгжүүлнэ.

5. Иргэний шашин шүтлэгийн байдлыг уг хүн өөрөө хүсэнээс бусад тохиолдолд албан баримт бичигт тусгахыг хориглоно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Төр, сүм хийдийн харилцаа

4 дүгээр зүйл. Төр, сүм хийдийн харилцааны үндэс

1. Монгол Улс дахь төр, сүм хийдийн харилцаа төр нь шашныг хүндэтгэж, шашин нь төрөө дээдлэх зарчимд үндэслэнэ.

2. Төрөөс Монголын ард түмний эв нэгдэл, соёл иргэншлийн түүхэн уламжлалаа эрхэмлэхийн үүднээс Монгол Улс дахь буддын шашны зонхилох байр суурийг хүндэтгэн үзнэ. Энэ нь иргэд бусад шашин шүтэхэд саад болохгүй.

3. Төрийн байгууллага, албан тушаалтан хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд сүм хийдийн дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцохыг хориглоно.

4. Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд хохирол учирч болох нөхцөлд төрөөс сүм хийдийн тухайн үйл ажиллагааг зөвлөн зохицуулах, шаардлагатай бол зогсоох эрхтэй.

5. Сүм хийд, лам санваартан нар Монгол Улсын хууль тогтоомжийг дээдлэн үзэж биелүүлнэ.

6. Сүм хийдээс төрийн байгууллагын үүргийг эрхлэн гүйцэтгэхгүй бөгөөд төрийн эрх мэдлийн төлөө улс төрийн үйл ажиллагаа явуулах, түүнд оролцох, санхүүжүүлэхийг хориглоно.

7. Шашны нэр хүнд, хүн амын сүсэг бишрэлийг улс төрийн нам, байгууллага, албан тушаалтны эрх ашгийг нийцүүлэн ашиглах, шашныг гаднаас зохион байгуулалттайгаар нэвтрүүлэх үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

8. Лам санваартан нарын үнэмлэхүй тоо, сүм хийдийн байршлыг төрөөс хянан зохицуулна.

5 дугаар зүйл. Төр, сүм хийдийн харилцааг тодорхойлон хэрэгжүүлэх

1. Төрөөс шашин, сүм хийдийн талаар баримтлах бодлогын үндсийг Монгол Улсын Их Хурал тодорхойлно.

2. Ард түмний эв нэгдэл, үндэсний аюулгүй байдлын эрх ашгийг нийцүүлэн төр, сүм хийдийн болон шашин хоорондын харилцааг Монгол Улсын Ерөнхийлөгч зохицуулна.

3. Төрөөс сүм хийдтэй харилцах харилцааг зохион байгуулж хэрэгжүүлэх ажлыг Монгол Улсын Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг дарга тус тус эрхлэн гүйцэтгэнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Шашны байгууллагын тухай

6 дугаар зүйл. Шашны байгууллага

Сүсэгтэн олны шашин-номын эрэлт хэрэгцээг хангах зорилгоор байгуулагдаж, шашны зан үйл, хурал ном, боловсролын ажлыг эрхлэн гүйцэтгэж буй албан ёсны зөвшөөрөл бүхий хийд, сүм, дацан, төв болон тэдгээрийн удирдах байгууллагыг (цаашид энэ хуульд «сүм хийд» гэх) шашны байгууллага гэнэ.

7 дугаар зүйл. Сүм хийд, лам санваартны үйл ажиллагааны эрх зүйн үндэс

1. Шашин-номын үйлсийг эрхлэн гүйцэтгэгч лам санваартан нар Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу иргэний эрхээ эдэлж, үүрэг хүлээнэ.

2. Сүм хийд, лам санваартан нар бурхан тахилын зүйлс, ном судар бүтээх, шашны зан үйл үйлдэх, хурал ном хурах зэргээр сүсэгтэн олонд чөлөөтэй үйлчилнэ.

3. Шашны зан үйлийг тухайн шашны уламжлалт ёс журмын дагуу энэ хууль, бусад хууль тогтоомжоор тусгайлан хориглоогүй газарт сүсэгтний хүсэлтээр тэдэнд зориулж чөлөөтэй үйлдэж болно.

4. Сүм хийд бие дааж буюу удирдах төвөөрөө уламжлан төрийн аль ч шатны байгууллагад асуудлаа тавих, харилцах эрхтэй.

5. Сүм хийд нь тухайн шашны уламжлалт ёс дэгийг тусгасан дотоод журмыг чанд баримтлах бөгөөд Монголын ард түмний уламжлал, зан заншилд харшлах болон хүмүүнлэг бус үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

6. Монгол Улс дахь буддын болон мусульман шашин, бөө мөргөлөөс бусад шашны номлол, сургалт, сурталчилгааг тухайн шашны сүм хийдээс гадуур явуулахыг хориглоно.

7. Аливаа шашны байгууллага, лам санваартан өөрийн шашныг эс шүтэгчдэд үзэл номлолоо хүчээр тулгах, шахалт үзүүлэх, эд мөнгөөр татах, хууран мэхлэх, тэдний эрүүл мэнд ёс суртахуунд хохирол учруулах, санаа сэтгэлийг үймүүлэх хийг хориглоно.

8. Сүм хийд нийгмийн даатгалын шимтгэл төлж лам санваартнаа тэтгэвэр, тэтгэмжид хамруулж болно. Лам сан

ваартан эрүүл мэндийн даатгалд сайн дурын үндсэн дээр хамрагдана.

9. Сум хийдэд гэрээгээр ажиллагсдын хөдөлмөрийн харилцааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

10. Шашны байгууллага гадаад харилцааны асуудлаа эрх бүхий төрийн байгууллагатай зөвлөлдөн шийдвэрлэнэ.

8 дугаар зүйл. Шашны сургалт

1. Шашны боловсролыг шашны сургууль, гэрийн сургалтаар олгоно.

2. Төрийн харьяалал бүхий сургууль, байгууллагуудад шашны сургалт, цугларалт зохион байгуулахыг хориглоно. Энэ заалт нь шашны соёл, мэдлэг ухааны өв уламжлалын тухай шинжлэх ухааны сургалтад үл хамаарна.

3. Шашны сургуульд суралцагсад иргэний суурь боловсрол олгохыг тухайн сургууль хариуцна. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Засгийн газраас батлсан журмын дагуу үүнд шаардагдах зардлын тодорхой хэсгийг гаргаж, багшлах боловсон хүчнээр ханган, мэргэжлийн хяналт тавина.

9 дүгээр зүйл. Сүм хийд байгуулах

1. Сүм хийд байгуулах тухай иргэдээс гаргасан өргөдлийг дүрмийн хамт аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хянан үзэж, зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ. Олгосон зөвшөөрлийг үндэслэн сүм хийдийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бүртгэнэ.

2. Буддын болон мусульман шашны сүм хийд байгуулахад Монгол Улс дахь тухайн шашны удирдах төвийн албан ёсны санал дүгнэлтийг авсан байна.

3. Сүм хийд дүрэмтэй байна. Дүрэмд дор дурдсан зүйлийг тусгана:

1) сүм хийдийн нэр, хаяг;

2) шашны харьяалал, бүтэц, үйл ажиллагаагаа эхлэх үеийн бүрэлдэхүүний байдал;

3) үйл ажиллагааны хамрах хүрээ, хэлбэр;

4) шашин-номын хэрэгслэлийн хангамжийн байдал;

5) үйл ажиллагаа явуулах, өргөжин бэхжих хөрөнгө санхүүгийн бодит боломж, анхдагч хөрөнгийн хэмжээ;

6) хуулийн этгээд болох үндэслэл;

7) бусад зүйл.

4. Сүм хийд нь дүрэмдээ оруулсан нэмэлт, өөрчлөлтийг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тухай бүр албан ёсоор мэдэгдэнэ.

5. Сүм хийдийн дүрэм, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Монгол Улсын хууль тогтоомжид харшлах бол сүм хийд байгуулах зөвшөөрөл олгохгүй буюу олгосон зөвшөөрлөө цуцална. Энэ шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо хууль тогтоомжийн дагуу шүүхэд гаргаж болно.

10 дугаар зүйл. Сүм хийдийн үйл ажиллагааг зогсоох

1. Сүм хийдийн үйл ажиллагааг дараахь үндэслэлээр зогсооно:

1) тухайн сүм хийд өөрөө үйл ажиллагаагаа зогсоохоор шийдвэрлэсэн;

2) Монгол Улсын хууль тогтоомж зөрчигдсөн нь шүүхээр тогтоогдсон тохиолдолд зөвшөөрөл олгосон байгууллага тухайн сүм хийдийн үйл ажиллагааг зогсоохоор шийдвэрлэсэн.

2. Сүм хийдийн үйл ажиллагааг зогсоох тухай шийдвэр гаргасан байгууллага энэ тухай хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад албан ёсоор мэдэгдэж бүртгэлээс хасуулна.

3. Сүм хийдийн үйл ажиллагааг зогсоох шийдвэрийг эс зөвшөөрвөл хууль тогтоомжийн дагуу шүүхэд гомдол гаргаж болно.

11 дүгээр зүйл. Сүм хийдийн өмч, аж ахуйн харилцааг зохицуулах

1. Сүм хийдийн өмч, аж ахуйн харилцааг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

2. Сүм хийд өөрийн эзэмшилд буй түүх, соёлын дурсгалт зүйлсийг улсын бүртгэлд бүртгүүлж, хамгаална.

3. Сүм хийд шашин-номын үйл ажиллагаагаа эрхлэн явуулахад нь шаардлагатай музей, номын сангуудад хадгалагдаж буй түүх, соёлын дурсгалт зүйлсийг гэрээ хэлцлийн дагуу авч хэрэглэж болно.

4. Сүм хийд нь шашин-номын үйл ажиллагаагаа эрхлэн явуулах, ахуйн хэрэгцээгээ хангахад зайлшгүй шаардагдах аж ахуйг өмчийнхөө хүрээнд эрхэлж болно.

5. Сүм хийд үйл ажиллагаагаа бүрмөсөн зогсоох тохиолдолд үүсгэн байгуулагчид нь анх оруулсан эд хөрөнгөө нэхэмжилбэл тэдгээрт хөрөнгийг нь олгож, хөрөнгийн бусад хэсгийг лам санваартнуудын саналыг харгалзан аль нэгэн сүм хийдэд, боломжгүй бол төрийн мэдэлд шилжүүлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Бусад зүйл

12 дугаар зүйл. Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль тогтоомж гадаадын иргэн, харьяалалгүй хүнд хамаарах

1. Төр, сүм хийдийн харилцааны тухай Монгол Улсын хууль тогтоомж нь тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнд нэгэн адил хамаарна.

2. Тус улсад шашны байгууллагын шугамаар шашин-номын зорилгоор ирсэн бусад гадаадын иргэн, харьяалалгүй хүн шашны сурталчилгаа явуулахыг хориглоно.

13 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

1. Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль тогтоомж зөрчсөн нь гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй бол гэм буруутай этгээдэд Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

2. Энэ хуулийн 3 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүх 15000 хүртэл төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

3. Энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 6, 7 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 5, 6, 7 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүх 5000—25000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

Монгол Улсын Их Хурлын дарга **Н. БАГАБАНДИ**

1993 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1993 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр

Улаанбаатар хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

«Монгол Улсын төр, сүм хийдийн харилцааны тухай хууль» хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн 1934 онд Улсын 7 дугаар Их Хурлаас баталсан «Төр, шашныг тусгаарлан явуулах тухай хууль»-ийг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Их Хурлын дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1993 оны 10 дугаар сарын 11-ний өдөр | Дугаар 69 | Улаанбаатар хот

«5 ТӨГРӨГ», «1000 ТӨГРӨГ»-ийн ДЭВСГЭРТИЙГ ХУУЛЬ ЁСНЫ ТӨЛБӨРИЙН ХЭРЭГСЭЛД ТООЦОХ, ГҮЙЛГЭЭНД ГАРГАХЫГ ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. «Мөнгөн тэмдэгтийн хэв загварыг батлах тухай» Улсын Бага Хурлын 1992 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 32 дугаар тогтоолын дагуу хэвлэгдсэн «5 төгрөг», «1000 төгрөг»-ийн дэвсгэртийг Монгол Улсын хууль ёсны төлбөрийн хэрэгсэлд тооцсугай.

2. Бэлэн мөнгөний гүйлгээний байдал, хэрэгцээг харгалзан Банкны хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн «5 төгрөг», «1000 төгрөг»-ийн дэвсгэртийг гүйлгээнд гаргахыг Монголбанк (Д. Моломжамц)-нд зөвшөөрсүгэй.

Дарга — Н. БАГАБАНДИ

Төмгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга — Н. РИНЧИНДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1993 оны 10 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар 70

Улаанбаатар хот

Н. ЖАНЦАННОРОВЫГ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНЭЭС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 2-т заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Улсын Их Хурлын гишүүн Нацагийн Жанцанноровыг өөрийн нь гаргасан хүсэлт, эрүүл мэндийн байдлыг харгалзан Монгол Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлсүгэй.

Дарга Н. БАГАБАНДИ

Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Н. РИНЧИНДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1993 оны 10 дугаар сарын 21-ний өдөр

Дугаар 71

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 1993 ОНЫ НАМРЫН ЧУУЛГАНААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Их Хурлын 1993 оны намрын чуулганаар дор дурдсан хуулийн төсөл хэлэлцүүлэхээр тогтоосугай:

1) Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль

2) Хөдөлмөрийн хамтын маргааны тухай хууль

3) Архидан согтуурах явдалтай тэмцэх тухай хууль

4) Статистикийн тухай хууль

5) Гадаадын иргэд, харьяалалгүй хүмүүсийн эрх зүйн байдлын тухай хууль

6) Гадаад валютын үйл ажиллагааг зохицуулах тухай хууль

7) Орлого тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээнээс хураах татварын тухай хууль

8) Нийгмийн даатгалын тухай багц хууль:

а) Монгол Улсын Нийгмийн даатгалын ерөнхий хууль

б) Нийгмийн даатгалын сангийн тухай хууль

в) Тэтгэвэрийн даатгалын хууль

г) Тэтгэмжийн даатгалын хууль

д) Ажилгүйдлийн даатгалын хууль

е) Үйлдвэрлэлийн ослын даатгалын хууль

9) Цагдаагийн байгууллагын тухай хууль

10) Хорих ял эдлүүлэх тухай хууль

11) Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль

12) Иргэний байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль

13) Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль

14) Газрын тухай хууль
15) Төрийн албаны тухай хууль
16) Төр, сум хийдийн харилцааны тухай хууль
17) Хүнсний хууль
18) Албан тушаалынхаа байдлыг урвуулан ашиглах, хээл хахууль авах явдалтай тэмцэх тухай хууль
19) Хүн амын нийгмийн хамгааллын тухай хууль
20) Бусад асуудал

Дарга Н. БАГАБАНДИ

Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Н. РИНЧИНДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1993 оны 10 дугаар сарын 21-ний өдөр

Дугаар 72

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН БАТЛАН ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ, ХИЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ БАТЛАГДСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Батлан хамгаалах тухай хууль, Хилийн тухай хууль батлагдсантай холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасугай:

1) зэвсэгт хүчин, бусад цэргийн бүтэц, зохион байгуулалтыг 1993 онд багтаан Батлан хамгаалах тухай хууль, Хилийн тухай хуульд нийцүүлэн шинэчлэх;

2) батлан хамгаалах үйл ажиллагаа, зэвсэгт хүчин, хилийн цэргийн талаар хүчин төгөлдөр үйлчилж байгаа

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл, Монгол Улсын Засгийн газрын тогтоол, бусад шийдвэрийг 1994 оны 1 дүгээр сарын 1-ний дотор багтаан эдгээр хуульд нийцүүлэх;

3) Батлан хамгаалах тухай хууль, Хилийн тухай хуульд заасан дүрэм, журам, зааврыг 1994 оны 4 дүгээр сарын 1-ний дотор шинэчлэн, боловсруулж гаргах;

4) батлан хамгаалах үйл ажиллагаа, зэвсэгт хүчин, бусад цэргийн шинэчлэлийн асуудлаар иж бүрэн хөтөлбөр боловсруулж 1993 онд багтаан Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд оруулах.

2. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавихыг Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хороонд даалгасугай.

Дарга Н. БАГАБАНДИ

Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Н. РИНЧИНДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1993 оны 10 дугаар сарын 25-ны өдөр | Дугаар 73 | Улаанбаатар хот

ДҮРЭМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. «Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны дүрэм»-ийг хавсралтын ёсоор баталсугай.

2. Энэ дүрмийг 1993 оны 10 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Дарга Н. БАГАБАНДИ

Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Н. РИНЧИНДОРЖ

Монгол Улсын Их Хурлын 1993 оны
73 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ДҮРЭМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Энэ дүрмийн зорилт нь Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасны дагуу Улсын Их Хурлын Байнгын хороо (цаашид энэ дүрэмд «Байнгын хороо» гэх)-ны үндсэн болон тодорхой бүрэн эрх, түс бүрийн чиг үүрэг, ажлын зохион байгуулалт, үйл ажиллагааг тодорхойлоход оршино.

2 дугаар зүйл. Байнгын хороо нь Улсын Их Хурлын ажлын зохион байгуулалтын хэлбэр мөн. Байнгын хороо нь Улсын Их Хурлаар хэлэлцэх асуудал боловсруулах, Улсын Их Хуралд өргөн барьсан хууль, бусад шийдвэрийг урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт, тогтоол гаргах, Улсын Их Хурлаас гаргасан хууль, бусад шийдвэрийн биелэлтэд хяналт тавих, түүнчлэн эрхлэх асуудлынхаа хүрээнд хяналт шалгалт хийх нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3 дугаар зүйл. Байнгын хорооны үйл ажиллагаа нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан зарчим, мөн Улсын Их Хурлын тасралтгүй ажиллагааг хангах, асуудлыг цөөнхийг хүндэтгэж, олонхоор шийдвэрлэх нэгдэл байх зарчимд үндэслэнэ.

4 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан тооны Байнгын хороо байх бөгөөд Байнгын хорооны гишүүдийн тоо мөн зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар тодорхойлогдоно.

5 дугаар зүйл. Байнгын хорооны бүрэлдэхүүнийг Улсын Их Хурлын гишүүдийн саналыг үндэслэж намын бүлэг Улсын Их Хурлын даргатай зөвшилцөнө. Намын бүлэгт харьяалагдаагүй Улсын Их Хурлын гишүүн аль нэгэн Байнгын хороонд орох саналаа Улсын Их Хурлын даргад шууд өгнө.

Улсын Их Хурлын дарга Байнгын хорооны бүрэлдэхүүний талаархи саналаа Улсын Их Хуралд оруулан батлуулж, тогтоол гаргана.

Улсын Их Хурлын гишүүний Байнгын хорооны харьяаллыг солих, нэхэн сонгохдоо энэ зүйлд заасан журмыг баримтална.

6 дугаар зүйл. Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл Байнгын хорооны дотор тухайн Байнгын хорооны гишүүдээс бүрдсэн дэд хороо байгуулж болно. Дэд хороо нь тухайн байнгын хорооны үйл ажиллагааны тодорхой чиглэлийг эрхлэн хариуцаж, туслах үүрэгтэй.

7 дугаар зүйл. Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай саналыг Хурал, захиргааны байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж, Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд оруулан шийдвэрлүүлнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Улсын Их Хурлын Байнгын хорооны үндсэн болон тодорхой бүрэн эрх

8 дугаар зүйл. Байнгын хороо нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндсэн бүрэн эрхээс гадна тус тусын эрхлэх асуудлаар дараахь тодорхой бүрэн эрх эдэлнэ:

1) салбарын төрийн бодлогын чиглэлийг тодорхойлох;

2) хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах. Энэ зорилгоор ажлын хэсэг байгуулж ажиллуулах;

3) улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлох, Засгийн газрын үйл ажиллагааны хэтөлбөрт санал, дүгнэлт өгөх;

4) улсын төсвийн төсөлд санал, дүгнэлт өгөх;

5) Ерөнхийлөгчийн хоригийг урьдчилан хэлэлцэж, саналаа Улсын Их Хуралд оруулах;

6) Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг урьдчилан хэлэлцэж саналаа Улсын Их Хуралд оруулах;

7) ард нийтийн санал асуулга явуулах тухай саналыг Улсын Их Хуралд оруулах;

8) эрхлэх асуудлынхаа хүрээнд Улсын Их Хурлаас томилогддог, сонгогдсон албан тушаалтны илтгэл, сонсголыг авч хэлэлцэх, мөн тэдгээрийг томилох, сонгох, огцруулах тухай санал дүгнэлт гаргах;

9) хууль, Улсын Их Хурлын болон бусад шийдвэрийн биелэлтийг дангаараа буюу мэргэжлийн байгууллагыг татан оролцуулж хянан шалгах.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Улсын Их Хурлын Байнгын хорооны тусгай чиг үүрэг

9 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах байнгын хороо:

1) газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал, агаар мандал болон байгалийн бусад баялаг;

2) ус цат уурын албаны бодлого;

3) байгаль орчин тогтвортой хөгжил байгалийн тэнцэл;

4) геологи, эрдэс түүхий эдийн талаарх бодлого;

5) ашигт малтмал олборлолт, нефть, хими, металл боловсруулалтын бодлого;

6) геологи, уул уурхай, байгаль орчны төрийн хяналт.

10 дугаар зүйл. Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байнгын хороо:

1) боловсролыг хөгжүүлэх бодлого;

2) оюуны өмчийн эрх зүйн үндэс;

3) монгол хэл, бичиг, үндэстний цөөнхийн хэл, бичиг, соёл, урлаг, ёс заншлын талаархи баримтлах бодлого;

4) шинжлэх ухаан, технологийн бодлого;

5) соёл, урлагийн хөгжлийн бодлого;

6) ард түмний түүх, соёл, оюуны өвийг сэргээх, хамгаалах талаарх бодлого.

11 дүгээр зүйл. Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хороо:

1) төрийн гадаад бодлого;

2) батлан хамгаалах бодлого;

3) улсын хилийн асуудал;

4) улсын аюулгүй байдлын асуудал;

5) иргэний хамгаалалтын асуудал;

6) Монгол Улсын иргэний харьяалал болон тус улсын иргэд гадаадад явах, гадаадын иргэд тус улсад зорчих, оршин суух тухай асуудал.

12 дугаар зүйл. Дотоод асуудлын байнгын хороо:

1) Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн асуудал;

2) Улсын Их Хурлын гишүүний ёс зүй;
3) Улсын Их Хурлын гишүүний хөдөлмөр, ахуйн асуудал;
4) Улсын Их Хурал, намын бүлгийн болон Улсын Их Хурлын гишүүний төсвийн хяналт;
5) Улсын Их Хурлын гишүүний орлогын мэдүүлэг;
6) Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн биелэлт;
7) Улсын Их Хурлын чуулганаар нэмж хэлэлцүүлэх асуудал.

13 дугаар зүйл. Төсөв, санхүү, мөнгө, зээлийн бодлогын байнгын хороо:

1) төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого;
2) улсын төсөв;
3) Монголбанкны зохион байгуулалт, үйл ажиллагаа.

14 дүгээр зүйл. Хурал, захиргааны байнгын хороо:

1) төрийн эрх барих дээд болон гүйцэтгэх дээд байгууллага, Ерөнхийлөгчийн байгуулалт;
2) Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын сонгууль;
3) Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, хилийн цэс, түүний удирдлагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагаа;
4) төрийн алба;
5) ард нийтийн санал асуулгын эрх зүйн үндэс;
6) төрийн бэлгэ тэмдэг, төрийн дууллын асуудал;
7) төр, сүм хийдийн харилцааны асуудал;
8) хэвлэл, мэдээллийн эрх зүйн үндэс;
9) нам, олон нийтийн байгууллагын харилцааны асуудал;
10) Улсын Их Хурлын дэргэдэх сургалт, эрдэм шинжилгээний байгууллага.

15 дугаар зүйл. Хууль зүйн байнгын хороо:

1) Монгол Улсын эрх зүйн бодлого;
2) хүний эрх, эрх чөлөөг хангах төрийн бодлого;
3) шүүх, прокурор, мөрдөн байцаах, хорих байгууллагын асуудал;
4) өршөөл үзүүлэх асуудал, түүний эрх зүйн үндэс;
5) нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийн эрх зүйн үндэс;
6) хууль зүйн харилцлага хүлээлгэх эрх зүйн үндэс.
7) эрүү, иргэн, захиргааны байцаан шийтгэх ажилласааны эрх зүйн үндэс.

16 дугаар зүйл. Хүн ам зүй, эрүүл мэнд, хөдөлмөр, нийгэм хангамжийн байнгын хороо:

1) хүн амын бодлого;
2) хүн амын эрүүл мэндийг хамгаалах бодлого;
3) хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа;
4) нийтийн даатгал, хангамж, халамж;
5) рашаан сувилал, нийтийн биеийн тамир, спорт.

17 дугаар зүйл. Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо:

1) мал аж ахуйн бодлого;
2) газар тариалангийн бодлого;
3) хүнсний үйлдвэрлэл, хангамж, аюулгүй байдлын бодлого;
4) хөдөөгийн нийгмийн бодлого;
5) хөдөө аж ахуйн эдэлбэр газрын ашиглалтын бодлого;
6) усны бодлого.

18 дугаар зүйл. Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн бодлогын байнгын хороо:

1) эдийн засгийн гадаад, дотоод бодлого;
2) улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн жилийн үндсэн чиглэл;
3) үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжил;
4) төрийн өмчийн асуудал;
5) статистик;
6) бизнесийн асуудал.

19 дүгээр зүйл. Энэ дүрэмд заагдаагүй боловч Улсын Их Хурлын аль нэгэн байнгын хороонд зайлшгүй харицаа шаардлагатай гэж үзсэн чиг үүргийг Улсын Их Хурлын дарга тухайн Байнгын хороонд хуваарилан гүйцэтгүүлж болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Их Хурлын Байнгын хорооны ажлын зохион байгуулалт, үйл ажиллагаа

20 дугаар зүйл. Байнгын хорооны ажлын зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хуралдаан мөн. Байнгын хорооны хуралдааныг долоо хоногийн Лхагва, Бямба гаригт хийнэ. Улсын Их Хурлын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан тохиолдолд Баасан гаригт, түүнчлэн Байнгын

хорооны дарга шаардлагагүй гэж үзвэл, тухайн өдрийн чуулганы хуралдааны дараа тус тус хуралдаан хийж болно. Улсын Их Хурлын даргын даалгаврааp Дотоод асуудлын байнгын хороо чуулганы үеэр хуралдаан хийж болно.

21 дүгээр зүйл. Хуралдааныг Байнгын хорооны даргын товлосноор хийнэ. Тухайн Байнгын хорооны гишүүдийн олонхи шаардсанаар, эсхүл Улсын Их Хурлын дарга, дэд даргын санал болгосноор Байнгын хорооны хуралдааныг хийж болно.

22 дугаар зүйл. Хуралдааныг Байнгын хорооны бүх гишүүдийн дийлэнх олонхи хүрэлцэн ирснээр хүчин төгөлдөрт тооцно. Хуралдаанд тухайн Байнгын хорооны гишүүн бус Улсын Их Хурлын гишүүд зөвлөх эрхтэй оролцоно.

23 дугаар зүйл. Хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын тухай хууль болон энэ дүрэмд заасан Байнгын хорооны бүрэн эрхэд хамаарах асуудал, түүнчлэн Улсын Их Хурлаас даалгасан бусад асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.

24 дүгээр зүйл. Байнгын хорооны хуралдаан болох газар, цагийг 3 хоногийн өмнө Улсын Их Хурлын гишүүдэд мэдэгдэнэ. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх хууль, бусад шийдвэрийн төсөл, баримт бичгийг Улсын Их Хурлын гишүүдэд дээрх хугацаанд тараана.

25 дугаар зүйл. Байнгын хорооны хуралдаанд дор дурдсан журмыг баримтална:

1) хуралдааныг Байнгын хорооны дарга нээж, хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг Байнгын хорооны гишүүд зөвшөөрч байгаа эсэхийг шийдсэний үндсэн дээр хэлэлцэх асуудлыг тодотгож, төлөвлөгөөнд орсон дарааллын дагуу нэг асуудлыг хэлэлцэж дуусаад дараагийнхыг хэлэлцэнэ;

2) хууль санаачлагч болон асуудал оруулж байгаа албан тушаалтны илтгэл сонссоны дараа байнгын хорооны гишүүд асуулт тавьж хариулт авна. Илтгэл, сонгол тавих хугацаа 20 минутаас илүүгүй байна;

3) асуулт хариулт дууссаны дараа гишүүд санал гаргана. Санал гаргаж, үг хэлэх хугацаа 7 минутаас хэтрэхгүй байна;

4) асуулт хариулт, санал нь зөвхөн хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой, товч тодорхой байна;

5) хуралдаан даргалагч хэлэлцэж байгаа асуудлын талаар гарсан саналыг нэгтгэн дүгнэж, тодорхой томьёоллоор санал хураалт явуулна;

6) тухайн асуудлаар санал хураалт явуулсны дараа цөөнх болсон гишүүд тайлбар хэлж, дахин санал хураалт явуулж болно. Санал хураалтад нэг томьёолол 2 удаа олонхийн дэмжлэг авсан бол уг томьёолол батлагдсанд тооцно. Харин 2 дахь удаа олонхийн дэмжлэг аваагүй бол цөөнх тайлбар хэлж, 2 дахь санал хураалтад олонхийн дэмжлэг авсан томьёоллоор дахин нэг удаа санал хураалт явуулж олонхийн санал авсан томьёоллоор уг томьёолол батлагдсанд тооцно.

26 дугаар зүйл. Байнгын хороо Улсын Их Хуралд хэлэлцүүлэх хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн талаар санал дүгнэлт, төслийг хууль санаачлагчид буцаах, ажлын хэсэг байгуулах болон зохион байгуулалтын чанартай бусад асуудлаар тогтоол гаргана. Санал дүгнэлт, тогтоолыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар батална. Цөөнхийн саналыг санал дүгнэлтэд тусгайлан хавсаргана. Тухайн асуудлаар Байнгын хорооны гишүүдийн санал тэнцвэл хуралдаан даргалагчийн саналаар дахин санал хураалт явуулна.

27 дугаар зүйл. Хуралдааны явцыг баримтжуулах ажлыг Тамгын газар эрхлэн гүйцэтгэх бөгөөд хуралдааны явцын тэмдэглэлийг гараар болон соронзон хальсанд тэмдэглэнэ. Шаардлагатай гэж үзвэл хуралдааны явцын талаар дуутай дүрс бичлэг хийж болно.

28 дугаар зүйл. Байнгын хороо нь хэтийн болон жилийн төлөвлөгөөтэй ажиллана. Хэтийн төлөвлөгөөг Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаагаар хийнэ. Төлөвлөгөөг Байнгын хорооны хуралдаанаар батална.

29 дүгээр зүйл. Байнгын хороо хяналт шалгалт хэрэгжүүлэхдээ дараахь журмыг баримтална:

1) Байнгын хороо эрхлэх асуудлаараа төрийн тодорхой байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт шалгалт явуулна. Түүнчлэн Улсын Их Хурлын даалгаврааар буюу түүний зөвшөөрлөөр хуулийн биелэлтийг улсын хэмжээнд хянан шалгаж болно;

2) хяналт шалгалтанд Улсын Их Хурлын гишүүд, төрийн хяналтын байгууллагын ажилтан, мэргэжилтнийг татан оролцуулна;

3) хяналт шалгалтын дүнг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж, цаашид авах арга хэмжээг тодорхойлно

Шаардлагатай гэж үзвэл Улсын Их Хуралд танилцуулж шийдвэр гаргуулна.

30 дугаар зүйл. Байгууллагын хороог Улсын Их Хурлаас 1 жилийн хугацаатай сонгогдсон дарга толгойлно. Байгууллагын хорооны даргыг улируулан сонгож болно.

Байгууллагын хорооны дарга түр эзгүйд Улсын Их Хурлын дарга шаардлагатай гэж үзвэл, түүний үүргийг аль нэг гишүүнээр гүйцэтгүүлэхээр захирамж гаргаж болно. Харин Байгууллагын хорооны дарга 7 хоногоос дээш хугацаагаар эзгүй байх тохиолдолд Улсын Их Хурлын дарга түүний үүргийг аль нэг гишүүнд хариуцуулж захирамж гаргана. Захирамжийг Улсын Их Хурлын нийт гишүүдэд танилцуулна.

31 дүгээр зүйл. Байгууллагын хорооны дарга дараахь ажлыг эрхэлнэ:

1) Байгууллагын хорооны хуралдааны бэлтгэлийн ажлыг зохион байгуулж, хуралдааны бэлтгэлийг хангуулах;

2) Байгууллагын хорооны нэрийн өмнөөс бусад байгууллагатай харьцах;

3) Байгууллагын хорооны ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцан тайлагнах;

4) Байгууллагын хорооны ажлын аппарат болон тодорхой төслийг боловсруулахаар Байгууллагын хорооноос байгуулсан ажлын хэсгийн ажлыг уялдуулан зохицуулах;

5) Байгууллагын хорооны гишүүдийн саналыг үндэслэн тэдэнд ажил хуваарилах;

6) Байгууллагын хорооны тогтоолд гарын үсэг зурж ёсчлох.

32 дугаар зүйл. Байгууллагын хорооны гишүүн нь Байгууллагын хорооны эрхлэх асуудлын чиглэлээр өөрт нь хариуцуулсан ажил үүргийг биелүүлж, үүний тулд Байгууллагын хороо, Улсын Их Хурлын удирдлагаас зохих дэмжлэг туслалцаа авах эрхтэй.

33 дугаар зүйл. Байгууллагын хорооноос энэ дүрэмд заасан үүрэгт ажлаа явуулахад Улсын Их Хурлын Тамгын газар мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

1993 оны 10 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 74

Улаанбаатар хот

САНАЛ ХУРААХ КОМИСС БАЙГУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Их Хурлын байнгын хороодын дарга нарыг сонгох ажлыг зохион байгуулж, дүнг илтгэх үүрэг бүхий санал хураах комиссыг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга	Д. Дагвасүрэн
Комиссын нарийн бичгийн дарга	Д.Батбаатар
Гишүүн	Н. Ганбямба
Гишүүн	Р. Цагаанхүү
Гишүүн	Р. Гончигдорж

Дарга **Н. БАГАБАНДИ**

Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга **Н. РИНЧИНДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1993 оны 10 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 75

Улаанбаатар хот

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЗАРИМ БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГЫГ СОНГОХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан журмын дагуу Улсын Их Хурлын зарим байнгын хорооны даргад нэр дэвшүүлэн ,хэлэлцэж, нууцаар санал хураасан тухай санал хураах комиссын 1993 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 1, 2, 3 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Байгаль орчныг хамгаалах байнгын хорооны даргаар Мондооны Мэндбилэг.

2. Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байнгын хорооны даргаар Базарын Дэмбэрэл.

3. Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хорооны даргаар Данзангийн Лүндээжанцан.

4. Дотоод асуудлын байнгын хорооны даргаар Самдангийн Чулуунбаатар.

5. Төсөв, санхүү, мөнгө, зээлийн бодлогын байнгын хорооны даргаар Аюурзанын Базархүү.

6. Хурал, захиргааны байнгын хорооны даргаар Ажханы Болат.

7. Хууль зүйн байнгын хорооны даргаар Цэндийн Нямдорж.

8. Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргаар Надмидын Баяртсайхан нарыг тус тус сонгосугай.

Дарга **Н. БАГАБАНДИ**

Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга **Н. РИНЧИНДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1993 оны 10 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 76

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИД ЭРХ ОЛГОХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТУХАЙ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан «Монгол Улсын Ерөнхийлөгчид эрх олгох тухай Монгол Улсын хууль»-ийн төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооны дүгнэлт, Улсын Их Хурлын гишүүдийн гаргасан саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Хууль тогтоомжийг Үндсэн хуульд нийцүүлэн бүрэн шинэчлэх ажлын хүрээнд ойрын жилүүдэд Улсын Их Хурлаас батлах хуулийн жагсаалтад орсон бөгөөд Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд хамаарахгүй, урьд хуулиар зохицуулж байгаагүй боловч цаг алдалгүй хуулийн хэмжээнд шийдвэрлэх шаардлагатай гэж үзсэн асуудлаар Улсын Их Хурлаас хууль батлан гаргах хүртэл хугацаанд Үндсэн хууль, бусад хуульд нийцүүлэн зарлиг гаргаж байх эрхийг Монгол Улсын Ерөнхийлөгчид олгох боломжгүй гэж үзсүгэй.

2. «Монгол Улсын Ерөнхийлөгчид эрх олгох тухай хууль»-ийн төслийг хууль санаачлагчид буцаасугай.

3. Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчид тодорхой эрх олгох асуудлыг судалж Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд оруулахыг Хууль зүйн байнгын хороо, Хурал, захиргааны байнгын хороонд даалгасугай.

Дарга **Н. БАГАБАНДИ**

Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга **Н. РИНЧИНДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

1993 оны 10 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 77

Улаанбаатар хот

ЗАРИМ АЛБАН ТУШААЛТНЫ ОРЛОГО, ЭД ХӨРӨНГӨ БҮРТГЭХ ЖУРАМ ТОГТООХ ТУХАЙ ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТУХАЙ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан «Зарим албан тушаалтны орлого, эд хөрөнгө бүртгэх журам тогтоох тухай» тогтоолын төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооны дүгнэлтийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Зарим албан тушаалтны орлого, эд хөрөнгө бүртгэх журам тогтоох тухай асуудлыг «Хээл хахууль авах, албан тушаалаа урвуулан ашиглах явдалтай тэмцэх тухай хууль»-ийн төслийн хамт иж бүрнээр хэлэлцэн шийдвэрлэх нь зүйтэй гэж үзсүгэй.

Дарга **Н. БАГАБАНДИ**

Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга **Н. РИНЧИНДОРЖ**

МОНГӨЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТӨГТООЛ

1993 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр

Дугаар 78

Улаанбаатар хот

ХӨДӨЛМӨРИЙН ХАМТЫН МАРГААН ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ, ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛҮҮДИЙН ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ БАТЛАГДСАНТАЙ ХОЛБОГДУУЛЖ АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуульд заасны дагуу аж ахуйн нэгж, байгууллага дахь үйлдвэрчний эвлэлийг бүртгэх бэлтгэлийг 1994 оны 1 дүгээр сарын 1-ний дотор хангахыг Засгийн газарт даалгасугай.

2. «Дүрэм батлах тухай» БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1990 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн 99 дүгээр зарлигийг Монгол Улсын Хөдөлмөрийн хамтын маргаан зохицуулах тухай хууль хүчин төгөлдөр болох өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

Дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1993 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр

Дугаар 79

Улаанбаатар хот

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЗАРИМ БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГЫГ СОНГОХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын зарим Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэн хэлэлцэж, санал хураах комиссын 1993 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн 1, 2 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Нэг. Хүн ам зүй, эрүүл мэнд, хөдөлмөр, нийгэм хангамжийн байнгын хорооны даргаар Доржийн Мөнхөө, Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн бодлогын байнгын хорооны даргаар Гүржавын Цэдэндагва нарыг түр тус тус сонгосугай.

Хоёр. Энэ тогтоолыг 1993 оны 11 дүгээр сарын 9-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Дарга Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1993 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр

Дугаар 80

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮНИЙГ ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Нэг. Монгол Улсын Их Хурлын Байнгын хороодын бүрэлдэхүүнийг дараахь байдлаар тогтоосугай:

1. Байгаль орчныг хамгаалах байнгын хороо:

1.) Н. Багабанди
2) Д. Базарсад
3) Д. Батбаатар
4) Ж. Батсуурь
5) Х. Володя
6) А. Ганбаатар
7) Б. Ганболд
8) Ч. Ган-Өлзий
9) М. Мэндбилэг
10) Н. Тогтох
11) Г. Төртогтох
12) Ж. Уртнасан
13) Ч. Хурц
14) Б. Чимид
15) Ц. Шаравдорж

2. Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байнгын хороо:

1) Ё. Адилбиш
2) Ж. Алгаа
3) О. Батмөнх
4) С. Батмөнх
5) Ж. Батсуурь
6) Ж. Болдбаатар
7) Ц. Ганбат
8) Г. Ганболд
9) Т. Ганди
10) Р. Гончигдорж
11) Б. Дэмбэрэл
12) М. Зэнээ
13) Б. Лхагвасүрэн
14) Н. Тогтох
15) Г. Төртогтох
16) Ш. Чунаг
17) Н. Энхбаяр

3. Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хороо:

1) Д. Базарсад
2) Д. Батбаатар
3) Ц. Ганбат
4) Н. Ганбямба
5) Т. Ганди
6) Ц. Гомбосүрэн
7) Р. Гончигдорж
8) Д. Дагвасүрэн
9) Н. Жалбажав
10) П. Жасрай
11) С. Зориг
12) Ч. Зоригтбаатар
13) М. Зэнээ
14) Б. Лхагвасүрэн
15) Д. Лүндээжанцан
16) Т. Султан
17) С. Төмөр
18) Г. Төртогтох
19) Б. Чимид
20) Ц. Шаравдорж
21) Ц. Элбэгдорж
22) Т. Эрдэнэбилэг

4. Дотоод асуудлын байнгын хороо:

1) Ё. Адилбиш
2) А. Базархүү
3) Ж. Болдбаатар
4) Ж. Бямбажав
5) А. Ганбаатар
6) Ж. Гомбожав
7) Ч. Дашдэмбэрэл
8) Д. Дэмбэрэл
9) Ж. Жадамбаа
10) С. Зориг
11) Г. Зуунай
12) М. Зэнээ
13) Ж. Норовсамбуу
14) Ц. Нямдорж
15) С. Чулуунбаатар
16) Ш. Чунаг

5. Төсөв, санхүү, мөнгө, зээлийн бодлогын байнгын хороо:

1) А. Базархүү
2) Ш. Батбаяр
3) Ч. Баянжаргал
4) Н. Баяртсайхан
5) Д. Ганболд
6) С. Гүндэнбал
7) Д. Дагвасүрэн
8 М. Далайхүү
9 Д. Данзан
10) Ж. Дэлгэрцэцэг
11) Д. Дэмбэрэл
12) Д. Мөнхөө
13) С. Нямзагд
14) Т. Очирхүү
15) Г. Цэдэндагва
16) Т. Эрдэнэбилэг

6. Хурал, захиргааны байнгын хороо:

1) Д. Батбаатар
2) С. Батмөнх
3) О. Батмөнх
4) А. Болат
5) Ж. Бямбадорж
6) Б. Ганболд
7) Д. Ганболд
8) Ч. Ган-Өлзий
9) Б. Гомбо
10) С. Гүндэнбал
11) Д. Дашцэдэн
12) Ж. Жадамбаа

13) Ч. Зоригтбаатар
14) С. Төмөр
15) Ц. Төрмандах
16) Ш. Чунаг
17) О. Шаалуу
18) Л. Энэбиш

7. Хууль зүйн байнгын хороо:

2) Ж. Бямбажав
1) Ж. Бямбадорж
3) Х. Володя
4) Г. Ганболд
5) Б. Гомбо
6) Р. Гончигдорж
7) М. Далайхүү
8) М. Дашцэдэн
9) С. Зориг
10) Ч. Зоригтбаатар
11) С. Нарангэрэл
12) Ц. Нямдорж
13) С. Нямзагд
14) С. Төмөр
15) Ц. Төрмандах
16) Ц. Шаравдорж
17) Ц. Элбэгдорж

8. Хүн ам зүй, эрүүл мэнд, хөдөлмөр, нийгэм хангамжийн байнгын хороо:

1) Ш. Батбаяр
2) Ж. Батсуурь
3) Ж. Бямбажав
4) А. Ганбаатар
5) Б. Дэмбэрэл
6) Н. Жалбажав
7) Г. Зуунай
8) Д. Мөнхөө
9) Ц. Намхайнямбуу
10) Ц. Товуусүрэн
11) Ц. Төрмандах
12) С. Чулуунбаатар
13) Н. Энхбаяр

9. Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо:

1) О. Батмөнх
2) Н. Баяртсайхан
3) А. Болат
4) Д. Дагвасүрэн
5) М. Далайхүү
6) Ч. Дашдэмбэрэл
7) Ж. Жадамбаа
8) Д. Идэвхтэн
9) М. Мэндбилэг
10) Ц. Намхайнямбуу
11) С. Нарангэрэл
12) Ж. Норовсамбуу
13) Ж. Уртнасан
14) Р. Цагаанхүү
15) Ц. Элбэгдорж

10. Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн бодлогын байнгын хороо:

1) Ж. Алгаа
2) Ч. Баянжаргал
3) Г. Ганболд
4) Д. Ганболд
5) Н. Ганбямба
6) Д. Данзан
7) Ж. Дэлгэрцэцэг
8) Д. Дэмбэрэл

9) Д. Идэвхтэн
10) Т. Очирхүү
11) Ч. Пүрэвдорж
12) Т. Султан
13) Ц. Товуусүрэн
14) Н. Тогтох
15) Ч. Хурц
16) Р. Цагаанхүү
17) Г. Цэдэндагва
18) О. Шаалуу
19) Т. Эрдэнэбилэг

Хоёр. Энэ тогтоолыг 1993 оны 11 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гурав. Монгол Улсын Их Хурлын 1992 оны 8 дугаар тогтоолыг энэ тогтоол хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

Дарга Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1993 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр

Улаанбаатар хот

Дугаар 81

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТИЙН ЯВЦЫН ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар авсан арга хэмжээ, дүгнэлт, зорилтын тухай Монгол Улсын Ерөнхий сайд П. Жасрайн илтгэлийг сонсоод Монгол Улсын Их Хурлаас ТЭМДЭГЛЭХ нь:

Манай орны эдийн засаг, нийгмийн амьдрал нэн хүндрэлтэй үед Засгийн газар шинээр байгуулагдаж үйл ажиллагаагаа эхлэв.

Өнгөрсөн нэг жилийн хугацаанд Засгийн газар төрийн захиргааны байгууллагын шинэ тогтолцоог төв, орон нутагт бүрдүүлэх, эдийн засгийг зах зээлийн харилцаанд тууштай шилжүүлэх орчин нөхцөл, эрх зүйн үндсийг буй болгох, шилжилтийн үеийн сөрөг үр дагавраас хүн амын эмзэг хэсгийг хамгаалахад анхаарлаа төвлөрүүлэн ажиллажээ.

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш, үнэ, тарифыг чөлөөт тогтолцоонд шилжүүлж, мөнгө, зээл, санхүүгийн хатуу бодлогыг хэрэгжүүлсэн нь эдийн засгийг жолоодлогогүй инфляцаас сэргийлэх, цаашид эрүүлжүүлэхэд чиглэгдсэн чухал алхам болов.

Валютын болон чухал хэрэгцээт барааны улсын нөөцийг сэргээх, хугацаа хэтэрсэн гадаад өрийн дарамтыг хөнгөлөх талаар мэдэгдэм ахиц гаргасан байна.

Эдгээр нь макро түвшний удирдлагыг хүчтэй болгох талаар Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн үндсэн зорилтууд хэрэгжин эхэлж байгааг харуулж байна.

Эдийн засгийг зах зээлийн харилцаанд шилжүүлэх талаар Засгийн газраас авч буй арга хэмжээг олон улсын байгууллага, дэлхийн олон орон талархан дэмжиж, хандивлагч орнуудын хүрээ өргөжсөөр байна.

Ажлын зарим тодорхой эхлэл, ахиц байгаа боловч эдийн засагт хямрал үргэлжилж үйлдвэрлэлийн бууралт зогсохгүй байгааг Засгийн газрын үйл ажиллагаатай холбон үзэх ёстой.

Дотоодын түүхий эдэд тушиглэсэн үйлдвэрлэлийн хэмжээ буурч, хүн ам өргөн хэрэглээний гол нэр төрлийн бүтээгдэхүүнээр гачигдаж байхад түүхий эдийг хилийн худалдаагаар гадагш гаргах явдал үлэмж нэмэгдэж байна. Энэ талаар Засгийн газраас зохицуулалтын оновчтой арга хэмжээ аваагүй байна.

Улс орны эдийн засгийг хямралаас гаргахад дорвитой нөлөө үзүүлж чадахуйц үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд чиглэгдсэн хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих эдийн засгийн нөлөөтэй арга хэмжээ аваагүй, санхүү, мөнгө, зээлийн хөшүүргийг зохистой ашиглаж чадаагүй байна.

Засгийн газар төрийн өмчийн болон төрийн өмч давамгайлсан үйлдвэр, аж ахуйн нэгжид эзэн болж удирдлага, зохион байгуулалт, өмчийн хамгаалалт, ашиглалтад нь хяналт тавьж үйл ажиллагааг нь зохицуулах талаар нэн чамлалттай ажиллаж байна.

Өмч хувьчлалын анхны үр дүн болж гарсан хувьцаат компаниудад өмч хөрөнгө эзэнгүйдэж, удирдлагын тогтолцоо нь жолоодлогогүй болж хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг хохирч байна. Хувьцаат компаний ажилд оршиж байгаа дутагдлыг арилгах, өмч хувьчлалыг эрчимжүүлэх, үнэт цаасны хөёр дахь зах зээлийг нээн ажиллуулах талаар Засгийн газар цаг алдаж, санаачилга муутай ажиллажээ.

Малчид, хувийн аж ахуйтныг үйл ажиллагааны нь өвөрмөц онцлогт зохицуулан зах зээлийн харилцаанд шилжүүлэх зохион байгуулалтын зохистой тогтолцоог бүрэлдүүлж чадаагүйгээс малчид, хөдөөгийн иргэд зах зээлд шилжих үеийн сөрөг үр дагаварт нэрвэгдэж, ажиллах, амьдрах нөхцөл нь зарим талаар доройтох байдалд хүрч байна. Хөдөөд хэвлэл шуудан хүргэх ажил, ахуй соёлын үйлчилгээ зогсонги байдалд орлоо.

Нийгэм, оюуны амьдралын хүрээнд буй болсон бэрхшээл үргэлжилсээр байна. Иргэдийн хөдөлмөр эрхлэх нөхцөлийг бүрдүүлж ажилгүйдлийг багасгах чиглэлд Засгийн газраас зохиож байгаа ажил бие даасан нийгмийн бодлогын хэмжээнд хүрч чадаагүй байна.

Үнэ, тарифын өсөлтөөс үүдэн гарч байгаа сөрөг үр дагавраас хүн ам, ялангуяа түүний эмзэг хэсгийг хамгаалах талаар Засгийн газраас авч байгаа арга хэмжээ нь байдлыг зөөлрүүлэх төдийгөөр хязгаарлагдаж байна.

Шинжлэх ухаан, соёл, боловсрол, эрүүл мэндийн талаар тавьсан зорилт хугацаандаа хэрэгжихгүй, зарим талаар хүрсэн түвшин алдагдахад хүрч байна.

Нийгмийн дэг журам сахиулах, сахилга, зохион байгуулалтыг бэхжүүлэх талаархи Засгийн газрын үйл ажиллагаа сул байгаа нь тавьсан зорилтоо хэрэгжүүлэхэд багагүй саад учруулж байна.

Засгийн газраас явуулж байгаа үйл ажиллагаа нь үндсэндээ хөтөлбөрөө хэрэгжүүлж, улс орныхоо нийгэм, эдийн засгийг хямралаас гаргахад чиглэгдэж байна гэж дүгнэж Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор дараахь арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай:

1) эдийн засгийн макро түвшний тогтворжилтын нааштай эхлэлийг бэхжүүлэн үндэсний үйлдвэрлэлийг сэргээж идэвх-

жүүлэх явдал нь эдийн засгийг хямралаас гаргах үндсэн нөхцөл гэж үзэж үйл ажиллагаагаа түүнд чиглүүлэх;

2) төрийн өмчийн аж ахуйн нэгжийн ашиг орлого, цалингийн сан, валютын нөөц, хөрөнгө оруулалтын зарцуулалт, ашиглалтад тавих хяналтыг чангатгаж нэгдсэн бодлогод захируулах, түүнчлэн төрийн өмчийн оролцоо бүхий хувьцаат компаниудад төрийн төлөөллийн тогтолцоог бүрдүүлж зүгшрүүлэх;

3) хувийн аж ахуйтан-малчид, тариаланчид хоршин ажиллах замаар хөдөөгийн онцлогт тохирсон зах зээлийн оновчтой дэд бүтцийг бүрдүүлэхэд чиглэсэн санаачилгыг бүх талаар дэмжин ажиллах;

4) тодорхой хөтөлбөрийн дагуу иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дээшлүүлэх, хүн амын эмзэг давхаргыг хамгаалах;

5) шинжлэх ухаан, соёл, боловсрол, эрүүл мэнд, нийгэм хангамжийн салбарыг зах зээлийн харилцааны нөхцөлд зохицуулан өөрчлөн шинэчлэх ажлыг эрчимжүүлэх;

6) нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг бүхий л талаар дэмжих, энэхүү байгууллага, Засаг дарга, яамдын уялдаа холбоог нягтруулах;

7) шүүх, прокурорын байгууллагаас үйл ажиллагаагаа идэвхтэй үр нөлөөтэй явуулах нөхцөл, бололцоог бүрдүүлэх;

8) Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын тухай тайланг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын Байнгын хороод, гишүүдээс гаргасан санал, дүгнэлт, шүүмжлэлийг судалж, үйл ажиллагаандаа харгалзан үзэж ажиллах;

9) Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын талаар Улсын Их Хурлын жил бүрийн намрын чуулганы эхэнд тайлагнаж байх.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан «Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн тухай» Монгол Улсын Их Хурлын 1992 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн 27 дугаар тогтоолын 2 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

Дарга Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1993 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр

Дугаар 82

Улаанбаатар хот

ДЭД ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮНИЙГ ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын Байнгын хороодын бүрэлдэхүүнийг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Хүний эрхийн дэд хороог дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

1) Ж. Бямбадорж
2) Х. Володя
3) Г. Ганболд
4) Р. Гончигдорж
5) С. Зориг
6) С. Төмөр
7) Ц. Элбэгдорж

2. Хээл хахууль авах, албан тушаалаа урвуулан ашиглах явдалтай тэмцэх дэд хороог дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

1) Ж. Болдбаатар
2) А. Ганбаатар
3) С. Зориг
4) Г. Зуунай
5) М. Зэнээ
6) Ж. Норовсамбуу

3. Улсын Их Хурлын 1993 оны 66 дугаар тогтоолын 1 дэх заалт, 67 дугаар тогтоолын 1 дэх заалтад заасан дэд хороодын бүрэлдэхүүнийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэ тогтоолыг 1993 оны 11 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

1993 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр

Дугаар 83

Улаанбаатар хот

ЗАРИМ ГАЗРЫГ УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТАД АВАХЫГ ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлас ТОГТООХ нь:

1. Байгалийн бүс, бүслүүрийн үндсэн хэв шинжийг төлөөлөх өвөрмөц тогтоцтой, ховор амьтан, ургамал бүхий дор дурдсан нутаг дэвсгэрийг:

1) Увс нуурын ай савын Увс нуур, Түргэн уул, Торхилог, Тэсийн голын адаг, Цагаан шувуут уул, Алтан элсний орчмыг хэсэгчлэн хамарсан Увс нуурын ай савын дархан цаазтай газар;

2) Туул голын эх, Хэнтийн нурууны өвөр хэсгийг хамарсан Горхи-Тэрэлжийн; Говь гурван сайхан, Нэмэгт уул, Хонгорын элс, Хэрмэн цавыг хамарсан Говь гурван сайханы байгалийн үндэсний цогцолборт газар;

3) ой хээр, хээрийн бүсийн онцлогийг хадгалсан Туул голын сав дахь Хустайн нурууг Хустайн; Хэнтий нурууны салбар болох Угтам уулыг Угтамын; монгол бөхөнгийн байршил болох Шаргын говь, Манханы талын хэсэг газрыг Шарга, Манханы байгалийн нөөц газар;

4) Ганга нуур орчмын хэсэг газрыг Ганга нуурын дурсгалт газар тус тус болгож улсын тусгай хамгаалалтад авахыг Засгийн газарт зөвшөөрсүгэй.

2. Дараахь арга хэмжээ авахыг Засгийн газарт даалгасугай:

1) Энэ тогтоолын 1 дэх заалтад зааснаар улсын тусгай хамгаалалтад авахыг зөвшөөрсөн газрын хилийн зааг, тэдгээрийн хамгаалалтын горимыг баталж, тухайн нутаг дэвсгэр дээр улсын тусгай хамгаалалттай газрын дүрэмд нийцэхгүй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг 1993 онд багтаан зохицуулах;

2) улсын тусгай хамгаалалттай газрын эрх зүйн үндсийг боловсруулж, холбогдох хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн барих.

Дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1993 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр

Дугаар 84

Улаанбаатар хот

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Т. ЭРДЭНЭБИЛЭГИЙН БҮРЭН ЭРХИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ

Т. Эрдэнэбилэгийг Улсын Их Хурлын гишүүнээр нөхөн сонгогдсонд тооцох тухай Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн ерөнхий хорооны 1993 оны 10 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 19 дүгээр тойргоос Улсын Их Хурлын гишүүнээр нөхөн сонгогдсон Төмөр-Очирын Эрдэнэбилэгийн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсүгэй.

Дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1993 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр

Дугаар 85

Улаанбаатар хот

Т. ЭРДЭНЭБИЛЭГИЙГ БАЙНГЫН ХОРООНЫ ГИШҮҮНЭЭР БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын гишүүн Төмөр-Очирын Эрдэнэбилэгийг Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хороо, Төсөв, санхүү, мөнгө, зээлийн бодлогын байнгын хороо, Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн бодлогын байнгын хорооны гишүүнээр тус тус баталсугай.

2. Энэ тогтоолыг 1993 оны 11 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1993 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр

Дугаар 86

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ГИШҮҮН ТОМИЛОХ, ЦЭЦИЙН ОРОН ТООНЫ ГИШҮҮНЭЭР АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн жарантавдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, нууц санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын дээд шүүхийн санал болгосноор Суурийн Жанцанг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилсугай.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн Лэгцэгийн Баасанг цэцийн орон тооны гишүүнээр ажиллуулсугай.

3. Энэ тогтоолыг 1993 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1993 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр

Дугаар 87

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ТӨР, СҮМ ХИЙДИЙН ХАРИЛЦААНЫ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. «Монгол Улсын төр, сүм хийдийн харилцааны тухай хууль» батлагдсантай холбогдуулан даган мөрдөж байгаа хууль тогтоомжийн актуудыг түүнд нийцүүлэх арга хэмжээг 1994 оны 2 дугаар сарын 1-ний дотор авч хэрэгжүүлэхийг Засгийн газар (П. Жасрай)-т даалгасугай.

2. «Монгол Улсын төр, сүм хийдийн харилцааны тухай хууль» батлагдсантай холбогдуулан 24 (1934) оны 12 дугаар сарын 27-ны өдөр хуралдсан Улсын 7 дугаар Их Хурлын 7-ны өдрийн тогтоолын «Төр, шашныг тусгаарлан явуулах тухай хуулийг» баталсан 13 дугаар зүйл, «Төр, шашныг тусгаарласан хуульд оруулах нэмэлтийн тухай» Улсын Бага Хурлын Тэргүүлэгчид, Сайд нарын Зөвлөлийн 26 (1936) оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хамтарсан 9 дүгээр хурлын тогтоол, БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1944 оны 5 дугаар сарын 22-ны өдөр хуралдсан 34 дүгээр хурлын тогтоол, «Төр, шашныг тусгаарлан явуулах хуулийн заримзүйлийг хүчингүй болсонд тооцох тухай» БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1986 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 189 дүгээр тогтоолын 2 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 10 дугаар сарын 5-ны өдөр

Дугаар 90

Улаанбаатар хот

ЗАРИМ ХҮНИЙГ ОДОН, МЕДАЛИАР ШАГНАХ ТУХАЙ

Стандартчилал, хэмжил зүйн албанд үр бүтээлтэй ажиллаж байгааг нь үнэлж дор дурдсан хүмүүсийг Монгол Улсын одон медалиар шагнасугай.

«АЛТАН ГАДАС» ОДОНГООР:

1. Балчингийн Пэрэнлэй — Баянхонгор аймгийн стандартчилал, хэмжил зүйн төвийн захирал
2. Осорын Сампил — Үндэсний стандартчилал, хэмжил зүйн төвийн дэд захирал
3. Очирбатын Чилхаасүрэн — Мөн төвийн хэлтсийн дарга

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Дүгэржавын Бадам — Үндэсний стандартчилал, хэмжил зүйн төвийн үйлчлэгч
2. Зэвэгийн Дархижав — Мөн төвийн мэргэжилтэн
3. Лувсаншаравын Дашням — Мөн төвийн албаны дарга
4. Намжилын Долзодмаа — Завхан аймгийн стандартчилал, хэмжил зүйн төвийн шинжээч-лобарант
5. Самбуугийн Дэгмид — Улсын стандартын хэвлэх үйлдвэрийн дарга

6. Осорын Намжил — Үндэсний стандартчилал, хэмжил зүйн төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан

7. Баясгалангийн Хишигжаргал — Мөн төвийн стандартын сангийн эрхлэгч

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 10 дугаар сарын 11-ний өдөр

Дугаар 93

Улаанбаатар хот

АДУУЧИЙН БАСХҮҮ, БАЛЖИННЯМЫН МИШИГДОРЖ НАРТ МОНГОЛ УЛСЫН СПОРТЫН ГАВЬЯАТ ДАСГАЛЖУУЛАГЧ ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

Биеийн тамир, спортын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, дасгалжуулсан баг, тамирчид нь улсын болон тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд удаа дараа спортын өндөр амжилт гаргахад оруулсан хувь нэмэр, гавьяаг нь үнэлж Спорт сургалт, эрдэм шинжилгээний үндэсний төвийн захирлын туслах, бөхийн чөлөөт барилдааны олон улсын шилэгдмэл шүүгч Адуучийн Басхүү, мөн спорт сургалт эрдэм шинжилгээний үндэсний төвийн боксын дасгалжуулагч багш Балжиннямын Мишигдорж нарт Монгол Улсын спортын гавьяат дасгалжуулагч цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 10 дугаар сарын 11-ний өдөр

Дугаар 94

Улаанбаатар хот

АГВААНЫ ГАНБААТАРТ МОНГОЛ УЛСЫН СОЁЛЫН ГАВЬЯАТ ЗҮТГЭЛТЭН ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

Авьяас ур чадвараа дайчлан ажиллаж монголын үндэсний баяр наадам, цагаан сарын баярт зориулсан бөх, бусад олон зуун барилдаан, тэмцээнийг бөх судлаачийн болон урлагийн өндөр түвшинд үзэгчид, сонсогчдын таашаалд хүрэхүйц тайлбарлан бөхийн спортыг хөгжүүлэх хэрэгт оруулж байгаа онцгой хувь нэмэр, гавьяаг нь үнэлж Нийслэлийн Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Залуучууд спортын хорооны бөхийн дасгалжуулагч Агвааны Ганбаатарт Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 10 дугаар сарын 11-ний өдөр

Дугаар 95

Улаанбаатар хот

ЗАРИМ ТАМИРЧИН, ДАСГАЛЖУУЛАГЧИЙГ ОДОНГООР ШАГНАХ ТУХАЙ

Биеийн тамир, спортыг хөгжүүлэх, улсын болон тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд удаа дараа амжилт гаргасныг нь үнэлж дор дурдсан хүмүүсийг Монгол Улсын одонгоор шагнасугай.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Цэрэнбаатарын Цогтбаяр — «Алдар» нийгэмлэгийн тамирчин
2. Эрдэнэцогтын Цогтжаргал — Боксын улсын шигшээ багийн тамирчин

«АЛТАН ГАДАС» ОДОНГООР:

1. Дашиймаагийн Батмөнх — Боксын төв клубын дасгалжуулагч
2. Цагааны Батцэцэг — Шатрын улсын шигшээ багийн тамирчин

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 10 дугаар сарын 11-ний өдөр

Дугаар 96

Улаанбаатар хот

ОХУ-ЫН ЗАРИМ ХҮНИЙГ ОДОН, МЕДАЛИАР ШАГНАХ ТУХАЙ

Монгол-Оросын эдийн засаг, соёлын хамтын ажиллагааг бэхжүүлэн хөгжүүлэх үйлсэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж ОХУ-ын Буриад Улсын Хөдөө аж ахуй, хүнсний сайд Николай Намдыкович Найданов, Дуурь, бүжгийн академик театрын гоцлол дуучин, ЗХУ-ын ардын жүжигчин, Орос, Буриад улсын ардын жүжигчин Дугаржап Церенович Дашиев нарыг Монгол Улсын «Алтан гадас» одонгоор, Буриад Улсын Соёлын хөгжлийн нийгэмлэгийн ерөнхийлөгч, зураач Дашинима Дугарович Дугаровыг «Найрамдал» медалиар шагнасугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 10 дугаар сарын 23-ны өдөр

Дугаар 97

Улаанбаатар хот

Ж. ЧОЙЖАНЦАНГ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ОРЛОГЧООР ТОМИЛОХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хуралтай зөвшилцсөнийг үндэслэн Жамц овогтой Чойжанцанг Улсын ерөнхий прокурорын орлогчоор 6 жилийн хугацаагаар томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 10 дугаар сарын 25-ны өдөр

Дугаар 93

Улаанбаатар хот

ГОМБЫН ВАНДАНМАГСАР, ДАМДИНЖАВЫН ДАВААДАГВА НАРЫГ «ШУДАРГА ЖУРАМ» МЕДАЛИАР ШАГНАХ ТУХАЙ

Авхаалж самбаа, зоригт тэвчээр гарган усны үерт нэрвэгдсэн хүний амь аварч иргэний хүмүүнлэг үүргээ нэр төртэй биелүүлснийг үнэлж Хөвсгөл аймгийн Галт сумын иргэн Гомбын Ванданмагсар, нийслэлийн Мамба дацангийн лам Дамдинжавын Даваадагва нарыг Монгол Улсын «Шударга журам» медалиар шагнасугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр

Улаанбаатар хот

Дугаар 101

ШҮҮХИЙН БЭЛГЭ ТЭМДГИЙН ХЭВ МАЯГ, ЗУРАГЛАЛ, ДҮРМИЙГ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Шүүхийн бэлгэ тэмдгийн хэв маяг, зураглал, дүрмийг 1—3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.


Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1993 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн 101 дүгээр зарлигийн 1 дүгээр хавсралт



Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1993 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн 101 дүгээр зарлигийн 1 а дугаар хавсралт





Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1993 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн 101 дүгээр зарлигийн 1 б дүгээр хавсралт



Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1993 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн 101 дүгээр зарлигийн 2 дугаар хавсралт

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН БЭЛГЭ ТЭМДГИЙН ЗУРАГЛАЛ

Шүүхийн бэлгэ тэмдэг нь дугуй хэлбэрийн дэвсгэр дээр үнэн цагааны билэгдэл хүндэтгэлийн навчин хүрээтэй, аливаа хууль бусыг даран арилгахыг билэгдсэн суман голчтой, хэрэг, маргааныг нягтлан дэнсэлж гаргахүү үнэнийг тогтоох дэнсний хэлбэртэй байна.

Дэнсний нуруугаар дэлгээстэй ном дүрсэлсэн нь шүүх зөвхөн Үндсэн хуульд нийцсэн, албан ёсоор хэвлэн нийтэлсэн хуулийг дээдлэн ажиллахыг билэгдэнэ.

Хүндэтгэлийн хоёр навчны үндсийг зөрүүлэн зангидаж, уулзварт нь монгол төрийн уламжлалт бэлгэдэл соёмбыг байрлуулна.

Шүүхийн бэлгэ тэмдгийн хүндэтгэлийн соёмбо, дэнс, сум, навч нь бат бэхийн бэлгэдэл хар өнгөтэй, дэвсгэр нь алтан шаргал өнгөтэй байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1993 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн 101 дүгээр зарлигийн 3 дугаар хавсралт

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН БЭЛГЭ ТЭМДГИЙН ДҮРЭМ

Монгол Улсын Шүүхийн бэлгэ тэмдэг нь шүүх хууль ёс, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсны баталгаа мөн болохыг илэрхийлнэ.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд зааснаар шүүхийн бэлгэ тэмдгийг бүх шатны шүүхийн шүүх хуралдааны танхимд хүндэтгэлтэйгээр байрлуулна.

Шүүхийн бэлгэ тэмдгийг шүүхийн албан байр, шүүгчийн албаны өмсгөл, энгэрийн тэмдэг, шүүхийн байгууллагын хаяг, хэвлэл, шагнал, албан бичгийн хэвлэмэл хуудас, шүүхээс зохиож байгаа баяр ёслол, түүнд зориулсан чимэглэлд хэрэглэж болно.

Шүүхийн бэлгэ тэмдгийг бусад байдлаар зөвхөн Монгол Улсын шүүхийн ерөнхий зөвлөлийн нарийн бичгийн даргын бичгээр өгсөн зөвшөөрөлтэйгээр хэрэглэнэ.

Шүүхийн бэлгэ тэмдгийг энэхүү дүрмийн дагуу хэрэглэж байгаа эсэхэд бүх шатны шүүхийн ерөнхий шүүгчид, шүүхийн тамгын газар, хэлтсийн дарга нар хяналт тавина.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр | Дугаар 102 | Улаанбаатар хот

Б. БАЯНТҮМЭН, С. ХАЛТАР НАРЫГ «АЛТАН ГАДАС» ОДОНГООР ШАГНАХ ТУХАЙ

Газар тариалангийн үйлдвэрлэлд үр бүтээлтэй ажиллаж манай улсад улаан лооль, өргөст хэмх зэрэг эрт ургацын нарийн ногооны үйлдвэрлэлийг хөгжүүлэн хүн амын хүнсний хэрэгцээг хангахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж нийслэлийн «Агро-Амгалан» компанийн ногоочин Байгуужингийн Баянтүмэн, мөн компанийн агрономч Сэрээтэрийн Халтар нарыг «Алтан гадас» одонгоор шагнасугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр | Дугаар 103 | Улаанбаатар хот

Д. ОТРЯДЫГ «АЛТАН ГАДАС» ОДОНГООР ШАГНАХ ТУХАЙ

Манай оронд шүхрийн спортыг хөгжүүлэх үйл хэрэгт үр бүтээлтэй ажиллаж, өөрөө болон дасгалжуулсан баг, тамирчид нь улсын, олон улсын тэмцээнд удаа дараа спортын ам-

жилт гаргахад оруулсан хувь нэмрийг нь үнэлж Нисэх спортын төв клубийн дасгалжуулагч Дагвын Отрядыг «Алтан гадас» одонгоор шагнасугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр

Дугаар 104

Улаанбаатар хот

Х. МӨНХТОГООГ «АЛТАН ГАДАС» ОДОНГООР ШАГНАХ ТУХАЙ

Мал аж ахуйн үйлдвэрлэлд үр бүтээлтэй ажиллаж нутгийн монгол үнээнээс арвин их сүү сааль ашиглаж хүн амын хүнсний хэрэгцээг хангахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Төв аймгийн Эрдэнэ сумын «Туяа» хувьцаат компанийн саальчин Хажидсүрэнгийн Мөнхтогоог «Алтан гадас» одонгоор шагнасугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 105

Г. ОРГОЙГ «АЛТАН ГАДАС» ОДОНГООР ШАГНАХ ТУХАЙ

Үндэсний зан заншил, амьдрал ахуйг яруу сайхнаар гаргасан олон арван ерөөл магтаал туурвин язгуур урлагийн урын санг баяжуулж, хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Өмнөговь аймгийн Мандал-овоо сумын малчин, уран сайханч Гомбын Оргойг «Алтан гадас» одонгоор шагнасугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 106

Б. ЗАГДААГ ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР ШАГНАХ ТУХАЙ

Хариуцсан техникээ хайр гамтай эзэмшиж ашиглалтын хугацааг уртасган геологи хайгуулын ажилд олон жил үр бүтээлтэй ажиллаж байгааг нь үнэлж Баянхонгор аймаг дахь «Баянхонгор геологи» хувьцаат компанийн тракторчин Бүдширийн Загдааг Хөдөлмөрийн хүндэт медалиар шагнасугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр

Дугаар 107

Улаанбаатар хот

Г. ЭНХЖАРГАЛЫГ ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР ШАГНАХ ТУХАЙ

Савхин эдлэлийн үйлдвэрлэлд үр бүтээлтэй ажиллаж чанар сайтай бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж Савхин эдлэлийн «Уян» компанийн чанар шалгагч Гэндэнжамцын Энхжаргалыг Хөдөлмөрийн хүндэт медалиар шагнасугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр

Дугаар 108

Улаанбаатар хот

Л. ЦОГБАДРАХЫГ ШУДАРГА ЖУРАМ МЕДАЛИАР ШАГНАХ ТУХАЙ

Усны үерт нэрвэгдсэн хүмүүсийн амь аврах ажлыг оновчтой, шуурхай зохион байгуулж иргэний хүмүүнлэг үүргээ нэр төртэй биелүүлснийг үнэлж Амгалан дахь хорих ангийн хүний бага эмч Лхагвын Цогбадрахыг Монгол улсын Шударга журам медалиар шагнасугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ

1993 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр

Дугаар 109

Улаанбаатар хот

ЗАРИМ ХҮНИЙГ ОДОН, МЕДАЛИАР ШАГНАХ ТУХАЙ

Барилгын салбарт үр бүтээлтэй ажиллаж барилга, байгууламжийг богино хугацаанд чанартай барьж байгуулах, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж дор дурдсан хүмүүсийг Монгол улсын одон, медалиар шагнасугай.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

Баасангийн Дамчаа — Улаанбаатар хотын цахилгаан сантехник угсралтын «Хүрд» компанийн гагнуурчин, бригадын дарга

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР

1. Цэндийн Тунгалаг — Улаанбаатар хотын Угсармал суурь иргэний барилгын хувьцаат компанийн засал чимэглэлийн бригадын дарга
2. Гарамын Ядамжав — мөн хотын Ханын материалын «Гэрэл» компанийн крановщик
3. Даваагийн Бат-Очир — мөн хотын Сантехник, угсралтын «Мон-сан» компанийн слесарьч
4. Долгорын Алгаа — мөн хотын «Хөсөг» компанийн жолооч

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр

Дугаар 110

Улаанбаатар хот

Р. МАХУМЫГ «АЛТАН ГАДАС» ОДОНГООР ШАГНАХ ТУХАЙ

Эрчим хүчний салбарт үр бүтээлтэй ажиллаж үйлдвэрлэлийн тоног төхөөрмжийг цаг хугацаанд нь чанартай засварлан шинэчлэж хэвийн найдвартай ажиллуулахад оруулсан хувь нэмрийг үнэлж Баян-өлгий аймгийн Эрчим хүчний нэгдсэн үйлдвэрийн инженер Рысбекийн Махумыг «Алтан гадас» одонгоор шагнасугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ

1993 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 111

ПРОКУРОРЫН ЗЭРЭГ ДЭВ ОЛГОХ ТУХАЙ

Монгол Улсын прокурорын байгууллагын тухай хуулийн 36 дугаар зүйлийг үндэслэн Улсын ерөнхий прокурор Н. Ганбаярт «Төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх», Ерөнхий прокурорын орлогч Ж. Энхнасан, Ж. Чойжанцан нарт «Төрийн хууль цаазын шадар зөвлөх»-ийн зэрэг дэвийг тус тус олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР АВСАН АРГА ХЭМЖЭЭ, ДҮГНЭЛТ, ЗОРИЛТЫН ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын 1993 оны, намрын чуулганы хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд П. ЖАСРАЙН тавьсан илтгэл

Монгол улсын Засгийн газар үйл ажиллагааныхаа хөтөлбөрийг өнгөрсөн оны 10 дугаар сарын 8-нд Улсын Их Хурлаар батлуулан хэрэгжүүлж эхэлснээс хойш нэг жил болж байна.

Тэр үеийн эдийн засгийн байдлыг уг хөтөлбөрт товч боловч цэгцтэй дүгнэж тэмдэглэсэн билээ. Ажлаа зөв эхлэхийн тулд байдлаа бодитой үнэлэх нь чухал байлаа.

Ямар гараанаас Засгийн газар ажлаа эхэлснийг ард түмэн тодорхой мэдэж байгаа.

Засгийн газар улс орноо бүрэлдэж буй болоод байсан хүнд байдлаас аль болох богино хугацаанд, хохирол багатайгаар гаргаж, цаашдын хөгжлийн эрүүл хөрсийг бүрдүүлэхийн тулд эдийн засгийг зах зээлийн харилцаанд туушгай, эргэлт буцалтгүй шилжүүлэхээс өөр зам байхгүй гэж үзэж цаг хожих зорилт тавьсан юм.

Ийм бодлогын эцсийн зорилт нь эдийн засгийн уналтыг зогсоож тогтворжуулах, цаашдын хөгжлийн үндэс суурийг тавьж эхлэхэд чиглэнэ гэж хөтөлбөрт тодорхойлсон.

Үндэсний эв нэгдэл, өндөр зохион байгуулалт, улс төрийн тогтвортой байдал нь үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх баталгаа байх болно гэдгийг ч уг баримт бичигт тов тодорхой дурдсан билээ.

Үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийн явцын тухай дэлгэрэнгүй танилцуулгыг Та бүхэнд тараасан. Ийм учраас хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар Засгийн газраас зохион байгуулж байгаа ажил, үр дүн, бэрхшээл, ойрын зорилтын талаар салбар, үйл ажиллагааны хүрээ тус бүрээр нарийвчлахгүй гээр, гол нь бодлогын чанартай зарим арга хэмжээнд анхаарлаа төвлөрүүлэн товч илтгэе.

Нэг. Эдийн засагт зах зээлийн харилцааг бүрдүүлж төлөвшүүлэх чиг бодлогыг гүнзгийрүүлэх талаар Засгийн газраас авч буй арга хэмжээ, цаашдын зорилт

Засгийн газар эдийн засгийг зах зээлийн харилцаанд шилжүүлэх иж бүрэн арга хэмжээг цэгцтэй дэс дараатай хэрэгжүүлэх зорилт тавьж үйл ажиллагаагаа эхэлсэн юм.

Зах зээлийн харилцааг төлөвшүүлэх гол үндэс нь эдийн засагт дангаараа зонхилж ирсэн төрийн болон төржсөн хоршооллын өмчийг задлан хувьчлах явдал билээ. Засгийн газар өмч хувьчлалын шинэчилсэн хөтөлбөр боловсруулан ажиллаж байна. Одоогийн байдлаар хувьчлагдвал зохих хөрөнгийн 80 шахам хувь хувьчлалд хамрагдаж, худалдаа, үйлчилгээний байгууллага, мал сүрэг үндсэндээ хувийн өмчид шилжиж, боловсруулах аж үйлдвэрийн газруудын дийлэнх нь их хувьчлалд хамрагдаад байна.

Өмч хувьчлалын ажлыг ихэнх аймаг, хотод зохих бэлтгэлгүй, хяналт муутай зохион байгуулснаас их хэмжээний өмч хөрөнгө үрэгдсэнийг нуух хэрэггүй биз. Ялангуяа хөдөө аж ахуйн нэгдлийн өмчийг нэгдсэн аргачлал, чиглэлгүй хувьчилснаас болж тийм хохирол газар сайгүй гарчээ.

Засгийн газраас хувьчлалын хүрээнд зохнох ажлын цаашдын чиглэл нь юуны өмнө их хувьчлалын эхний үр дүн болж үүссэн хувьцаат компаниудын удирдлагын гүйцэтгэх үүрэг, эдлэх эрх, хувьцаа эзэмшигчдийн өмнө хүлээх хариуцлагыг тодорхой болгох, нөгөө талаар үнэт цаасны хоёрдогч зах зээлийг бий болгож хөрөнгийн биржийн үйлчилгээг эрчимжүүлэхэд оршиж байна.

Түүнчлэн үйлдвэрлэл, нийгмийн дэд бүтцийн салбаруудад хийх хувьчлалыг сайтар боловсруулсан хөтөлбөр, удирдамжийн дагуу зохион байгуулалт сайтай хийж, урьд гарсан алдааг давтахгүй байх, төрийн өмчийн үйлдвэр, аж ахуйн газруудад хувийн хэвшлийнхний хөрөнгийг оруулах, зээлээр эзэмшүүлэх, гадаадын хөрөнгө оруулагчдад тэдгээрийг худалдах, түрээслүүлэх зэргээр хувьчлах бусад оновчтой арга хэлбэрүүдыг өргөн хэрэглэх чигийг барьж байна.

Орон сууц хувьчлалын талаар Улсын Их Хурлын намрын чуулганы нээлт дээр Монгол улсын Ерөнхийлөгчөөс санал болгосон чиглэлийг Засгийн газар үндсэнд нь дэмжиж байна.

Манай малчид сал сүргээ хувьчлан авч, хувийн аж ахуйтнууд болцгоолоо. Энэ бол зарчмын ач холбогдох бүхий том өөрчлөлт юм. Одоо тэднийг зах зээлийн харилцаанд шударгаар оролцуулах, эдийн засгийн зүй ёсны ашиг сонирхлыг нь хамгаалах, малчдын нийгмийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлэх шинэ арга замыг эрт сүвэгчлэх явдал чухал болж байна.

Өнгөрсөн нэг жилийн хугацаанд үнэ, тариф, валютын ханшийг чөлөөлөх арга хэмжээг гурван үе шаттайгаар хэрэгжүүллээ.

Энэ даваа бартаатай, бэрхшээлтэй ч гэсэн тойрох аргагүй, цаашдаа эдийн засгийг эрүүлжүүлэх чадвартай гэдэгт Засгийн газар эргэлзээгүй, манай ард түмэн ч ойлгож зориг тэвчээр гарган хүлээж авсан нь бидэнд ихээхэн урам хайрлаж, итгэл төрүүлсэн юм.

Монгол орны түүхэнд төгрөг анх удаа дотооддоо чөлөөтэй хөрвөдөг боллоо. Одоо нийслэл хотын нийтийн үйлчилгээний тээврээр зорчих тариф, орон нутгийн дизелийн шахилгаан станц, уурын зуухнаас түгээх эрчим хүчний үнийн зөрүүг төсвөөс санхүүжүүлж байгааг бодолцохгүй бол үнэ, тариф бүхэлдээ чөлөөт тогтолцоонд шилжлээ.

Үнэ, валютын ханшийг чөлөөлөх арга хэмжээ нь үйлдвэрлэл, үйлчилгээг өргөтгөх, шударга өрсөлдөөний явцад үйлдвэрлэн бүтээгчид чадваржин бэхжих нөхцөлийг бүрдүүлэх зорилгыг агуулсан юм.

Ингэхдээ манай нийгмийн даац, ард түмний амьдралын түвшинд нөлөөлөх байдлыг харгалзан ачааллыг аль болохоор хөнгөлөхөд төсвийн бүхий л бололцоог дайчилж байгаа нь нийтэд илэрхий билээ.

Валютын ханшийг чөлөөлөх эхний алхмыг энэ оны эхнээс хэрэгжүүлснээс хойш барагцалабал 4 сарын дараа буюу 5 дугаар сард инфляци 1,8 хувь хүртэл буурч эдийн засаг тогтворжих хандлага илэрхий мэдрэгдсэн. Гэвч энэ бол түр зуурын үзэгдэл, хагас алхам хийгээд хол явахгүй гэдэг нь тодорхий байлаа. Иймээс энэ оны 5 дугаар сарын 28-наас валютын ханш, үнэ тарифыг бүрэн чөлөөлөх, энэ хүрээнд эцсийн гэж хэлж болох арга хэмжээ авсан билээ.

Үнэ, тарифыг чөлөөлөхөөр инфляцийн цочир өсөлт гарах нь зүй тогтолт үзэгдэл. Иймээс валютын ханш, үнэ тарифыг чөлөөлөхдөө зээл түгээх, төсвөөс зардал гаргах явдлыг аль болохоор хязгаарлаж, хадгаламж, зээлийн хүүг эрс нэмэг

дүүлэх зэргээр жолоодлогогүй инфляцид хальтран орох аюулаас урьдчилан сэргийлэх хатуу бодлого явуулахаас өөр аргагүй байлаа. Бас зах зээлийн хангамжийг сайжруулах зорилгоор гадаад худалдааны элдэв хязгаарлалтыг багасгаж зарим барааны импортыг урамшуулах арга хэмжээ авсан юм.

Энэ бүхэн бол эрс шинэчлэлтийн үед эдийн засгийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн цогцолбор бодлого байсан гэж хэлж болох байх. Иймэрхүү бодлого үр дүнгээ өгч байна гэж Засгийн газар үздэг.

Валютын ханшийг чөлөөлөх үед чөлөөт зах дээр нэг ам. доллар 420 орчим төгрөгөөр үнэлэгдэж байсан нь одоо 360—370 төгрөг болоод байна. Инфляцийн хэмжээ 6 дугаар сард 28,5 хувь болтол өссөнөө 7 дугаар сард 5,2 хувь, 8 дугаар сард 8,6 хувь, 9 дүгээр сард 3,6 хувь болж саарлаа.

Дэлгүүр, зах дээр бараа элбэгшлээ. Хүн амын худалдан авах чадвар буурсан нь үүнд нөлөөлсөн гэдгийг зөвшөөрөх хэрэгтэй. Гэхдээ импортоор авсан өргөн хэрэгцээний бараа гэхэд л энэ оны эхний 9 сард өмнөх оны мөн үеийнхээс 40 гаруй хувиар өссөн явдал зах зээлийн хангамжийг сайжруулахад ихээхэн нөлөөлснийг бас үгүйсгэж болохгүй.

Зэсийн баяжмал, шатах, тослох материалын аль, алины нь дэлхийн зах зээлийн үнэ сүүлийн үед буурч байгаагаас гадаад худалдааны эргэлтийн өсөлт саарсан боловч төлбөрийн урсгал баланс манай хувьд одоогоор ашигтай байна.

Тулгамдаад байсан гадаад өрийн дарамтыг нэлээд хөнгөлж, валютын хэрэглийн бага ч гэсэн зохих нөөцтэй болж амжлаа.

Шатах, тослох материал, түлш, хүнс, өргөн хэрэглээний зарим чухал барааны шавхагдсан байсан улсын нөөцийг энэ хугацаанд нэлээд хэмжээгээр сэргээн бүрдүүллээ.

Эдийн засаг тогтворжиж эхлэн урьдчилсан нөхцөл бүрдэх шатандаа байгааг эдгээр баримт харуулж байна.

Эдийн засгийн тогтворжилт дэлхийн жишгээр, тийм тусмаа шилжилтийн үеийн нөхцөлөөр авч үзвэл өргөн хүрээтэй ойлголт байдаг.

Найдвартай зах зээлгүй бөгөөд бусад салбарт зардал, дарамт болж байдаг бүтээгдэхүүний үрэлгэн шинжтэй үйлдвэрлэлийн өсөлтөөр эдийн засгийн тогтворжилтыг хэмжих утгагүй гэдэг нь тодорхой юм.

Эдийн засагт зах зээлийн харилцааг бүрдүүлж, төлөвшүүлэх бодлогын арга хэмжээ ихээхэн бэрхшээл, хүндрэлтэй нөхцөлд хэрэгжиж байна.

Валютын ханш, үнэ, тарифыг чөлөөт тогтолцоонд шилжүүлсэн явдал эдийн засгийн амьдралын ужиг гажуудлыг ил гаргаж, үйлдвэр, аж ахуйн олон байгууллагыг гэнэтийн цочролд оруулаа.

Хөдөө аж ахуй, үүний дотор газар тариалан эрхэлдэг компаниуд, түүнчлэн хүнсний үйлдвэрүүд, хатуу үнийн нөхцөлд, олон жилийн турш зээлээр амь зогоож дассан байлаа. Аж ахуйн эдгээр нэгжийн хувьд мөнгө, зээлийн түр хугацааны хатуу бодлого үнэхээр хурц мэдрэгдэж байгаа нь ойлгомжтой юм.

Түүнийг нь зөөллөх талаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөл дээр ярьж тогтсон дагуу Засгийн газар энэ оны тухайд зарим тодорхой арга хэмжээ авсан.

Сүүлийн жилүүдэд үйлдвэрлэл эрхлэхгүйгээр валютын ханш, үнийн зөрүү дээр тоглож эргэлтийн хүрээнд ажиллан хялбар аргаар ашиг олж бэсрэг хамт олныхоо өдөр тутмын хэрэгцээг хангах төдийгөөр ажлаа хязгаарладаг аж ахуйн нэгж олширсон билээ. Өмч хувьчлалаар зохион байгуулагдсан хувьцаат компаниуд ч энэ хүрээнд ямар нэг хэмжээгээр татагдан орсон. Аж ахуйн нйм нэгжүүдийн хувьд валютын ханш, үнэ, тарифын чөлөөт тогтолцоо нь цоо шинэ орчинг бий болгож, тэднийг мэдэгдэм цочролд оруулсан нь бас тодорхой юм.

Үнэ, тариф чөлөөтэй болсныг харгалзан үйлдвэрлэлээ нэмж, үйлчилгээгээ өргөтгөх, зардал хэмнэх арга замаа эрж хайхаас өмнө, монополь байдлаа ашиглан зөвхөн үнэ нэмэх, бүтээгдэхүүний нь борлолт удааширвал үнээ хямдруулж, эргэлтээ түргэтгэхийг бодохгүйгээр үйлдвэрлэлээ багасган хиймэл хомсдол үүсгэхийг оролдох явдал олонтаа тохиолдож байна. Энэ нь эцсийн дүндээ хэрэглэгчдийн эрх ашгийг хохирооход хүргэж байгаа юм.

Зээл олгох явдлыг хязгаарлаж, хүүг нь өндөр тогтоосон явдал жолоодлогогүй инфляцид орох аюулаас хамгаалахад чухал байсан ч гэсэн бас сөрөг үр дагавар өгч байна.

Зээлийн хүү өндөр болохоор эргэлтийн түргэнийг бодож аж ахуйн нэгжүүд худалдааны хүрээг эн түрүүнд шохоорхох хандлага гарч байна. Энэ нь эрэлт, нийлүүлэлтийн харьцааг сайжруулахад нөлөөлж байгаа сайн талтай боловч гол нь

үйлдвэрлэл эрхлэх явдлыг урамшуулахад саад тотгор болж байна. Түүгээр ч барахгүй зээлийн өндөр хүүг зардалд шингээж байгаа учир тэр нь инфляци руу түлхэх нэгэн төрлийн хөшүүрэг болон хувирч байна. Тэгэхдээ эрэлт, нийлүүлэлтийн байдлаас шалтгаалан үнийн түвшинг зах зээл өөрөө тохируулдаг болохоор дан үнээ нэмэгдүүлэх аргаар хол явахгүй гэдгийг аж ахуйн авхаалжтай менежерүүд аль хэдийнээ олж харсан байх.

Чөлөөт зах дээр нэлээд барааны үнэ улсын болон тохиролцооны дэлгүүрийнхээс мэдэгдэм доогуур байгаа нь үйлдвэрийн удирдлагуудыг цочроох дохио юм.

Ер нь зах зээлийн харилцаа бол хатуу тоглоом гэдгийг аж ахуйн удирдагч бүр ойлгох учиртай.

Цаашдаа улирлын чанартай хэвийн хэлбэлзлийг бодолцохгүй бол үнийн огцом өсөлт гарахгүй болов уу гэж төсөөлж байна. Харин энэ жилийн ургацын байдал, зардлын өөрчлөлтөөс шалтгаалан эх орны үйлдвэрийн гурил талхны үнэ тодорхой хэмжээгээр нэмэгдэх байх. Үүнийг ойлгож, зөвшөөрөн хүлээхээс өөр аргагүй.

Одоо үйлдвэрлэлийг сэргээх түүнчлэн үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалтыг урамшуулахад мөнгө, зээлийн бодлогыг чиглүүлэх цаг тулж ирлээ гэж үзэж байна. Тэгэхдээ өндөр инфляцид дахин нэрвэгдэхгүй байхын тулд уян хатан, ухаалаг хандах явдал чухал гэдэг нь эргэлзээгүй.

Зээлийн зориулалтыг тодорхой болгож, зээл авах хариуцлагыг өндөржүүлж, үйлдвэрлэл нэмэгдүүлэх зорилалттай зээлийн хүүг бууруулах арга хэмжээ авах нь зүйтэй гэж үзэж байна.

Төрөөс зах зээлийн эдийн засгийн харилцааг бүрдүүлж төлөвшүүлэх, түүний үйлчилгээг хангах үндсэн хэрэгслийн нэг нь төсвийн бодлого байдаг билээ. Энэ нь орлогын эх үүсвэрийг бүрдүүлэх утгаараа татварын бодлого, Засгийн газраас үйлдвэрлэлийг дэмжих, хүн амын нийгмийн хамгаалалт, нийгмийн бодлогоо хэрэгжүүлэх, төрийн байгууллагын хэвийн ажиллагааг хангах утгаараа санхүүжилтийн бодлого гэсэн хоорондоо амин холбоотой хоёр гол талыг хамарсан цогц асуудал юм. Тэгэхдээ зах зээлийн харилцаа зүгшрэхийн хэрээр эдийн засгийг тэтгэхэд гүйцэтгэх төсвийн санхүүжилт, төсвийн хөрөнгө оруулалтын үүрэг улам бүр хязгаарлагдмал шинжтэй болж төрөөс явуулах бодлого нь аж ахуйн нэгж,

байгууллагын болон хувийн хуримтлал нэмэгдэх нөхцөл бололцоог аль болохоор бүрдүүлэхэд чиглэх учиртай.

Монголын нийгмийн бодит бүтэц, зах зээлийн харилцааны шинэ нөхцөл байдлыг харгалзан татварын багц хуулиуд болон төсвийн хуулийг батлуулан мөрдөж эхэлснээс хойш жил шахмын хугацаа өнгөрөөд байна.

Уг хуулиуд бүхэлдээ цаг үеийн шаардлага, онцлогийг тусгасан амьдрах чадвартай эрх зүйн чухал баримт бичиг болсон нь нотлогдож байна.

Үүний хамт манайд хувийн хэвшил цоо шинээр үүссэн хөрөнгийн анхны хуримтлалыг, гол төлөв эргэлтийн хүрээнээс, бий болгож байгаа, санхүүгийн чадвар нь сулхан, албан татвар төлж хэвшээгүй зэргээс шалтгаалан хэдийгээр уг хуулиар тогтоосон орлогын албан татварын хэмжээ тухайн үеийн үнэ, ханшийн нөхцөлд, олон улсын нийтлэг жишгээс ихээхэн доогуур байсан боловч албан татварын хэмжээ ихэдсэн гэсэн яриа дэлгэрч татвараас зайлсхийх, орлогоо нуун дарагдуулах явдал газар авах хандлагатай байна.

Аж ахуйн нэгж, иргэн бүр албан татвар төлснөөр төрдөө дэмжлэг үзүүлж, нийгмийн эмзэг хэсгийг хамгаалахад хувь нэмрээ оруулж, үүргээ биелүүлж байна гэж үзэж туйлын хүндэтгэлтэйгээр ханддаг соёлт нийгмийн туршлагаас бид суралцах ёстой болж байна.

Зах зээлийн эдийн засгийн нөхцөлд төсвийн орлого үндсэндээ албан татвар, төрийн өмчийн байгууллагаас авах ногдол ашгаас бүрддэг жамтай. Бид ч энэ замаар явж байна.

Валютын ханшийг чөлөөлсний дараа эдийн засагт бүрэлдэн бий болж байгаа нөхцөл байдал, түүнчлэн татвар төлөгчдийг бэхжүүлэх, тэдний хүрээг өргөтгөх шаардлагыг харгалзан орлогын албан татварын хуульд зарим өөрчлөлт оруулах шаардлагатай болж байна. Үүний хамт татвар төлөхөөс зайлсхийх явдалтай хийх тэмцлийг, янз бүрийн арга хэлбэрээр саармагжуулахгүйгээр, улам чангатгах хэрэгтэй гэж үзэж байна.

Хувараа эрхлэх аж ахуй, иргэдийн хоршоод, бүрэн бус харицлагатай компаниуд ажлын шинэ байр бий болгоход зорилуулан хөрөнгө оруулбал түүнийг нь орлогын татвараас чөлөөлөх зэргээр үйлдвэрлэл нэмэгдүүлэх тааламжтай орч-

ныг бүрдүүлэхэд татвар, санхүүгийн бодлогыг чиглүүлэх бодолтой байна.

Хувийн хэвшлийг дэмжихэд зорилуулан олон улсын банк, зарим дэмжин туслагч орноос нэлээд хэмжээний зээл авахаар тохиролцсон билээ. Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд үйлдвэрлэл зохион байгуулах, ажлын шинэ байр бий болгоход нь туслах зорилгоор уг эх үүсвэрийг тэдэнд төсөл уралдуулах замаар шалгаруулан Засгийн газрын хөнгөлөлттэй зээл хэлбэрээр шилжүүлэх боломжийг судалж, зөвлөдөхөөр төлөвлөж байна.

Мөнгө, зээлийн бодлогын талаар Монгол банк чуулганы тус хуралдаанд жилд нь илтгэж байгаа учир энэ талаар дэлгэрэнгүй ярих шаардлагагүй гэж бодож байна.

Эдийн засгийн харилцаа, аж ахуйн амьдралд бүрэлдэн бий болж байгаа шинэ нөхцөл байдлыг харгалзан мөнгө, зээл, санхүүгийн хүрээнд хэрэгжүүлэх бодлогын чанартай ээлжит арга хэмжээний талаар ойрын үед улсын төвлөрсөн төсвийн 1994 оны төсөл, эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлогын ирэх оны төслийн хүрээнд нэлээд дэлгэрэнгүй авч үзэх шаардлагатай болж байна.

Хоёр. Эдийн засагт зах зээлийн харилцааг нэвтрүүлж төлөвшүүлэх шилжилтийн үе шатанд иргэдийн нийгмийн баталгааг хангах талаар авч байгаа арга хэмжээ, тохиолдож байгаа бэрхшээл, шийдвэрлэх зорилт

Хямралыг гэтлэн давахын тулд эдийн засагт зах зээлийн харилцааг нэвтрүүлж зүгшрүүлэх бодлогыг хэрэгжүүлэхдээ Засгийн газар иргэдийн, эн түрүүнд нийгмийн эмзэг хэсгийн амьдралын баталгааг хангах, ядуурлаас хамгаалах арга хэмжээнд анхаарлаа төвлөрүүлэн ажиллаж ирлээ.

Эдийн засагт зах зээлийн харилцаа нэвтрэх үйл явцтай зэрэгцэн хүн амын амьдралын түвшинд мэдэгдэм ялгарал явагдаж байна.

Валютын ханш, үнэ, тарифыг чөлөөт тогтолцоонд шилжүүлсэнтэй уялдан инфляци үе үе огцом нэмэгдэж, төсөвт байгууллагаас цалин авч амьдардаг хүмүүс, тэтгэврийн өвгөд, хөгшид, олон хүүхэдтэй айл өрх өвчин зовлонд нэрвэгд-

сэн хүмүүс зэрэг нийгмийн эмзэг хэсгийн амьдралд хүнд ачаалал ногдож байна.

Төвлөрсөн бэлтгэл, худалдаа, хангамжийн тогтолцоо задарч хувийн аж ахуйн нэгжийнхэн энэ хүрээнд эрчимтэй нэвтэрч эхэллээ. Иймэрхүү нөхцөлд өргөн хэрэгцээний барааны үнийг урьдын адил улсын хэмжээнд адил түвшинд байхаар зохицуулах бололцоогүй болсон нь төвөөс алслагдсан аймаг, сумдын ард иргэдийн худалдан авах чадвар, барааны хүрэлцээ хангамжид давхар нөлөөлж байна. Иймэрхүү байдал үйлчилгээний хүрээнд ч гарч байгаа юм.

Үнэ, тариф өнгөрсөн нэг жилийн хугацаанд 393 хувь буюу бараг 4 дахин өслөө.

Эмч, багш нар, соёл, урлаг, шинжлэх ухааны ажилтан, төрийн байгууллагын албан хаагчид зэрэг төсвөөс цалин авч амьдардаг иргэдийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газрын гурван удаагийн шийдвэрээр цалин нэмэх, нөхөвөр олгох арга хэмжээ авлаа. Үүний дүнд эдгээр хүмүүсийн орлого энэ хугацаанд 5,3 дахин өссөн юм. Тэтгэвэр, тэтгэмжээр амьдардаг иргэдийг ядуурлаас хамгаалах явдал Засгийн газрын анхаарлын төвд байсаар байна. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд эдгээр иргэдэд Засгийн газрын 5 удаагийн шийдвэрээр нөхөн олговор олгох арга хэмжээ авснаар тэдний орлого дунджаар 6 гаруй дахин нэмэгдсэн юм. Оюутан залуучуудын амьдралд дэмжлэг үзүүлэх, алслагдсан аймгаас төвд ирж эмчлүүлэх орлого багатай иргэдэд туслах арга хэмжээ авч байна.

Халамжийн төв зохион байгуулж ажиллуулах, баг, хороодоор дамжуулан нэн ядуу иргэдэд туслах зэрэг янз, янзын арга хэлбэрээр иргэдээ хэт ядуурлаас хамгаалахад чиглэсэн ажил зохион байгуулахаар чармайж байна.

Гэхдээ бүхэлд нь авч үзвэл сүүлийн 3 жилд үнэ, тариф өссөнөөс гарсан нэмэгдэл ачааллыг хүн амын эмзэг хэсэгт бүрэн нөхөн өгч чадаагүй. Монгөний масштабт өөрчлөлт оруулсан 1991 оны 1 дүгээр сарын 16-наас эхлэн тооцвол өнгөрсөн хугацаанд үнэ, тариф 16 дахин өссөн байна.

Иймээс Засгийн газраас авсан дээрх арга хэмжээнүүд нь сүүлийн жилд бий болсон үнэ, тарифын өсөлтийн нэлээд хэсгийг нөхөх хэмжээнд байсан боловч, бүхэлд нь авч үзвэл, зах зээлийн харилцаанд шилжих үеийн сөрөг үр дагаврыг зөөлрүүлэх төдий түвшинд үйлчилж байна гэвэл үнэнд ойртоно.

Шинээр бий болсон хувийн хэвшлийн үйлдвэр, үйлчилгээний газруудын үйл ажиллагаа цэгцэрч зүгшрэх эхний ша-

тандаа байгаа, хуучин цагт улсын байсан өнөө үеийн гол хувьцаат компаниуд зах зээлийн нөхцөлд хөлөө олохгүй бүдчиж үйлдвэрлэлийн хэмжээ нь буурч байгаа, хөрөнгө оруулалт, барилга-угсралтын ажил эрс буурсан зэргээс шалтгаалж, нэг талаас ажилтай байгаа хүмүүсийн орлого өөдтэй өсөхгүй, нөгөө талаас ажилгүй байгаа хүмүүсийн тоо нэмэгдэж байгаа явдал байдлыг улам хүндрүүлж байна.

Энэ оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр ажил идэвхтэй эрж байгаа хөдөлмөрийн захад бүртгэгдсэн ажилгүйчүүдийн тоо 67 мянгад хүрэхээр байгаа нь өнгөрсөн оныхоос 13 мянгаар илүү байна.

Малчид хувьдаа малтай болж амьдрал, ахуйд нь өөрчлөлт гарч байгаа ч гэсэн, бүтээгдэхүүнийг нь худалдан авах, хэрэгцээт барааг нь хүргэж худалдах тогтолцоо задарснаас болж мөнгө, бараагаар гачигдаж ихэнх тохиолдолд шударга бус солилцоонд нэрвэгдэхэд хүрч байна.

Өнөөгийн энэ хүнд байдлаас гарах ямар арга зам байх вэ? Засгийн газрын энэ хүрээний бодлого юунд чиглэх вэ? гэсэн асуулт өнөөдөр хамгийн хурц тавигдаж байна. Энэ бол зүй ёсны хэрэг. Хүн амын бүх давхаргын сонирхлыг хөндөж байдаг энэ хүрээний бодлогын талаар дээр, дороос болон хөндлөнгөөс гарч байгаа аливаа шүүмжлэл саналд Засгийн газар онцгой анхааралтай, ул суурьтай хандаж, эдийн засагт гарч байгаа тогтворжилтын үйл явцыг эвдэн бусниулахгүйгээр хүнээ хөгжүүлэх, амьдралыг нь сайжруулах чиг бодлогоо тууштай баримтлах бодолтой байна. Тэгэхдээ тодорхой бодлого, түүнийг хэрэгжүүлэх цэгцтэй механизм чухал гэдгийг иш үндэс болгож байна.

Бүхэлд нь авч үзвэл амьдрал сайжрах ганцхан зам бий. Энэ бол бүтээлч хөдөлмөрийг өрнүүлэх явдал.

Үйлдвэрлэлийг сэргээж, гэрийн аж ахуй, хувийн хэвшлийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэн ажлын нэмэгдэл байр бий болгох тааламжтай орчныг бүрдүүлэх явдал энэ хүрээнд шийдвэрлэх эхний ээлжийн зорилт болж байна.

Энэ бол хүн амын дийлэнх олонхийн амьдралыг сайжруулахад чиглэсэн бодлого гэж хэлж болно.

Хүн амын эмзэг хэсгийн амьдралын баталгааны талаар дор дурдсан чиглэл баримталж ажиллах бодолтой байна.

Улирлын чанартай ердийн хэлбэлзлийг бодолцохгүй бол урьд өмнө гарч байсан шиг, үнэ тарифын цочмог өсөлт цааш-даа гарахгүй биз гэж бодож байгаагаа дээр хэлсэн. Гэхдээ

хэвийн инфляци зах зээлийн нөхцөлд байдаг зүйл гэдгийг ч үгүйсгэхгүй байна. Монголын Засгийн газар, Олон улсын валютын сангийн хамтран боловсруулсан дунд хугацааны хөтөлбөрт цаашдаа жилийн инфляцийг нэг оронтой тоогоор илэрхийлэгдэх хэмжээнд хүртэл бууруулахад чиглэсэн зохицуулалтын цогцолбор арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байгаа.

Засгийн газар бодлогын энэхүү хөтөлбөртөө итгэлтэй байгаа учраас цаашдаа төсвийн байгууллагад ажиллагчид, тэтгэвэр тэтгэмж, тэтгэлгээр амьдардаг хүмүүсийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлийг тооцохдоо үнэ, тарифын цаашдын өсөлтийг нөхөх тухай биш, харин амьдралын нь түвшнийг, бололцооны хэмжээгээр аажим ч гэсэн нэмэгдүүлж эхлэх зорилтыг иш үндэс болгож байна.

Төсөвт мөнгө орох хэмжээгээр зарлага гаргах бололцоо бүрддэг энгийн боловч хөдөлбөргүй үнэн, түүнчлэн инфляцийг хөөрөгдөх аюулаас сэрэмжлэх зайлшгүй шаардлагын аль алиныг харгалзан ийм арга хэмжээ ээлж дараатай, шаталж хэрэгжүүлэхээс өөр аргагүй нь мэдээж юм.

Төсвийн орлогыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ, нэг хэсэгтээ тэвчиж болох зардлыг мэдэгдэм хасч байж л энэ зорилтыг хэрэгжүүлж болно.

1994 оны төвлөрсөн төсвийн төсөлд эдгээр арга хэмжээг харилцан уялдаатай тусгаж, тодотгон судалж байна.

Боловсрол, эрүүлийг хамгаалах, соёл, шинжлэх ухааны салбарт урьд өмнө олсон ололт, амжилтаа алдаж ухрахгүй байхын төлөө тэмцэх явдал манай хамгийн тулгамдсан чухал зорилгын нэг болж байна. Тэгэхдээ хэвшмэл царцанги байдлаас шийдвэртэй салах ёстой нь ойлгомжтой юм.

Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын тогтолцоог нийгмийн харилцааны шинэ нөхцөл байдалд зохицуулан өөрчлөн шинэчлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг боловсруулах, бололцооны хэрээр хэрэгжүүлэхэд Засгийн газар анхаарч ажиллаж байна.

Хөдөө орон нутгийн ерөнхий боловсролын сургуулиудыг байршлыг оновчтой болгох, хувийн сургуулиудыг бие даасан дэд бүтэц болгон хөгжүүлэх, үндэсний монгол бичгийн сургалтын хүрээг өргөжүүлэх ном, сурах бичгийн хүрэлцээг сайжруулах арга хэмжээ авч байна.

Боловсролыг зах зээлийн шинэ харилцаанд нийцүүлэн өөрчлөх зарим эхлэл хийгдэж байгаа боловч санхүүжилтийн эх үүсвэрийн хомсдлоос голчлон шалтгаалж бүх шатны сургууль, дотуур байр, хүүхдийн цэцэрлэгийн материаллаг баазыг бэхжүүлэх, багш, сурган хүмүүжүүлэгчдийн ахуй хангамжийг сайжруулах ажилд бэрхшээл учирсаар байна.

Сүүлийн жилүүдэд 100-гаад мянган хүүхэд сургууль завсардсаны 40-өөд мянга нь бүрэн уншиж бичиж чадахгүй, бага насны хүүхэд байна.

Үүний зэрэгцээ манай боловсролын агуулгыг сайжруулах, сургалт, хүмүүжлийн ажлын чанарыг дээшлүүлэх талаар нухацтай бодож боловсруулах ажил ч их байгаа бөгөөд энэ хүрээнд цаг алдах эрх бидэнд байхгүй гэдгийг хэлмээр байна.

Эрүүл мэндийн даатгалын хуулийг боловсруулан батлууллаа. Эм тарилгын зүйлийг гаалийн татвараас чөлөөлснөөр нийлүүлэлт хангамж нь сайжрах хандлагатай болж байна.

Энэ оны эхний 9 сарын байдлаар эрүүлийг хамгаалахын зарим үзүүлэлтүүд сайжирч, халдварт өвчин гаралт, эх нялхсын эндэгдэл урьд оныхоос харьцангуй багассан байна.

Гэвч бид үүнд тайвшрах үндэс байхгүй. Хүн амын Эрүүл мэндийн асуудлыг нэг талаас зах зээлийн эдийн засгийн бодит нөхцөл, хэрэгцээ шаардлагатай холбож авч явах, нөгөө талаас эрүүл биетэй, саруул ухаантай хүн манай нийгмийн хамгийн үнэтэй эрдэнэ гэсэн төрийн бодлогын үүднээс түүнд хандах явдлыг хослуулан Засгийн газар цаашид ч энэ талаар уйгагүй шургуу ажиллах болно.

Хүн амын нийгмийн амин чухал асуудлуудын дотор нийгмийн даатгалын бүхэл бүтэн тогтолцоог бий болгох асуудал онцгой байр суурь эзлэх боллоо.

Энэ талаар Засгийн газар хэтийн чиглэлтэй бодлого боловсруулж нийгмийн даатгалын багц хуулиудын төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн бариад байна.

Гурав. Үйлдвэрлэлийн уналт үргэлжиж байгаа нөхцөл, шалтгаан, хийх дүгнэлт

Засгийн газар өөрийн үйл ажиллагааны хөтөлбөрт эдийн засгийн уналтыг ойрын 2 жилд багтаан зогсоож, тогтворжуулах, бүрэн эрхийнхээ үлдсэн хугацаанд эдийн засгийн

цаашдын өсөлтийн суурийг тавьж, ард түмний аж амьдралыг дээшлүүлэх үндсийг бүрдүүлэх стратегийн зорилтыг дэвшүүлсэн билээ.

Ингэхдээ бид эдийн засгийн уналт гэдэг ухагдахуунд үйлдвэрлэл, гадаад дотоод худалдаа, мөнгөний ханш, бүтээмж зэрэг цогц ойлголтыг хамруулан авч үзэж түүнд Засгийн газраас дам ба шууд байдлаар нөлөөлөх хүчин зүйл, арга хэрэгслийг багтаан ойлгож байгаа юм. Эдийн засгийг зах зээлийн харилцаанд шилжүүлэх ажлыг эрчимжүүлэхийн хамт, 1993 онд нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг бууруулахгүй байх шахуу зорилт тавьж ажилласныг та бүхэн мэдэж байгаа.

Гэвч эхний 9 сарын ажлын явцаас үзэхэд үндэсний нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн уналт 1993 онд өмнө оныхоос 2 дахин саарахаар байгаа боловч дэвшүүлсэн зорилт бүрэн биелэгдэх боломжгүй болсон тал харагдаж байна.

Бойжиж байгаа төлийн тоо өнгөрсөн оныхоос 1,3 саяар буурч малын хорогдол 400 гаруй мянгаар нэмэгдсэн явдал үүнд голлож нөлөөллөө. Ургацаа хурааж дууссч байна. Үр тариа ноднингийнхоос бага зэрэг нэмэгдэх боловч мал аж ахуйд учирсан хохирлыг нөхөж чадахааргүй байна.

Уул уурхай, хөнгөн аж үйлдвэрийн зарим салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн уналт, саарч байгаа ч аж үйлдвэрийн салбарт бүтээгдэхүүний үйлдвэрлэл өнгөрсөн оныхоос 4,5 хувь буурахаар байна.

Их барилга, тээвэр бусад салбаруудад ч уналт үргэлжилсээр байна.

Эдийн засгийн бодит мэдээ, мэдээллийн хомсдол, үндэсний тооцоонд шилжих үеийн аргачлал, тооцоо судалгааны үндэслэл сайнгүй байгааг энэ дашрамд дурдах хэрэгтэй.

Ганц жишээ хэлэхэд энэ жил нийслэл хотод талх, нарийн боовны, гол төлөв хувийн хэвшлийн 120 гаруй жижиг үйлдвэрлэл, хүнсний 8 зах шинээр зохион байгуулсан. Эдгээр нь хэрэглэгээ хангамжид зохих нэмэр болж байгааг үгүйсгэх аргагүй. Гэтэл энэ мэт жижиг, дунд хэмжээний үйлдвэрлэл, үйлчилгээний орлого дотоодын нийт бүтээгдэхүүний мэдээнд бүрэн орж чадахгүй байгаа

Дэвшүүлсэн зорилт бүрэн хэрэгжээгүйн шалтгааныг Засгийн газар юуны урьд өөрийн үйл ажиллагааны арга барил, зохион байгуулах ажлын дутагдалтай холбон үзэж байна.

Засгийн газрын танхимаас эхлээд төрийн захиргааны төв орон нутгийн байгууллагын ажилд ажил хэрэгч, шуурхай

байдал дутагдсан, шийдвэрийн биелэлтийг тодорхой зохион байгуулж, үр дүнг хянаж тооцохгүй байгаагаас удирдлагын бүх шатанд ажлын хариуцлага, эрс хүч нь суларч төлөвлөсөн ажил газар дээрээ хэрэгжихгүй, хэлээсэн үр дүнд хүрэхгүй байна.

Энэ нь юуны өмнө оны эхнээс Засгийн газар анхааралдаа авч ажилласан, тариалалт, ургац хураалт, түлш, эрчим хүчний салбарын өвлийн бэлтгэл, хотын нийтийн тээврийн үйлчилгээ зэрэгт шууд хамаарна.

Байгаа бололцоог дайчилж хөрөнгө, валютын асуудлыг шийдвэрлэж өгсөөр байтал эдгээр ажил дээр мэдэгдэм ахиц гараагүйн гол хариуцлагыг эн түрүүнд холбогдох сайд, салбар хариуцсан яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар хүлээх ёстой.

Малчид, хувийн аж ахуйтныг зах зээлтэй холбох асуудал шийдвэрлэгдээгүй, хувийн аж ахуйтнууд хоршиж ажиллах оновчтой арга хэлбэрээ олж чадаагүй, мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн онцлогт тохирсон мөнгө, зээлийн цэгцтэй бодлого, механизм бүрдээгүй байгаа нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд ноцтой нөлөөлж байна.

Харилцан бие, биенээ үгүйсгэж туйлшрахгүйгээр байгаа хөрөнгө бололцоог малчдын зүй ёсны ашиг сонирхолд нийцүүлэн ашиглаж шинэ хэлбэрийн хоршоо, нөхөрлөл үүсгэн байгуулах явдлыг дэмжин, дундаас нь завшихгүйгээр бүтээгдэхүүнийг нь зохион байгуулалттай борлуулан үйлчилж эхэлбэл зөвхөн хөдөө аж ахуйн төдийгүй, хөнгөн, хүнсний үйлдвэрүүдийн үйл ажиллагааг сэргээхэд ихээхэн түлхэц болохсон билээ гэж үзэж байна.

Газар тариалан эрхэлдэг компанууд утга, учиргүй бутарч, задарч байсан хохиролтой, хүнд үеэ давж, зохион байгуулалтын хувьд цэгцрэх замдаа орж эхэлж байна. Одоо газар тариалангийн компаниудын хувьцааг хөрөнгийн биржээр борлуулж эхлээд байна. Үнэ чөлөөлсний дүнд хэвийн ажилладаг компаниудын хөрөнгийн чадвар дээшлэх боломж бүрдлээ.

Сүүлийн 4 жилд газар тариалангийн техникт хэрэг дээрээ ямар нэгэн сэлбэлт хийгээгүй юм. Бүгдийг нэг зэрэг шинэчилж чадахгүй нь ойлгомжтой. Газар тариалангийн техникийг шинэчлэх бэсрэг хөтөлбөрийг яаралтай боловсруулж 1994 оноос бололцооны хэрээр хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөж байна.

Шинэ нөхцөлд аж үйлдвэрийн хувьцаат компаниудын ажиллах чадвар үнэхээр дутагдаж байна. Тэнд төрийн оролцоо алга, нөлөөлөх механизм ч байхгүй.

Ихэнх тохиолдолд удирдах нөхдийн нь арга барил үндсэндээ хуучнаа мөрөөдөх төдийгээс хол хэтрээгүй, дарга нар нь «би эзэн биш» гэсэн байр сууринаас ажилд хандаж байна. Үнэхээр ч тэд эзэн биш гэдэг нь тодорхой. Иймд байдлаас болж хувьцаа эзэмшигчдийн зүй ёсны эрх, эдийн засгийн сонирхол хохирч байна. Компаниуд нь өөдтэй ажиллавал хувьцааны ногдол ашгаар дамжин мянга, мянган хүний, хэрэг дээрээ манай нийт ард түмний амьдрал мэдэгдэм дээшлэх учиртай.

Валютын «албан» нэртэй хиймэл хямд ханшийг саяхан болтол албадан хэрэглэж ирсэн нь экспортын зориулалттай бүтээгдэхүүн хийдэг арьс, ноос боловсруулах компаниуд (үйлдвэрүүд)-ыг эдийн засгийн хувьд тамирдуулан унагаах нэг гол механизм болж байлаа. Үүнээс болоод гол үйлдвэрлэгчид түүхий эдээ зах зээлийн үнээр худалдан авах санхүүгийн чадваргүй болсон бөгөөд одоо ч тэр байдлаасаа гарч чадаагүй байна.

Ингэхлээр эдгээр компаниудын удирдлагын тогтолцоог өөрчлөн шинэчилж, хувьцаа эзэмшигчдийн зүгээс тавих хяналтыг хүчтэй болгох, компаниуд санхүүгийн чадвараа сэргээхэд нь туслалцаа үзүүлэх боломжийг эрс хайхаас өөр аргагүй болж байна.

Ур ашигтай үйлдвэрлэлийг төрөөс дэмжиж, зохицуулахгүйгээр тогтворжилтыг бэхжүүлж, эдийн засгийг сэргээж чадахгүй.

Засгийн газрын бодлого, үйл ажиллагаа 1994 онд үйлдвэрлэлийг дэмжих, үйлдвэрлэлд хөрөнгө оруулагчдыг урамшуулахад илүүтэй чиглэх болно.

Дэмжиж туслах хэлбэрийн нэг нь хяналж, зохицуулах явдал гэдгийг харгалзан төрийн өмчийн болон төрийн өмч оролцсон аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зохицуулж, өмч эзэмшигч байх эрхээ Засгийн газрын байгууллага эдэлж, хариуцлагаа дээшлүүлэх шаардлагатай болж байна.

Төрийн өмчийн аж ахуйн нэгжийн ашиг орлого, цалингийн сан, хатуу валютын нөөц, хөрөнгө оруулалтын зарцуулалт, ашиглалтад тавих хяналтыг чангатгаж нэгдсэн бодлогод захируулах болно.

Худалдаа үйлчилгээний хүрээнд эмх цэгцгүй байдал ихээхэн газар авч байна. Энэ бол өмч эзэмшигчдийн чадавхийн түвшин, үйлчилгээний соёлтой очоо талаар холбоотой юм.

Олон тумний дургүйцлийг төрүүлж байдаг энэ болхи байдалтай төрийн захиргааны байгууллага шийдвэртэй тэмцэл хийхийн тулд Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн идэвхтнүүд, тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа ард иргэдийн дэмжлэгт илүү түшиглэх ёстой.

Зах зээлийн харилцааны амин чухал нэг жишиг бол «хэрэглэгчийн шаардлага ямагт зөв» гэдэг зарчим байдаг билээ. Өмч эзэмшигч-үйлдвэрлэгч, нийлүүлэгч нь энэ зарчмыг дагахгүй бол эрт, орой хэзээ нэгэн цагт дампууралд гарцаагүй ордог жамтай гэдэг.

Нэгэнт макро түвшний бодлогын гол арга хэмжээг хэрэгжүүлсэн болохоор Засгийн газар, түүний байгууллагын үйл ажиллагаа үйлдвэрлэлийг сэргээж, нэмэгдүүлэх явдлыг дэмжихэд чиглэх цаг тулж ирлээ гэж үзэж байна.

Гэгэхдээ Засгийн газар аж ахуйн байгууллагыг төлөвлөгөөгөөр удирдаж, төлбөрийн баталгаагүй зээлээр тэтгэн албадан хөдөлгөж байсан хуучин арга барил руу өчүүхэн төдий ч хэлбийхгүйгээр, эдийн засаг өөрөө өөрийнхөө хүчээр хөдөлж хөгждөг тийм хэв шинжид шилжих нөхцөл бололцоог бүрдүүлэхэд үйл ажиллагааныхаа голыг чиглүүлэх болно.

Энэ нь манай бүх шатны байгууллага хариуцлага, сахилгыг өндөржүүлж ажлын зохион байгуулалтыг сайжруулах зорилтын хүчийг сулруулж хариуцлагагүй, сахилгагүй байдлыг халхавчлах үндэс болох ёсгүй гэдгийг цохон тэмдэглэж байна.

Засгийн газар хариуцлага, сахилга, зохион байгуулалт, зохицуулалтын тухай асуудлыг авч үзэхдээ ерөөс төрийн захиргааны байгууллагын шинэ үүрэг зорилт, асуудлыг урьдаас судалж боловсруулсан байх шаардлага, засаг захиргааны байгууллагын оновчтой бүтэц, төрийн албаны шинэ зохион байгуулалт, боловсон хүчний шинэ үеийг сургаж бэлтгэх, дадлагажуулах зэрэг манай нийгмийн хөгжлийн шаардлагад нийцсэн стратегийн гэж хэлж болох томоохон асуудлуудтай холбон авч үзэж байгаа юм.

Ер нь аливаа Засгийн газар цаг үеийн чанартай олон асуудлуудын дунд хөл алдахгүй байж зөвхөн өөрөө оршин тогтнохын төлөө биш харин өөрчлөгдөж байгаа нийгмийнхээ ирээдүйг харж, түүнд бодитойгоор үйлчилж чадах удирдла-

гын тогтолцоо, хэв шинжийг бий болгох асуудалд ажлынхаа гөлыг чиглүүлж байвал илүү тустай гэсэн чиг баримжааг удирдлага болгон энэ талаар хийх ажлыг цаашид ч эрчимжүүлэх шийдвэр төгс байна.

Дөрөв. Гадаад харилцаа

Засгийн газар үйл ажиллагааны хөтөлбөрт гадаад харилцааны талаар тусгагдсан бүхий л зорилт, чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулахыг эрмэлзэж ирлээ. Ингэхдээ санхүүгийн бололцоо, цаг хугацааны хүчин зүйлийг харгалзан анхаарлаа хоёр үндсэн гол чиглэлд төвлөрүүлж ажиллахыг чухалчилсан. Энэ нь хөрш орнуудтай харилцах, Монголыг дэмжигч орнууд, олон улсын санхүү, эдийн засгийн байгууллагуудтай харилцах асуудлууд юм. Энэ хоёр чиглэл нь чухамдаа манай ардчилал, шинэчлэлийг бататгах, эдийн засгийн бэрхшээлийг нимгэлж гэтлэн давахад шийдвэрлэх нөлөө үзүүлэх гадаад хүчин зүйл гэдгийг Засгийн газар нш үндэс болгож байгаа юм.

Монгол, Оросын харилцааг шинэтгэн байгуулах чиглэлд нэлээд алхам хийгдлээ. Монгол улсын Ерөнхийлөгч Оросын Холбооны Улсад албан ёсоор айлчилж Монгол, Оросын Холбооны Улсын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны гэрээ байгууллаа. Украин, Казакстан Киргизтэй бүх талын хамтын ажиллагаа улам гүнзгийрч байна. Монгол Улсын Их Хурлын дарга Казакстан, Турк улсад айлчиллаа. Монгол-Хятадын харилцаа хэвийн хөгжиж байна.

Манай улсаас өрнөдийн орнуудтай тогтоон хөгжүүлж буй харилцаа, хамтын ажиллагаа батжиж байна. Өнгөрсөн долдугаар сард Токио хотноо болсон 7-гийн бүлгийн удирдагчдын уулзалтаас Монголын өөрчлөлт, шинэчлэлийг цаашид ч дэмжихээ илэрхийлсэн явдал дээрхийн нэг нотолгоо юм. Түүнээс гадна Монголыг дэмжигч орнуудын Токиогийн III уулзалтад 23 улс, олон улсын 6 байгууллага оролцоо. Өнөөдөр Япон, АНУ, БНСУ, ЕЭЗХН, түүний гишүүн гол орнуудтай идэвхтэй харилцаа барьж тэдний тусламж дэмжлэгийг авч байна.

Олон улсын валютын сантай эдийн засгийн бүтцийг өөрчлөн шинэчлэх дунд хугацааны буюу 1993—1996 оны хөтөлбөрийг тохирон хэрэгжүүлж байна. Уг хөтөлбөр нь үйлдвэрлэл, нийгмийн дэд бүтэц, хөгжлийн хүчин зүйл, түүнчлэн удирд-

лагын бүтцийг өөрчлөн шинэчлэх өргөн хүрээтэй асуудлыг хамарч байгаа юм. Дэлхийн банк, Азийн хөгжлийн банктай хамтын ажиллагааны шинэ гэрээ байгуулж, эхний ээлжийн арга хэмжээг хэрэгжүүлж эхлээд байна. НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудтай хамтран ажиллах, түүний тусламж дэмжлэгийг авах явдал эрчимжиж байна.

Нэг үгээр хэлбэл, өнөөдрийн тулгамдсан зорилтыг шийдвэрлэх гадаад таатай нөхцөлийг бүрдүүлэх чиглэлд мэдэгдэм үр дүн гарч байна. Гэхдээ энэ бол бүх юм болж бүтэж байна гэсэн үг биш. Ажлын зохион байгуулалтыг сайжруулах, зээл, тусламжийн хөрөнгийг хугацаа алдалгүй олж авч үр дүнтэй ашиглах, гадаадын хөрөнгө оруулалтыг бодитойгоор нэмэгдүүлэх, ойрын болоод хэтийн зорилтыг оновчтой холбох зэргээр цаашид анхааран ажиллах зүйл их бий.

Тав. Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо шинэчилж, төрт ёсыг бэхжүүлэх асуудал

Хууль ёсыг хүндэтгэн сахиж, хариуцлагын тогтолцоог бүх шатанд бэхжүүлэх явдал чөлөөт эдийн засаг бүхий иргэний ардчилсан нийгэм бүрэлдэж зүгшрэхэд шийдвэрлэх ач холбогдолтой нь хэн бүхэнд тодорхой юм.

Өнгөрсөн хугацаанд Засгийн газар Монгол улсын Үндсэн хуулийн дагуу Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Засгийн газрын тухай хуулийг батлуулан төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагыг шинээр эмхлэн бүрдүүллээ.

Засгийн газар төрийн гүйцэтгэн захирамжлах байгууллагын шинэ тогтолцоог бүрдүүлэхдээ нэг талаас захиргааны аппаратын ажил хэрэгч, шуурхай, цомхон байдлыг хангаж зардлыг хямдруулах, нөгөө талаас тэдгээр байгууллагууд үйл ажиллагаагаа зах зээлийн эдийн засгийн шинэ нөхцөлд тохируулан өөрчилж сайжруулах чадвартай байх зорилтын аль алийг удирдлага болгосон юм.

Төрийн захиргааны төв байгууллагуудыг шинэ зохион байгуулалтад оруулснаар яам, тусгай газар гурваар, ажилтагчид нь 12 хувиар, хэлтэс, тасгийн тоо нь 30 гаруй нэгжээр цөөрөв.

Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаадын бүтцийг шинэчлэн тогтоосноор орон тоо нь 20 орчим хувиар, түүний дотор удирдах ажилтны орон тоо нь 40 шахам хувиар багаслаа.

Тус улсын төсвийн нийт зардалд удирдлагын зардлын хувийн жин 1992 онд 9,3 хувь байсан бол 1993 онд 5,6 хувь болж буурсан юм.

Засгийн газар зах зээлийн эдийн засгийн дэд бүтцийг бүрдүүлж зүгшрүүлэхийн хэрээр аль болох цомхон, цэгцтэй аппараттайгаар төрийн ажил хэргийг явуулах чиглэл баримтлан удирдлагын мэргэшсэн тогтвортой бүтэц бий болгох зорилт тавьж ажиллаж байна.

Уг зорилтыг шийдвэрлэхэд Олон улсын валютын сан, Дэлхийн банктай хамтран боловсруулж хэрэгжүүлж эхлээд байгаа дунд хугацааны хөтөлбөр мөн манай Засгийн газрын хүсэлт саналыг үндэслэн НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрөөс хандивлагч орнуудтай хамтран гүйцэтгэхээр төлөвлөж байгаа удирдлагын чадавхийг дээшлүүлэх төсөл чухал үүрэг гүйцэтгэх болно.

Эдгээр төсөл, хөтөлбөрийг олон улсын холбогдох байгууллагатай хамтран боловсруулж хэрэгжүүлэхдээ Монголын Засгийн газраас баримталж байгаа зарчмын гол үзэл баримтлал нь нийтэд тодорхой юм. Энэ бол Засгийн газар, түүний үндсэн нэгж хэсэг болох яам, газрууд нь аж ахуйн амьдралын өдөр тутмын асуудалтай зууралдаж байсан хуучин зуршлаас салж эдийн засаг, нийгмийн амьдралыг хуульд эрх зүйн тохируулга, төсөв, санхүүгийн бодлогоор голчлон зохицуулах, төвлөрлийг багасгах, эрх, үүрэг хариуцлагыг анхдагч ба дунд шатанд илүү шилжүүлж удирдлагын дээд шатанд нийт улс орны шинжтэй бодлого, стратегийн асуудлуудад голлон анхаардаг тийм тогтолцоонд тууштай шилжих явдал юм.

Эдгээр зорилтыг зөв шийдвэрлэх үүднээс төрийн албаны хууль, яам, тусгай газрын эрх зүйн байдлын тухай хууль зэрэг захиргааны шинэчлэлд холбогдох эрх зүйн гол гол баримт бичгийг боловсруулах ажилд цаг алдах, алгуурлах явдал гаргахгүй байж тус улсын төрийн захиргааны удирдлагын тогтолцооны бүдүүвчийг гаргаж мөрдөх шаардлага тулгарч байна.

Нөгөө талаар цаг үеэ сайтар мэдэрч шинэлэг сэтгэлгээ зөв арга барилаар ажиллаж чаддаг үнэхээр төр улс, ард түмнийхээ эрх ашгийн төлөө ухамсарт амьдралаа зорилгочин эрмэлзэлтэй төрийн захиргааны мэргэжсэн ажилтнуудын шинэ үеийг бэлтгэх том зорилт бидэнд тулгарч байна.

Төсвийн байгууллага, түүний дотор төрийн захиргааны ажилтнуудын цалин хөлс доогуур, амьдралын нийгмийн баталгаа нь сул, удирдлагын бүтэц тогтворгүй зэрэг шалтгаанаас эдгээр салбарт ажиллагчдын тогтвор суурьшил хангалтгүй байгаа тодийгүй энэ нь хүмүүсийн ажлын хариуцлага, санаачилга, идэвх хангалтгүй байгаагийн бас нэг үндсэн шалтгаан болж байгааг ч нуухын хэрэггүй юм.

Ардчилал, чөлөөт байдал, эдийн засгийн зах зээлийн харилцааны мөн чанарыг ташаа ойлгож захирах, захирагдах ёсыг үгүйсгэн үүргээ бүрэн биелүүлэхгүй байх, хариуцлага алдах, түүгээр ч зогсохгүй эрхэлж буй албан тушаал, эрх мэдлээ ашиглан шударга бус аргаар хөрөнгөжих, хувийн эрх ашгийг эн түрүүнд тавьж төрийн ажлыг түүнийхээ хавсарга болгон эрхлэх, үлгэр дууриалалгүй байдал гаргах зэрэг төрийн ажилтны ёс суртахуунд харш аливаа дутагдалтай бид бүх чиглэлээр эвлэршгүй тэмцэл явуулах болно.

Төрийн захиргааны төв байгууллагуудад ажиллагчдын ажлын хариуцлага, гүйцэтгэх сахилгыг бүх талаар сайжруулах, тэднээс төрийн ажилтны ёс суртахууны хэм хэмжээг чандлан сахихад тавих шаардлагыг өндөржүүлэхийн зэрэгцээ тэднийг аливаа гүтгэлэг, нэр төрд нь харшилсан худал, хуурмаг явуулгаас тууштай хамгаалах шаардлага ч бас байхыг үгүйсгэхийн аргагүй.

Хариуцлага, халамж анхаарал хоёр эн тэгш байх зарчмыг газар сайгүй чанд баримтлах нь бүх шатны боловсон хүчин, түүний дотор төрийн захиргааны ажилтнуудтай ажиллах гол зарчим байх ёстой.

Энэ бүхэн бол угтаа Монгол оронд манай төрт ёсны арвин баялаг өв уламжлал, дэлхийн бусад оронд хуримтлагдсан мэдлэг туршлагад тулгуурлан сайтар судалж боловсруулсны үндсэн дээр төрийн захиргааны шинэчлэл явуулах тухай цогц асуудал мөн.

Судалгаа шинжилгээний бие даасан байгууллага, эрдэмтэн мэргэд, эгэл жирийн хүмүүсийг өргөн оролцуулах замаар тодорхой цаг, хүч зарж хийх энэ ажлыг нэг удаагийн арга хэмжээгээр төгс шийдвэрлэчих боломжгүй учир Засгийн газар уг ажлыг эхлэж дараатай, чиглэсэн зорилготой, цэгцтэй хэрэгжүүлэх шийдвэр төгс байгаагаа энэ ялдамд илэрхийлж байна.

Нийгэм, эдийн засгийн харилцаанд үндсээр нь өөрчлөлт байгаа шилжилтийн үед элдэв бэрхшээл, сөрөг үзэгдлүүд олон

гарч байна. Улс орны хэмжээнд сахилга хариуцлага суларч, дэг журам алдагдсанаас гэмт хэрэг, түүний дотор хүний амь нас, эрүүл мэндийг хохироох, хулгай дээрэм хийх, архидан согтуурч танхайрах явдал эрс өсч аюултай зааг тулж ирээд байна.

Оны эхний 9 сард 12,5 мянган гэмт хэрэг гарсан нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 44 хувиар өслөө. Гэмт хэрэг, зөрчлийн улмаас 674 хүн амь насаа алдаж, аж ахуйн нэгж, байгууллагын болон иргэдийн өмч хөрөнгөд учирсан хохирлын хэмжээ 1 тэрбум шахам төгрөгт хүрсэн байна. Энэ нь цаг тутамд 2 гэмт хэрэг гарч элдэв зөрчил, гэмт хэргийн уршгаар өдөрт дунджаар 2 иргэн амь насаа алдаж байна гэсэн үг юм.

Он гарсаар ууж согтуурсан 28,1 мянган хүнийг эрүүлжүүлсэн нь нодининийн мөн үеийнхээс 1,5 дахин өсчээ. Архидан согтуурах энэ хорт үйлдэлд эмэгтэйчүүд, хүүхэд, залуучууд татагдан орж байна.

Гэмт хэргийн өсөлтийн үндсэн шалтгаануудад нийгмийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг цаг алдалгүй хийж хуучин шинийн зааг ялгаа, залгамж холбоог бүрэн хангаж чадаагүй, төрийн хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд тавих хяналтын иж бүрэн тогтолцоо бүрдээгүй, хууль хяналтын байгууллагуудын харилцан уялдаа хангалтгүй, гэм буруутай хэн боловч хуулийн өмнө эрх тэгш байж зохих хариуцлага хүлээх зарчим тэр бүр хэрэгжихгүй, ардчилал, хүний эрхийг урвуулан ойлгогчид олширсон зэргийг хамруулж болно.

Байдал ийм байгааг ард түмэн ойлгож, төр, захиргаа, хуулийн байгууллага, тэдгээрийн албан тушаалтнаас хууль ёсыг сахиулах, дэг журмыг чангатгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахыг зүй ёсоор шаардаж байна. Иймч учраас Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар «Монгол улсад нийгмийн дэг журмыг хангах талаар төрөөс явуулах үйл ажиллагааны үндсэн чиглэл»-ийг Улсын Их Хурал баталж мөрдүүлж, Ерөнхийлөгчийн дэргэд «Нийгмийн дэг журмыг хангах ажлыг зохицуулан зохион байгуулах үүрэг бүхий түр зөвлөл» байгуулагдан ажиллаж байна.

Ерөнхийлөгчийн эдгээр санал, санаачилгыг Засгийн газар бүх талаар дэмжин хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахаар чармайж байна. Шүүх Цагдаагийн байгууллагыг боловсон

хүчнээр хангах, материаллаг баазыг бэхжүүлэх арга хэмжээ авч Цагдаагийн хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн бариад байна.

Түр зөвлөлийн зөвлөмжийг хэрэгжүүлэн нийгмийн дэг журам, сахилгыг бэхжүүлэх чиглэлээр бүх аймаг, нийслэл, хот, зарим сум, дүүрэг, хороо, багт үзлэг шалгалт хийж энэ чиглэлээр ажил төрлийн төрөлжсөн семинарыг зохион байгууллаа. Семинарын үеэр тухайн нутаг дэвсгэр дээр гарч буй гэмт хэрэг, зөрчлийн байдал, нөхцөл шалтгаанд дүн шинжилгээ хийж, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журам, сахилгыг бэхжүүлэх арга замыг нухацтай шүүн хэлэлцэж 2 жилийн хөтөлбөрийг баталлаа.

Төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагууд дотоодоо дэг журам, сахилгыг бэхжүүлэх, хариуцлага дээшлүүлж, ажил хэрэгч байдлыг хангах, архидан согтуурахтай хийх тэмцлийг хүчтэй болгох чиглэлээр зохих шийдвэрүүд гарган хэрэгжүүлж эхлээд байна.

Хяналтын төрөлжсөн байгууллагууд Түр зөвлөлийн шугамаар хийгдэх сэдэвт шалгалтуудыг удирдан зохион байгуулж байгаагийн зэрэгцээ томилогдсон ажлын хэсэг төрийн хяналтын өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгч, төрийн хяналтын хуулийн үзэл баримтлал, уг хуулийн төслийг боловсруулаад байна.

Төрийн хяналтын хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж батлах нь нийгмийн дэг журам, сахилгыг бэхжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой гэж үзэж эмэ талаархи Ерөнхийлөгчийн саналыг дэмжиж байгаа юм.

Хууль тогтоомжийг мэдээллийн бүхий л арга хэрэгслээр олон түмэнд тайлбарлан таниулах, итгүүлэн үнэмшлүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, явцыг хянах, үр дүнг мэдээлэхэд төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагуудын бүх шатны удирдах ажилтны анхаарлыг төвлөрүүлэн ажиллах болно.

Төр, захиргаа, хууль хяналтын болон олон нийтийн байгууллага бүх шатанд гар нийлэн ажиллаж нийгмийн дэг журам, сахилга, зохион байгуулалтыг бэхжүүлж, хууль дээдлэх ёсыг хэвшүүлэх нь ард олныхоо амгалан тайван ажиллаж, аж төрөх наад захын баталгааг хангахад шийдвэрлэх ач холбогдолтой гэж Засгийн газар үзэж байна.

Их Хурлын эрхэм гишүүд ээ!

Улсын Их Хурлын хаврын чуулганаас өгсөн үүргийн дагуу Монгол Улсын төвлөрсөн төсвийн энэ оны эхний 9 сарын гүйцэтгэлийн тухай танилцуулгыг Та бүхэнд тараасан билээ.

Улсын Их Хурал, валютын ханшийг чөлөөлсөнтэй холбогдуулан энэ оны 7 дугаар сарын 12-нд төвлөрсөн төсөвт тодотгол хийх шийдвэр гаргасан юм. Тэр цагаас хойш, эхний 9 сарын гүйцэтгэлийн гаргасан хугацаа нь 2 сар 18 хоногийг хамарч байна.

Төвлөрсөн төсвийн эхний 9 сарын гүйцэтгэлийн талаар товч илтгэе.

Тайлангийн хугацаанд улсын төвлөрсөн төсөвт 22 тэрбум төгрөгийн орлого орж, 26,5 тэрбум төгрөгийн санхүүжилт хийсний дотор 6,8 тэрбум төгрөгийн татаасыг орон нутгийн төсөвт олголоо.

Төсвийн орлого төлөвлөсөн хэмжээнээс 6,8 тэрбум төгрөгөөр доогуур байгаа нь үндсэндээ импортын барааны гааль, худалдааны татварт ногдож байна. Энэ хугацаанд манай улс нийтдээ 245,7 сая долларын импортын бараа татан авсны дотор гааль, худалдааны татвараас чөлөөлөгдөг болон хөнгөлөлт эдэлдэг хүнс, өргөн хэрэгцээний зарим бараа, зээл, тусламж, реэкспорт 50 гаруй хувийг нь эзэлж байна. Түүнчлэн төгрөг-валютын ханш урьдчилан тооцож төлөвлөснөөс 10 гаруй нэгжээр доогуур явж ирлээ. Энэ бүхэн нь гааль, худалдааны татварын орлого тасрахад зонхилох нөлөөтэй байлаа. Шатах, тослох материалын гадаад худалдааны үнэ тооцож байснаас энэ хугацаанд хямдарсан явдал үүнд бас нөлөөлсөн. Үүнээс гадна төлбөрийн чадвар сул, түүхий эд, материалын хомсдол, үйл ажиллагааны доголдлоос голчлон шалтгаалж төвлөрсөн төсөвтэй харьцдаг 40-өөд аж ахуйн нэгжийн бараг гуравны нэг нь төсвийн өмнө хүлээсэн үүргээ тасалдуулсан байна. Төсөвт орох орлогын тасалдлын нэлээд хувь нь Эрдэнэт үйлдвэр, Нефть импорт концерид ногдож байгаа болно.

Эхний 3 улиралд жилийн санхүүжилтийн 45,3 хувийг хийжээ. Энэ нь улирлын төлөвлөгөөт хэмжээнээс 10 орчим тэрбум төгрөгөөр бага байна. Үүний 7,7 тэрбум төгрөг нь 1990—1991 онуудын худалдааны тэнцлээр гарсан зарим гадаад өрийг эх үүсвэрийн дутагдлаас шалтгаалан бүрэн төлж чадаагүйтэй холбоотой юм.

Орлогын тасалдалтай уялдаж орон нутгийн төсөвт болоод тэтгэврийн санд олгох татаас, зарим байгууллагын санхүүжилт хугацаандаа бүрэн гарч чадаагүйг 10 дугаар сард нөхөн олгож байна.

Тайлангийн хугацаанд нийгмийн зориулалттай арга хэмжээнд 10,6 тэрбум, үйлдвэрлэлийн салбарт 1,5 тэрбум хөрөнгө оруулалтад 3,2 тэрбум, цаг үеийн бусад зардалд 4,8 тэрбум төгрөгийн санхүүжилт хийлээ.

Хаврын мал бэлтгэл, уринш боловсруулалт, хүнсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, саалийн механикжсан фермүүдийг засварлах, намрын ургац хураалт, үр тэжээлийн улсын нөөц бүрдүүлэх зэрэг улс орны амин чухал хэрэгцээнд зориулж төсвөөс эргэж төлөгдөх нөхцөлөөр 1,4 тэрбум төгрөг олголоо.

Энэ хугацаанд орон нутгийн төсөвт 7,1 тэрбум төгрөгийн орлого орж, 11,9 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна.

Төвлөрсөн төсвийн энэ оны гүйцэтгэлийг урьдчилсан байдлаар тооцож үзэхэд төсөвт 46 тэрбум төгрөгөөс илүүгүй орлого орох төлөвтэй байна. Орлогын төлөвлөгөөний тасалдал үндсэндээ импортын барааны гааль, худалдааны татвар дээр гарахаар байгаа болно.

Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлттэй уялдуулан Улсын Их Хурлаас баталсан алдагдлын хэмжээнд багтаан зарлагын санхүүжилт хийхээр ажиллаж байна. Ингэхдээ энэ оны төсөвт бодогдсон нийгмийн арга хэмжээг санхүүжилтийн эх үүсвэрээр хангахад Засгийн газар анхаарч ажиллах болно.

ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХУУЛИЙН ТУХАЙ

Монгол Улс «Зах зээл» гэдэг их далайд хөлөглөн орлоо. Энэ хөлгийн хөдөлгүүр нь өрсөлдөөн. Өрсөлдөх чадваргүй л бол живж үхнэ. Бусдын онгоцонд дайгдвал бид (зээл, тусламжид нь дулдуйдаж өдөр хоног өнгөрөөсөөр байгаад) өрөнд баригдана, эсвэл «социалист систем»-тэйгээ хамт живчихнэ. Яах вэ? Хариулт бол ганц! Эдийн засгийн бие даасан байдлаа хангаж, өрсөлдөх чадвараа дээшлүүлэх! Энэ зорилтыг хэрэгжүүлэх гол арга замын нэг нь дэлхийн олон орны туршлагаар нотлогдсон гадаадын хөрөнгө оруулалтыг өөртөө татах арга юм.

Дэлхийн улс орнуудын хооронд зах зээлд эзэмдэх асар их өрсөлдөөн явагдаж байгаа нь гадаадын хөрөнгө оруулалтын төлөө өрсөлдөөнийг ихээхэн хүчтэй болгож байна. Ялангуяа хөгжиж байгаа орнууд, түүний дотроос БНХАУ, ОХУ хоёр гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхлыг өөртөө татах, тэдэнд нэн таалмжтай нөхцөл бүрдүүлж өгөхийг хичээж байна. Иймд нөхцөл байдалтай уед ГХОХ боловсрогдож гарлаа.

Гадаадын хөрөнгө оруулагч (ГХО-ч) Монгол улсад ямар эрх эдлэх вэ?

— Өөрийн хөрөнгөө (эд хөрөнгө, ашиг орлогоо) чөлөөтэй захиран зарцуулна (10 дугаар зүйл).

— Өмч хөрөнгийг нь нийгэмчлэх, хууль бусаар хураажавах үйлдлийг Монгол Улс хэзээ ч хийхгүй (8 дугаар зүйл).

— Монгол Улсын хуулиар хориглосноос бусад бүх салбар, нутаг дэвсгэрт хөрөнгө оруулж болно.

— Хөрөнгөө оюуны үнэт зүйл, материаллаг эд юмсын аливаар нь ч оруулж болно. Чөлөөт валютаар болон төгрөгөөр хөрөнгө оруулалт хийж болно. Харин анхны хөрөнгө оруулалтыг төгрөгөөр хийхгүй, хийж болох ч үгүй. Зөвхөн дахин хөрөнгө оруулалтыг хийж байгаа нөхцөлд л төгрөгөөр болно

— Хөрөнгө оруулалтыг дангаараа ч хийж болно, монголын хөрөнгө оруулагчтай хамтарч болно.

— Монгол Улсад монголын хөрөнгө оруулагчтай адил зарим талаар давуу нөхцөл эдэлнэ. Давуу нөхцөлийг өндөр рисктэй (ө. х. аз туршилт ихтэй) нөхцөлд л бүрдүүлж өгнө

— Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаатай холбогдолтой маргаан гарвал хэнээр таслуулахаа өөрөө шийдвэрлэнэ. Гагцхүү гэрээндээ л энэ тухай тодорхой бичсэн байх хэрэгтэй болно.

ГХО-ч ямар хөнгөлөлт эдлэх вэ?

— Гаалийн ба худалдааны татвараас тодорхой нөхцөлөөр чөлөөлөгдөнө. Технологийн зорилалттай, дүрмийн санд бүрдэл болж орох тоног төхөөрөмжийг гаалийн ба худалдааны татвараас чөлөөлнө.

— Импортын түүхий эд, материал, сэлбэг хэрэгслийг үйлдвэрлэлийн зорилалтаас нь хамаарууллан гаалийн татвараас 5 жил чөлөөлнө. Харин худалдаа, нийтийн хоолны салбарт энэ хөнгөлөлт хамаарахгүй. Учир нь нэг талаас эдгээр салбар богино хугацаанд үр ашигтай ажиллах бололцоотой, нөгөө талаас нэг орны хөрөнгө оруулагчдын сонирхолд хэт их автагдахгүй байх манай эрх ашигтай холбоотой.

— Монгол Улсын эрх ашигт нийцэх салбарт хөрөнгө оруулбал харилцан ашигтай байхаар орлогын татвараас хөнгөлнө. Манай улсын эдийн засгийн суурь дэд бүтэц болох, хөгжлийн түвшингээр нэн дорой байгаа эрчим хүч, зам харилцаа, холбооны үндсэн сүлжээ байгуулахад хөрөнгө оруулбал орлогын татвараас 10 жил чөлөөлөгдөж, 5 жил 50 хувиар хөнгөлөлт эдэлнэ.

Манай эрдэнийн түүхий эд нефть, хатуу түлш олборлох, боловсруулах салбарт хөрөнгө оруулж аж ахуйн үйл ажиллагаа эрхэлбэл татварын ачааллаас 7,5 жил чөлөөлөхөөр хуульчилж байна (20 дугаар зүйл).

Гагцхүү оруулж байгаа хөрөнгө нь дорвитойхон байж, үйлдвэрлэл нь 15-аас доошгүй жил тасралтгүй явагдахаар байвал манай эрх ашигт илүү нийцнэ. Машины үйлдвэрлэл, электроник, хими, төмөрлөгийн зэрэг монгол улсад техникийн дэвшлийг хангах, хүнд үйлдвэр хөгжүүлэхэд суурь болох салбарт мөн дээр дурдсантай ижил хөнгөлөлт үзүүлэх болно.

— Экспортын чиглэлтэй, гадаад зах зээлд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа бол энэ хуулийн (20 дугаар зүйлийн 2 дахь заалтын) дагуу орлогын татварын хөнгөлөлт үзэж, гаалийн хуулийн дагуу экспортын татвараас чөлөөлөгдөнө.

— Экспорт бол хамгийн орчин үеийн загвар, хамгийн сонин дизайн, хамгийн өндөр чанар чансаа, хамгийн тэргүүний

технологи зэрэг өрсөлдөх чадварын цогц шинж учир хөрөнгө оруулалтын бодлогын зангилаа бөгөөд Засгийн газар ч экспортыг хөгжүүлэх нэн таатай нөхцөл бүрдүүлэхийг эрмэлзэж байна.

— Гадаадын хөрөнгө оруулагч өөрт ногдох орлогоосоо Монгол Улсад дахин хөрөнгө оруулалт хийвэл ГХО-ын хуулийн 20 дугаар зүйлийн дөрөв дэх заалтад томьёолсон урамшил хүртэнэ.

ГХО-ч газар өмчлөх, эзэмших эрхтэй юу?

— Газар өмчлөх, эзэмших эрхгүй.

— Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу гадаадынханд газрыг зөвхөн ашиглуулна. Ашиглуулахдаа гэрээний үндсэн дээр гүйцэтгэнэ. Гэрээнд ашиглуулах болзол, журам, төлбөр, хугацаа, харилцагыг тусгана. Гэрээг зөвхөн тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн төлөөлөгчдийн хурал болон Тэргүүлэгчдийн зөвшөөрснөөр байгуулна.

Газар ашиглуулах хугацаа нь хэдэн жил байх вэ?

— Хугацаа нь аж ахуйн үйл ажиллагаа явуулах хугацаагаар тодорхойлогдох бөгөөд 60 жилээс илүүгүй байна. Энэ хугацааг нэг удаа сунгаж болно. Тэр нь 40 хүртэл жил байж болно.

ГХО-ч ямар үүрэгтэй вэ?

— Хууль тогтоомжид тусгайлан зааснаас бусад тохиолдолд Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн нэгэн адил үүрэг хүлээнэ. Өөрөөр хэлбэл Монгол Улсын хууль тогтоомжийг сахин биелүүлэх үүрэгтэй бөгөөд ялангуяа хүн ам, байгаль орчинд хортой нөлөө үзүүлэхгүй байх ёстой. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авахыг гадаадын хөрөнгө оруулагчаас шаарддаг нь дэлхий нийтэд мөрддөг нийтлэг зарчим болсон байна. Энэ тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2-т заасан болно. Үүргээ биелүүлэхгүй байвал хуулийн дагуу харилцлага хүлээнэ.

ГХО-чид хориглох, хязгаарлах зүйл гэж бий юу?

— Байна. Тухайлбал:

— Монгол Улсын хууль тогтоомжоор хориглосон үйлдвэр, үйлчилгээ явуулж болохгүй.

— Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхийг хориглосон нутаг дэвсгэрт хөрөнгө оруулалт хийж аливаа үйл ажиллагаа явуулахгүй.

— Монгол Улсын аж ахуйн байгууллагын хувьцааг эзэмшихдээ гадаадын хөрөнгө оруулагчдад зөвшөөрсөн хязгаарлалтын хүрээг баримтална. Тухайлбал, тодорхой салбар, аж ахуйн нэгжийн хувьцааны хэдэн хувийг гадаадын хүн эзэмшиж болох тухай заалтыг Монгол Улсын Үнэт цаасны хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан Засгийн газрын болон аж ахуйн тухай нэгжийн эзний шийдвэрээр тодорхойлно.

ГХО-ч үйл ажиллагаагаа юунаас эхлэх вэ?

— Хөрөнгө оруулалтыг дангаараа хийж байгаа бол Худалдаа, үйлдвэрийн яамтай урьдчилан зөвшилцөх ба монголын хөрөнгө оруулагчтай хамтран хөрөнгө оруулалт хийх бол төслийн баримт бичгээ Худалдаа, үйлдвэрийн яамны загвар, шаардлагын дагуу гүйцэтгэнэ.

— Энэ хуулийн 12, 15 дугаар зүйл, Аж ахуйн нэгжийн хуулийн дагуу Монгол Улсад хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх зөвшөөрлийг Худалдаа, үйлдвэрийн яамнаас авч, аж ахуйн нэгжийн бүртгэлийг Улсын татварын албанд хийж гүйцэтгэнэ.

Улсын Их Хурлын гишүүн Т. ОЧИРХҮҮ

ХӨДӨЛМӨРИЙН ХАМТЫН МАРГААНЫГ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

Ийм хууль яагаад гарах шаардлагатай болсон бэ?

Монгол Улсын Үндсэн хууль, Хөдөлмөрийн хуулийг батлан гаргаснаар хөдөлмөрийн харилцааны нэг чухал хэсэг болох хөдөлмөрийн хамтын маргааныг зохицуулах эрх зүйн үндсийг боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдсан юм.

Сүүлийн жилүүдэд хамтын шинж чанартай маргаан нэг бус удаа гарч, зарим тохиолдолд ажил хаялтад хүрч байсныг АИХ-ын тэргүүлэгчдийн 1990 оны 99 дүгээр зарлигаар баталсан Хөдөлмөрийн хамтын маргаан шийдвэрлэх дүрмээр тэр бүр бүрэн зохицуулж чадалгүй өнөөг хүрлээ.

Монгол Улсын үндсэн хууль батлагдсанаар дээрх дүрмийн зарим заалт нь Үндсэн хуулийн заалттай зөрчилдсөн гэж үзэж Үндсэн хуулийн цэц тэдгээрийг хүчингүй болгосон билээ.

Хамт олны хөдөлмөрийн маргааныг шийдвэрлэх дүрэмд Хөдөлмөрийн харилцаанд тэгш эрхтэй оролцох зарчим болсон захиргаа (эзэн)-наас ажлын байрыг түр хаах эрхийг орхигдуулсан, шүүхээс хууль бус гэж тооцогдсон, ажил хаялт, ажлын байрыг түр хаасан үйл ажиллагааг зохион байгуулсан эттээдэд хүлээлгэх хариуцлагыг заагаагүй зэрэг нь шинэ хууль батлан гаргах үндсэн шалтгаан болсон байна.

Хуулийн үндсэн үзэл баримтлал юу вэ? Энэ хуулиар хамтын гэрээ байгуулах, биелүүлэх явцад талуудын хооронд үүссэн, хөдөлмөрийн хамтын маргаантай холбогдсон харилцаа (хуулийн 1 дүгээр зүйл)-г зохицуулах бүрэн бололцоотой юм. Яагаад ийм хүрээг сонгон авсан бэ? Үүнд дор дурдсан үзэл баримтлалын чанартай хариуг өгөх нь зүйтэй.

а) Хамтын гэрээ гэдэг бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагын ажлын онцлогт тохирсон нэгэн ёсны «бага хөдөлмөрийн хууль» гэдгийг байгууллагын эрх баригч тэр, үйлдвэрчний эвлэлийн байгууллага ч тэр сайн мэднэ. Иймд болохоор тухайн байгууллагын хувьд хамтын гэрээнд тусгагдсан хөдөлмөрийн харилцааны асуудлыг хамарч маргаан гарвал уг хууль түүнийг зохицуулна гэсэн үг;

б) энэ хуулиар хамтын гэрээг аж ахуйн нэгж, байгууллагын түвшинд нэг талаас захиргаа (эзэн), нөгөө талаас

үйлдвэрчний эвлэл, хэрэв үйлдвэрчний эвлэл байхгүй бол хамт олны төлөөлөгчдийн хооронд заавал байгуулах, хэрэв гэрээ байгуулаагүй буюу байгуулахыг оролдоогүй бол хөдөлмөрийн хамтын маргаан байхгүй гэж ойлгох ёстой.

Эвлэрүүлэх үйл ажиллагаанд энэ хууль анхаарал хандуулсны учир юу вэ? Энэ хуулийг олон хүн ажил хаялтын тухай хууль гэж ойлгож, ярьдаг. Гэтэл захиргаа, ажилтны хооронд үүссэн хөдөлмөрийн харилцааны асуудлаархи саналын зөрүүг нь аль болохоор зохицуулж, ажил хаялтад хүргэхгүй байх нөхцөл боломжийг бүрдүүлэх эрх зүйн үндсийг тавихад уг хууль чилгэгдсэн болохыг ойлгох ёстой. Тухайлбал энэ хуулийн 4, 5, 6, 7 дугаар зүйлүүдэд маргалдаж буй талууд харилцан буулт хийх буюу тавьж буй шаардлага, түүний албан ёсны хариуд талууд хүндэтгэлтэй хандах, асуудлын гол үндэслэл байгаа боломжийг зөвөөр ойлгож аль болохоор тайван айван хэлэлцэж эвлэрч байх боломжийг бүрдүүлэх чиглэл тусгагдсан юм.

Ажил хаялтад хүрвэл яах вэ? Энэ хуулийн дагуу талууд эвлэрэх бүх шатны арга хэмжээ авсан боловч тохиролцоонд хүрч чадаагүй бол хуулийн 8 дугаар зүйлд зааснаар гэрээнд оролцсон үйлдвэрчний эвлэлийн байгууллага тавьсан шаардлагаа шийдвэрлүүлэх эцсийн арга хэмжээ болгож ажил хаялтыг санаачлан зохион байгуулж, хожмын хариуцлагыг бие дааж хүлээх юм.

Харин аж ахуйн нэгж, байгууллагын захиргаа (эзэн) нөгөө талаас тавьсан шаардлагыг хүлээн авах боломжгүй гэж үзвэл ажил хаялтын эсрэг арга хэмжээ болгож ажил хаялтад оролцож буй ажилтны ажлын байрыг түр хааж болно гэсэн шинэ хэм хэмжээ тогтож байгаа юм. Үүнийг бусад орнуудад локаут гэж нэрлэдэг. Уг арга хэмжээг авсан захиргааны эрх баригч буюу эзэн хожмын хариуцлагаа өөрөө хүлээхээр хуульд тусгасан болно.

Харин хөдөмлөрийн хамтын маргаан хууль гарахаар бүхий л төрлийн ажил хаялтыг энэ хуулиар зохицуулах мэтээр ойлгох, ярих нь олонтаа байдаг. Тухайлбал улсын хэмжээгээр Шинжлэх ухаан, соёл, боловсрол, эрүүл мэндийн салбарын ажилтнуудыг нэгтгэн хамруулсан ажил хаялтыг хэрхэн зохицуулах вэ? гэсэн асуулт гарна.

Эдгээр салбарын хувьд төрийн хуулийн дагуу улсын төсвөөр санхүүжиж өөрийн үйл ажиллагааг явуулдаг. Аж ахуйн нэгжид хамтын гэрээгээр шийддэг олон асуудал төрийн эрх

барих дээд байгууллагаас баталсан хуулийн дагуу Засгийн газрын шийдвэрээр тогтоосон хэм хэмжээ, норм, норматив торийн төсөвт байгууллагын хувьд үйлчилж байдаг учраас тэнд ажиллагчдын нийгмийн баталгааг хангах үүрэг төрийн байгууллагад ногдож байгааг харгалзан үзвээс төсөвт байгууллагын ажилтнаас салбараараа нэгдэж тавьсан шаардлага нь төрийн хууль, шийдвэрийг өөрчилж байж хангагдах шинжтэй болж ирдэг.

Хэрэв төсөвт байгууллагын ажилтнуудыг салбарын хэмжээгээр нэгтгэн зохион байгуулж ажил хаялтад хүргэх нь шууд утгаараа хөдөлмөрийн хамтын маргааны гэхээсээ илүү улс төрийн тэмцлийн шинжтэй учраас энэ хуулиар зохицуулах хүрээнд хамруулах боломжгүй гэж үзсэн юм. Төсөвт байгууллагын ажилтны нийгмийн баталгааг хангах асуудал нь Үйлдвэрчний эвлэл, Засгийн газрын байгууллага, Засаг даргатай хийх хэлцлийн хүрээнд ажил хаялтад хүргэхгүйгээр шийдэгдэж байхаар бодож тусгай хуулиар зохицуулахаар тооцсон болно.

Ингэхдээ сургууль, эмнэлэг, театрын захиргаа, үйлдвэрчний эвлэлтэйгээ хамтын гэрээ байгуулан эдгээр байгууллагын хүрээнд үүссэн маргааныг энэ хуулиар зохицуулна гэж ойлговол зохино.

Ажил хаялтыг хориглох, хойшлуулахад ямар үзэл баримтлалыг иш үндэс болгосон бэ? Манай улс НҮБ-аас сайшаан баталсан Хүний эрхийн түгээмл тунхаглал, улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт, бусад конвенцид гишүүнээр элсэж зохих үүрэг хүлээсэн билээ. Үүний дагуу манай шинэ Үндсэн хуульд хүний эрхийг хуульчлан баталгаажуулсан юм.

Иймээс хөдөлмөрийн харилцаанд оролцогч талуудын хувьд ажил хаях эрхийг эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактад заасан үзэл санааны дагуу хуучин 99 дүгээр зарлигаар батлагдсан хамт олны хөдөлмөрийн маргааныг шийдвэрлэх дүрэмд ажил хаялтыг хориглох салбарын хүрээг хянан үзэж зарим хэсгийг нь хүчингүй болгох тухай шийдвэрийг Үндсэн хуулийн цэц гаргасан билээ.

Үүнээс үндэслэн Монгол Улсын Батлан хамгаалах, улсын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журам сахиулах үүрэг бүхий байгууллагад ажил хаяхыг хориглох (хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг)-оор заасан юм.

Мөн санал зөрүүтэй асуудлаар хэлэлцээ хийх, хамтын маргааныг хянан шийдвэрлэх явцад ажил хаяхыг хориглох (9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг)-оор заав.

Харин хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан аж ахуйн нэгж байгууллагад ажил хаях нь улс орны ашиглагүй байдал, бусдын эрх ашгийг хохироохоор байвал Засгийн газар уг арга хэмжээг 1 сар хүртэл хугацаагаар хойшлуулахаар заасан нь энэ хугацаанд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх боломжийг нээж байгаагийн зэрэгцээ шинэ Үндсэн хуулийн үзэл санаанд нийцэж байгаа юм.

Хуулийн 11 дүгээр зүйлээр ажил хаялт, ажлын байрыг түр хаахад хамрагдсан ажилтны баталгааг тодорхойлов.

Ажил хаясан, ажлын байрыг түр хаасан нь хууль бус байснаас үүдэх хариуцлагыг хэрхэн тодруулсан бэ? Ашуны өмнө хууль бус ажил хаялтыг зохион байгуулсан Үйлдвэрчний эвлэл ажлын байрыг хууль бус түр хаасан эрх баригч (эзэн)-д болон ажил хаялтад оролцох, түүнийг үргэлжлүүлэхийг ямар ч тохиолдолд, түүнчлэн ажил хаялтыг : зогсоох, түүнд оролцохоос татгалзахыг хуульд зааснаас бусад тохиолдолд тулган шаардсан, санал зөрүүтэй асуудлаараа талууд санал бодлоо солилцох, чөлөөтэй сонголт хийхэд нь хуульд зааснаас бусад тохиолдолд хөндлөнгөөс оролцсон этгээдэд захиргааны хариуцлага (хуулийн 12 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг) хүлээлгэхээр заав.

Харин хууль бус ажил хаялт, хууль бусаар ажлын байрыг түр хаасны улмаас бусдад учирсан хохирлыг гэм буруутай этгээд хариуцахаар хуулийн 12 дугаар зүйлийн 3 дахь хэсэг тогтоов.

Үүнийг хэн яаж шийдвэрлүүлэх вэ гэвэл дээрх арга хэмжээний улмаас өөртөө хохирол учирлаа гэж үзсэн этгээд шүүхэд нэхэмжлэл гаргасны үндсэн дээр шүүх уг асуудлыг Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу эцсийн шийдвэр гаргана гэж ойлговол зохино.

Энэ хуулийг хэрэгжүүлэхийн тулд цаашид юу хийх ёстой вэ?

Аж ахуйн нэгж, байгууллагын түвшинд хамтын гэрээг Хөдөлмөрийн хууль, Монгол Улсын Засгийн газар, Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбооны Төв Зөвлөлийн 1991 оны 200/50 дугаар тогтоолоор баталсан зөвлөмжийн дагуу заавал байгуулдаг журамд шилжих хэрэгтэй, эс тэгвээс ажилтны эрх ашиг хохирч болохыг үгүйсгэхгүй.

Энэ ажлыг аж ахуйн нэгж байгууллагын эрх баригчид, үйлдвэрчний эвлэлийн анхан шатны байгууллага аль аль талаасаа санаачилгатай, идэвхтэй зохион байгуулахыг зөвлөж байна.

Хууль санаачлах эрх бүхий субъектээс хамтын гэрээний тухай хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хурлаар ойрын үед батлуулж мөрдөх нь энэ хуулийг хэрэгжүүлэх үндсийн нэг болох ёстой юм гэдгийг ч энэ дашрамд тэмдэглэе.

Ц. Товуусүрэн (Улсын Их Хурлын гишүүн)

МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1973 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн 161 дүгээр зарлигаар батлагдаж өнөөг хүртэл мөрдөж ирсэн «БНМАУ-ын хил хамгаалах хууль» нь шинэ Үндсэн хууль, хил хамгаалах одоогийн бодлого, хилийн асуудлаар хөрш орнуудтай байгуулсан гэрээ, хэлэлцээрүүд, цаг үеийн бусад нөхцөл байдалтай олон талаар нийцэхгүй болж улмаар улсын хил, түүнтэй холбогдсон бусад харилцаар зохицуулж чадахгүйд хүрсэн юм. Тэрчлэн уг хуулинд хилийн тухай нийтлэг үндэслэл, хил хамгаалах асуудлын зааг ялгаа бүдэг байв. Тухайлбал хил залгаа улстай хилийн асуудлаар харилцан тохирсон дэглэмийн асуудлыг хилийн журамтай хамтатган заасан, хилийн тусгай журам нь хилийн дэглэмдээ үйлчилж байдгийг тодорхой зааг ялгаагүй тусгаснаас хоёр өөр асуудлыг хутгаж ойлгоход хүргэсэн, улсын хил хамгаалах журманд зөвхөн хилийн цэргийн эрх үүргийг тодорхойлсон зэрэг зайлшгүй арилгавал зохих алдаатай зүйл байлаа. Түүнчлэн цаг үеийн өнөөгийн шаардлагатай уялдан хилийн цэргийн бүтэц, зохион байгуулалт, хамгаалалтын арга тактик өөрчлөгдөж байгаа, хил хязгаараа хамгаалах асуудал ард нийтийн үйл хэрэг болж буйг харгалзан үзэх, хилийн хууль тогтоомж зөрчсөн болон хилийн зөрчил гаргасан хүмүүст хариуцлага хүлээлгэхийг шинээр тусгах зэрэг зүй ёсны шаардлагууд амьдралаас урган гарлаа

Монгол Улсын хилийн тухай хуулийг шинэчлэн боловсруулж мөрдсөнөөр улсын хил хамгаалах талаар баримталж буй бодлого маань олон улсын гэрээ хэлэлцээрүүд, шинэ тутам мөрдөж байгаа хуулиудтай зохицолдож, эмх цэгцтэй болж өнөөгийн шаардлаганд нийцэж байгаа болно. Шинэ хуулийг боловсруулахдаа хил залгаа улстай хилийн асуудлаар байгуулсан сүүлийн үеийн гэрээ, хэлэлцээр, «Хил хамгаалах хууль» мөрдөгдөж байсан хугацаанд хуримтлагдсан сургамж, төрийн захиргааны байгууллага, хилчид, олон түмний санаа бодлыг харгалзаж, зарим улсын хуулиудыг судалж үзсэн болно.

Хуучин хууль нь,—Ерөнхий зүйл;

Хилийн тусгай дэглэм; Хил хамгаалах журам гэсэн бүлгүүдтэй байсан бол сая баталсан «Монгол Улсын хилийн тухай хууль» нь:

— нийтлэг үндэслэл
— улсын хилийн дэглэм
— улсын хил орчмын дэглэм
— улсын хил хамгаалалт, улсын хил хамгаалах байгууллага, түүний тогтолцоо, чиг үүрэг, бүрэн эрх
— улсын хил хамгаалалтад иргэн, байгууллага оролцох
— хүлээлгэх хариуцлага гэсэн бүлгүүдээс бүрдэж байна.

Нэгдүгээрт бүлэгт: хуулийн зорилт, бүрдэл, улсын хил болон хилийн усны тодорхойлолт, улсын хилийг тодорхойлох, тогтоох, тэмдэглэх, хамтран шалгах болон улсын хилээр нэвтрүүлэх журмыг тогтоох зарчим, хилийн тухай гэрээ, хууль тогтоомжийн биелэлтэд тавих төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааны хэм хэмжээг нарийвчлан заалаа.

Улсын хилийг тогтоохдоо хуульд зааснаас өөр зарчмаар хил тогтоохыг зөвхөн Улсын Их Хурал шийдвэрлэж байхаар тусгасан болно.

Уг зүйлд улсын хилийг хуурай газар, хил дээрх төмөр зам, авто зам, гүүр, далан бусад барилга байгууламжинд тогтоох зарчим, хилийн шугамын байршилтыг тодорхойлох аргыг шинээр тусгаж, улсын хилээр нэвтрүүлэх журмыг тогтоох зарчим, хилийн тухай хууль тогтоомжийн биелэлтэнд тавих төрийн хяналт шалгалтыг шинээр тусгав.

Хоёрдугаар бүлэгт: Монгол Улсын хилийн тухай дэглэмийн зорилго, агуулга, тогтоох журам, улсын хилийг арчлан хамгаалах, улсын хилээр зорчигч тээврийн хэрэгслийг нэвтрүү-

лэх болон нэвтрүүлэх үеийн хяналт шалгалт, хилийн ус, улсын хилийн шугам дээрх зам холбооны байгууламж, улсын хил дээр ан агнах, ажил үйлдвэрлэл явуулах, улсын хил орчмын байгаль орчин, ан амьтныг хамгаалах журам, хилийн зөрчил, хэнийг ямар нөхцөлд хил зөрчсөнд тооцох, хилийн төлөөлөгчийн үйл ажиллагааны талаар тусгав.

Хилийн дэглэмийн асуудлыг хил залгаа улстай байгуулсан гэрээний агуулгын дагуу задлан тодорхой тусгаж, ямар үйлдлийг хилийн зөрчилд тооцох, хилийн төлөөлөгчийн өөрийн харицуцсан хэсэгт гарсан хилийн зөрчлийн асуудлыг бие даан шийдвэрлэж байх, хэрэг бүртгэх эрх бүхий Засгийн газраас томилогдсон албан тушаалтан байж, хил залгаа улсын хилийн төлөөлөгчтэй харилцан ажиллах зэрэг зарчмын ялгаа заалтууд оруулсан болно.

Гуравдугаар бүлэгт: Улсын хил орчмын дэглэмийн зорилго, агуулга, хилийн бүс, зурвас, хилийн боомт газар гэж юуг хэлэх, түүнд мөрдөх журам, хил орчмын нутаг дэвсгэрийн тодорхойлолтыг тусгалаа.

Хилийн бүс, зурвасын гүний хязгаарыг 1973 оны хуулинд заасан хэмжээтэй ижил хэмжээгээр тусгасан боловч тэдгээрт мөрдөх журмыг хуулиар тогтоосон болно. Харин хилийн боомт, түүнд мөрдөх журам, хил орчмын нутаг дэвсгэрийн тодорхойлолтыг шинээр тусгалаа. Хил орчмын дэглэм нь хилийн дэглэмийг сахиулах, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилго бүхий тодорхой бүс, зурваст тогтоосон дэглэм байхаар тусгасан болно.

Дөрөвдүгээр бүлэгт: Улсын хил хамгаалалт, улсын хил хамгаалах байгууллага, түүний үйл ажиллагаа, чиг үүрэг, бүрэн эрх, Хилийн цэргийг удирдах байгууллагын даргын бүрэн эрх, улсын хил хамгаалалтанд агаарын довтолгооноос хамгаалах цэргийн гүйцэтгэх чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх, улсын хилд албан үүрэг гйцэтгэж байгаа цэргийн албан хаагч, иргэний эрх зүйн баталгаа, улсын хилийг хамгаалахад зэвсэг хэрэглэх журмуудын тухай тусгалаа.

Хил хамгаалалт гэж ямар үйл ажиллагааг хэлэх, түүний улс орны хэмжээнд удирдан зохион байгуулах байгууллага ямар бүтэц зохион байгуулалт, чиг үүрэг, бүрэн эрхтэй байх болон Хилийн цэргийг удирдах байгууллагын даргын эдлэх бүрэн эрхийг хуульчлан баталлаа.

Улсын хилд албан үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн-албан хаагч, иргэнийг онцгойлон үзэж тэдний эрх зүйн баталгааг шинээр хуульчлан баталлаа.

Хилийн албаны дүрмэнд байсан зэвсэг хэрэглэх журмыг хуулинд тусгаж, хилийн цэргийн тусгай анги, салбар хилийн маяа ямар тохиолдолд урьдчилан анхааруулахгүй болон урьдчилан анхааруулж байлдааны зэвсэг, техник хэрэглэхийг тусгав.

Ингэснээр хилийн маяа, хил залгаа улстай байгуулсан дэглэмийн гэрээний заалтуудтай уялдуулан байлдааны зэвсэг, техник хэрэглэх асуудал хуульчлан батлагдав.

Тавдугаар бүлэгт: Улсын хил хамгаалалтанд төрийн захиргааны байгууллагын харилцан ажиллах журам, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн засаг даргын бүрэн эрх, Монгол Улсын иргэний хил хамгаалалтад оролцож гүйцэтгэх үүрэг, эдлэх эрхийг тусгалаа.

Улсын хил хамгаалалт бол зөвхөн цэргийн хүчээр хамгаалах үйл ажиллагаа бус түүнд байгууллага, иргэд өргөнөөр оролцож, ард нийтээрээ улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах нь өнөөгийн гол асуудал болохыг шинэ хуулийн заалтууд илэрхийлж байгаа болно.

Зургадугаар бүлэгт: Улсын хилийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд түүний гэм буруу, хууль бус үйл ажиллагаанаас учирсан хохирлын хэм хэмжээг харгалзан хуульд зааснаар хүлээлгэх хариуцлагын үндэслэл, хүлээлгэх хариуцлагын талаар тусгалаа.

Энэ нь хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хилийн зөрчлийг таслан зогсоох гол хөшүүрэг болно.

Монгол Улсын хилийн тухай хуультай уялдуулан одоогийн албандаа мөрдөж байгаа дүрэм зааврыг шинэчлэн батлуулж, хилийн албаны арга тактикаа өөрчлөн мөрдөж, улсын хилийн хамгаалалтыг өнөөгийн цаг үеийн шаардлагын хэмжээнд зохион байгуулах болно. Улсын хилийн хууль шинэчлэгдсэнтэй холбогдуулан төрийн хуулиар олгогдсон эрх хэмжээндээ ажиллаж, амьдарч сурах явдал гол зорилт болж байна.

Улсын Их Хурлын гишүүн Д. БАЗАРСАД

МОНГОЛ УЛСЫН БАТЛАН ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

Улсын Их Хурал 1993 оны намрын чуулганаараа «Монгол улсын Батлан хамгаалах тухай» хуулийг эцэслэн хэлэлцэж батлав. Он жил дамжин хүлээгдсэн энэ хууль гарснаар Үндсэн хуулийн тулгуур заалтууд, тухайлбал «Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж үндэсний аюулгүй байдлыг хангах нь төрийн үүрэг мөн», «Монгол улсын иргэн эх орноо хамгаалах хуулийн дагуу цэргийн алба хаах үүрэгтэй», «Монгол улс өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчинтэй байна. Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгулалтыг хуулиар зохицуулна» гэсэн зарчмын чухал заалтыг амьдралд хэрэгжүүлэх эрх зүйн үндэс тавигдлаа.

Хуулийг Монгол Улсын цэргийн байгуулалт, манай эрх зүйн практикт төдийгүй, нийгмийн улс төрийн амьдралд гарсан шинэ үзэгдэл хэмээн зүй ёсоор үнэлж болно. Учир нь Монгол улсад батлан хамгаалах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг бүхэлд нь зохицуулсан эрхийн акт, тэрчлэн төрийн батлан хамгаалах болон цэргийн нэгдсэн бодлого үнэн хэрэгтээ байгаагүй юм гэж үзэх үндэстэй билээ.

Энэхүү хуулиар Монгол Улсын төрийн батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны хүрээ, зорилго, агуулгыг «Батлан хамгаалах нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг гаднын зэвсэгт халдлага, түрэмгийллээс хамгаалахад улс орны бэлэн байдлыг хангах, хамгаалах зорилго бүхий улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, цэргийн цогцолбор арга хэмжээ мөн.

Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, хүн амыг байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул, үл олноор устгах зэвсгийн хөнөөлөөс хамгаалах нь батлан хамгаалах үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг мөн» гэж тодорхойллоо. Үүнээс үзэхэд улс орныг батлан хамгаалах нь туурга тусгаар төр, улсаа хөгжүүлэх гадаад таатай орчинг бүрдүүлэх, эдийн засгийнхаа чадавхийг сайжруулах, дархан хилийнхээ халдашгүй байдлыг хангахаас аваад «хэрэгцээ шаардлага» гарвал эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг зэвсэглэн хамгаалах хүртэлх өргөн цар хүрээтэй арга хэмжээг цогцолбороор шийдвэрлэсэн гэж үзэж болох байна.

Хуулинд эх орноо батлан хамгаалахад төр, түүний байгууллага, Монгол Улсын иргэд, аж ахуйн нэгж байгууллага (өмчийн хэлбэрээс үл хамааран)-ын үүргийг тодорхойлон заасан нь батлан хамгаалах нэгдмэл тогтолцооны эрх зүйн үндсийг бүрдүүлэхэд нэн чухал ач холбогдолтой юм. Хуулийн хоёр, гуравдугаар бүлэг)

Төрийн байгууллагууд, тухайлбал Улсын Их Хурал,, Ерөнхийлөгч, Засгийн газар, Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, төрийн захиргааны байгууллагын бүрэн эрхийг тодорхойлохдоо Үндсэн хуулийн «Засаглал хуваах» үзэл санаа, мөн батлан хамгаалах үйл ажиллагаа, цэргийн байгуулалт, зэвсэгт хүчин нь төрийн удирдлага, иргэний хяналтад байх, улсын хил хамгаалах болон иргэний хамгаалалт байгууллагууд нь харьцангуй бие даасан байх зарчимд тулгуурласан болно. Хуулнар Монгол Улсын төрийн эрх барих дээд байгууллага УИХ-д (хуулийн хоёрдугаар бүлгийн 6-р зүйлийг үз) батлан хамгаалах тогтолцооны эрх зүйн үндсийг тогтоож, зэвсэгт хүчин, бусад цэргийн үйл ажиллагаанд иргэний хяналт тавих; Монгол Улсын Ерөнхийлөгчид төрийн тэргүүнийх нь хувьд төрийн удирдлагыг хэрэгжүүлэх нэг үндсэн институт байхаас гадна Үндсэн хуулинд заасны дагуу зэвсэгт хүчний Ерөнхий командлагч байх (7 дугаар зүйл), Засгийн газарт батлан хамгаалах болон цэргийн бодлогыг боловсруулах, хууль, төрийн бодлогын хэрэгжилтийг батлан хамгаалах асуудал эрхэлсэн гишүүн, төр захиргааны төв байгууллагаараа дамжуулан зохион байгуулах үүргийг оногдууллаа.

Засгийн газрын Батлан хамгаалах асуудал эрхэлсэн гишүүн нь улсыг батлан хамгаалах болон цэргийн бодлогын хэрэгжилтийг Засгийн газрын өмнө хариуцан, Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг толгойлж хилийн болон иргэний хамгаалалтын байгууллагуудын үйл ажиллагааг чиглүүлэн удирдахаар боллоо.

Төрийн захиргааны бүх байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн үүргийн тухай хуулийн заалтууд нь (11—14-р зүйлийг үз) төр, нийт ард иргэдээс эх орноо хамгаалах зорилтыг хэрэгжүүлэхэд тэдгээрийн хүлээх үүрэг хариуцлага, байр суурийг тодруулсан, тэдний үйл ажиллагааны агуулга, хэлбэрийг тодорхойлж байгаа юм.

Хуулинд зэвсэгт хүчнийг улс орныг гадныи зэвсэгт халдлага, түрэмгийллээс цэргийн хүчээр батлан хамгаалах зорилго бүхий төрийн цэргийн байгууллагуудын тогтолцоо болохыг заагаад зэвсэгт хүчин, цэргийн байгуулалтын үндэс, зарчим, бүтэц, зохион байгуулалт, үндсэн чиг үүрэг, удирдлагын тогтолцоог нь хуульчлан баталгаажуулав.

Зэвсэгт хүчний байгуулалтын үндэс нь төрийн хууль, тогтоомж, батлан хамгаалах бодлого, цэргийн номлолоор тодорхойлогдож, үйл ажиллагаа нь төрийн удирдлага, иргэний хяналтад байхаас гадна бүтэц, зохион байгуулалт нь түүний тайван ба дайны үеийн гүйцэтгэх үүрэгт зохицсон; үндсэн үүргээ биелүүлэхэд (өөрөөр хэлбэл эх орноо зэвсэглэн хамгаалахад) бэлэн байх, цэргийн бүх төрлийн хангамжийг төрөөс баталгаажуулах, хууль дээдлэх болон бусад зарчимд тулгуурласан юм.

Цэргийн байгуулалтын үндэс, зарчмыг Монгол Улсын хуулиар нийхүү хуульчлан баталгаажуулснаар бие бүрэлдэхүүнийг бүрдүүлэх болон тайван цагийн сургалт бэлтгэлийн тогтолцоог оновчтой, чиглэсэн зорилготой болгон, цэргийн бодлого, үйл ажиллагааны бүх асуудал (хуулиар нууцалснаас бусад зүйл) ард иргэдэд ил тод байх, энд аливаа дур зоргоор авирлах болон бусад субъектив алдаа зөрчлөөс сэргийлэх, улмаар ард иргэд-цэргийн холбоог бэхжүүлэх чухал ач холбогдолтой болов.

Энх тайван цагт Монгол Улсын зэвсэгт хүчин нь ерөнхий зорилалтын, улсыг агаарын довтолгооноос хамгаалах, барилгын, иргэний хамгаалалтын цэрэг дайчилгааны нөөцөөс бүрдэх бөгөөд дайн бүхий болон дайны байдлын үед бусад цэрэг (хилийн болон дотоодын цэрэг) зэвсэгт хүчний бүрэлдэхүүнд орж үүрэг гүйцэтгэж байх юм.

Түүнчлэн зэвсэгт хүчин, бусад цэрэг нь цэргийн удирдлагын байгууллага, төрөл мэргэжлийн цэргийн болон ар тал, техникийн нэгтгэл, ангиуд, цэргийн сургууль, эрдэм шинжилгээ, соёл урлаг, эмнэлэг, аж ахуй, үйлчилгээний байгууллагатай байх бөгөөд тайван цагт зэвсэгт хүчний нэгтгэл ангиуд нь бүрэн (үндсэн зорилалтын нэгжүүд, зэвсэг, байлдааны техник, удирдлага нь байлдааны цагийн орон тоогоороо, харин бие бүрэлдэхүүн нь дайчилгааны хязгаарлагдмал арга хэмжээний дараа бүрэн бүрдэх), хураангуй, нэн хураангуй (цэргийн дайчилгааны арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж бэлт-

гэл нөөцөөр нөхөн хангасны дараа бэлэн болох болон зөвхөн байнгын бүрэлдэхүүнээрээ үүрэг гүйцэтгэж буй) зохион байгуулалттай байж болохыг хуульчиллаа.

Хууль гарахаас өмнө зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд зөвхөн цэргийн жинхэнэ албан хаагчид (офицер, ахлагч, хугацаат албаны цэрэг, түрүүч нар)-ыг л хамруулан ойлгодог байсан бол одоо зэвсэгт хүчинд гэрээгээр ажиллаж байгаа энгийн ажилтнууд бие бүрэлдэхүүнд хууль ёсоор багтах болов. Энэ нь цэргийн бэлэн байдлыг хангах, хамт олны өмнөх тулгамдсан зорилтыг шийдвэрлэхэд тэдний гүйцэтгэх үүрэг хариуцлагыг өндөржүүлээд зогсохгүй, нийгмийн баталгааны заримд давуу эрхээр хангагдах боломжийг нээж өгч байгаа юм.

Хуулинд зэвсэгт хүчин нь эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг гадныи зэвсэгт халдлага, түрэмгийллээс хамгаалах үндсэн чиг үүргийн гадна улс орныхоо энхийн бүтээн байгуулалтад оролцох чиг үүргийг (тодорхой нөхцөлд) хэрэгжүүлж болохыг хуульчиллаа. (20 дугаар зүйлийг үз)

Батлан хамгаалах тухай хуулийн нэн чухал хэсэг нь зэвсэгт хүчин; бусад цэргийн удирдлагын тогтолцоог томьёолсон зүйл, заалтууд юм (21—24-р зүйлийг үзнэ үү)

Хуулинд зааснаар зэвсэгт хүчин бусад цэргийн удирдлага нь ерөнхий болон цэргийн мэргэжлийн удирдлагаас бүрдэх юм. Зэвсэгт хүчин бусад цэргийн ерөнхий удирдлагыг Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ дагуу; цэргийн мэргэжлийн удирдлагыг зэвсэгт хүчний ерөнхий штаб, бусад болон төрлийн цэргийн дарга, штабууд, нэгтгэл, ангийн захирагч, штаб, аймаг, нийслэл, дүүргийн цэрэг-иргэний хамгаалалтын штабууд тус тус хэрэгжүүлэх юм.

Энд ерөнхий удирдлагад: хууль тогтоох; иргэний хяналт тавих; бодлого боловсруулан хэрэгжилтийг нь удирдан зохион байгуулах төрийн захиргааны удирдлагыг; иргэний хяналтанд батлан хамгаалах хууль тогтоомжийн биелэлт, зэвсэгт хүчин, түүний цэргийн мэргэжлийн удирдлагын үйл ажиллагаа, батлан хамгаалах төсөв, санхүүжилтэд тавих хяналтыг багтаасан юм. Өргөн утгаар нь авч үзвэл иргэний хяналтыг батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний үйл ажиллагаанд төрийн эрх барих иргэнлэг дээд байгууллага, албан тушаалтан (иргэний парламент, иргэний Засгийн газар, Ерөнхий-

лөгч-төрийн тэргүүн болон шүүх, засаглалын зүгээс)-уудын хуулийн дагуу тавих хяналтын үйл ажиллагаа гэж үзэх үндэстэй юм.

Сонирхол татаж буй өөр нэг асуудал бол олон намын төлөөлөгчдөөс бүрдсэн парламентын байгуулсан иргэний Засгийн газрын батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь энгийн хүн байж болох асуудал бөгөөд энэ нь хуулийн үзэл баримтлалд зохих тусгалаа олсон байна.

Хуулийн дагуу зэвсэгт хүчний ерөнхий штаб нь цэргийн мэргэжлийн удирдлагын төв байгууллага байх, түүний дүрмээр эрх хэмжээг нь тогтоох, даргыг нь томилох, чөлөөлөх асуудлыг Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний командлагч Засгийн газрын батлан хамгаалах асуудал эрхэлсэн гишүүнтэй зөвшилцөн шийдэж байх юм.

Хуулинд улс орныг батлан хамгаалах арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр хийгээд цэргийн албан хаагчдын эрх зүйн байдлыг төрийн хуулиар зохицуулах заалтууд болон зэвсэгт хүчин, бусад цэргийн бүх төрлийн хангамжийг төрөөс баталгаажуулах зарчмыг хуульчилсан нь эх орноо хамгаалах ажил мэргэжлийг сонгосон хүмүүст ирээдүйдээ итгэх итгэлийг нь бататгах, төрдөө хууль ёсоор зүтгэж, төрийнхөө хууль ёсны ивээлд багтах эрх зүйн үндсийг тавив.

Батлан хамгаалах тухай хууль нь батлан хамгаалах үйл ажиллагаатай холбогдсон бусад хууль тогтоомжийг иж бүрнээр нь боловсруулах, батлан гаргах үндсийг тавьж байгааг эцэст нь тэмдэглэе.

Улсын Их Хурлын гишүүн Н. ЖАЛБАЖАВ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАЙЛБАР

Монгол оронд парламентат ёс хөгжин буй өнөө үед улс орны өмнө тулгараад байгаа олон чухал асуудлуудыг шуурхай шийдвэрлэхэд Улсын Их Хурал, ялангуяа түүний хууль тогтоох, хуулийн биелэлтийг хянан шалгах үйл ажиллагааг боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Иймч учраас Улсын Их Хурал энэ удаагийн намрын чуулганаараа өмнө Улсын Бага Хурлаас батлан мөрдөж байгаа «Монгол Улсын Их Хурлын тухай хууль»-д, зарим нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлан гаргалаа. Эдгээр нэнэлт, өөрчлөлтийг 1993 оны 11 дүгээр сарын 8-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна.

Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болсон шалтгаан нь одоо мөрдөж буй Улсын Их Хурлын хууль, түүний хуралдааны дэг хоёрыг нэгтгэж хийснээс болж зарим зүйл арай ерөнхий, бүрхэг тусгагдсан, нөгөө талаар хуулийн 8 дугаар бүлэг буюу дэгийн хэсгийг практикт хэрэгжүүлэхдээ зарим талаар гажуудсан нь Их Хурлын чуулганы ажиллагааг сунжруулахад нөлөөлж байгаатай холбоотой юм. Түүнчлэн Ерөнхийлөгчийн хориг, Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт зэрэг тодорхой асуудал хэлэлцэх журмыг хуульчлаагүй байсныг хуульчлах шаардлагатай болсон юм.

Энэ хуульд гол төлөв процессын шинжтэй асуудал тусгагдсан болохыг хэлэх нь зүйтэй. Гэхдээ бас зарчмын шинжтэй зарим асуудал ч бий. Тухайлбал одоогийн хуулиар Их Хурлын дэд дарга аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагааг чиглүүлэх үүрэгтэй байгаа нь Үндсэн хуулийн үзэл санаа, Засгийн газрын хууль, нутгийн өөрөө удирдах зарчимд төдийлөн нийцэхгүй байна гэж үзээд хуулиас хасчээ.

Улсын Их Хурлын ажлын голыг Байнгын хороодод төвлөрүүлэх, Байнгын хороодыг аль нэг том байгууллагын төв аппаратын хэлтэс, газрын хэлбэрээр биш, жинхэнэ парламентын ажлын хэлбэрт оруулах, Их Хурлын гишүүдэд аль ч байнгын хороонд очиж ажиллах, санал дүгнэлтээ хэлэх, хамтран ажиллах, сонирхсон асуудлаараа Их Хурлын болон аль ч байнгын хорооны ажлын хэсэгт орж ажиллах боломж бүр-

дүүлэх бодлогод үндэслэн зарим өөрчлөлт нэмэлт оруулжээ. Улсын Их Хуралд орж ирж байгаа асуудал нэг бүрийг Байнгын хороод бүрийн хурлаар хэлэлцүүлэхийг шаарддаг, ингэж ойлгодог буруу арга барилыг зогсоолоо. Үүнтэй холбогдуулж Улсын Их Хурлын хуулийн 49 дүгээр зүйлийн зарим заалтад өөрчлөлт, тодотгол оруулсан юм.

Хуульд Улсын Их Хурлын чуулганы хуралдаан дээр санал хураалтыг хязгаартай болгох, түүнийг нэг мөр ойлгох, Их Хурлын шийдвэрийг ёсчлох, хаалттай хуралдаан явуулах зэрэг нэлээд асуудлыг тодруулж өөрчиллөө.

Байнгын хороод, намын бүлгийн үүрэг ролийг дээшлүүлж, ажлын голыг, өөрөөр хэлбэл нэгдмэл буюу нэг мөр санал дүгнэлтэнд хүрэх асуудлыг тэнд хийж байх парламентат ёсны арга ажиллагаанд шилжиж байгаатай холбогдуулан нэгдсэн хуралдааныг 7 хоногт 4 биш 3 өдөр хуралдуулж болох тухай заалт нэмж оруулав.

Улсын Их Хурлын гол чиг үүргийн нэг болох хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах тухай асуудлыг хуульд дэлгэрүүлэн зааж өглөө. Тухайлбал, Улсын Их Хурлын тухай хуулийн 55[1] дүгээр зүйлд заахдаа:

Улсын Их Хурал чуулганы хуралдааны болон түүний чөлөө цагт хянан шалгах бүрэн эрхээ Улсын Их Хурлын гишүүн, Байнгын хороо, мөн Улсын Их Хурал буюу Байнгын хороонооос байгуулсан ажлын хэсгээр дамжуулан хэрэгжүүлнэ.

Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ дараахь хэлбэрээр хэрэгжүүлнэ:

1) Улсын Их Хурлын гишүүн асуулт, асуулга тавьж хариулт авах;

2) холбогдох албан тушаалтны мэдээлэл сонсох, түүний илтгэл, сонсголыг хэлэлцэх;

3) хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг хэрхэн биелүүлж байгаа байдлыг шалгах;

4) хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийн талаар иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн санал, хүсэлт, мэдээллийг сонсох, хүлээн авах:

Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хэлбэрээр хэрэгжүүлсэн хяналт шалгалтын дүнг Улсын Их Хурлын чуулганы болон байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж шаардлагатай гэж үзвэл зохих шийдвэр гаргана.

Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах явцад уг шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулах,

эсхүл түүнийг хүчингүй болгохоор байвал Улсын Их Хурал уг асуудлыг даруй хэлэлцэж шийдвэрлэнэ гэжээ.

Улсын Их Хуралд сонгогдсон ард түмний элч болох Улсын Их Хурлын гишүүн нь ноуны өмнө сонгогчдынхоо эрх ашгийн төлөө уйгагүй зүтгэгч, төрийн зүтгэлтэн байх нь чухал хэдий боловч түүний бүрэн эрхээ хэрэгжүүлэх баталгааг, ялангуяа өөрийнх нь амьдралын баталгааг хангаж өгөх тухай асуудал орхигдоод байгааг хуульд нэмж тусгаж өглөө. Тухайлбал,

Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон хүндэтгэн үзэх шалтгааны улмаас гишүүнийхээ үүргийг гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд түүнийг төрийн сонгуульт ажилд сонгогдохоос өмнөх ажилд нь эгүүлэн ажиллуулах буюу тухайн ажил байхгүй бол ажил эрхлэх хүртэлх 6 сарын хугацаанд Улсын Их Хурлын гишүүн байсан үеийн авч байсан цалинтийн хэмжээнээс буурахааргүй тэтгэмж, хэрэв бага цалинтай ажил эрхэлж байгаа бол цалингийн зөрүүтэй тэнцэх хэмжээний тэтгэмж мөн хугацаанд олгоно. Хэрэв Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдохоос өмнө оршин сууж байсан газраа шилжвэл өөрийнх нь болон гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүний замын зардал, ачаа тээшийн хөлсийг авто хөсгийн тарифаар тооцож олгоно гэж хуульд заажээ.

Хууль, Улсын Их Хурлын шийдвэрт цаашид зөвхөн Улсын Их Хурлын дарга гарын үсэг зурж байхаар хуульд заажээ. Мөн тэрчлэн Улсын Их Хурлын Тамгын газраас эрхлэн гаргадаг «Төрийн мэдээлэл» сэтгүүлд хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлигийг эмхтгэн нийтэлж байсан бол одоо Засгийн газрын тогтоол, Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбарыг мөн нийтэлж байх боллоо.

Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль бүрэн эхээрээ «Ардын эрх» сонины 1993 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн . . . дугаарт нийтлэгджээ.

Улсын Их Хурлын Тамгын газрын зөвлөгч
Б. ОДОНЖИЛ